

Гар бичмэл, хувилбар 2

Д.ЦЭВЭЭНДОРЖ, Д.БАЯР, Я.ЦЭРЭНДАГВА, Ц.ОЧИРХУЯГ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ

**УЛААНБААТАР
2002**

Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн батласнаар хэвлэв

**Редактор: Д.Цэвээндорж
Д.Баяр**

ГАРЧИГ

Өмнөх үг.....	3-4
I Бүлэг. Археологийн шинжлэх ухааны судлах зүйл, зорилго, арга зүй, ач холбогдол.....	5-11
II Бүлэг. Хүний үүсэл хөгжлийн тухай асуудал археологийн тулгуур асуудлын нэг болох нь.....	12-19
III Бүлэг. Монголын археологийн судалгааны тойм.....	20-35
I Хэсэг. Чулуун зэвсгийн үе IY Бүлэг.Палеолит.....	37-38
§ 1. Доод палеолит.....	38-45
§ 2. Дунд палеолит.....	46-50
§ 3. Дээд палеолит.....	51-55
§ 4. Палеолитын үеийн урлагийн дурсгал.....	55-63
§ 5. Палеолитын үеийн аж ахуй, нийгэм соёлын асуудал.....	63-67
Y Бүлэг. Мезолит, неолитын үе § 1. Мезолитын үе.....	68-73
§ 2. Мезолитын урлаг.....	73-75
§ 3. Неолитын үе.....	75-82
§ 4. Неолитын урлаг.....	82-85
§ 5. Мезолит, неолитын үеийн аж ахуй, нийгэм соёлын асуудал.....	85-89
II Хэсэг. Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе YI Бүлэг. Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе § 1. Энеолитын үе.....	89-91
§ 2. Хүрэл зэвсгийн үе.....	91-93
§ 3. Дөрвөлжин булш.....	93-97
§ 4. Хиргисүүр.....	97-99
§ 5. Буган хөшөө.....	100-106
§ 6. Хадны зураг.....	106-114
§ 7. Төмөр зэвсгийн түрүү үе. Чандманийн соёл...	115-131
§ 8. Төмөр зэвсгийн түрүү үеийн түүвэр олдвор....	132-134
§ 9. Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн аж ахуй, нийгэм соёлын асуудал.....	134-146
III Хэсэг. Эртний улсуудын археологийн дурсгалууд YII Бүлэг. Хүннүгийн археологийн дурсгалууд.....	147-148
§ 1. Хүннүгийн булш бунхан.....	148-161
§ 2. Хүннүгийн хот суурин.....	161-164
§ 3. Хадны зураг.....	164-166
YIII Бүлэг. Түрэгийн үеийн археологийн дурсгалууд.....	167-169
§ 1. Түрэгийн тахил тайлгын онгон.....	169-177
§ 2. Бичиг үсгийн дурсгал.....	177-179
§ 3. Хүн чулуу.....	179-184
§ 4. Хот суурин, уран барилга.....	184-186
§ 5. Булш оршуулга.....	186-189
IX Бүлэг. Уйгурын археологийн дурсгалууд.....	190-191
§ 1. Уйгурын хот балгад.....	192-196
§ 2. Уйгурын тахил тайлгын онгон.....	196-197
§ 3. Бичиг үсгийн дурсгал.....	197-202
§ 4. Хүн чулуу.....	202-207
X Бүлэг. Киргисийн археологийн дурсгалууд.....	208-211
XI Бүлэг. Киданы археологийн дурсгал.....	212-214
§ 1. Киданы хот суурин.....	214-219
§ 2. Булш оршуулга.....	219-222
§ 3. Бичиг үсгийн дурсгал.....	222-223
§ 4. Хүн чулуу.....	224-226
XII Бүлэг. Монгол гүрний үеийн археологийн дурсгалууд.....	227-229
§ 1. Хот суурин.....	229-236
§ 2. Монголчуудын булш оршуулга.....	237-242
§ 3. Хүн чулуу.....	242-248
§ 4. Бичиг үсгийн дурсгал.....	248-251
§ 5. Хадны зураг.....	252-254
Товчилсон үгийн жагсаалт.....	255
Гарчиг.....	256-257

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

АРХЕОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУДЛАХ ЗҮЙЛ, ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, АЧ ХОЛБОГДОЛ

Түүхийн шинжлэх ухааны эх хэрэглэгдэхүүний нэг болох эд өлгийн дурсгалыг тусгайлан судлаж, он цагийг нь тогтоон, тухайн үеийн байдлыг олдсон эд өлгийн дурсгалаар нь сэргээн тогтоож түүхчлэн бичих шаардлагын үүднээс түүхийн шинжлэх ухааны нэгэн салбар ухаан үүсэн бий болж хөгжсөнийг археологи хэмээн нэрлэдэг. Археологи гэдэг нь монголоор эртний судлал гэсэн утгатай үг ажээ.

Археологи гэсэн нэр томьёо анх Эртний Грект МЭӨ IV зууны үед үүссэн байна. Тодруулбал Платон өөрийн “Гиппей” (харилцан яриа) хэмээх зохиолдоо энэхүү нэр томьёог анх эртний дурсгалыг судлах ухаан гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Тэрээр энэ нэр томьёоны дор эрт үед холбогдох бүхий л зүйлийг хамааруулан авч үзэж байсан бол, Европын сэргэн мандалтын үед археологи нь Грек, Ромын урлагийн илэрхийлэл болж үнэн хэрэгтээ музейн хуучин ховор зүйлийн нэг хэсгийг нэрлэсэн нэр болж байв. Орчин үед ч дэлхийн практикт археологийн зорилго, судлах зүйлийн тухай, ялангуяа он цагийн асуудлынх нь талаар нэг мөр тогтсон зүйлгүй байна.

Археологийг жинхэнэ шинжлэх ухаан болон хөгжихөд М.Э. 79 оны үед Везувын галт уулын дэлбэрэлтэд тэр чигээрээ дарагдсан Помпей, Геркуланум хотуудыг XVIII зууны эхээр малтан шинжилсэн ажил онцгой ач холбогдолтой байсан юм. Помпейн малтлагын үеэр анх удаа 1600 гаруй жилийн өмнө сөнөсөн энэ хотын ард олны аж байдал, амьдралын дүр зургийг тэр чигээр нь нөхөн сэргээж чадсан юм. Малтлага хийсэн судлаачид юуны түрүүнд аж ахуйн холбогдолтой зүйлийг судлахын ач холбогдлыг анх удаагаа мэдэрсэн гэдэг.

Анхны бичиг үсэг үүссэн цагаас эхлэн он цагийн хувьд наашлах тусам түүхийн бичмэл сурвалжууд олширч, утга агуулга нь баяжин, тодорхой үйл явдлын тухай өгүүлсэн байдаг боловч тэдгээр үйл явдлыг харилцан адилгүй байр сууринаас тайлбарлаж, тэмдэглэн бичсэн (тухайн түүхчийн өөрийн байр суурины үүднээс) байдгаас үүдэн түүхийг нэгдмэл нэгэн хүрээнд нь авч үзэхийн тулд археологийн шинжлэх ухааны судалгааны үр дүнтэй харьцуулах шаардлага зайлшгүй тохиолддог. Ийм шаардлагын үүднээс нэгэнт түүх нь эртний сурвалжуудад тэмдэглэгдсэн хожуу үеийн дурсгалыг ч улируулан судалдаг байна. Энэ нь археологчдыг бичгийн сурвалжид дурдагдсан зүйлтэй археологийн олдворуудаа харьцуулан жишиж судлах бололцоог олгодог билээ. Хамгийн наад зах нь л гэхэд XV-XVII зууныг хүртэлх үеийн түүхийг судалдаг байна. Энэ бүхнээс үзэхэд археологи бол түүхийн туслах ухаан биш харин өөрийн хэрэглэгдэхүүнээрээ түүхийн томоохон асуудлыг дэвшүүлэн тавьж шийддэг олон талтай шинжлэх ухаан юм.

Археологийн шинжлэх ухаан нь хүний биеийн бүтцээс авахуулаад гарал үүсэл, түүний нийгмийн ухамсрын хэлбэрүүдийн үүслийг хүртэлх бүхий л асуудлыг бусад аль ч ухаанаас илүү бүрэн судалдаг. Археологийн шинжлэх ухаан нь янз бүрийн шинжлэх ухаан, салбар ухаануудтай нягт холбоотой бөгөөд нумизматика-зоос зүй, эпиграфика-бичээс судлал, сфрагистика-тамга судлал зэрэг өөрийн салбар ухаантай болно.

Археологийн шинжлэх ухааны гол хэрэглэгдэхүүн бол эртний хүмүүсийн эдлэж, хэрэглэж, цогцлон бүтээж байсан эд өлгийн дурсгалт зүйлс юм. Археологчид эртний эд өлгийн зүйлс, байгууламжийг шинжлэн судлах чадварыг эзэмшиж, тэдгээр эд өлгийн зүйлсийг түүхийн сурвалж болгон ашиглах боломжтой болохыг батлан харуулсан юм.

Эд өлгийн эх сурвалжийг шинжлэх арга нь бичгийн баримтыг судлах аргаас ихээхэн ялгаатай байдаг. Эдгээр аргуудын шинжлэх ухааны үндэслэл нь археологийн шинжлэх ухааныг түүхийн шинжлэх ухаан болгодог байна. Эртний эд өлгийн зүйлсийг нягт нямбай судалдаг боловч, тэр нь эцсийн зорилго биш юм. Харин тэдгээр эртний эд өлгийн гол үнэ нь түүхийн судалгааны эх хэрэглэгдэхүүн болж буйд оршино.

Археологи, үйлдвэрлэлийн хэрэгслэлийн түүхийг мөн судалдаг бөгөөд гэхдээ тэдгээр хэрэгслээр хийсэн эд өлгийн зүйлсийг судалдаг. Үйлдвэрлэлийн хэрэгслэлээр шууд үйлдвэрлэлийн харилцааны тухай авч үзвэл алдаанд хүрч болно. Эд өлгийн зүйлсийг тухайн нийгмийн хүрээнээс салгаж болохгүй.

Археологчийн судлах эд өлгийн дурсгалт зүйлс нь хөдөлмөрийн багаж, зэр зэвсгийн зүйл, гоёл чимэглэл, сав суулга, зоос, эртний тамга, бичээс, хадны зураг, хөшөө, сууц оромж, хот суурин, далан, бэхлэлт, эртний усжуулалтын байгууламж суваг шуудуу зэрэг олон янз байдаг. Иймээс археологийн шинжлэх ухаан бол хүний нийгмийн түүхийн хөгжил ба тэрхүү хөгжлийн зүй тогтлыг гол төлөв эд өлгийн түүхэн эх баримтаар судладаг байна. Археологийн судлагдахуун болох эртний эд өлгийн дурсгалт зүйлсийг эртний булш, хот суурин, оромж сууцны үлдэгдлийг малтан судлах замаар олж илрүүлдэг. Эртний булш, тахилгын байгууламж нь газрын гадарга дээрхи дараас чулууныхаа хэлбэр төрхөөр дугуй дөрвөлжин, зууван дугуй, гадуураа хүрээтэй, хашлагат, олон жижиг чулуун цагирагаар хүрээлэгдсэн, дэргэдээ хөшөөтэй зэрэг олон янз байдаг.

Булшинд, нас барагсадыг дагалдуулан гол төлөв хөдөлмөрийн болоод ан агнуур, дайн байлдааны багаж зэвсэг, хувцас хэрэглэл, морь малын тоног хэрэгсэл, морь, бод, бог малын толгой, бусад хэсгийн махыг дагалдуулан тавьсан байдаг явдал нь тухайн үеийн хүмүүсийн сүсэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, нэг ёсондоо хойд насны тухай төсөөлөлтэй холбоотой билээ. Харин эртний хүмүүсийн суурьшин амьдарч байсан баримт болох оромж сууцны үлдэгдэл, суурин газраас олддог эд өлгийн зүйлс арай өөр юм. Эртний хүмүүсийн амьдарч байсан суурингийн орчимд сууцны байгууламжийн үлдэгдэл, хоол хүнс, хувцас хунар, сав суулга, багаж зэвсгийн үлдэгдэл, гарсан хог хаягдал, үнс нүүрс зэрэг нь шороонд булагдан аяндаа он жилийн уртад газрын хөрсөнд дарагддаг байна. Ийнхүү эртний хүмүүсийн хөдөлмөрийн үр дүнд буй болсон эд өлгийн зүйлс олон арав зуун жилээр булагдан газрын давхрага нь хүнд анзаарагдахгүй үе үеэрээ зузааран нэмэгддэг. Эдгээр үе давхаргад хадгалагдаж үлдсэн эд өлгийн олдвор нь тэднийг хийж үлдээсэн нийгмийн соёлын түвшинг тусгадаг тул ийм байдлаар тогтсон үе давхаргыг соёлт давхрага гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон материаллаг зүйлсийг хадгалсан, бүхэл бүтэн түүхэн хугацаанд, бүрэлдэн тогтсон үе давхаргыг соёлт давхарга гэдэг. Соёлт давхарга байгаль цаг уурын болон ахуйн олон янзын хүчин зүйлээс шалтгаалан хэдхэн сантиметрээс аваад хэдэн арван метрийн зузаан тогтоцтой байдаг.

Газрын гадарга дээр ил гарсан байгууламж бүхий булш, суурин, балгас, хөшөө зэрэг археологийн дурсгалыг хялбар илрүүлж болдог. Харин газрын хөрсөн дээр ил гарсан шинж тэмдэггүй, чулуун зэвсгийн бууц суурин, далангүй булш, зам, суваг (даланг нь эвдсэн булш, хэрэм, даланг нь хагалж тариа тарьсан суурин) зэргийг олж илрүүлэхэд нарийвчилсан хайгуул, археологчийн нарийн мэдрэмж судалгаа хэрэгтэй болдог. Газрын хөрсөн дээр ямар нэгэн тодорхой мэдэгдэх шинж тэмдэггүй байсан археологийн дурсгалууд салхи, цас, усны үер болон газар шорооны ажлын явцад илэрч олох тохиолдол байдаг. Ингэж олдсон томоохон дурсгал бол газар шорооны ажлын явцад илэрсэн Увс аймгийн Улаангомын ойролцоох Чандмань уулын төмөр зэвсгийн түрүү үеийн булшнууд юм.

Археологчид өөрсдийн хайгуул судалгааныхаа ажилд шинжлэх ухаан-техникийн шинэхэн ололт, аргуудыг өргөн ашигладаг. Эдгээрийн дотроос хамгийн эртнийх нь агаарын зураг авалтын арга юм. Энэ аргын давуу тал нь өргөн уудам хэмжээний талбайг эзлэн оршиж байгаа томоохон хотын үлдэгдэл зэргийг илрүүлдэгт оршино. Сүүлийн жилүүдэд сансараас авсан зургийг археологийн судалгаанд ашиглах явдал дэлхийн олон оронд эрчимтэй нэвтэрч байна.

Археологийн шинжлэх ухаанд өргөн ашигладаг өөр нэгэн арга бол геофизикийн судалгааны арга болно. Энэ арга нь сонирхолтой мэдээлэл агуулж байж магадгүй гэж үзсэн тодорхой талбайд, тогтсон хэмжээний гүйдэл өгөхөд үзүүлж буй эсэргүүцлийн тоон утгыг тодорхойлох замаар газрын хөрсөн доор байж болох байгууламжийн тухай мэдээлэл авч болдог арга юм.

Археологийн шинжлэх ухаан нь химийн шинжлэх ухааны хөрсний бүтцийн нэгдлийг тодорхойлдог аргыг өөрийн судалгаандаа өргөн ашигладаг. Чингэхдээ эртний хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан органик зүйлсийн хаягдал, орхигдосын фосфатын хэмжээг тодорхойлох замаар хөрсний соёлт давхаргын заагийг тодорхойлдог юм.

Сүүлийн үед археологийн шинжлэх ухаанд нэгэн шинэлэг салбар төрөн гарч ирсэн нь далай тэнгис, гол мөрөн ихтэй улсад үүсэн хөгжсөн усан доорхи археологи болно. Өөрөөр хэлбэл, эртний хот суурингийн үлдэгдэл, булш бунхан нь өнөөдөр далай тэнгисийн усан доор живж орсон байх нь цөөнгүй бөгөөд тэдгээрийг судлан шинжлэх шаардлага зүй ёсоор бий болж байна. Мөн түүнчлэн цоо шинээр астроархеологи буюу одон ертөнцийн археологи гэсэн салбар үүсэн бүрэлдээд байна. Энэ нь эрт үеийн хүмүүсийн сансар ертөнц, одон гарагийн төсөөллийг тэдний хад чулуу яс мод зэрэгт сийлж зурж үлдээсэн хуанли, өвөрмөц сонин хэлбэрийн зураас, толбо цэг зэрэгт тулгуурлан судалдаг археологийн шинжлэх ухааны цоо шинэ салбар гарч ирэх төлөвтэй байна.

Археологийн шинжлэх ухааны судалгааны нэгэн чухал асуудал бол аливаа эд өлгийн олдворын он цагийн хамаарлын асуудал юм. Археологийн олдворыг судлахад, тухайн дурсгал чухам ямар үед холбогдож болохыг урьдчилсан байдлаар тодорхойлох хэрэгтэй. Зарим нэгэн олдворын он цагийг урьдчилсан байдлаар тогтоох нь хэдийгээр төвөгтэй, зарим тохиолдолд огт боломжгүй байдаг учраас чухам ямар цаг үед хамаарах болохыг нь харьцуулсан судалгааны аргаар тогтоох ч явдал байдаг. Олон тооны эд өлгийн хэлбэр төрхөөр харьцуулан он цагийг тогтоох арга нь археологийн уламжлалт гол арга билээ. Гэхдээ археологийн шинжлэх ухаанд олон тоотойгоор байгаа олдворуудаасаа илүүгээр цөөн тоотой байгаа олдворууд нь харьцангуй их мэдээлэл өгөх тохиолдол ч байдаг байна. Тухайлбал: Хүннү нарын зохион бүтээсэн хэл хуурыг дурдаж болно. Гэвч цөөн тоотой байгаа олдворууд их мэдээлэл өгдөг гэдэгт хатуу баригдаж болохгүй юм. Тодорхой нэг булшинд харьцангуй өөр өөр үеүдийн зоос хийсэн байх нь элбэг тохиолддог. Зөвхөн зоосыг нь харгалзан он цагийг нь тогтоох гэвэл булшинд буй бусад эдлэлийн он цагтай тохирохгүй он цагийн хувьд хямрал үүснэ. Иймээс тухайн булшны он цагийг тогтоохдоо түүнд буй олдворуудын хамгийн сүүлийн үед холбогдох олдворын насаар тогтоодог. Уламжлалт хэв шинжийг харьцуулан олдворын насыг тогтоодог аргаас гадна археологийн шинжлэх ухаанд төрөл бүрийн шинжлэх ухааны үр дүнг хэрэглэх нь зайлшгүй шаардлагатай болж байна. Үүнийг чулуун зэвсгийн үеийн судалгааны жишээгээр тайлбарлавал, чулуун зэвсгийн үеийн дурсгалын насыг тогтооход газар зүй, геоморфологи (газрын

тогтоцын онол), палеомагнит (эртний соронзон орон судлал), палеоантропологи (эртний хүн судлал), палеоботаника (эртний ургамалшилт), палеонтологи (эртний амьтан судлал), хими-физикийн шинжлэх ухааны зарим үр дүнг ашиглах шаардлагатай байдаг. Иймээс тухайн салбарыг судалдаг археологич тэдгээр шинжлэх ухааны талаар зохих шатны мэдлэгтэй байж үр дүнг ашиглаж чаддаг байх хэрэгтэй юм.

Археологийн дурсгалын холбогдох он цагийг нарийн тогтоох боломж тэр бүр байдаггүй ч гэсэн тухайн дурсгалаас олдсон нэг болон хэд хэдэн эдлэлийн он цагийг лабораторийн нарийвчилсан шинжилгээгээр тогтоосноор тухайн дурсгалын он цагийг тогтоож болдог.

Зарим тохиолдолд эртний ургамалшилтын судалгааны аргуудыг хэрэглэж дурсгалын он цагийг тогтоож болдог байна. Ингэхдээ хөрсний бүтцийн найрлагыг нарийвчлан задлан шинжилсний үр дүнд тухайн хөрсний бүтцэд буй ургамлын тоосонцороор эртний ургамшилтыг он цагийн тогтсон дараалалтай харьцуулах замаар уг олдворын хамаарагдах үеийг тогтоож болдог. Энэхүү арга нь хуучин чулуун зэвсгийн үеийн агуйн болон соёлт давхрага бүхий суурин газрыг нарийвчлан судлахад ихээхэн ач холбогдолтой билээ. Учир нь тухайн үеийн хүмүүсийн амьдралд эн тэргүүнд байгаль орчин, цаг уур чухал нэгэн үүргийг гүйцэтгэж байсан нь ойлгомжтой.

Өнөө үед археологийн судалгаанд байгалийн болон тодорхой шинжлэх ухааны аргуудыг өргөн хэрэглэх замаар археологийн дурсгалын он цагийг найдвартай тогтоож байна. Тухайлбал аливаа амьд амьтан, ургамал нь өөрөөсөө байнга C^{14} атомын жин бүхий радиоидэвхт изотоп ялгаруулж байдаг бөгөөд уг биет үхэж мөхсөний дараа нүүрс төрөгчийн уналт явагддаг байна. Археологийн малтлагын явцад олдсон хүн малын яс, модны нүүрс зэргийн нүүрстөрөгчийн уналтын түвшинг тогтоох замаар тухайн хүн, ан амьтан, мод зэрэг амьтан ургамлын гаралтай зүйлийн үхэж мөхсөн цаг хугацаа, шатаагдсан үеийг тогтоож болдог байна. Энэ аргаар ямар нэгэн тодорхой жил сарыг тогтоодоггүй, зөвхөн судлаж буй дээжийн хамаарах он цагийг дундажаар тогтоодог. Энэ аргыг хэрэглэн ойролцоогоор бидний амьдарч буй үеэс 60 мянган жилийн өмнөх үе хүртэлх хугацааг тодорхойлох боломжтой.

Байгалийн шинжлэх ухааны дээрх аргуудыг өргөн хэрэглэж олдвор хэрэглэгдэхүүний он цагийг тогтоож байна. Олонх тохиолдолд хэв шинжийн талаас нь үндэслэн тогтоосон он цаг байгалийн шинжлэх ухааны аргыг хэрэглэж тогтоосонтой тохирдог.

Археологийн судалгааны өөр нэг тулгуур асуудал бол эд өлгийн зүйлсийг хийж бүтээсэн газар нутгийн тухай асуудал байдаг. Өөрөөр хэлбэл археологийн малтлага судалгааны явцад олдсон эд өлгийн зүйлсийг тухайн орон нутагт үйлдвэрлэж байж уу, эсвэл өөр нутгаас авчирсан зүйл үү гэдгийг тогтоон тодруулах асуудал юм. Дээрх асуудлыг тодруулснаар түүхэн нэгэн үеийн ард олны аж ахуйн хөгжилтийн түвшин, оюуны сэтгэлгээний чадавхи, гар урлал, гадаад улс оронтой хэрхэн харилцаж байсан зэрэг олон хүчин зүйлийг сэргээн тодруулан авч үзэх боломж олгодог.

Тухайн эд өлгийн зүйлсийг нутгийн гаралтай болохыг тогтоох олон янзын арга байдаг. Эдгээрээс хамгийн бодитой нь ямар нэгэн эдлэлийг цутгаж байсан хэв олодох явдал юм. Хэв олдож байгаа нь түүгээр тэр газар үйлдвэрлэл явуулж батлах шууд баримт болдог ач холбогдолтой.

Археологийн нарийн мэргэжлийг эзэмшээгүй хэнийг ч археологийн малтлага судалгаа хийхийг Монгол Улсын Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуулиар хатуу хориглосон байдаг. Учир нь тухайн нөхцөлд хувийн ашиг сонирхлын үүднээс шинжлэх ухаанд урьд өмнө нь мэдэгдээгүй байсан ховор чухал эд өлгийн дурсгалыг устгаж үгүй хийх тохиолдол ихээхэн байдаг.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хуулиар (2001 оны 6-р сарын 12-наас мөрдөгдөж буй) Монгол улсын нутагт археологийн хайгуул малтлага, судалгаа явуулах зүйлийг тогтоосон археологийн судалгаа дагнан эрхэлдэг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага (ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төв)-д олгож, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн гүйцэтгэхээр хуульчилан тогтоосон нь дэлхийн соёл шинжлэх ухаан хөгжсөн бусад орнуудын нэгэн адил монголын ард түмний эртний түүх археологийн дурсгалд төрөөс тодорхой анхаарал тавьж буйн илрэл юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТУХАЙ АСУУДАЛ АРХЕОЛОГИЙН ТУЛГУУР АСУУДЛЫН НЭГ БОЛОХ НЬ

Эрт дээр цагаас хүн төрөлхтний анхаарлыг татсаар ирсэн нэг асуудал бол хүний үүслийн тухай асуудал билээ. Орчин үед олон тооны бодит олдворууд дээр тулгуурлан шинжлэх ухаан хүний үүсч бий болж хөгжсөн үйл явцыг гүнзгийрүүлэн судалсаар байна.

Дэлхийн түүхэнд хүн бий болсон цагаас орчин үе хүртэлх үеийг антропоген хэмээн нэрлэдэг. Археологийн шинжлэх ухаан антропогений гурван гол асуудлыг хөндөн тавьдаг. Энэ нь 1) хүний үүсэл, энэ үйл явц болсон газар хугацаа 2) антропогений материаллаг үйлдвэрлэлийн хөгжил, археологийн соёлтой хэрхэн холбогдох, 3) арьсний өнгөний ялгавартай байдлын шалтгаан, үйл явц эдгээр юм.

Хүн биологийн зүйлийн хувьд дээд сүүн тэжээлтний баг болох приматын бүрэлдэхүүнд багтана. Энэ багт хүнээс гадна хагас сармагчин, сармагчин ордог ажээ. Приматын талаар бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн ангилал байдаггүй ч дотор нь хүн дүрст мич (*Pongidae*), хүн болон түүний ойрын төрлүүдийг багтаасан гоминид (*Hominidae*) гэж хуваан авч үзсээр иржээ. Орчин үеийн хувьслын харьцуулсан анатомийн онолыг баримтлагчдын дунд хүний ойрын төрлийн хүн дүрст мичтэй холбогдох тухай онол давамгайлдаг байна. Цусны плазмын биохимийн судалгаагаар хүн шампанзетай их төстэй гэсэн дүгнэлт гарчээ.

Дээд приматуудын салаалалт миоцений дунд үед явагдсан гэж үздэг байна. Гоминидын салаа мөчиртэй холбогдох хамгийн эртний приматын үлдэгдэл анх 1962 онд Египетийн нийслэл Каираас өмнө зүгт 20 орчим км-т оршдог Эль-Файюм хотын ойролцоох хөндийгөөс олдсон байна. 20-8 сая жилийн өмнө амьдарч байсан мич (примат)-ний үлдэгдэл яснууд Кени, Энэтхэг, Пакистан, Хятад болон Европ тивээс олдсон хэдий ч тэдгээрийн ямар нь ч эцсийн эцэст гоминидийн бүл бүрэлдэн бий болох үндэс болж байсангүй. Гоминидийн бүлийн гол онцлог нь босоо явалт, гар нь бугуйгаараа чөлөөтэй хөдлөх, харьцангуй том уураг тархи гэсэн гурван үндсэн бие эрхтний бүтцийн өөрчлөлтийн онцлог байжээ. XX зууны 20-иод оны эхээр Африкаас анх биеийн босоо зохион байгуулалттай хүн дүрст приматын ясны үлдэгдэл олсон бөгөөд үүнийг гоминидийн бүлийн хамгийн эртний төлөөлөгч болгон авч үзжээ. Эдгээрээс хамгийн эртнийх нь 4 сая жилийн өмнө амьдарч байсан Афарын австралопитек (*australopithecus afarensis*) юм. Анх 1974 онд Африк тивийн Этиоп улсын Хадар гэдэг газраас энэ мичний араг ясны үлдэгдэл олджээ. Ясанд хийсэн судалгаагаар тэр нь 25 орчим насны 110 см өндөртэй, ойролцоогоор 30 кг орчим жинтэй байсан бололтой. Одоогийн байдлаар Африкийн зүүн хэсгийн нутаг дэвсгэрээс 60 гаруй ийм төрлийн араг ясны үлдэгдэл олоод байна.

Австралопитекийн өөр нэгэн төлөөлөгч бол африкийн австралопитек (*australopithecus africanus*) юм.

Энэ мичний гавлын ясны хагас анх 1924 онд Өмнөд африкийн Таунг төмөр замын өртөөний ойролцоо шохойн чулуу олзворлох явцад олжээ. Шүдэнд нь хийсэн шинжилгээгээр 3-4 насны хүүхдийнх болох нь тогтоогджээ. Энэ гавлын ясны үлдэгдэлд хийсэн судалгаагаар 126 см урт гавалтай, уураг тархи нь 390 см³ багтаамжтай байжээ гэж тогтоосон байна. Энэ төрлийн мичний оршин байсан хугацаа нь 2,8-1 сая жилийн тэртээх үе юм.

Харьцангуй биерхэг австралопитекийн төрөл болох *australopithecus robustus*-ын үлдэгдлүүд Африкийн өмнөд хэсгээс олджээ. Энэ төрөл нь дундажаар 1,6 м өндөр, 50 кг жинтэй, уураг тархины багтаамж нь 530-550 см. байсан нь тогтоогджээ. 2,5 сая жилийн тэртээ үүсэж 1,5 сая жилийн тэртээ мөхсөн гэж үздэг байна. Мөн түүнчилэн Африкийн Дорнод хэсгийн Омо, Кооби-Фора, Чесованья, Олдувайн хавцал зэрэг газраас 2,5-1 сая жилийн тэртээд амьдарч байсан *australopithecus boisei*-н үлдэгдэл олджээ. Энэ төрлийн мичин хүний ясны үлдэглийн хамт бүдүүлэг хагалсан чулуун зэвсгийн зүйлс гарсан нь чулуун зэвсэг хийх дадал чадвартай болсон байсныг харуулах баримт болжээ.

Австралопитекын ясны үлдэгдлүүдэд хийсэн шинжилгээгээр тэд босоо явдаг байсан төдийгүй урд хоёр мөч болох гар нь чөлөөтэй болсон байсан байна гэж үзжээ. Мөн түүнчилэн дундажаар 600 см³ багтаамжтай уураг тархитай байсныг нь ч тогтоосон байна. Австралопитек нь хөдөлмөрийн багаж зэвсэг хийх чадвартай болсон нь хүн төрөлхтний түүхэнд гарсан том эргэлтийн нэгэнд зүй ёсоор тооцогддог. Тодорхой зорилготойгоор хөдөлмөрийн багаж зэвсэг хийх нь оюун ухааны тодорхой түвшинг илтгэн харуулдаг.

Одоохондоо эрдэмтэд австралопитекийн хэд хэдэн зүйлийн алинаас нь хүн болон хөгжих цаашдын үйл явцын үндэс болсныг хараахан тогтоож чадаагүй байна. Ямартай ч энэ төрлийн мич нь хүний үүслийг хувьслын онолын үүднээс тайлбарлах хамгийн бодит өвөг гэдэг нь нэгэнт тодорхой болсон юм.

Сүүлийн 100 гаруй жилийн турш Америкаас бусад тивээс хөгжлийнхөө янз бүрийн шатанд хамаарах нэн эртний хүний ясны үлдэгдлийг олж илрүүлжээ. Эдгээр олдворууд нь юуны түрүүнд хүний хөгжлийн түүх, хувьслын онолын баталгаа болж байна. Хүн өөрийнхөө цаашдын хөгжлийн явцад нэн эртний хүн буюу архантропууд (*homo habilis*, *homo erectus*), хүй нэгдлийн үеийн хүн буюу палеантропууд (*neandertal*), орчин үеийн (*homo sapiens*) гэсэн гурван том шатыг туулжээ. Геологийн

түүхийн үүднээс авч үзвэл хүн бүрэлдэн бий болж хувьсан хөгжсөн дэрхи үе шатууд нь дөрөвдөгч галавтай холбогддог.

Английн археологич Луис Лики 1959 онд Африкийн дорнод хэсэгт орших Танзани улсын Олдувайн хавцлаас хожим Зинжантроп (*Zinjanthropus*) буюу дорнодын хүн хэмээн нэрлэгдсэн эртний хүний ясны үлдэгдлийг олжээ. Түүний уураг тархины багтаамж нь австралопитекийнхтэй төстэй байсан байна. Гэвч биеийнх нь зарим онцлог нь хүн үүсэх үйл явцын эртний хэлбэр мөн болохыг үзүүлж чадсан ажээ. Удалгүй Л.Лики дахин нэгэн ясны үлдэгдлийг олсон бөгөөд түүний тархины багтаамж нь 670-680 см³ буюу өөрөөр хэлбэл австралопитекийнхээс илүү багтаамжтай байв. Уг хүний ясны үлдэгдэлд хийсэн шинжилгээгээр 2 сая жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогдсон. Хүний хөгжлийн нэн эртний төлөөлөгч болох эдгээр *Homo Habilis*-ууд нь австралопитекийн зарим зүйлтэй нэгэн үед зэрэгцэн амьдарч байсан нь (2,5-1,5 сая жил) он цагийг нь тогтоох судалгаагаар батлагджээ. Олдувайн хавцлаас олдсон эдгээр эртний хүний ясны хамт анх удаагаа кварцитаар хийсэн чулуун зэвсэг, араатан амьтны ясны үлдэгдлийн хамт олдсон нь анх хийж түүхий мах идэх болсныг гэрчилж өгсөн билээ. Ийм ч учраас чулуун зэвсгийн үеийн хамгийн эртний үеийг олдувайн үе хэмээн нэрлэх болжээ. Сүүлийн жилүүдэд явуулсан судалгаанаас *Homo habilis* Олдувайгаас гадна Өмнөд, Дорнод африкийн бусад газар нутагт ч тархсан байсан нь тогтоогджээ. Кени улсын Туркана нуурын зүүн эргийн Кооби-фора гэдэг газраас олсон эртний хүний ясны үлдэгдэл одоогоор олоод байгаа үлдэгдлүүдээс хамгийн сайнд тооцогддог байна.

Хүний хөгжлийн дараагийн шат нь *Homo erectus* юм. Голландийн эмч Э.Дюбуа 1891 онд Ява арлаас эртний хүний ясны үлдэгдэл болох гавлын ясны хайрцаг, дунд чөмөг олсон бөгөөд үүнийгээ Ява арлын питекантроп (*pithecanthropus*) хэмээн нэрлэжээ. Энэ нээлтээс даруй 45 жилийн дараа дахин Ява арлаас хүн төрхөт амьтны ясны үлдэгдэл, болхи хийцтэй чулуун зэвсэг түүний дотор гилбэр хэлбэрийн зэвсгийг олсон байна.

Питекантроп нь австралопитекээс нэлээд том байсан ба 900-1200 см³ тархины багтаамжтай, ойролцоогоор 150 см орчим өндөртэй байжээ. 500-800 мянган жилийн өмнө дэлхий дээр амьдарч байв. 1929 онд Хятадад Бээжингийн ойролцоох Чжоукоудянь агуйгаас эртний хүний үлдэгдэл олджээ. Үүнийг анх Д.Блэк Бээжингийн синантроп (*sinanthropus pekinensis*) хэмээн нэрлэх санал тавьсан байна. Уураг тархины багтаамж нь питекантропоос хавьгүй илүү байв. Синантропын ясны үлдэгдэлтэй хамт хайрга, цахиур бугын эврээр хийсэн олон тооны хөдөлмөрийн багаж зэвсгийг олсон. Малтлагын явцад олон тооны галын ором илэрсэн явдал нь синантропууд гал хэрэглэж байсныг батлах баримт болсон байна.

Явагаас олдсон питекантроп, хятадын синантроп хоёрыг хоёуланг нь *Homo erectus*-ийн төрөлд багтаан авч үзэх болсон байна. Эдгээр нь одоогийн байдлаар Африк тивээс өөр газар нутгаас олоод байгаа эртний хүний үлдэгдлүүд гэж зүй ёсоор тооцогдож байна. *Homo erectus*-ийн үлдэгдэл Нариокотомэ, Кооби-Фора, Тернифин зэрэг Африкийн зүүн болон, хойд талын нутгаас олдсон байна. Туркан нуурын баруун эргээс олдсон хүний ясны үлдэгдэл ойролцоогоор 1,6 сая жилийн тэртээ холбогдох нь тогтоогдсон. Энэ зүйлийн өмнөх зүйлүүдээс ялгагдах гол онцлог нь уураг тархины багтаамж (880-1100 см³) томорсон явдал юм. Араг яс нь мөн адил томорч, бадриун болсон байна. Энэ зүйлийн түрүү үеийн төлөөлөгчид төрөл бүрийн чулуун зэвсэг хийж чаддаг болсон төдийгүй, гал гарган авч өргөн хэрэглэж, магадгүй хоол хүнсээ ч боловсруулан болгож чанаж идэх чадвар суусан байж болох талтай. Эдгээр эртний хүмүүс ойролцоогоор 1,6-0,2 сая жилийн тэртээ оршин амьдарч байжээ. Гэвч 0,5-0,2- сая жилийн тэртээх үед холбогдох Ази, Европ, Африкийн нутгаас олдсон зарим эртний хүний олдворуудын талаар судлаачдын дунд эсрэг тэсрэг санал байдаг. Зарим судлаачид эдгээр эртний хүний ясны олдворуудыг *Homo sapiens*-ийн эртний хэлбэр (*archaic*) хэмээн үздэг. Германий Мауэрээс олдсон Гейдельберг хэмээн нэрлэгдсэн хүний доод эрүүний яс 500 мянган жилийн өмнөх үед холбогдох ба бүтцийн хувьд орчин үеийн хүнийхтэй их төстэй байжээ.

Мөн түүнчилэн *Homo Sapiens (archaic)*-д хамааруулж байгаа хүний ясны үлдэгдлүүд Унгарын Вертешселош (400 мян. жил), Их Британий Сванскомб (250 мян. жил), Лондоны ойролцоо (300 мян. жил), Германий Штейнгем, Грекийн Петралоны агуй, Африкийн Замби улсын Кабве (200 мян. жилийн өмнөх), Өмнөд Африкийн Сальданыя (200 мян. жилийн өмнөх), Ява арлын Нгандонга, Хятадын Шаньси мужийн Дали зэрэг газруудаас олоод байна. Гавлын ясны үлдэгдлүүдэд хийсэн шинжилгээгээр уураг тархины багтаамж нь 1035-1400 см³ багтаамжтай байсан нь тогтоогджээ.

Homo sapiens (archaic)-ийн ясны үлдэгдлүүдтэй хамт чулуу, мод, ясаар хийсэн олон тооны багаж зэвсгийн зүйлс олдсоноос гадна оромж сууцны үлдэгдлүүд ч олджээ.

1836 онд Германы судлаач Фультрот Рейн мөрний цутгал Дюссель голын хөндий Неандерталиас эртний хүний ясны үлдэгдлийг олсон ба анх олдсон газрынхаа нэрээр түүхэнд нэршиж ирсэн байна. Энэ төрхийн хүн цэвэр дунд палеолитийн үед (мустье) амьдарч байсан боловч ойролцоогоор 250-100 мянган жилийн өмнөх үед ч холбогдох неандерталийн үлдэгдлүүд Германий Эрингдорф, хойд Уэльсийн Понтневид, Францын баруун хэсгийн Фонтешевад, Югославын Крапинаас олдсон ба судлаачид тэдгээрийг неандерталийн эртний хэлбэрт багтаан үздэг байна.

Сонгодог неандерталийн бүлэг хэмээн суудлаачдын нэрлэсэн 70-35 мянган жилийн өмнөх үед холбогдох олдворууд, Францын Ортю, Ля Шэз, Ля Кина, Ля Ферраси, Италийн Монте-Черчео,

Гуаттари, Бельгийн Спи, Испанийн Уртиага, Гибралтар, Баньолас зэрэг газрууд болон Герман, Унгар, Чех, Словак, Украины газар нутгуудаас олджээ.

Дээрхээс үзэхэд неандерталийн хүний ясны үлдэгдлүүд ихэвчлэн Европ тивээс олдож байгаа хэдий ч цөөн тооны олдворууд Израилийн Табун, Амуд, Кафзехын агуй, Схул, Иракийн Шанидарийн агуй, Узбекистаний Тешик-Ташийн агуй, Хятадын Мабайн агуй, Мароккогийн Жебел-Ирхунд, Ливийн Хуа-Фтеа зэрэг газруудаас олдсон байна.

Неандерталь хүн том толгой, өргөн нүүр, түүштэй, том хамартай, доод эрүүний яс бахим, дух налуу, хөмсөгний том товгортой, булчинлаг бахим биетэй байжээ. Тэдний амьдарч байсан үе нь байгаль цаг уурын хувьд эрс тэс, хүйтэн байсан учир тэр байдалдаа ч дасан зохицож бие махбодийн зохион байгуулалтад ийнхүү өөрчлөлт гарч иржээ. Тэд гол төлөв агуй хонгилд амьдардаг байсан байна. Неандертальчуудыг нас барагсадаа оршуулж байсан анхны хүмүүс гэж үздэг. Оршуулгын зан үйл нь ч өвөрмөц байжээ. Одоогоор мэдэгдээд байгаа тэдний оршуулгын байдлаас харахад хүнээ дагалдуулан чулуун зэвсгийн зүйлсийг тавьж чулуун дэр дэрлүүлж, хөвд дэвсэн, баавгайн толгой дагалдуулан оршуулдаг байжээ. Мөн зарим тохиолдолд улаан зосон будаг ч цацдаг байсан байна.

Хүний хөгжлийн дараагийн үе нь *Homo sapiens (modern)* буюу *homo sapiens sapiens* юм. Энэ төрөлд орчин үеийн төлөөлөгчид болох *Homo sapiens recens* ч дээд палеолитийн үед амьдарч байгаад мөхсөн *Homo sapiens fossilis* ч багтдаг.

1868 онд Францын Дордонь мужийн Ле-Эзи суурингийн Кроманьон агуйгаас орчин үеийн хүнийхтэй нэн төстэй ясны үлдэгдэл олдсон. Он цагийн хувьд кроманьон хүн 40-10 мянган жилийн өмнөх үед холбогдоно. Энэ хүний ясны үлдэгдлүүд Кроманьонаас гадна Францын шанселад, Истуриц, Ле-Рош, Гаргас, Чехийн Младеч, Словакийн Пржедмости, Болгарийн Бачо-Кира, Оросын Сунгирь, Костёнки, Афонтова гора, Кенийн Элмейнтейта, Өмнөд Африкийн Фиш-Хок, Израилийн Кзар-Акил, Хятадын Чжоукоудянь, Цзиянь, Люцзиянь, Дуньдянянь зэрэг газрууд болон Энэтхэг, Шри-Ланк, Ява арал, Австралийн газар нутгаас олджээ.

Дээд палеолитийн үеийн хүний уураг тархины багтаамж нь нэмэгдэн, дүрслэн бодох чадвар сайжран хэл яриа сайн хөгжиж, хөдөлмөрийн багаж зэвсгээ улам боловсронгуй хийх чадвартай болж, бодит байдлыг дүрслэн зураг зурах зэрэг чадвартай болжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ¹

Монгол орон бол нэн эртнээс хүн нутаглаж ирсэн өлгий нутаг, Ази тивийн өвөрмөц иргэншлийн төв учир хуучин чулуун зэвсгийн үеэс дундад зууны үеийг хүртэлх археологийн олон зуун мянган жилийн дурсгалаар баялаг билээ. 1889 онд Оросын эрдэмтэн Н.М. Ядринцев Орхон голын хөндийгөөс эртний Түрэгийн үл уншигдах бичээст хөшөөг олж, Монголын эзэнт их гүрний нийслэл болж байсан Хар Хорум хотын ор үлдэцийг малтаж, эрдэм шинжилгээний тодорхойлолт бичсэн цагаас Монгол орны археологийн судалгааны ажил эхэлсэн.

Ядринцевын дараагаар Финляндийн эрдэмтэн Г.Гейкелээр удирдуулсан шинжилгээний анги 1890 онд Хөшөө Цайдамд буй Билгэ хаан, Культегины хөшөөний руни бичээсийг судалжээ.

1891 онд Оросын ШУА-аас академич В.В.Радловын толгойлсон тусгай шинжилгээний ангийг Монголд томилон ажиллуулсан ба Туул, Орхон хоёр мөрний хөндийн дурсгалуудыг шинжилсэн, шинжилгээний ангийн ажлын үр дүн нь “Орхоны археологийн шинжилгээний ангийн бүтээлүүд” гэдэг дөрвөн боть зохиолд тусгалаа олжээ.

Радловын шинжээний ангийн дараагаар Монгол орны археологийн дурсгал ялангуяа эртний түрэг бичээсийг судлах зорилгоор олон судлаачид ирж байжээ. 1897 онд Е.Н.Клеменц Тоньюкукийн, 1909 онд финийн судлаач Г.И.Рамстедт Моюнчурын, 1912 онд Польшийн эрдэмтэн В.Л.Котвич Кульчур хааны гэрэлт хөшөөдийг тус тус сурвалжлан олж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж байжээ.

1897 онд оросын судлаач Разинцев одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ойролцоох элсэн манханаас хянгар хэлбэрийн зэвсэг, хусуур, хутган ялтас, говийн үлдэц зэрэг чулуун зэвсгийн олдвор цуглуулсан байна. Үүний дараа 1912-1913 онуудад Н.П.Лисовский мөн тэр газраас олон тооны чулуун зэвсгийн зүйл олж цуглуулжээ.

1922 онд Монголын өмнөд хэсэгт АНУ-ын Нью-Йоркийн Байгалийн Түүхийн музейн Р.Ч.Эндрюсийн удирдсан Төв Азийн экспедиц хайгуул судалгааны ажил хийсэн бөгөөд тус шинжилгээний анги дараа нь дахин 1923, 1925, 1928, 1930 онуудад ажилласан байна. Палеонтологич, геологич, газарзүйч голлосон тус экспедицийн бүрэлдэхүүнд 1925 оноос археологич Н.К.Нельсон оролцон ажилласан бөгөөд Хаалган хотоос Улиастай хүртэл 1600 гаруй км зурвас газарт хайгуул хийж 180-иад чулуун зэвсгийн бууц суурин илрүүлэн олж, 200 мянга гаруй чулуун зэвсгийн зүйлс олж цуглуулсан байна.

Одоогийн ШУА-ийн үүсгэл болсон Судар бичгийн хүрээлэнг 1921 онд байгуулж, улмаар түүхийн кабинет ажиллаж эхэлжээ. Түүхийн кабинет археологийн дурсгалыг илрүүлэн олох, түүний тухай мэдээ хурааж, дурсгалын сургыг гаргах ажлыг эрхэлдэг болжээ.

1922 оноос эхлэн археологийн анхны алхам болох хайгуул шинжлэлийн ажлыг монголчууд биеэ дааж, заримдаа зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хамтаар явуулж иржээ. Монгол Ард Улсын Судар бичгийн хүрээлэн, ЗХУ-ын ШУА хоёрын хамтын хүчин чармайлын үрээр манай орны нутаг дэвсгэр дээрх археологийн дурсгал, хөшөө, булш, хуучин хот, хэрмийг сурвалжлан олж, заримд нь малтах ажлыг хийж байжээ.

Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хийсэн археологийн шинжилгээний анхны том ажлуудын нэг нь Ноён уулын хавьд Хүннү гүрний язгууртнуудын том булшийг П.К.Козловын удирдсан Монгол-Түвэдийн шинжилгээний анги 1924-25 онд малтан шинжсэн явдал юм.

Ноён уулын булшнаас ховор нандин үнэт олдворууд олдсны дотор хатгамал ширдэг, торгон эдлэл, баатаруудын нэхмэл дүр хөрөг, хаш чулуун чимэглэл, давтмал алт зэрэг олон зүйл байсан байна. Бүдүүн цул нарсаар зааж газрын гүнд хийсэн оршуулгын хашлага авс, ваар сав, амуу будаа зэрэг мөн олджээ. Ноён уулын булшуудыг малтсан явдал Монгол орны археологийн судалгаа шинжлэлийн түүхэнд гойд содон хэрэг явдал болж, XX зууны үеийн археологийн их нээлтийн нэг нь болсон билээ.

XX зууны 20-30-аад онд явуулсан археологийн шинжилгээний ажлууд нь түүх-археологийн ба этнографи-археологийн холимог шинж чанартай байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тэр үед Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан О. Жамъян, Ж. Цэвээн, Н. Дэндэв, Зөвлөлтийн судлаач В.А. Казакевич, С.А. Кондратьев, А.Д. Симуков, Д.Д. Букинич нарын зэрэг эрдэмтэд монголын археологийн судалгаанд сонин сонин ажил туурвиж байсан нь манай археологийн судалгаа цаашдаа хөгжих эхлэл болжээ.

Монголч эрдэмтэн В.А.Казакевич Монгол Ард Улсын нутгаар аялан явж, говийн Алтан уул, Халхын гол, Хэрлэн гол, Туул голын хөндийг байгаа археологийн дурсгалуудыг олж үзээд, эрдэм шинжилгээний тодорхойллого бичсэний дотор Хэнтий аймгийн өмнө захад орших XVII зууны үеийн Хэсэг байшин, Олон байшин гэдэг суурин газруудыг шинжилсэн байна. Мөн тэрээр Дариганга нутагт

¹ Дэлгэрэнгүй тоймыг Д.Цэвээндорж. Монголын археологийн судалгаа // Археологийн судлал. т. XIY. f. 1. тал 10-46-д үзнэ үү.

байгаа хүн чулуун хөшөөдийг анх удаа эрдэм шинжилгээний үүднээс тодорхойлон бичиж нийтлүүлжээ.

1925 онд ЗХУ-ын ШУА-аас тусгай шинжээний анги гаргаж П.К.Козловын Ноён уулаас нээж олсон булш, түүнээс гарсан олдворын ач холбогдлыг тодорхойлуулахаар Монголд ирүүлсэн байна. Тухайн шинжилгээний анги нь Ноён ууланд буй хүннүгийн язгууртны булшийг археологийн малтлагын горимын дагуу явуулж, Ноён уулын булшийг Хүннү улсын үед холбогдохыг тогтоосноос гадна Туул голын (Улаанбаатараас баруун тийш) сав газраар явж 92 булш бүртгэн шинжиж, шинэ чулуун зэвсгийн үед холбогдох материал цуглуулжээ. 1925 онд Г.Боровка Туул голын дунд урсгалаар археологийн хайгуул малтлага хийж 400 орчим дөрвөлжин булш олж заримыг нь малтан шинжилсэн ба Улаан хад, Их алаг, Дөрвөлжин зэрэг газраас хадны зураг, тамга нэлээдийг олж илрүүлэн анх удаа буган хөшөө, дөрвөлжин булш, хадны зарим зургыг нэгэн үед холбогдоно хэмээн үзжээ.

Мөн онд академич Б.Я.Владимирцов, буриад эрдэмтэн Барадий нар Хэрлэн, Туулын эхэн хавиар шинжилгээ хийж Хэрлэнгийн Тэрэлжид “Хасар балгасаныг” малтаж XIII зууны үед холбогдоно гэсэн ба Баян Давааны аманд түрэг ноёдын булш малтаж шинжсэн байна.

А.Д.Симуков 1927 онд Ноён ууланд булш малтаж, эсгий ширдэгийн тасархай, ургамлын хээтэй давтамал алтны өөдөс, морины алтадмал хавтгай төмөрлөг дүрс, торгоны өөдөс, хятад бичээстэй чий будагтай аяга зэргийн онц сонирхолтой олдворыг олжээ. Аяганы хятад бичээсийг тайлан уншихад манай эриний I-р онд Хятадын Сычуань мужид үйлдсэн болох нь мэдэгдсэн юм. Түүнчлэн Л.А.Амстердамская, Б.Б.Бамбаев нар угсаатны зүйн материал цуглуулах далимаар археологийн дурсгалуудыг судлан, Хэрлэн ба Сэлэнгийн сав газруудад байгаа Түрэгийн хүн чулууны дурсгалуудыг тодорхойлон тэмдэглэсэн байна.

1933-1934 онд Д.Д.Букинич Хангай уул хавиар археологийн шинжилгээ хийж, цөөн тооны дөрвөлжин булш малтан шинжилж монголын тэр цагийн археологийн шинжилгээний дүн тоймыг нэгтгэн гаргаж байжээ.

Шинжлэх ухааны хүрээлэн 1927 оноос хойш археологийн мэдээ баримт байнга цуглуулсаар байсан бөгөөд 1935-1939 оны үест орон нутгийг судлах товчоо байгуулан өөрийн төлөөлөгчийг орон нутагт суулган, идэвхтэн сурвалжлагч нарыг элсүүлэн ажиллуулж, тус орны археологи-түүхийн дурсгалуудын сураг мэдээг арвин ихээр хурааж байжээ.

Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхийн кабинетэд 19 жилийн турш хуримталсан мэдээ зүйлс ба орос эрдэмтэн нарын ХҮИИ зууны үеэс эхлэн бүртгэн тэмдэглэсэн археологийн дурсгалуудын мэдээ зангийг үндэс болгон Х.Пэрлээ 1941 оны эцсээр “Монгол Ард Улсын археологийн картын сан”-г зохиож эхэлсэн бөгөөд түүнээс хойш хэд дахин шинэ материалаар баяжуулан, нэмэн засварлажээ.

1942 онд Х.Пэрлээ Төв аймгийн Авдарбаян сумын нутаг Авдар уул, Хүйтний голын баруун хөтлийн археологийн дурсгалуудын газрын зургийг үйлдэж, эртний хэдэн булшийг малтан шинжилж, улмаар малтлагын үр дүнг нийтэлсэн нь Монгол оронд Монгол оронд монгол хүн анх удаа археологийн малтлагыг бие даан хийсэн анхны эрдэм шинжилгээний ажил байлаа.

“БНМАУ-ын түүх” нэгэн ботийг Монгол-Зөвлөлтийн эрдэмтэд хамтран зохиох ажлын бэлтгэл хийх үед 1946-1947 онд профессор С.В.Киселев Монгол Ард Улсын археологийн дурсгалуудыг шинжсэн байдал төлөвийг судлаж “Монгол орон эрт цагт” гэдэг өгүүллийг бичиж нийтлүүлсэн юм. Энэ нь монголын археологийн талаар 1922-1946 онд хооронд их бага завсарлагатай явуулсан шинжилгээний дүн тойм нь болсон билээ.

1948-1949 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний анги профессор С.В.Киселев, Х.Пэрлээ нарын удирдлагын дор ажиллаж, Хар Хорум хот, Хар балгасыг малтан, гар үйлдвэр-худалдааны хороолол, орд харшийн үлдэгдлийг илрүүлэн олжээ. Тухайн шинжилгээний анги Орхоны сав газарт эртний аймгуудын булш нэлээд хэдийг малтан шинжилсэн байна. Түүний хоёр салбар нь профессор А.П.Окладников, угсаатны зүйч К.И.Вяткина нарын удирдлагын дор манай нутгийн баруун аймгууд, зүүн хэсэг, говь нутгуудаар аялан ажиллаж эртний олон дурсгалыг үзэж тэмдэглэн судалснаас чулуун зэвсгийн үеийн урьд мэдэгдсэн буюу эс мэдэгдсэн бууцуудыг нягтлан шинжиж шинэ бууц, сууринг нэмэн олж судалсан байна. Мөн Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Наран толгой зэрэг газраас хэдэн буган хөшөө илрүүлжээ. К.В.Вяткина Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай уулын хаднаа хонхойлон цохиж сийлсэн зураг олсон байна.

1948-1949 онд А.П.Окладниковын удирдсан палеолитын дурсгал судлах анги Архангай аймгийн Лүн сумын нутаг орхон голын Мойлтын ам, Дорнод аймгийн Матад сумын Тамсагбулаг зэрэг газраас палеолит, неолитын суурин, Өвөрхангай аймгийн Ховд сумын нутаг Тэвш уул, Улаанбаатар хотын орчим Гачууртын ам зэрэг газраас хадны сүг зураг олж илрүүлжээ.

1950-иад оноос манай орныг археологийн талаар судлах тодорхой чиглэлийн биеэ даасан шинжилгээний ажил болох чулуун зэвсэг, хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн, эртний (Хүннү, Түрэг, Кидан) улсуудын археологийн шинжилгээг манай археологч нар гол төлөв бие даан, мөн заримдаа Зөвлөлт болон бусад социалист орны эрдэмтэн нартай хүч хавсран явуулах болсон. Энэ үед археологийн мэргэжилийн боловсон хүчин бий болж бие даан судалгаа явуулж иржээ.

1950-аад оноос Х.Пэрлээ Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт буй Чин толгойн балгас, Талын улаан балгас, Хар бухын балгас, Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Хэрлэн мөрний хөндийд

орших Зүүн хэрэм, Баруун хэрэм, Дорнод аймгийн нутагт буй Хэрлэн барс, Хэнтий аймгийн Батширээт сумын Өглөгчийн хэрэм зэрэг арав орчим хотуудыг малтан шинжилж сурвалж бичгийн мэдээтэй харьцуулан судалжээ.

1951 онд Х.Пэрлээ Дундговь аймгийн нутаг Их газрын чулууны ойролцоох Тахилын усны суурин, “Дүүдий тээгийн дүнгэндэг газар” гэдэг суурин, Дорнод аймгийн нутаг Хэрлэн голын хойт хөвөөнд буй Тогоон төмөр хааны байгуулсан Барс хот III зэргийг судалж, Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт буй IX-XII зууны үед холбогдох булшийг, 1967, 1968 онд Хэнтий аймгийн Батширээт (хуучин Хэнтий сум) сумын нутаг Төгсийн өвдөг, Хурхын гол, Жаргалантын голын сав газарт хорь гаруй булшийг малтан шинжилж тэдгээрийг Хятан нарын булш мөн гэдэг саналыг дэвшүүлжээ. Тэрээр 1952 онд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянцогт овоо, Төв аймгийн Мөнгөнморьт сумын Сүүжийн булаг зэрэг газруудад арваад дөрвөлжин булш малтан шинжилж, 1952-1957 онд Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг Гуа дов, Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Хүрэн дов, Эрдэнэ сумын Өндөр дов, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутаг Цэнхэрийн голын хэрэм, Чойбалсан аймгийн Цагаан овоо сумын Барс хот II (Баруун дөрөөгийн хэрэм), Булган аймгийн Бүрэгхангай сумын Шувуутайн голын хэрэм, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулгийн туурь зэрэг хүннүгийн үеийн суурингуудыг нэлээдийг нь малтан шинжилж үр дүнг удаа дараа нийтэлсэн байна. Х.Пэрлээгийн судалгааны гол ач холбогдол нь “Цэвэр нүүдэлчид” гэдэг хийсвэр онолд няцаалт өгч нүүдэлчдийн хот суурины асуудлыг бодит баримтанд тулгуурлан ул суурьтай авч үзсэнд оршино.

1954-1955 онд Ц.Доржсүрэн Ноён ууланд Хүннү нарын 20 орчим булш, дөрвөлжин булш хоёрыг малтсаны гадна Архангай аймгийн Хүнүй голын савд гурван зуу гаруй хүннү булш илрүүлэн олж 26-г нь малтан шинжилсэн бөгөөд 1956-1958 онд Архангай аймгийн нутагт мөн Улаанбаатар хотын орчим Хүрхрээгийн ам зэрэг газарт хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үеийн дурсгал нэлээдийг судалсны дотор 1956 онд Архангай аймгийн Их тамир сумын нутаг Алтан сандал уулын орчимд найман дөрвөлжин булш малтжээ.

Ц.Доржсүрэн 1955 онд Увс аймгийн нутаг Долоодойн хиргисүүр гэдэг газраас орхон-енисейн бичээстэй гэрэлт хөшөө, уйгар бичээстэй гэрэлт хөшөө, 1956 онд Архангай аймгийн Их Тамир сумын Бугат бригадын төвийн нутгаас YI зууны 80-аад онд холбогдох Түрэгийн анхны Хант улсын түүхийн чухал мэдээ агуулсан согд, санскрит бичигтэй том гэрэлт хөшөө бүхий дурсгалыг, 1957 онд Архангай аймгийн Тариат сумын нутаг Долоон мод гэдэг газраас орхон-енисейн бичээс бүхий гэрэлт хөшөөний оройн хэсгийг олж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ.

1956 онд Н.Сэр-Оджав Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай ууланд дөрвөлжин булш нэгийг малтсан бөгөөд 1957 онд Ц.Доржсүрэнгийн хамт Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт буй Түрэгийн мэргэн сайд Тоньюкукийн гэрэлт хөшөө, тахилын сүм бүхий цогцолбор дурсгалыг малтан шинжилж барилгын хэрэглэгдэхүүн, шавар, шаазан сав суулга, гоёл чимэглэлийн зүйлс болон барилгын хананд бичсэн Орхон бичээс, 1957-1958 онд Архангай аймгийн Өндөрсант (одоо Хотонт) сумын Цэнэгтийн ам, Баян-Өлгий аймгийн Уйгар сумын Хөх хөтлийн Тост өтгө зэрэг газраас ан амьтан, буга, ан агнуурыг харуулсан сонирхолтой зургууд олжээ.

1952 онд О.Намнандорж Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйд зосон зураг олж заримыг нийтлэн неолитын үед холбогдуулан үзсэн ба 1953 онд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутгаас Мөнх хааны орд хотын туурь болон түүнд зориулан босгосон гэрэлт хөшөөг нээж олсон юм. 1960-1966 онд А.П.Окладников, Н.Сэр-Оджав, Д.Дорж нарын зэрэг монгол зөвлөлтийн археологич эрдэмтдийн бүрэлдхүүнтэй Монголын чулуун зэвсгийг судлах анги манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан хайгуул судалгаа явуулж хуучин чулуун зэвсгийн дунд, дээд шат шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгал олон газраас олж илрүүлсэн юм. Жишээ нь, Алтайн нурууны Их-Богд, Гурван Сайхан, Арц Богд, Тамирын голын сав Тайхар чулуу, Баянхонгор аймгийн Орог нуур, Улаанбаатар хотын ойролцоох Сонгино уул, Буянт-Ухаагийн дэнж, Шар хадны дэнж, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Өмнөговь аймгийн Оцон мааньт зэрэг газраас палеолитын үеийн хэд хэдэн бууцыг илрүүлэн олжээ. Оцон Мааньтын чулуун зэвсгүүд нь дунд палеолитын үед холбогдох бөгөөд Европ, Өвөр Ази, Африкийн мөн үеийн дурсгалтай адилсаж буй нь эрдэм шинжилгээний хувьд сонирхолтой юм. Үүний зэрэгцээ 1960, 1961, 1964 онуудад Өвөрхангай аймгийн Хар хорины сангийн аж ахуйн нутаг Орхон голын хойт дэнжид буй Мойлтын амны 4 соёлт давхрага бүхий палеолитын үеийн сууринг малтан шинжилсэн бөгөөд энэ нь Төв, Умард, Дорнод Азийн хэмжээнд нэн ховор дурсгал болох нь тодорхой болсон юм.

1967-1989 оны хооронд манай орны нутаг дэвсгэрт Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици академич Ш.Нацагдорж, Д.Дорж А.П.Окладников, А.П.Деревянко нарын удирдлагын доор хэд хэдэн судалгааны ангийн бүрэлдэхүүнтэй ажиллаж, манай ард түмний эрт дундад үеийн түүх, археологи, угсаатны зүйн дурсгалыг эрэн сурвалжилах, судлах үйлст нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги болон хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дурсгал судлах анги 1970 оноос эхлэн монголын бараг бүх аймгийн нутгаар хайгуул судалгаа эрчимтэй явуулж чулуун зэвсгийн болоод хүрэл, төмөр зэвсгийн түрүү үе, Хүннү гүрэн, Түрэгийн хаант улс, Уйгар, Кидан, Монгол гүрний түүхэнд холбогдох бууц суурин, булш бунхан, буган

хөшөө, хүн чулуун хөшөө, гэрэлт хөшөө, хадны зураг, эртний бичээс зэрэг олон мянган дурсгалыг илрүүлэн олж шинжлэн судалжээ.

Тус экспедицийн бүрэлдхүүнд А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги тогтмол ажиллаж 1967-1969 онуудад Монголын дорнод хэсэг Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт палеолитын үеийн дурсгалаас гадна мезолит, неолитын хэдэн арван шинэ бууц, суурин илрүүлэн Чойбалсан хотын ойролцоох Овоот, Тамсагбулаг, Хэрлэнгийн урд эрэгт неолитын үеийн булш, сууцыг анх удаа малтан шинжилсэн билээ. Тус ангийн Монголын чулуун зэвсгийн талаар гүйцэтгэсэн томоохон ажлын нэг нь 1969 онд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Ярх уулын дэргэдээс доод палеолитын үед холбогдох гилбэр зэвсгийн соёлын дурсгал болох дархны газар нээсэн явдал юм.

1970-1973 онд Дундговь аймгийн Ёроол говь, Хулд сумын Цахиурт, зэрэг газраас доод палеолитын чулуун эдлэлүүд Өмнөговь аймгийн нутаг Зүүн, Баруун хайрхан уул орчимд мезолитын үеийн бууц зэргийг илрүүлэн олжээ.

1975, 1979 онд А.П.Окладников Д.Цэвээндорж нарын удирдсан анги Төв аймгийн Заамар сум, Сэлэнгэ, Дэлгэр мөрний сав, Толбо нуурын хөвөө, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Хонгиогийн голын сав, Манхан сумын Цэнхэрийн гол, Мөст сумын нутаг зэрэг олон газраас палеолит, неолитын чулуун зэвсэг, дархны газрыг олж илрүүлсэн байна.

1982 онд Р.С.Васильевский, Д.Цэвээндорж нарын удирдсан анги Туул, Орхон, Урд Тамир, Хойд Тамир, Дэлгэр мөрний хөндий, Сэлэнгэ мөрний савыг хамарсан өргөн хайгуул хийж палеолит, неолитын арвин баялаг хэрэглэгдэхүүнийг олж цуглуулсан юм.

Мөн МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах Д.Цэвээндорж, Д.Наваан, В.в.волков нарын удирдсан анги 1971 онд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тэмээн чулууны аманд хэд хэдэн дөрвөлжин булш, 1976 онд Архангай аймгийн Их Тамир сумын Шивэртын аманд 4 дөрвөлжин булш малтан шинжилжээ. 1976-1983 онд Хэнтий аймгийн Мөрөн сумын Чандган тал, Буянт сумын Буянтын чулуу, Дорноговь аймгийн Алтанширээ сумын төвийн орчим, Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Хан хад, Архангай аймгийн Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын нутаг Хөшөөн тал, Тариат сумын Алтанцэцэг, Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай уул, Зүйл сумын Наран толгой, Булган аймгийн Бүрэгхангай сумын Зараа толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын Бурхантайн гацаа зэрэг газарт 50 орчим дөрвөлжин булш малтан шинжилж, сувс, оюу зүүлт, алтан ээмэг, шавар савны хагархай, ясан эдлэл, малын яс зэрэг шинжилгээний нэлээд хэрэглэгдэхүүн олсноос гадна 1976-1977, 1980 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хөшөөн талд Түрэгийн үеийн мэлхий чулуу бүхий дурсгал, 1980-1982, 1984 онуудад Сэлэнгэ аймгийн Хонгорийн сангийн аж ахуй нутаг Буурал уулын энгэрт монголын үеийн 20 орчим булш малтжээ.

МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах анги, Түүхийн хүрээлэнгийн нүүдэлчдийн дурсгал судлах анги хамтран 1972-1974, 1981-1982 онуудад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулнаа Монголын төмөр зэвсгийн түрүү үед буюу МЭӨ YII-III зуунд холбогдох 50 гаруй булшийг малтан шинжилсэн юм. Чандмань уулнаа малтсан шороон далантай дүнзэн бунхант булш, приамид хэлбэрийн далантай булш, чулуун далантай авсгүй булш, чулуун хайрцган австай булш үндсэн дөрвөн төрлийн булш нь урьд манай улсын нутгаас олдож байгаагүй булшны шинэ хэлбэр төрх бөгөөд эндээс хөдөлмөрийн багаж, зэр зэвсэг, гоёл чимэглэлийн холбогдолтой олон зуун эд өлгийн дурсгал илрүүлэн олсон нь монгол нутагт төмөр зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрсэн он цагийг тодотгоод зогсохгүй, тэр үеийн аж ахуй, нийгмийн байгууламж, оюуны соёлыг судлахад чухал ач холбогдолтой юм.

МЗТСХЭ-ийн Х.Пэрлээгийн удирдсан хот суурин судлалын анги 1970 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Хар Бухын балгаснаас хэдэн арван нэр төрлийн үйсэн дээр бичсэн номуудыг нээж олсон юм. Эдгээр номуудын дотор урьд өмнө шинжлэх ухаанд мэдэгдээгүй ховор нандин номууд ч нэлээд байв. Тухайлбал ХҮI-ХҮII зуунд Халхын дөрвөн хошуу, зургаан хошуу, долоон хошуудын ноёдын 18 удаагийн чуулганаар хэлэлцэн тогтсон 18 цаазын хураамж хуулга байв. Х.Пэрлээ эдгээр түүх соёл, эрхийн ховор дурсгал судлан боловсруулж нийтэлсэн нь түүнд төрийн соёрхолыг нэхэн олгосон гол бүтээлүүдийнх нь нэг билээ.

1979 онд МЗТСХЭ-ийн палеолитын анги Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгой, Хойт үзүүр хөх хад, Эрдэнэбүрэн сумын Алаг чулуу, Ихэр Хөшөөт, Баянхогор аймгийн Жаргалант сумын Бугат, Говь-Алтай аймгийн Тонхил сумын Хуудасны орой зэрэг газраас хадны зураг илрүүлэн олж судалсан бөгөөд эдгээрээс палеолитын үед холбогдох Ишгэн толгойн зургууд, хоёр үхэрт хөллөсөн анжисаар газар хагалж буй Алаг чулууны зураг зэрэг шинжилгээний чухал ач холбогдол бүхий дурсгал нилээдийг илрүүлэн олж судалжээ.

1983-1989 оны хооронд А.П.Деревянко, Д.Дорж нарын удирдсан анги Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай Баянхонгор аймгийн нутгаар хайгуул хийж Сагсай голын хөндий, Хар ус нуур, Олон нуурын сав, Ховд гол, Хойд, Дунд, Урд Гурван Цэнхэрийн голын сав Манхан сумын орчим, Хулман нуур, Бууцагаан сумын орчим, Түй, Байдраг, Нарийн голын хөндий, Их нууруудын хотгор, Таацын голын сав зэрэг нийт 300 гаруй газраас олон мянган чулуун зэвсэг олж цуглуулж тэдгээрийн хэлбэр төрх, хийсэн арга барилыг судалж он цагийг нь тогтоож хэд хэдэн ном, олон арван товхимол зэрэг бүтээлүүд нийтэлжээ.

1995-2001 онд А.П.Деревянко Д.Цэвээндорж Ж. Олсен нарын удирдсан Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги Баянхонгор аймгийн Цагаан агуй, Чихэн агуйд палеолит, мезолитын соёлт давхрага бүхий палеолитын суурингуудыг судалж хамраах он цагийг нь геологи, палеоботаник, радиокарбоны аргаар тогтоох ажлыг Орос, АНУ-ын лабораториудад тэдгээр орны эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэж буй нь Монголын чулуун зэвсгийн судалгаанд нэвтэрч буй шинэ зүйл бөгөөд мөн малтлага шинжилгээний ажлыг хийжээ. Мөн Алтайн өвөр говиор хайгуул хийж олон тооны хуучин ба шинэ чулуун зэвсгийн сууринг илэрүүлж олж судалсан юм. Эдгээр дурсгалуудын дотроос Өвөрхангай, Өмнөговь аймгийн зааг нутагт орших Цахиуртын хөндийн суурин эрдэм шинжилгээний хувьд онцгой ач холбогдолтой бөгөөд дэлхийд ховорхон тохиолддог дурсгал юм. Тус суурин нь 25 хавтгай дөрвөлжин км талбайг эзлэх ажээ. Эдгээр судалгааны үр дүнд 3 боть тайлан бичиж орос, монгол, англи хэлээр нийтэлсний гадна хэд хэдэн нэгэн сэдэвт зохиол, олон тооны өгүүлүүд нийтэлжээ.

1960-аад оны эхэн үеэс Монгол-Унгарын хамтарсан археологийн шинжилгээний анги ажиллаж 1961 онд Н.Сэр-Оджав Т.Хороват нар Улаанбаатар хотын ойролцоох Сэлбийн голын хөндийд буй хүннүгийн үеийн 11 булшнаас хоёрыг, 1962 онд Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт дөрвөлжин булш, Хараагийн Ноён уулын Хужиртын аманд Ц.Доржсүрэн, И.Эрдели нар хоёр булш, 1963, 1964 онд И.Эрдели, Д.Наваан нар Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүнүй голын Наймаа толгой гэдэг газар буй хүннүгийн булшнаас дөрвийг, Д.Цэвээндорж, И.Эрдели нар Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Хүнүй голын Найман толгойд буй хүннүгийн 26 булшнаас 1974 онд 5-ыг, 1987 онд 11-ыг, Д.Цэвээндорж, В.Волков нар 1975 онд Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг Нүхтийн аманд буй 100 булшнаас 3-ыг, Д.Наваан И. Эрдели нар Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга ууланд буй 142 булшнаас 1969 онд цөөн хэдийг, Д.Цэвээндорж И.Эрдели нар 1988 онд таван булш, 1987 онд Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Худгийн толгойд 2, Солби ууланд 2, Эрдэнэмандал сумын нутаг Наймаа толгойд 11-ийг хүннү булш малтаж судалсан бөгөөд 1988 онд Төв аймгийн Баян сумын Зараа толгойд 17 булш илрүүлж 5-ыг, 1989 онд Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан Хүннүгийн дурсгал судлах ангийхан Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойд 2, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд 1, Өвөрхангай аймгийн Зүйл сумын Тарвагатай, Хужирт сумын Хүүшийн хөтөлд нэжгээд хүннү булшийг, Д.Цэвээндорж, И.Эрдели, П.Б.Коновалов нар 1988 онд Дорноговь аймгийн Их хэт сумын Хөшөөнө ухаа гэдэг газар дундад зууны үеийн хүний оршуулга, мөн XIII зууны үеийн тахилын сүмийн орыг тус тус малтан шинжилж, Төв аймгийн Бороогийн хүннү сууринд туршилтын малтлага хийсэн байна. Дээрхи судалгааны явцад олдсон олон төрлийн эд өлгийн дотор Морин толгойн булшнаас олдсон хүннүгийн хөгжмийн зэмсэг болох хэл хуур онцгой ач холбогдолтой юм. Энэхүү хэл хуур нь одоогоор мэдэгдэж буй энэ төрлийн хөгжмийн зэмсгийн хамгийн эртнийхэд тооцогдож байна.

Түрэгийн дурсгалыг дагнан шинжлэх ажлыг дээр дурьдсан Орос ба Зөвлөлтийн судлаачидаас гадна Н.Сэр-Оджав 1957 оноос дангаараа буюу Чехословакийн эрдэмтэн нартай хамтран явуулсан юм.

1958 онд Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамд буй Түрэгийн хун тайж Культегиний гэрэлт хөшөө, тахилын сүм бүхий цогцолбор дурсгалыг Монгол-Чехословакийн хамтарсан археологийн шинжилгээний анги малтан шинжилж арвин их барилгын хэрэглэгдэхүүн, сав суулга, төмөрлөг эдлэл, чулуун сийлбэр зэрэг дурсгалууд олсны дотор Культегиний чулуун толгой зэрэг эрдэм шинжилгээний чухал ач холбогдол бүхий зүйлс байсан ажээ.

МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги 1973-1978 онд М.Шинэхүү, С.Г.Кляшторный нарын удирдлагаар Монгол нутаг дахь орхон бичгийн дурсгалыг судлах талаар өргөн хэмжээний хайгуул судалгаа хийжээ.

Түүхийн хүрээлэнгээс 1981-1983 онд Дорнод Монголын хүн чулууг судлах тусгай шинжилгээний ангийг Д.Баярын удирдлагаар зохион явуулж, урьд судлаачидын мэдэж тэмдгэлсэн 40-өөд хүн чулуунаас гадна 30 орчим хүн чулууг шинээр илрүүлэн олсон байна. Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн нутгаас олдсон эдгээр хүн чулуудын нэлээд нь исэр (сандал) дээр суусан ба Монгол Дундад Азид өргөн тархсан Түрэгийн үеийн хүн чулуунаас өвөрмөц үр хийцтэй бөгөөд тэдгээрийн малгай, дээл, бүс, гутал, хавтага сэтгүүр,эрхи болон гээг үс зэрэг бүхий л талыг Д.Баяр нарийн судалж XIII-XIV зууны үеийн монголчуудын дурсгал болохыг тогтоож судалгааны үр дүнг хэд хэдэн өгүүлэл болгон нийтэлсний гадна ганц сэдэвт зохиол бичиж Солонгос болон монгол хэлээр нийтэлжээ.

Д.Цэвээндорж 1981 онд Увс аймгийн Их сар, Тэрэм хад, Гурван толгой, Үнхэлцэг, Төмөр Цорго, Эхэн Хүзүүвч, Хад үзүүр, Бужаа, Можоо, Хөвсгөл аймгийн Цахир, Харгантын ам, 1982 онд Увс аймгийн Шовгор хад, Тушаат, Хамуут, Хар хөндийн наран, Гурван толгой, Нарийн дэл, Хоо үзүүр, Тэрэм хад, Хар нарт, Цагаан Өтөг, Бургалтайн зурагт хад, Тэхийн хөтөл, Хэрэгтийн ам, Мөнгөт цахир, Хар цагаан ус, Хөвсгөл аймгийн Хүнх Цахир, 1983 онд Завхан аймгийн Улаан овоо, Талын ухаагийн ац, Дүнгээн уул, Түвд уул, Булган аймгийн Өвгөнт, Үүдэнт, Шовгор зараа, Хөтөл өтгө зэрэг газраас олон зуун хадны зургийг шинээр илрүүлэн олсон юм.

Тэрбээр 1989 онд Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний анги тус аймгийн Хүрэн хадны үзүүр, Хөх толгой, Үлдэнтийн орой, Тогтохын шил, Шар булаг, Хар дэлийн үзүүр,

Модот хар хяр, Яшуур, Гулзат, Хар үзүүр, Далиугана, Баядсай зэрэг газраас хаданд сийлсэн олон тооны зургийг илрүүлэн олсон юм.

1990-1994 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хээрийн шинжилгээний анги Д.Цэвээндорж, Ш.Като нарын удирдлагаар Гурван голын савд 4000 орчим, Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баянадрага зэрэг сумдын нутгаас нийт 310 газраас түүхийн өөр өөр үед холбогдох 2300 орчим булш, дурсгал илрүүлэн олж бүртгэн газрын зурагт тэмдэглэсэн ба судалгааны үр дүнг хоёр боть ном болгон нийтэлжээ.

1994-2001 онд Д.Цэвээндорж, Э.Якобсон, Д.Кубарев нарын удирдсан Монгол-Америк-Оросын хамтарсан “Алтай” төслийн судалгааны явцад Монгол Алтайн нурууны эхэн нутаг Хар ямаа, Цагаан салаа, Бага ойгор, Хар ус, Цагаан ус, Харуул толгой, Хатуу зэрэг газраас олон тооны хадны зургийг илрүүлж олоод судалж байна. Эдгээр шинэ дурсгалууд зөвхөн зургийн тооны хувьд төдийгүй агуулгын хувьд Монгол төдийгүй нийт Азийн хадны зургийн дунд томоохон байрыг эзлэх ач холбогдолтой ажээ.

1994-2000 онд Монгол, Францын хамтарсан археологийн экспедиц Г.Жискар, Д.Эрдэнэбаатар нарын удирдлагаар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын савд ажиллан хүрэл, хүннү, монголын үеийн олон тооны булшийг малтан шинжилжээ. Тус экспедицийн чулуун зэвсгийн судалгааны анги Б.Цогтбаатар, Ж.Жабер нарын удирдлагаар 1996-1997 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын ам, 1998-2001 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын Их Дөрөлжид малтлага хийж олон тооны чулуун зэвсгийн зүйлс олж илрүүлжээ.

Монгол, Солонгосын хамтарсан Дорнод Монгол төслийн хүрээнд А.Очир, Д.Цэвээндорж, Д.Баяр, Сон Покее нарын зэрэг археологчид 1993 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Устын амны адагт дөрвөлжин булш малтаж, Хэрлэн голын зүүн дэнжээс шинэ чулуун зэвсгийн үеийн чулуун зэвсгүүд олж түүвэрлэснээс гадна модон царил болон загасны торны хүндрүүлэгчийн үүргээр ашиглаж байсан дугуй чулуун эдлэл олсон нь эрдэм шинжилгээний хувьд онц сонирхолтой олдвор байсан байна. Тус экспедиц 1994, 1996 онд Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутаг дахь Сантын эртний хотын турь, Сүхбаатар аймгийн Дариганга сумын нутаг дахь Гуулин улсын хотын үлдэгдлүүдэд малтлага судалгаа хийж, Наран, Онгон сумдын нутагт буй Хөрөгт, Шивээт, Таван толгойн хүн чулууг нягтлан үзэж харьцуулсан судалгаа хийсний үр дүнг 5 боть ном болгон нийтэлжээ.

Монгол, Америкийн хамтарсан “Эгийн гол” судалгааны анги 1994 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын савд судалгаа хийж хүрэл зэвсэг болон хүннүгийн үед холбогдох 10 гаруй булш малтан шинжилжээ.

1995 онд Монгол-Солонгосын хамтарсан хадны зураг судлах анги Д.Цэвээндорж, Ж.Б.Ким нарын удирдлагаар Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын нутаг Их Дөрөлж, Паалуу зэрэг газраас хадны зургийн томоохон дурсгалуудыг олж судалжээ.

1996-2000 онд Монгол-Америкийн хамтарсан “Умард Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги Ч.Амартүвшин, У.Эрдэнэбат, Б.Ханичарж нарын удирдлагаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутаг Бичэгтэй эрүү, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын савын Баянгол, Бурхан толгой, Дархан уул, Хайлантайн гол, Мухдагийн ам, Хужир нуга, Хун толгой зэрэг газруудад археологийн нарийвчилсан хайгуул хийж, хүннүгийн үеийн суурин илрүүлж, хүрэл болон хүннү, монголын үеийн олон тооны булш малтан шинжилжээ.

1995-1996 онд Монгол-Японы хамтарсан Хархорин төслийн хээрийн шинжилгээний анги Д.Цэвээндорж, Ш.Като нарын удирдлагаар Монгол гүрний эртний нийслэл Хархорины үлдэцэд хайгуул судалгаа хийж хотын нарийвчилсан зураг үйлдсэн байна.

1997-2001 онд Монгол Солонгосын хамтарсан Монсол төслийн хээрийн шинжилгээний анги Д.Цэвээндорж, Сон Юүн нарын удирдлагаар Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн гол, Хурхын гол, Төв аймгийн мөнгөнморьт сумын нутаг Их хөтөл, Хустын булаг, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Морин толгой, Архангай аймгийн Батцэнгэл сумын Худгийн толгой зэрэг газруудад ажиллаж чулуун зэвсгийн суурин илрүүлэн, хүрэл, хүннү, монголын үеийн булуудыг малтан судалж, үр дүнг 2 боть ном болгон нийтэлжээ.

1998, 1999 онд Монгол, Японы хамтарсан хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дурсгал судлах анги Завхан, Архангай, Өвөрхангай, Булган аймгийн нутгаар хайгуул судалгаа хийж Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушгийн өвөрт нэг хиргисүүрийг тахилгын байгууламжийн хамт малтан судлаж, энд байх буган чулуун хөшөөдийн хэвийг хуулан авсан байна.

1999-2001 онд Монгол, Германы хамтарсан Хархорумын экспедици Д.Баяр, Гутелл, Ротт нарын удирдлагаар Хархорумын үлдэгдэлд геодизи, геохронологийн судалгаа, малтлагын ажлыг гүйцэтгэсэн байна.

1999 онд Монгол, Америкийн хамтарсан археологийн анги Д.Цэвээндорж, Ж.Дэвис-Кэмбел, Я.Цэрэндагва нарын удирдлагаар Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших Байрамын даваанд орших нэгэн хиргисүүрийг малтан судалжээ.

1996-2001 онд Монгол-Туркийн хамтарсан шинжилгээний анги Архангай аймгийн Хашаат сумын нутагт Түрэгийн Билгэ хааны цогцолбор дурсгалыг малтан шинжлэх ажлыг хийж байна.

1996-1998 онд Монгол-Японы хамтарсан бичээс судлалын анги А.Очир, Т.Мориясу нарын удирдлагаар Монгол нутагт буй зарим монгол, орхон-енисей, түвд зэрэг бичээсүүдийг нарийвчлан судлах ажлыг гүйцэтгэж, тусгай тайлан нийтэлжээ.

2001 онд Монгол-Японы хамтарсан археологийн анги “Шинэ зуун” төслийн хүрээнд Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар, Ш.Като, Н.Ширайши нарын удирдлагаар Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Чингис хааны анхны нийслэл Аварга ордонд малтлагын ажлыг эхлэн явуулж байна. 2001 онд Монгол-Бельгийн хамтарсан археологийн экспедици Д.Цэвээндорж, Б.Гүнчинсүрэн, Я.Цэрэндагва, Ф.Смоларский, В.Ситливый нарын удирдлагаар Булган аймгийн Дашинчилэн сумын харбухын гол, Буурлын өвөлжөө, Бүрэгхангай сумын Өвгөнт зэрэг газруудад хиргисүүр, хүннүгийн үеийн жирийн иргэдийн булш малтан шинжилсэн байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

- Амстердамская Л.А. Отчет о поездке в Кэнтейсий аймак.- Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. ¹ 27/453.
- Баяр Д. Гурван Мандалын хадны зураг // SA. t.XVI. f.7. УБ., 1996. тал 89-102.
- Бамбаев Б.Б. Отчет об археологической поездке в 1927 году. Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.
- Боровка Г.И. Археологические обследование среднего течения р. Толы. Северная Монголия. 1927. с.50-51. 79-84.
- Букинич Д.Д. Общий отчет по археологическим работам 1933-1934г. Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.
- Владимирцов Б.Я. Отчет. Түхийн хүрээлэн гар бичмэлийн сан. ¹ 110.
- Волков В.В. Доржсүрэн Ц. Ховд аймгийн Манхан сумын нутагт эртний судлалын малтлага хайгуул хийсэн тухай // SA. t.II. f. 5. УБ., 1963. -Тал 51-68.
- Вяткина К.Н. Археологические памятники МНР. СА. ¹ 1,1960,
- Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. УБ.1978
- Дорж Д. Неолит Восточной Монголии . УБ.,1971
- Дорж Д. Каменный век Монголии. Новосибирск. 1990.
- Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг. АС. т.П. УБ., 1963. тал 9-15.
- Дорж Д. Э.А.Новгородова. Петроглифы Монголии. УБ., 1975. ч.П. с.6.
- Доржсүрэн Ц. 1955 онд Төв баруун аймгуудад археологийн шинжилгээ хайгуулын ажил явуулсан тухай. ЭШБ. ¹2. УБ., 1957. тал 108.
- Деревянко А.П., Дорж Д., Васильевский Р.С., Ларичев В.Е., Петрин В.Т., Девяткин Е.В., Малаева Е.М. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск., 1990.
- Казакевич В.А. Поездке в Дариганги, Каменные статуи Дариганги. М.,1927
- Казакевич В.А. Некоторые вопросы истории Монголии в свете археологи.``Современная Монголии``1-34 ¹ 4
- Киселев С.В. Монголия в древности ``Известия АН СССР``Серия истории и философии. 1947,т,IY,¹ 4.
- Киселев С.В. Древние города Монголии. СА.1957,¹ 2.
- Козлов П.К. Северная Монголия. Нойн-улинские памятники.
- Намнандорж О. Орон нутгийг судлах экспедицийн замын тэмдэглэлээс // ШУ. 1953. ¹1. тал 51-55.
- Намнандорж О. 1953 оны экспедицийн замын тэмдэглэлээс. ШУТ. 1954. ¹1. тал 81.
- Окладников А.П. Петроглифы Чулутын-гола /Монголия/ Наука, Новосибирск. 1981. с 182.
- Окладников А.П. Палеолит Центральная Азии. Новосибирск., 1981.
- Ренчин Б. Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл. СМ. Т.XVI, Ф,1, УБ.,1968.
- Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. УБ.1976.
- Симуков А.Д. Отчет по раскопам двух Курганов в падях Зурумте и Суджигте // Түүхийн хүрээлэнгийн бичмэлийн сан. ¹ 27 /453.
- Сэр-Оджав Н. Монголын Төв, Умарт хэсгийг археологийн талаар судалсан нь // SA. t.IV. f. 1-7. УБ., 1965.- тал 59-62.
- Сэр-Оджав Н. Монголын археологичид 1968 онд // ШУАМ. УБ., 1969 ¹ 2. тал 54-64.
- Сэр-Оджав Н. Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалыг судалсан нь. SH. t. VIII. УБ., 1970. -тал 17-26.
- Сэр-Оджав Н. Баянлигийн хадны зураг. УБ. 1987.
- Труды Орхонской экспедиции: Атлас древностей Монголии. вып. 1. СПб.
- Цэвээн Ж. Монголын Эртний судлалын асуудал // Шинэ толь 1936.
- Цэвээндорж Д. Чандманийн соёл. SA. t.IX.f.4. УБ., 1980. -тал 34-200
- Цэвээндорж Д. Петроглифы Цахира // SA. t. XVIII, f.6. УБ., 1998. - тал 56-87.
- Цэвээндорж Д. Хад үзүүрийн зураг. SA. t. XV. f.1. УБ. 1995. -тал 3-16.
- Цэвээндорж Д. Хар цагаан усны хадны зураг. Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ-4. Сөүл, 1996. - тал 305-312.
- Цэвээндорж Д., Баяр Д. ба бусад. Монголын нутаг дахь түүх-соёлын дурсгал. УБ., 1999.

D.Tseveendorj E.Jacobson and V.V.Kubarev. Report on Archaeological and Art Historical Research in Bayan-Olgı and Ubs aimags Mongolia August- September 1994. pp. 56. ТХГБС.
D.Tseveendorj E.Jacobson and V.V.Kubarev. Report on Archaeological and Art Historical Research in Bayan-Olgı aimag Mongolia August-September 1995. pp. 23. Foto 21. 86. 1996.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕ

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Энэ үеийн хүмүүс хөдөлмөрийн багаж зэвсгээ гол төлөв чулуугаар хийж байсан учраас ийнхүү чулуун зэвсгийн үе хэмээн нэрлэдэг.

Чулуун зэвсгийн үе нь палеолит (хуучин), мезолит (дунд), неолит (шинэ) хэмээх гурван үед хуваагдана. Түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүс чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, амьд байгальтай харьцаа, байгалийн хатуу ширүүнд дасан зохицох, шинэ газар нутгийг эзэмших зэрэгт томоохон өөрчлөлт дэвшилт гаргасаар иржээ. Чухамхүү энэ үед л хүний эрт үеийн өвөг бүрэлдэн бий болж, хөгжиж, орчин үеийн арьстнууд үүсэн, дэлхийн бөмбөрцөгийн өнцөг булан бүрийн байгал цаг уурын таатай нөхцөл бүхий газар нутгийг эзэмших үйл явц явагджээ. Чухам чулуун зэвсгийн үеийн хүмүүс галыг гарган авч, зөв хэрэглэн сурч, хувцас зохион бүтээн, оромж сууц барих дадал зуршлыг эзэмшин, нум сумыг зохион бүтээж, ан агнуурын олон төрлийн зэвсэг багажийг хийж ашигладаг болсон байна.

Чулуун зэвсгийн үеийн төгсгөлд хүн төрөлхтөн үйлдвэрлэлийн аргын хувьд хувьсгал хийж мал аж ахуй, газар тариаланг эрхлэх болжээ.

Чулуун зэвсгийн үе бол хүн төрөлхтний түүхийн үндсэн суурь нь учраас тэр үеийн түүхийн судалгаагүйгээр орчин үеийн соёл иргэншил, түүхийг төсөөлөхийн аргагүй.

ПАЛЕОЛИТ

Палеолит гэдэг нь эртний грекийн “палайос”- хуучин, “литос”- чулуу гэсэн үгнээс гаралтай. 1836 онд Данийн эртний эд өлгийн зүйлийн музейн ажилтан К.Ю.Томсен музейн олдворуудаа чулуу, хүрэл, төмөр зэвсгийн үе гэсэн гурван хэсэгт хуваасан нь хүн төрөлхтний түүхийг гурвалсан системээр хуваасан анхны эхлэл байсан төдийгүй археологийг шинжлэх ухаан болон хөгжих эхлэлийг тавьсан. Харин 1865 онд Английн судлаач Ж.Леббок палеолит гэдэг нэр томъёог анх шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ. Францын археологич Буше де Перт (1788-1868) XIX зууны тэргүүн хагаст Европын хэд хэдэн агуйд хийсэн малтлагын дүнд чулуун зэвсгийн хамт олон тооны араатан амьтны яс олдсоныг нарийвчлан судлаж эдгээр хоёр төрлийн олдворууд нь хоорондоо нарийн холбоотой болох тухай санал дэвшүүлэн тавьсан нь тухайн үеийн шинжлэх ухаанд дуулиан болж, чулуун зэвсгийн дурсгалт газруудыг хайж илрүүлэх, малтлага хийх ажилд том түлхэц болж өгчээ. Чулуун зэвсгийн судалгааны эцэг хэмээн нэрлэгддэг Францын археологич Габриэль де Мортилье (1821-1898) чулуун зэвсгүүд нь хэлбэр, хийцийн хувьд харилцан адилгүй байгааг анхааран, хоорондоо адил төсгүй зэвсгүүдийг олдсон газар нутгийнх нь нэрээр нэрлэж эхэлжээ. Ийнхүү хамгийн болхи хийцтэй эдлэлүүдийг Францын Парис хотын ойролцоох Шелль хэмээх жижиг хотын нэрээр шеллийн гэж нэрлэх болсноор энэ нь хуучин чулуун зэвсгийн доод шатны дурсгалуудыг нийтэд нь нэрлэх нэр болон хувирчээ. Дараагийн үеүүдийг Амьен хотын дүүрэг Сент-Ашелийн нэрээр Ашель, Ля мустье гэдэг газрын нэрээр Мустье хэмээн нэрлэсэн байна. Тэрээр палеолитын төгсгөлийн шатыг ориньяк, солютре гэсэн 2 үед хуваажээ. Палеолитын эдгээр үечлэл дээр А. Брейль мэдлэн хэмээх нэгэн шатыг нэмснээр хуучин чулуун зэвсгийн үеийг ангилах европын сонгодог ангилал бий болжээ. Энэ үечлэл нь нэгэн үе зөвхөн Францын төдийгүй Баруун Европын дурсгалуудад тохирч байсан боловч палеолитын судалгааны хөгжилтийн явцад Европ, Ази, Америкийн зарим бүс нутгийн хуучин чулуун зэвсгийн ангилал, үечлэлд тохирохгүй болсон тул палеолитын төгсгөлийн гурван үеийг багтаан дээд палеолитын үе гэж нэрлэж, ерөнхийд нь палеолитыг доод, дунд, дээд гэсэн гурван том үед хуваан авч үзэх болсон.

Палеолитын үечлэл

Палеолитын үе	Францын сонгодог үечлэл	Дэлхий нийтэд баримталж буй үечлэл	Он цаг (мян. жилээр)
Доод		Олдувай	2 500-2 600
	Шелль Ашель	Ашель Эртний Дундад Хожуу	I 500-1 500 I
Дунд	Мустье	Мустье	80-100
Дээд	Ориньяк Солютре Мадлен		35-40 I 10-12

§1. ДООД ПАЛЕОЛИТ

Доод палеолитын үед эртний хүмүүс тодорхой хэлбэр дүртэй хөдөлмөрийн багаж зэвсгийг хийж сурснаас хайрган зэвсэг, гилбэр мэсийг голчлон үйлддэг байжээ. Хайрган зэвсгийн гол төлөөлөгч нь чоппер, чоппинг юм. Хайрган хугадас зэвсэг буюу чоппер, чоппингийг зөвхөн ирэн хэсгийг нь хагалж бэлтгээд бусад хэсгийг нь хагалалж засалгүй үлдээдэг байв. Чопперыг хийхдээ зөвхөн нэг талаас хагалж хурц ирмэг ир гарган хийдэг байсан бол чоппингыг хоёр хажуугаас нь хагалж хийдэг байжээ.

Доод палеолитын ашелийн үеийг бүрэн толорхойлж чадахуйц зэвсэг нь гилбэр зэвсэг юм. Гилбэр зэвсгийг том хайрга, баргил залтсаар голчлон хийдэг байжээ. Энэ зэвсэг нь гонзгой хэлбэртэй, ирэн талыг нь шовх үзүүрлэн засаж эсрэг талыг нь хүний гарт багтахаар засаж бэлтгэсэн зэвсэг юм. Гилбэр зэвсэг олон төрлийн зориулалттай байв. Тухайлбал, энэ зэвсгээр цохих, хэрчих, яс бутлах, газар ухах, модон жад, гадас мэт багажийг шовхолж үзүүрлэх зэрэг олон төрлийн ажлыг хийж болдог байна.

Үндсэндээ доод палеолитын дээр дурдсан чулуун зэвсэг хийх (үйлдвэрлэх) хоёр арга нь палеолитын дараачийн үеийн чулуун зэвсэг хийх арга барилын үндэс болжээ.

Доод палеолитын хүмүүс чулуун зэвсгийг хийхдээ гол төлөв чулууг чулуугаар нь цохиж хагалах аргыг өргөн ашиглаж байжээ. Зэвсэг хийхдээ голын усанд мөлийж элэгдсэн гонзгой хэлбэрийн хайрга чулууг сонгодог байсан байна. Энэ хайрга чулууг гонзгой уртавтар цохиур чулуугаар цохиж хагалж шаардлагатай зэвсгээ хийдэг байжээ. Ингэхдээ хайрган чулууныхаа хамгийн нарийн талаас нь эхлэн цохиж хагалдаг байв. Эхний энэ хагалалт нь дараа дараагийн цуулалт хагалалтын эхлэл болдог байв. Гол төлөв хоёр талаас нь ээлжлэн цохиж, хагалж цуулдаг байсан учир хоёр талт буюу бифас хэмээн нэрлэгдсэн зэвсэг өргөн дэлгэрсэн. Эртний хүмүүс дээрхи аргаар өөрт хэрэгтэй хэлбэр дүрс, хэмжээ, зориулалт бүхий зэвсгээ хийдэг байжээ.

Доод палеолитын үед болхи хийцтэй цоолтуур, үзүүр мэс, хянгар, шүдлэг-хүнхэр иртэй зэвсгүүд ч тааралддаг. Тухайн үеийн зэвсгийн хэлбэр нь хайрган чулууны хэмжээнээс бус ямар үйлд зориулагдснаас нь шалтгаалж байжээ. Бүтэн хайрга төдийгүй, хагархайнуудыг нь ч засаж янзлан хөдөлмөрийн багаж зэвсэг болгон ашиглаж байжээ.

Чулууг засаж хөдөлмөрийн багаж зэвсэг хийх арга ажиллагаанд доод палеолитын төгсгөл үед тодорхой дэвшилтэт өөрчлөлт гарчээ. Энэ үед үлдэц чулуунаас тэгш зууван хэлбэрийн, уртавтар ялтас цуулж авах арга өргөн дэлгэрсэн байна. Ялтас цуулж авах энэхүү шинэ аргыг Францын Парис хотын ойролцоох энэ төрлийн зэвсэг анх олдсон газрын нэрээр леваллуагийн хэмээн нэрлэджээ. Үлдэцнээс цуулж авсан энэ ялтсыг дахин ирлэх засаж янзлах замаар үзүүр мэс, хянгар, цоолтуур зэрэг зэвсэг хийдэг болжээ. Ашелийн сүүл үед мөн чулууг холтчин түүнээс гарсан жижиг хэсгүүдээр зэвсэг хийх клетоны хэмээх арга бас өргөн дэлгэрсэн байна.

Доод палеолитын үеийн хүмүүсийн үлдээсэн чулуун зэвсгийн зүйлс манай орны нутгаас элбэг олддог.

Монгол орны палеолитын үеийн хамгийн эртний үед холбогдох олдворууд бүхий бууц суурин Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, Жаргалант сумын Байдрагын гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Хан Богд сумын Оцон Мааньт, Өвөрхангай аймгийн Гучин ус (Гучин ус-4), Ховд аймгийн Манхан сум (Манхан-4), Хойт Цэнхэрийн гол (Хойт Цэнхэрийн гол-2), Баян-Өлгий Аймгийн Алтанцөгц, Олон нуур (Олон нуур-2), Алтай сумын Баралгийн гол, Үенчийн голын сав, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул, мөн аймгийн Хулд сумын төвийн дэргэд, Дэлгэрцогт сумын Ёроол говь, Дорноговь аймгийн Сайншандын орчим зэрэг олон газраас олджээ. Дээрхи бууц суурин дархны газруудаас хайрга, зануу, болоржин болон хасын хольцтой шар, хар, цайвар цахиурлаг чулуунаас цуулсан залтас, гурван талт хажуугийн цуулдас, ялтсан хянгар, нэг чулууг нөгөөгөөр цохиж залтас авч байсан үлдэц чулуу, голын хайрган чулууг хөндлөн хагалж хийсэн хугадас зэвсэг, гурвалжин хэлбэрийн гилбэр мэс, хоёр талаас нь зассан үзүүр мэс зэрэг тэр үеийн хүний ахуй амьдралдаа өдөр тутам хэрэглэж байсан чулуун багаж зэвсэг олдсон байна. Доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь хугадас, гилбэр ба мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг ашиглаж байжээ.

Дөрөвдөгч галавын үед хэдийгээр дэлхий нийтээр мөстлөг эхлэж хүйтэрч байсан боловч манай орны, ялангуяа төв, өмнөд, дорнод хэсэг одоогийнхоос харьцангуй их чийглэг, урин дулаан уур амьсгалтай, хаяагүй их бороо орж, олон гол горхи, нуур цөөрөм, өвс ургамал ихтэй тал ба ойт тал байсан бөгөөд байгалийн ийм таатай нөхцөлд амьдарч байсан арслан заан, савгат хирс, зэрлэг үхэр, адуу, буга, тэмээ, янгир зэрэг амьтдыг хүмүүс олуулаа хүч хавсран өндөр эрэг, уулын хавцал, жалга, ганга юмуу тусгай ухсан нүх, намаг зэрэгт шахан унагаах аргаар агнадаг байжээ.

Том амьтдаас гадна нуур, ус, хээр талын жижиг амьтдыг мөн хүнс тэжээлдээ хэрэглэж байснаас гадна үр жимс зэрэг ургамлын төрлийн зүйлийг түүх ажил тэр үеийн хүмүүсийн амьдралд багагүй үүрэг гүйцэтгэж байв.

Манай орны доод палеолитын үеийн дурсгалуудын хамаарах он цагийн асуудлыг нарийн хэлхээсэнд авч үзэхэд онцгой чухал үүрэг, ач холбогдол бүхий дурсгал нь Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Цагаан агуйн суурин юм.

Уг агуйг Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедицийн Чулуун зэвсгийн дурсгал судлах анги 1987 онд олж илрүүлсэн бөгөөд 1995-2000 онд Монгол-Орос-Америкийн судлаачид малтан шинжилжээ.

Цагаан агуй нь шохойн чулуун тогтоцтой Цагаан цахир уулыг зүүн хойноос баруун тийш хөндлөн огтлон гарсан нэгэн хавцлын зүүн этгээдэд байрлах бөгөөд агуйн үүд нь баруун өмнө зүг хандсан агуйн том хонгилын нийт урт нь 38 м, үүд нь өргөнөөрөө 5,3 м, өндрөөрөө 4,6 м. Үүдний талбай нь огцом налуу бөгөөд энэ байдал нь ч агуйн хонгил дотор 7-8 м үргэлжилнэ. Харин агуйн хонгилын төв хэсэгт талбай нь тэгшхэн. Агуйн нь бүтцийн хувьд Гол, Бага, Доод гэсэн гурван хонгилоос бүрддэг.

Гол хонгилд хөрсний 13 соёлт давхаргыг агуулсан дөрвөн том давхарга илэрчээ. Эдгээрээс 6-12-р давхаргуудад хийсэн лабораторийн олон төрлийн шинжилгээгээр доод палеолитийн янз бүрийн шатанд холбогдох нь тогтоогдсон байна. Эдгээр давхаргууд нь бүгд чулуун зэвсгийн дурсгалыг агуулж байгаа бөгөөд, гол төлөв бор шаргалдуу өнгийн хас чулуугаар хийсэн байна. Дээрх давхаргын ургамалын үлдэцний тоосонцорт хийсэн шинжилгээгээр тухайн үед энэ бүс нутагт цаг агаар дулаан чийглэг, навчит, шилмүүст модоор байялаг ой модтой байсан нь тогтоогджээ. 1995 онд агуйн үүдний талбайн 11-р давхаргаас авсан дээжинд хийсэн палеомагнитын шинжилгээгээр 730 мянган жилээс өмнөх үед энэ давхарга бүрэлдсэн нь тогтоогджээ.

Монгол орны доод палеолитын өөр нэг томоохон дурсгал бол Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших Уран хайрхан уулын орчмын Нарийн голын хөндийн палеолитын суурингууд юм. Эндээс палеолитын доод, дунд, дээд үеүдэд холбогдох 47 бууц, сууринг илрүүлэн олсноос 12 нь доод палеолитын үед холбогдохын зэрэгцээ дөрөв нь дархны газар байжээ. Эдгээрээс хамгийн эртнийх нь Нарийн гол-17 хэмээн тэмдэглэгдсэн дархны газар бөгөөд эндээс ногоон саарал өнгийн хайрган чулуугаар хийсэн ихэд өгөршсөн шинжтэй 212 чулуун эдлэлүүд олдсоны гадарга нь эртний шинжтэй болохыг судлаачид онцлон анхаарч үзсэн байдаг юм. Эдгээр чулуун зэвсгийн дотор цохилтын талбайгаас цохиж хэд хэдэн хажуугаас нь залтас, ялтас цуулдаг үлдэцүүд арай илүү олон тоотойгоор олдсон байна. Иймэрхүү төрлийн үлдэцүүд ховор байдгийн зэрэгцээ леваллуа маягийн үлдэцтэй харьцуулахад завсарын шинжийг агуулж байдаг. Хөндлөн огтлолоороо чон хэлбэрийн гилбир зэвсэг олдсон нь нэн сонирхолтой. Бүхэлдээ энэхүү цуглуулгын доод палеолитын үед хамааруулан үзэж болох эртний шинжтэй хэсгийн онцлог шинж нь чулууг хагалж засах анхдагч үйл ажиллагаатай холбоотой болохыг онцлон тэмдэглэлтэй.

Нарийн голын суурин, дархны газрууд нь он цаг тогтооход чухал хэрэглэгдэхүүн болох соёлт давхаргагүй, газрын өнгөн хөрсөн дээр ил байна. Иймд судлаачид түүний он цагийн хамаарлыг нь тухайн үед нэгэнт шинжлэх ухаанд мэдэгдэж байсан дурсгалуудтай харьцуулан 500.000 жилээр тогтоосон юм. Харин сүүлийн үеийн судалгааны ажлын явцад энэхүү суурингийн чулуун эдлэлүүд нь Хятадын баруун хойд нутагт орших Сихоудоугийн суурингийн чулуун зэвсгийн дурсгалуудтай хийсэн арга барил, төрөл зүйлийн болон хэв шинжийн хувьд ижил төстэй байгаа нь дээр өгүүлсэн он цагийн тодорхойлолтыг эргэн харахад хүргэж байна. Сихоудоугийн сууринтай харьцуулан үзвэл Нарийн гол-17 нь плейстоцений доод үед буюу 800.000 жилийн тэртээд, түүнээс ч өмнөх үед ч хамаарч болох бүрэн боломжтой хэмээн судлаачид үзэж байна.

Монгол орны нутгаас олдсон доод палеолитын өөр нэг томоохон дурсгал нь Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Ярх уулын дэргэдээс олдсон доод палеолитын үеийн суурин юм. Энэ нь одоогоос 300 мянга орчим жилийн өмнөх үед холбогдох чулуун зэвсгийн дархны газар бөгөөд хасын хольцтой шаргал өнгийн цахиурын төрлийн чулуугаар хийсэн олон төрлийн зэвсэг байгаагийн дотор хөндлөн огтлолоор гурвалжин хэлбэрийн хатуу хутган цуулдас, цохилтын нэг ба хоёр талбайт үлдэц, хянгар, хусуурын төрлийн зүйлс олон байгаагын зэрэгцээ гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүд цөөнгүй тоотой олджээ. Эдгээр зэвсгүүд хийсэн арга барил болон бусад бүхий л шинжээрээ Өмнөд Ази, Европ, Африкын доод палеолитын ашелийн үед өргөн тархсан гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүдтэй ижил байна. Уг гилбэр зэвсгүүд нь нэлээд баргилдуу, хоёр хажуугийн хавтгай талыг ялтаслан цуулж зассанаас гадна ирэн талыг хоёр талаас нь ээлжлэн цохиж гаргасан зэрэг нь европын гилбэртэй адил долгио иртэй болжээ.

Хоёр талаас нь зассан үзүүр мэсэн зэвсгүүд нь европын доод палеолитын микок гэгдэх шатны дурсгалуудтай адилаар бөгөөд гилбэр зэвсгээ бодвол арай нимгэн, хавтгайдуу хэмжээгээр бага болно.

Ярхын дурсгал нь Евразийн доод палеолитын үеийн соёл анхлан бий болсон тодорхой үүсвэр газар нутгийн тухай тухайн үед тогтсон зарим ойлголтыг хянан үзэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Учир нь 1970-аад оноос өмнө Америкийн эрдэмтэн И.Х. Мовиусын дэвшүүлж, палеолит судлаачдын нэг хэсэг нь баримталж байсан "чулуун зэвсгийн үеийн орон нутгийн хөгжлийн тухай онол"-д "хуучин чулуун зэвсгийн үед өрнө зүгийн орнуудад гилбэр зэвсэг бүхий хүмүүс, Өмнөд ба Зүүн өмнөд Азийн орнуудад мөлгөр хайрган чулууг хөндлөн хугалж зөвхөн нэг талаас нь ирэлж зассан зэвсэгтэй хүмүүс бүхий доод палеолитын соёлын хоёр том бүс байсан" гэж үздэг байв. Гэтэл Ярхын дурсгалыг олж

судалсны үр дүнд "гилбэр зэвсэг хийж эзэмшигчдийн нутгийн хил хязгаар нэлээд хэмжээгээр тэлэгдэж "сонгодог" гилбэр зэвсэгтэн гэж нэрлэгддэг Африк, Баруун европ, Бага Ази, өмнөд Энэтхэгтэй нэг мужид Төв Азийн нутаг, түүний дотор Монгол орон багтах нь эргэлзээгүй" болсон билээ.

Монгол орны палеолитын эхэн үеийн дотоод хөгжлийн зүй тогтлыг харуулж чадахуйц Ярхын дурсгалын нэг онцлог нь гилбэр ба үзүүр мэсэн зэвсэг үйлдэж эзэмшигчид нь өрнө зүгийн доод палеолитын үеийн хүний нэг адил чулууг засаж, түүгээр хоёр талаас нь янзалж ирлэсэн зэвсэг хийх өөрийн тогтсон арга барилтай байсанд оршино.

Монгол ба Европын гилбэр мэсэн зэвсгийн ижил төсөөтэй байдлыг тэртээ алс холын эртний хүнтэй тус орны мөн үеийн хүн ямар нэг гарал төрлийн холбоотой юм уу, эсвэл өөр хоорондоо харилцан нөлөөлөлцөж байснаар биш, зөвхөн гадаад шинжээрээ адил боловч тус тусдаа үүсэж хөгжсөн хоёр өөр соёл буюу, өөрөөр хэлбэл хуучин чулуун зэвсгийн үеийн хөгжлийн тодорхой шатанд амьдарч байсан ази, европ хүний аль аль нь чулууг засаж гилбэр зэвсэг хийх нэгэн үзүүр санааг сэдэж олсноор тайлбарлагдаж байна.

Үүгээрээ Ярхын хуучин чулуун зэвсгийн үеийн дархны газар нь бичигдээгүй түүхийн хэдэн зууны өмнөх үнэнийг өгүүлсэн томоохон суурин газар юм.

Монгол орны нутгаас олдсон ашеллийн үеийн дараагийн томоохон суурин нь Өмнөговь аймгийн хамгийн урд зах, улсын хилийн ойролцоо орших Оцон Мааньтын чулуун зэвсгийн суурин юм. Оцон Мааньтын чулуун зэвсгийн эдлэлүүдийг хар саарал өнгийн чулуугаар хийжээ.

Оцон Мааньтаас олдсон дугуйдуу хэлбэрийн үлдэц, гонзгойдуу үлдэцүүд нь их эртний шинжтэй бөгөөд тийм хэлбэрийн үлдэц Европ, Өмнөд Ази, Африкт доод палеолитоос дунд палеолитод шилжих шилжилтийн үед элбэг тохиолддог юм. Гонзгойдуу хэлбэрийн үлдэцнээс маш нямбай зөөлөн цохилтоор товгор артай тэгш ирмэгтэй урт зууван гурвалжин ялтас цуулж авдаг байжээ. Энэ нь тус улсын нутаг дэвсгэрт амьдарч байсан эртний дархчууд бие биетэйгээ харилцан хамааралгүйгээр ашеллийн үед шилжсэн болохыг нь харуулж байна.

Монгол орны нутгаас олдсон доод палеолитын үеийн бас нэгэн өвөрмөц томоохон дурсгал нь Өвөрхангай аймгийн Богд, Өмнөговь аймгийн Булган сумдын нутгийн зааг Цахиуртын хөндийн суурин юм. Ойролцоогоор 20 км² талбай эзлэх энэ суурин нь газрын хөрсөн дээрээ хуучин чулуун зэвсгийн доод шатнаас эхлэн шинэ чулуун зэвсгийн үеийн эхэн үеийг хамарсан хэдэн зуун мянган чулуун зэвсгийн дурсгалыг агуулдаг. Он цагийн хамаарлын хувьд асар урт хугацааг хамарсан, өргөн уудам талбайг эзлэн оршсон чулуун зэвсгийн ийм суурин Монгол, Төв Ази төдийгүй дэлхийд урьд өмнө тохиолдож байсангүй.

Эл сууринг 1995 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" төслийн хээрийн шинжилгээний ажлын үеэр хийгдсэн хайгуулын явцад анх олж илрүүлсэн юм.

Цахиуртын хөндий нь Говийн Алтайн нурууны зүүн-өмнөд төгсгөлийн төв хэсэгт буюу Арц богд, Гурвансайхны нуруудын дундах нам дор газарт орших газар зүйн хувьд элсэн манхан, дов, гүвээ, жалга, гуу, гүн ангал зэрэгцэн оршсон өвөрмөц тогтоцтой нутаг юм. Энэ тогтоцын төв хэсэгт шохойн чулуун хурдас дээр тогтон өндөрлөгдсөн талбай байгаа бөгөөд түүний дээд тал нь цахиурын төрлийн чулуугаар нэлдээ хучигдсан байна. Эдгээр чулууны ихэнх нь хүний хөдөлмөрийн үр дүнд хагалагдаж цуулагджээ. Чулуун зэвсгийн зүйлс нь хийсэн арга барил, хадгалалтын байдлаараа хоорондоо эрс ялгардаг бөгөөд доод палеолитын үед холбогдох зэвсгүүд нь нар, салхи зэрэг байгалийн элдэв хүчин зүйлийн нөлөөгөөр өгөршилд илүү орсон байдалтай байх ажээ.

§2. ДУНД ПАЛЕОЛИТ

Доод палеолитоос дунд палеолитод шилжих үед цаг агаар эрс хүйтэрч Ази Европ тивийн ихэнх нутаг мөсөөр хучигджээ. Мустьен үе нь рисс-вюрмийн мөстлөгө хоорондын төгсгөл, вюрмийн мөстлөгийн эхэн үеийн хугацаатай давхцдаг байна. Тухайн үеийн байгалийн нөхцөл байдал нь орчин үеийнхээс эрс ялгаатай байв. Ихээхэн чийглэг болсны зэрэгцээ Европ, Ази, Америкийн хойд хэсгээр нэлэнхүйдээ хүйтэрсэн нь хойд болон дундад өргөргөгийн нутаг дэвсгэрийг нэлэнхүйд нь хамарсан зузаан мөсөн хучлага тогтоход хүргэжээ. Энэхүү мөстлөгийн гол төв нь Скандинавын хойг буюу одоогийн Норвег, Шведийн нутагт байсан. Тухайн үед хэдэн сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр мөсөн хучлагаар хучигдаж энэхүү хучлага нь зарим газартаа 2 км хүртэл зузаантай байжээ. Мөстлөгийн энэ үеийн цаг уур чийглэг, зундаа сэрүүн, өвөлдөө харьцангуй дулаан байдаг байв. Тэр үед Монгол орон эх газрын хуурай уур амьсгалтай, хур тунадасаар бага байсан тул Европ, Умард Америкийг бодвол мөсөн хучлага харьцангуй бага бөгөөд мөстлөгө зөвхөн Хөвсгөлийн уулс, Хэнтийн уулс, Алтайн нуруу зэрэг томоохон уул нуруудаар хязгаарлагдсан байна.

Уулархаг газар ийнхүү мөсөн уул, мөсөн гол зонхилж байсан бол түүний зах хязгаараар урьдын адил уудам тал үргэлжлэн арслан заан, савгат хирс, одос үхэр, адуу, үхэр, буга, янгир болон бусад туурайтан амьтдын зэрэгцээ хүйтэн сэрүүн уур амьсгалд зохицсон цаа буга, хандгай, агуйн баавгай, агуйн арслан, үнэг мэтийн амьтад нутаглаж байжээ.

Дунд палеолитын үед зөвхөн ургамал амьтны аймагт өөрчлөлт гараад зогссонгүй, мөн хүний бие махбод хувьсан өөрчлөгдөж иржээ. Мөстлөгийн үеийн байгал цаг уурын нөхцөл байдал нь хүмүүсийн амьдралд үлэмж их нөлөөлжээ. Хүмүүс хүйтэнд дасч, байгал цаг уурын эсрэг тэмцэж

чаддаг болж, амьтдын арьсаар өөрсөндөө дулаан хувцас хийж өмсөж сурч, гал гаргах арга нь улам боловсронгуй болон шинэчлэгдэж, оромж сууц барьж амьдрах болсон нь зэлүүд шинэ газар нутагт нүүдэллэн очиж амьдрах үйл явцад чухал түлхэц өгсөн байна. Энэ үед амьдарч хүнийг Германд энэ төрлийн хүний яс анх олдсон газрын нэрээр неандерталь хүн хэмээн нэрлэдэг. Орчин үеийн хүний өмнөх хөгжлийн шат болсон тэрхүү хүн урьдын хүмүүсийн адил дух нь намхан, хөмсөгний яс товгор, гарын хуруу болхи байсан зэрэг нь орчин үеийн хүнээс ялгагдах гол шинж боловч тархины багтаамж нь 1.400-1.600 см³ болж хөгжсөн байна. Тэдний амьдралын дадлага туршлага нь урд үеийнхийг бодвол нэлээд арвижиж хөдөлмөрийн багаж зэвсэг нь ч улам сайжирсан нь орчин үеийн хүний төрхөд ойртож ирснийг харуулж байна. Дунд палеолитийн үед хүй нэгдлийн үеийн хүмүүсийн үйлдвэрлэх хүчний хөгжилд томоохон ахиц дэвшил гарчээ. Төрөл зүйл, зориулалтын хувьд маш олон тооны чулуун зэвсгүүдийг хүмүүс хийж чаддаг болсон байна. Энэ үед ялтас цуулах леваллуагийн арга боловсорч гүйцжээ. Бүтэн цул чулууны гадна талын өнгөн хэсгийг нь ховхолж аваад дараагаар нь чулууныхаа гол руу чиглэсэн цохилтоор тал талаас нь холтчин цохиж цуулалтын гадаргууг бэлтгээд, уг талбайгаас нь ганц цохилтоор гурвалжин хэлбэрийн урт, хурц үзүүр бүхий ялтсыг гарган авах болжээ. Чулуун зэвсэг боловсруулах леваллуагийн аргыг боловсронгуй болгож хэрэглэсэн нь хөдөлмөрийн багаж зэвсгийн чанарыг сайжруулж, төрлийг нь олшруулсан байна. Ийм ялтсыг дараа нь ирлэж хурц иртэй хутга, жадны үзүүр, хянгар болгоход амар байсан нь туршлагаар нотлогддог. Хурц ирмэгтэй гурвалжин мэсийг хутга, чинжаал, нимгэн мэсийг мод, ясанд суулгаж жад болгон хэрэглэж байснаас гадна хянгарыг арьс шир зүсэх, халимлах, мод, ясан эдлэл хийхэд голчилж ашиглаж байсан байна. Одоогийн байдлаар мустьен үед хэрэглэж байсан 60 гаруй төрлийн чулуун зэвсгийг судлаачид тогтоогоод байна. Хамгийн их өргөн дэлгэр хэрэглэгдэж байсан зэвсэг нь гилбэр, үзүүр мэс, хянгар байжээ. Үзүүр мэс нь өргөн суурьтай гурвалжин хурц үзүүр бүхий зэвсэг юм. Түүний ирийг холтчин засч тэгш хэмтэй хийдэг байжээ.

Хянгарыг өргөн ялтас, залтасаар хийдэг байв. Зөвхөн нэг талыг нь сайтар засч ир гаргадаг байжээ. Энэ зэвсэг олон тоогоор олддог нь тухайн үеийн хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээний зэвсэг байсныг харуулж байна. Хянгарыг голчлон мал амьтны арьс ширийг өвчих, боловсруулахад ашиглаж байжээ. Хажуу ирмэг болон үзүүр, ёзоор хэсгийг нь хүнхийлгэн холтчин ир гаргасан хүнхэр-шүдлэг иртэй зэвсэг энэ үеийн өвөрмөц эдлэлийн тоонд багтдаг. Мустьен үеийн дурсгалт газруудаас дээд палеолитийн үеийн хэв шинжит зэвсгүүд болох уртавтар ялтас, хянгар, сийлүүр, цоолтуур олддог явдал нь энэ хоёр үеийн гарал үүслийн хувьд холбоотойг харуулж байгаа явдал юм.

Энэ үеийн хүмүүсийн гол эрхлэх аж ахуй болж байсан ан агнуурын үндсэн зэвсэг нь чулуун гилбэртэй жад, урт модон жад байжээ. Анг голчлон хамтран хийдэг байсан байна.

Неандерталчууд хүнээ оршуулдаг байсныг Узбек улсын Тешик-Таш хэмээх агуйд хийсэн малтлагын дараа тогтоосон байна. Ийнхүү нас барагсадаа оршуулдаг болсон нь тэдний оюун санаанд шүтлэгийн төсөөлөл үүсэн бүрэлдснийг харуулж байгаа явдал гэж үзэж болно. Тухайлбал Крымийн Киик-Коба хэмээх газар хийсэн малтлагаар зориуд ухсан нүхэн дотор нас барсан хүнээ хажуугаар нь хэвтүүлэн хөлийг атийлган гарыг нь мөн тохойгоор нь нугалан оршуулсан оршуулга илэрсэн нь хожуу үеийн оршуулгийн зан үйлтэй төстэй байна. Манай орны хувьд одоогийн байдлаар дунд палеолитийн үеийн хүний оршуулга хараахан илрээгүй байгаа хэдий ч тэрхүү хүмүүсийн эдлэж хэрэглэж байсан ан агнуурын болоод хөдөлмөрийн багаж зэвсгүүд олон тоотойгоор олддог.

Дунд палеолитын үеийн хүний хөдөлмөрийн багаж зэвсэг бүхий бууц суурин Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оцонмааньт, Булган сумын Цахиуртын хөндий, Гурвансайхан, Баянхонгор аймгийн Богд сумын Их Богд уул, Орог нуурын хөндий (Орог нуур 1,2), Өвөрхангай аймгийн Богд сумын Арц Богд уул, Хархорины орчим Орхон голын сав (Орхон 1; 7 доод давхарга), Мойлтын амны зүүн дэнж, Ховд аймгийн Баралгийн гол (Баралгийн гол 1), Хойт Цэнхэрийн гол (Хойт Цэнхэр 2), Олон нуур (Олон нуур 1) зэрэг олон газраас олдсон байна.

Оцон мааньтаас дугуй ба тэгш өнцөгт, шовхдуу маягийн үлдцүүд, өргөн урт ялтас, хянгар зэрэг леваллуагийн аргаар хийсэн эдлэлээс гадна мустьегийн гурван талт үлдцүүд олдсны цохих талбай нь ар тал руугаа налуу бөгөөд доод талын суурь хэсгийг нь модонд зоож суулган ялтас цуулж авахад тохиромжтой болгожээ. Оцон мааньтын чулуун зэвсгүүд монголын палеолитийн үеийн олон дурсгалын нэгэн адил газрын хөрсөн дээр ил байдалтай олдсон байна.

Монгол Алтайн нурууны орчмын дунд палеолитийн дурсгалууд дотроос нэлээд эртнийх нь Олон нуур, Баралгийн голын дурсгалууд юм. Эдгээр суурингуудад леваллуа-мустьен арга техникээр хийгдсэн эдлэлүүд зонхилдог байна. Ер нь мустьен үед чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хөгжлийн хоёр чиг хандлага байдаг бөгөөд хоёрдахь нь эдлэлүүдэд иржгэр шүд маягийн ир ирмэг гарган хийдэг арга юм. Үүнийг шүдлэг мустье хэмээн нэрлэх нь ч бий.

Леваллуагийн чиг хандлага бүхий дурсгалуудын дотор Орог нуур 1, 2-ын суурин томоохон байр суурь эзэлнэ. Энэ хоёр суурингийн чулуун зэвсгийн дотор Леваллуагийн аргаар хийсэн эдлэлүүд зонхилж байгаа бөгөөд уртавтар ялтас цуулж авсан нэг ба хоёр талбайт үлдэц, өргөн богиновтор залтас цуулж авсан леваллуагийн үлдэц олон тоотой байна. Эндээс леваллуагийн залтас, ялтас, үзүүр мэс олон тоотойгоор олдож байгаа нь Орхон-1-ийн доод давхаргын эдлэлүүдтэй хийсэн арга барил, зэвсгийн төрөл зүйлийн хувьд тун адил байгаа бөгөөд Орхон-1-ийн дээр дурдсан давхарга нь

34-38 мянган жилийн өмнөх үед холбогдоно гэж үзвэл Орог нуурын суурингууд ч мөн адил дээрх он цагийн хамаарал магадгүй түүнээс ч өмнөх үед холбогдох нь маргаангүй ажээ.

Дунд палеолитийн үед холбогдох өөр нэг томоохон дурсгал бол Орхон-7-гийн соёлт давхарга бүхий суурин юм. Энэ сууринг МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судлалын анги малтан шинжилж хөрсний 11 давхарга илрүүлэн тодорхойлсноос нэгээс бусад нь соёлт давхаргууд юм. 10-р давхаргаас мустьен дунд үед холбогдох чулуун зэвсгүүд олдсон байна. Их том биш голын хайргыг хагалж цуулан өргөн залтас гарган авах, уртавтар хайргын нэг талыг нь хагалж бэлдсэн цохилтын талбайнаас урт ялтас цуулан авах ерөнхий хоёр аргаар чулуун зэвсэгхийх анхдагч цуулдасыг авч байсан байна. Дараа нь гаргаж авсан цуулдасуудаараа шүдлэг иртэй зэвсэг, хүнхэр ирт хянгар, бусад төрлийн хянгар зэргийг хийдэг байжээ. Ирийг чулууныхаа хоёр талаас нь ээлжлэн гаргаж байжээ. Хөрсний дээж болон ясанд хийсэн радикарбон болон цахилгаан хос соронзон давтамжийн (ЭПР) шинжилгээгээр 45-62 мянган жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогджээ.

7-9-р давхаргууд нь дунд палеолитийн төгсгөл дээд палеолитийн эхэн үед хамарч байгаа бөгөөд чулуун зэвсгийн дурсгалуудад леваллуагийн уламжлалт арга дээр суурилсан ялтсан эдлэлүүд голлож байна. Он цагийн хувьд 35-40 мянган жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогдсон байна.

Дээр дурдсан бууц суурингуудаас гадна дунд палеолитын үеийн таргил үлдэц, урт гурвалжин хутган ялтас, залтас зэрэг эдлэл Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутаг, Говь-Алтай аймгийн Сүүжийн хөндий зэрэг газраас, баргил дугуй үлдэц, болхи зассан хайрган чулуун багаж, үлдэцнээс ховхолсон залтасны зүйл Баянхонгор аймгийн Их богд, баргил ялтас, залтас, нэг ба хоёр талбайт таргил үлдэц, үзүүр мэс, хусуур, хянгар, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, мөн сумын нутаг дахь Хавцалын хөндий, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Цагаан тунг (дэрс) зэрэг газар дунд палеолитын бууц суурингаас олж илрүүлсэн байна. Бусад оронд хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд мустьегийн үед чулуун зэвсгээс гадна ан агнах болон түүнтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагаанд том амьтдын хавирга, эрүү, чөмөг, далны ясыг бага сага засаж зэвсэг хийх, урт модны үзүүрийг галд түлж хатууруулан модон жад хийж оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглах явдал багагүй үүрэгтэй байжээ.

Дунд палеолитын үеийн хүний соёлын томоохон ололт нь гал гаргаж ашиглаж сурсан явдал юм. Хэрэв доод палеолитын үед хүн галт уулын дэлбэрэлт, ойн ба тал газрын түймэр, аянга цахилгаанаас шатсан мод, бичил организмуудаас цогшиж үүссэн гал зэргийг ашиглаж байсан бол одоо цахиур цохих, модны үрэлтийн аргаар галыг аль хэрэгцээтэй цагт гаргаж авч чадах болжээ.

§ 3. ДЭЭД ПАЛЕОЛИТ

Палеолитын дараагийн үе болох дээд палеолит нь мөстлөгийн эцсийн шатанд холбогддог бөгөөд ойролцоогоор одоогоос 40 000-35 000 жилийн тэртээ эхэлж 12-10 мянган жилийн өмнөх үе хүртэл үргэлжилжээ. Энэ үеийн гол онцлог нь орчин үеийн хүний шинжийг хадгалсан хүн бүрэлдэн бий болсон явдал байв. Хүн амын тоо олширч, чулуун зэвсэг үйлдвэрлэх арга ажиллагаанд ололт дэвшилүүд гарч эхэлсэн байна. Цаг уур хүйтэн, хуурай, зарим үед эрс тэс байдалтай байсан боловч эцэстээ орчин үеийнхтэй төстэй болж иржээ.

Энэ үед тус орны уул нуруудаар дунд палеолитод тогтсон мөсөн хучлага, жилд унах тундасны хэмжээ эрс багассаны улмаас одоогийн Онон, Хэрлэн, Туул, Сэлэнгэ, Орхон зэрэг их гол болон нуурууд усаар арвижин улмаар орчин үеийн усны тогтоц, урсгалын горим бий болжээ.

Цаг агаар хуурайшин, эх газрын уур амьсгалтай болсон нөхцөлд арслан заан, хирс зэрэг урьдын том амьтдын зэрэгцээ зэрлэг адуу (тахь, хулан), үхэр, буга, янгир, аргаль угалз, цаа буга, бөхөн, цагаан үнэг, тэмээн хяруул зэрэг амьтад зэрэгцэн амьдарч байжээ.

Дээд палеолитын эхэн үеийн нэг чухал онцлог бол хүний бие бялдарт гарсан чанарын том өөрчлөлт юм. Хүний гавлын яс томорч дух өндөржиж ирсэн нь мичин хүний морфологийн үлдэц болох хөмсөгний ясны товгорыг арилгаж, хэл ярианы цаашдын хөгжил болон үг ярианы эрхтэн өөрчлөгдсөнтэй холбогдон эрүүний яс одоогийнхтой адил болж орчин үеийн хүн (homo sapiens-ухаалаг хүн) бий болжээ.

Ийнхүү орчин үеийн хүн бий болсон нь дунд палеолитоос дээд палеолитод шилжсэн хүний амьдрал, нийгмийн харилцаа, үйлдвэрлэхүй хүчинд асар их нөлөө үзүүлсэн байна. Үйлдвэрлэхүй хүчний хөгжил нь юуны өмнө чулуун зэвсгийг шинэ аргаар хийдэг болсноор илрэлээ олсон бөгөөд дунд палеолитын үеийн дугариг таргил үлдэцнээс гурвалжин хэлбэрийн болхи залтас хэлтэлж авдаг байсан бол гонзгой хэлбэрийн үлдэцнээс нимгэн урт хутган ялтасыг цуулж авдаг болж эргэн тойрон уртааш нь түүний ирмэгийг нэг ба хоёр талаас нь дахин холтчин засаж хурц ир гаргадаг болсон байна.

Чулууг цуулах ба холтчин ирлэх болсон нь энэ үед чулуун эдлэл хийх үйл ажиллагаанд гарсан нэг ёсны эргэлт болсон шинэ арга байжээ. Гэвч дунд палеолитын үед хэрэглэж байсан чулуун зэвсэг бүрмөсөн шахагдаж гараагүйгээр үл барам тэдгээрийг улам боловсронгуй хийх болсноос гадна эсгүүр, цоолтуур, үзүүр мэс, тал дугариг ба үзүүр бичил хусуур, жижиг сүх, ангийн цахиурт жад, шинээр буй болж хянгар, хутга зэрэг бусад олон зэвсгийн хамт төрөлжин олширч, чанар чансаа нь урьд урьдынхаас эрс сайжирчээ.

Огтлох, цоолох, зүсэх зэрэг үйлдэлд зориулсан хөнгөн багаж зэвсэг нь энэ үед мод ба ясан бариултай болсон байна.

Шинэ аргаар хийсэн нарийн хийцтэй хурц иртэй чулуун зэвсгийн зэрэгцээ арслан зааны дал, соёо, бугын эврээр жад, шөвөг, үр үндэс ухах зэвсэг хийж, буга зэрэг бусад амьтдын шүд, соёогоор гоёл чимэглэлийн зүйл, оёдлын зүү, загас агнах сөрлүүрт жад хийх болжээ.

Дээд палеолитод холбогдох анчдын бууц суурин манай улсын бараг бүх нутгаас олдоод байна. Тухайлбал: Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн дэргэдэх Орхон голын баруун эрэгт буй Мойлтын амны сууринг малтахад үлдэц, хугадас маягийн цавчих зэвсэг, хянгар, хусуур, цоолтуур, хутга, үзүүр мэс, ирлэж зассан ба засаагүй хэдэн зуун чулуун эдлэл гарсан байна. Энэ суурин монгол орны хувьд анх удаа олдсон соёлт давхарга бүхий суурин юм. Нийт 4 соёлт давхарга илэрч олдсон бөгөөд энэ нь энд дээд палеолитын эхэн үеэс мезолитын үеийг хүртэл эртний хүн тасралтгүй оршин амьдарч ирсний баталгаа болж өгч байгаагаарай ач холбогдолтой юм. Мойлтын амны суурингаас гадна мөн үед холбогдох дурсгалаас Улаанбаатар хотын дэргэдэх Шархад, Сонгино уул, Буянт-Ухаа; Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуйн доод давхарга, Түйн голын сав; Архангай аймгийн Цэцэрлэг; Өвөрхангайн Хужирт зэрэг газруудын бууц суурин, дархны газар зэргийг нэрлэж болно.

Монгол Алтайн нурууны орчмын бүс нутагт мөн дээд палеолитын үеийн өвөрмөц соёлын үлдэгдэл болох Манхан-5, Баяннуур-13, Улаан хусын сууринг илрүүлэн олоод байна. Эдгээр суурингуудын чулуун зэвсгийн дурсгалуудад леваллуагийн уламжлалт аргаар хийсэн эдлэлүүд олон тоотой байгаагаараа онцлогтой.

Дунд палеолитоос дээд палеолитод шилжих шилжилтийн үед леваллуагийн арга барил солигдон ялтасан зэвсгүүд олон тоотойгоор бий болсныг Орхон-7 суурингийн дээд палеолитын эхэн үеийн давхаргаас тодорхой харж болно. Энд ялтас цуулж авах зориулалт бүхий нэг ба хоёр талбайт үлдэц зонхилж байна. Он цагийн хувьд 15-25 мянган жилийн өмнөх үед холбогдох 4-5-р давхаргуудын чулуун зэвсгийн дотор уртавттар хянгар, хусуур болон ялтсан зэвсгүүд зонхилж байна.

Дээд палеолитын турш леваллуагийн арга барил улам боловсронгуй болж, хөгжсөн нь Түйн голын хөндийн болоод Монгол Алтайн нурууны болон бусад дурсгалуудад тодорхой байна. Түйн голын хөндийн дунд урсгалын дагуу 1985-1986 оны хооронд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги чулуун зэвсгийн 54 бууц суурин илрүүлэн олж, 3312 ш чулуун зэвсгийн олдворудыг олж цуглуулсны ихэнх нь дээд палеолитын үед холбогдох ажээ. Түйн голын хөндийн суурингуудаас хамгийн эртнийх нь Их Булган уулын ойролцоох суурин бөгөөд (Түйн гол-5) дээд палеолитын эхэн үед холбогдоно. Эндээс леваллуагийн болон зэрэгцээ цуулалтын арга бүхий үлдэц, леваллуагийн үзүүр мэсэн зэвсэг, ялтас, залтас, хянгар, хайрган зэвсэг, хусуур олдсон бөгөөд сийлтүүр зэвсэг, цоолтуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсгүүд цөөн тоотой олджээ. Энэ бууц сууринд мөн туршилтын малтлага хийхэд 40 см гүнтэй соёлт давхарга илэрсэн боловч мөлхөгч амьтдын үүр ноохойгоор ихээхэн эвдэрч давхаргын бүтцийг тодорхойлоход хүндрэл учруулсан байна.

Бусад суурингуудын чулуун зэвсгүүд нь бүгд газрын хөрсөн дээрээс ил олдсон агаад янз бүрийн байдлаар өгөршиж элэгджээ. Харьцангуй их элэгдэлтэй эдлэлүүд нь элэгдэлд бага орсон болон огт элэгдээгүй дурсгалуудаа бодвол эрт үед холбогдох нь тодорхой. Ийм төрлийн эдлэлүүдийн дотор хянгар, хусуур, үрүүл, сийлтүүр олон тоотой байна. Мөн цүүц, баргил том хайрган зэвсгүүд ч олджээ.

Түйн голын хөндийн бууц суурингуудын дийлэнхи нь энэ бүс нутгийн дээд палеолитийн үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн шинж байдлыг бүрэн тодорхойлохуйц гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл дээд палеолитийн дунд болон төгсгөлийн үед холбогдох эдлэлүүд дийлэнхи нь болох ажээ. Олон талст болон зэрэгцээ цуулалтат үлдэцүүдийн эзлэх хувь нэмэгдэж, хусуурын төрөл зүйл нь олширч байна. Үүнээс гадна өвөрмөц хэлбэрийн болон цүүц, хосолмол зориулалттай зэвсгүүд ч бий болжээ. Бичил чулуун зэвсгүүд ч ганц нэг тааралдаж байна.

Түйн голын хөндийн чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүнээс харахад дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн шатнаас эхлэн дээд палеолитын төгсгөл хүртэлх үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хөгжлийн нэгдмэл чиг хандлага ажиглагдаж байна гэж дүгнэж болно.

Сүүлийн үед олдоод байгаа дээд палеолитын үеийн дурсгалуудын дотор Чихэн агуйн палеолитын дурсгалууд онцгой байр суурь эзэлж байна. Чихэн агуйн хонгилд хийсэн малтлагын явцад хөрсний доод давхаргаас палеолитын чулуун зэвсгүүд олдсон ажээ. Эндээс гол төлөв леваллуагийн аргаар хийгдсэн эдлэлүүд гарсан бөгөөд хөрсний дээж болон малтлагаас гарсан ясанд хийсэн шинжилгээгээр 24-27 мянган жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогджээ. Энэ дурсгал нь манай орны нутаг дэвсгэр дээрээс одоогоор олдоод байгаа соёлт давхарга бүхий цөөхөн дурсгалын нэг болж байгаагаараа эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм.

1998 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн нэг хэсэг Чихэн агуйн ойролцоо дахин нэг соёлт давхарга бүхий сууринг (Чихэн-2) илрүүлэн олж туршилтын малтлага хийсэн бөгөөд 2001 онд энд талбайг нь өргөсгөн дахин малтлага хийжээ. Малтлагын явцад 3 соёлт давхарга илэрсний доод талынхаас дээд палеолитын үеийн леваллуагийн болон нэг талбайт үлдэц, леваллуагийн үзүүр мэс, хусуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, хянгар, урт ялтас олдсон байна. Хамгийн сонирхолтой олдвор нь 2001 оны малтлагаас гарсан 13 см урттай том ялтас юм.

Доод талын давхаргаас илэрсэн гал голомтын үлдэгдлийн модны нүүрсэнд хийсэн радиокарбоны шинжилгээгээр 30550 жилийн өмнөх үед холбогдох нь тогтоогджээ. Түүнчилэн Чихэн-2-ын ойролцоох хавцлын зүүн талын сайрын эргээс дээд палеолитын үед холбогдох эдлэлүүд олдсон байна.

Дээд палеолитын хүн олон төрлийн зэвсэг хийж эзэмших болсон нь түүний амь зуух үндсэн сурвалж болох ан агналтыг улам хүчтэй боловсронгуй болгож тодорхой хэмжээний газраас хэрэгцээний хэрээр агнуурын олз омог олж нэг газарт удаан хугацаагаар оршин суух бололцоотой болжээ.

Нөгөө талаар дээр дурдсан манай орны дээд палеолитын чулуун зэвсгүүдтэй адил төстэй эдлэлүүд Умард Азийн мөн үеийн дурсгалуудад элбэг бөгөөд хийсэн аргын уламжлалын хувьд ижилсэж байгаа нь Монголын палеолитын үеийн анчдын зарим хэсэг их гол мөрний хөндий дамжин умард зүг нүүдэллэн очиж суурьшиж байсны баримт юм.

Дээд палеолитын үеийн хүн агуй хонгилыг оромж болгон ашиглаж байснаас гадна нөмөр дулаан газарт урц маягийн сууц барьж суух болсон бөгөөд тэдгээр сууцны гал голомтын үлдэгдлүүд археологийн малтлагаар олдож байна.

§ 4. Палеолитын Үеийн урлагийн дурсгал

Палеолитын үеийн хүмүүсийн оюуны соёл, ертөнцийг үзэх үзлийг тодорхойлон судлахад тэдний үлдээсэн урлагийн дурсгалууд эн тэргүүн чухал хэрэглэгдэхүүн болдог.

Археологийн хайгуул судалгаагаар олддог палеолитийн үеийн урлагийн дурсгалын тоонд арслан зааны соёогоор хийсэн эмэгтэй хүний дүрсүүд, чулуу, ясан дээр сараачин сийлсэн элдэв төрлийн дүрс тэмдэгтүүд, агуй хонгилын хана хаданд зурсан зураг зэрэг багтдаг байна.

Палеолитын үеийн хамгийн эртний урлагийн дурсгал анх Францын Ориньяк хэмээх агуйгаас олджээ. Эндээс олдсон Венера хэмээн нэгэнт нэрлэгдэж заншсан яс чулуугаар хийсэн эмэгтэй хүний дүрс хожим Франц, Итали, Австри, Чех, Оросын палеолитын суурингаас олдсон билээ.

Дээд палеолитын үеэс эртний хүмүүс өөрсдийн орогнон амьдарч байсан агуй хонгилынхоо хана болон хаданд араатан амьтдыг зурж дүрслэх болжээ. Эртний анчид өдөр тутмын амьдралтай нь салшгүй холбоотой, амь зуулгынх нь амин сүнс болж байсан араатан амьтдын зан ааш, хөдөлгөөн бүрийг ихэд гярхай ажиглан мэддэг байсан нь хад чулуунаа тэдгээрийг бодитой, ихэд уран чадамгай дүрсэлснээс харж болно. Хаднаа зураг зурахдаа палеолитын үеийн хүмүүс байгал дээр элбэг тааралддаг шороон будаг буюу улаан хүрэн зосыг, агнасан араатан амьтдынхаа өөхтэй хольж зураг зурдаг байсан бололтой. Эртний зураачдын үлдээсэн зургуудаас харахад одос үхэр, арслан зааны дүрс голлох байр эзэлдэг байна.

Палеолитын үеийн хадны зосон зургийг анх 1879 онд Дон Марселино де Саутуоло гэгч Испанийн Альтамирын агуйгаас олж илрүүлжээ. Газар зүйн байршлын хувьд палеолитын хадны зургууд харилцан адилгүй бүс нутагт тархсан байх боловч Франц, Испанийн Франк-Кантабрийн бүс нутагт харьцангуй их хэмжээтэй байдаг байна. Палеолитын үеийн хүний үлдээсэн гайхамшигт зосон зургууд бүхий томоохон газруудын тоонд Ляско, Альтамир, Фон-де-Гом, Труа-Фрер, Нио, Комбаррель зэрэг агуй ордог байна.

Манай орны өгүүлэн буй үеийн хадны зосон зураг Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойт Цэнхэрийн агуйд байдаг. Хойт Цэнхэрийн агуйн цайвар өнгийн хананд ан амьтан, мод зэргийг дүрслэхдээ нэг хэсэг зургийг өтгөн улаан хүрэндүү, нөгөө хэсгийг арай цайвар ягаан туяатай, улаан шаргал өнгийн зосон будгаар зуржээ. Агуйн мухрын тааз болон хананд олон тооны ан амьтан, тэмдэг сэлтийг бие бие дээгүүр нь давхардуулан зуржээ. Энд тайван зогсож байгаа буга, данхар том эвэртэй одос үхэр, арслан заан, тэмээн хяруул, аргаль, янгир зэргийг дүрсэлсэн байна. Үүнээс гадна 8 м өргөн, 10 м урттай өөр нэгэн хонгилын хананд хоёр бөхтэй тэмээ, мод, олон тооны тэмдэг дүрс зэргийг зурсан байна.

Хойт Цэнхэрийн агуйн хананаа зурсан зургууд Өрнөд Европын дээд палеолитын үеийн зургуудтай урласан арга барил, зурсан будгийн өнгө, ан амьтдыг дүрсэлсэн арга барил зэргээрээ адил төстэй гэдэг нь судалгаагаар нэгэнт нотлогджээ. Академич А.П.Окладников Хойт Цэнхэрийн агуйн хадны зургийг судлаж, “урлагийн эхлэл, түүний үндэс, анхны үүсвэр өрнө дахинд байсан шиг дорно дахинд Төв Азийн гүнд байсан” гэж эрдэм шинжилгээний чухал дүгнэлт гаргасан юм.

Хойт Цэнхэрийн агуйн зургийг палеолитын үед хамруулан авч үзэх нэг онцлог нь янгир, тэмээн хяруулын дүрс зургийг дагалдуулан гаргасан хуруугаар дарсан мэт толбууд бөгөөд энэ нь тэрхүү зурсан амьтнаа олон дахин давтан зурахын оронд тэдгээр толбоор төлөөлүүлэн үзүүлдэг палеолитын үеийн урлагийн нэг онцгой шинж билээ.

Палеолитын үед хамаарах хадны сийлмэл зургууд Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгой, Буянт сумын Чандмань хар үзүүр, Увс аймгийн Сагил сумын Хад үзүүр, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад зэрэг газраас олдсон бөгөөд бүгдийг бодит байдлаар дүрсэлжээ.

Чандмань Хар үзүүрийн зураг. Ховд аймгийн Буянт сумын нутаг Ховд хотоос зүүн тийш 13 км-т голынхоо урд эрэгт орших өнчин ганц толгойг Чандмань Хар үзүүр гэж нэрлэх бөгөөд толгойн баруун талын том толигор хаднаа олон тооны амьтдын зургийг хонхойлон цохиж сийлсний зэрэгцээ түүний ар ба зүүн хажуугийн хаднаа цөөн зургийг цоолборложээ.

Энд гол төлөв сүрэг амьтдыг тэгш тольгор хаднаа дүрслэхдээ амьтны биеийн гадаад ерөнхий тэгийг хонхойлон гаргах, амьтны дүрийг бүх талбайгаар нь хонхойлон цохиж урлах, амьтны ерөнхий тэгийг гаргаад улмаар цээжин хэсгийг бүх талбайгаар нь хонхойлж их биений хэсэг хадыг хөндөлгүй орхих гурван барилыг хэрэглэсэн байна. Чандмань Хар үзүүрийн хадны зургийн гол сэдэв бол ан амьтан бөгөөд үүнд адуу, үхэр, буга, аргаль, янгир голлох ба чоно, үнэг, могой зэрэг амьтдыг ч цөөвтөр дүрсэлсэн байна.

Амьтдыг тайван, тогтуун байдалтай ихэд сүрлэгээр дүрсэлсний зэрэгцээ тэдгээр амьтдын эр, эм хүйсийг тод томруун гаргахдаа басхүү сонирхолтой аргыг хэрэглэсэн байна. Жишээлбэл: буга, үхэр, адууны эр хүйсийг танигдахаар дүрсэлж харин гүү зэрэг эх амьтны хүйс эрхтэнийг бус харин унага төлтэй нь хамт дүрсэлсэн ажиглагдана.

Харин эр амьтдыг хүйсний харалдаа доор дугуй хонхор гарган дүрсэлжээ. Дурдсан амьтдаас гадна ганц нэг хүн, тэмдэг зэргийг бас урласан тохиолдоно. Чандмань Хар үзүүрийн хадны зургийн сэдэв, сийлбэр дүрслэлийн арга барилаар төдийгүй зураг хонхойлж сийлсэн хад он удаанаар нар салхинд идэгдэж улмаар байгалийн хадны өнгөнөөс бараг ялгагдахгүй болсноос үзэхэд ч энд амьтдын зургийг сийлснээс хойш хэдэн мянган жил өнгөрсөн нь илэрхий.

Судлаачид Чандмань Хар үзүүрийн хадны сийлмэл зургийн дотроос үхэр, адуу, хандгай зэрэг амьтны зургийг чулуун зэвсгийн үед холбогдуулан үздэг. Эдгээр зургаас Чандмань Хар үзүүрийн хаданд сийлсэн нэгэн үхрийн зургийг төлөөлүүлэн авч үзье. Босоо том эвэртэй, урт биетэй, богино хөлтэй үхрийн ерөнхий тэгийг хонхойлон цохиж гаргаад, их биений хэсгийн доторхи талбайг хөндөлгүй товгор хэвээр үлдээсний гадна түүний гэдсэн доор нэгэн дугуй тэмдэг цохиж гаргасныг судлаачид амьтны “эм хүйс, үржлийг” бэлгэдсэн утгатай тэмдэг хэмээн тайлбарлаж улмаар ерөнхий дүрслэлийн байдлаар чулуун зэвсгийн үеийн шинжтэй зураг гэж үзсэн байна

Ишгэн толгойн хадны зураг. Монгол Алтайн нурууны ар биеэс эх авсан Урд Цэнхэр, Дунд Цэнхэр, Хойд Цэнхэрийн гурван гол Ховд аймгийн Манхан сумын төвийн орчимд нийлж урсах ба түүний хөндийд орших хоёр жижиг хадан толгойн нэг болох Ишгэн толгойн хаднаа үхэр, адуу, буга, янгир, тэмээ зэрэг амьтдын дүрсийг хадны толион дээр гол төлөв ганц нэгээр урласан байх бөгөөд зургийн сийлсэн өнгө хадны байгалийн өнгөнөөс бараг ялгарахгүй болж зөвхөн гараар тэмтрэхэд сийлмэл зурагтай болох нь мэдэгдэх төдий байна. Ишгэн толгойн хадны ихэнх зураг түүний хойт талд өөрөөр хэлбэл салхин талд нь зонхилсон байдалтай байна.

Ишгэн толгойн хаднаа нийт 150 дүрс сийлснээс хүн 1, адуу 18, үхэр 13, буга, хандгай, гөрөөс 19, тэмээ 1, янгир 17, аргаль 11, могой 5, бар 3, тэмдэг дүрс 9, чухам ямар амьтан болох нь тодорхой танигдахгүй амьтдын дүрс 53 байна. Энд дан зэрлэг амьтдыг дүрсэлсэн бөгөөд дүрслэхдээ амьтдын биеийн ерөнхий тэгийг хүрээлэн цохиж гаргах, бүх талбайг хонхойлон цохих хоёр үндсэн барилыг хэрэглэн тухайн амьтны дүрсийг бодит байдлаар харуулахдаа яг байгаагаар хуулбарлалгүй онцлог шинжийг нь цохон бодитойгоор дүрсэлж зарим эрхтэнүүдийг орхигдуулсан нь ч тохиолдоно. Үхрийн том эвэр, адууны чих, сүүл, бугын олон салаа эвэр, барын арьсны судал, тэмээний бөх зэргийг цохон урлахын зэрэгцээ, янгирын махир эврийг гоёмсог байдалтай нум хэлбэртэй гаргаж нуруунд хүргэлгүй дүрсэлсэн байхад аргалийн эврийг тал дугуй хэлбэрээр хүзүүтэй нь давхардуулан махирлуулсан байна.

Ишгэн толгойн хаднаа амьтны биеийн ерөнхий тэгийг хөвөөлөн цохиж зөвхөн толгойн хэсгийг бүх талбайгаар хонхойлон дүрсэлсэн буй нь Монголын чулуун зэвсгийн урлагийн нэгэн онцлог арга билээ.

Амьтдын ерөнхий тэгийг хөвөөлөн цохиж гаргаад түүний зүрхний харалдаа хонхойлон цохисон ба хүзүү нуруунаас доош хөндлөн зураас гаргаж хонхойлсон байх нь олонтой бөгөөд ийм барил Ховд аймгийн Чандмань Хар үзүүрийн зурагт мөн ажиглагддаг. Ишгэн толгой ба Чандмань Хар үзүүрийн зургийн аль алинд том адууны дэргэд жижиг адуу (унагатай гүү) дүрсэлсэн хийгээд энэ хоёр газрын хадны зураг нийт дүрсэлсэн амьтад, дүрслэлийн арга барил зэрэг бүхий л талаараа ижил төстэй зэргээрээ нэгэн үед хамаарах нь тодорхой юм.

Ишгэн толгойн зурагт амьтны гадаад тэгийг хөвөөлөн цохиж гаргаад түүний хэвлий, хөл хоёрыг залгалгүй дутуу орхисон тохиолдол байдаг. Үүнтэй ижил дүрсэлж буй амьтныхаа зарим хэсгийг дутуу орхисон зураг Хойт Цэнхэрийн агуй дахь хуучин чулуун зэвсгийн зосон зурагт мөн тааралддаг. Мөн аргаль, гөрөөс зэргийг Ишгэн толгой ба Хойт Цэнхэрийн агуйн зурагт тун адилхан зурсан ба аль алинд нь хоёр бөхтэй тэмээний зураг байна.

Ишгэн толгойн хаднаа могойн зураг нилээд хэд буй нь палеолитын үеийн зурагт элбэг тохиолддог дүрслэл билээ.

Амьтны хүйсний харалдаа доор зууван тэмдэг дүрсэлсэн зураг палеолитын үед холбогдох ОХУ-ын Шишкиний хясааны адуу, үхэр, бугын зурагт байдаг билээ. Үүнтэй ижил дүрсэлвэр Ишгэн толгой хийгээд Чандмань хар үзүүрийн зурагт байгаа бөгөөд түүнийг судлаачид эм амьтны хүйс, амьтдын үржлийг билэгдсэн тэмдэг хэмээн тайлбарладаг билээ.

Ишгэн толгойн хадны зураг нь Чандмань Хар үзүүрийн чулуун зэвсгийн үеийн зурагтай сэдэв, зохиомж, дүрслэлийн арга барил бүхий л талаар адил ба Хойт Цэнхэрийн агуй, Шишкиний хясааны палеолитын үеийн зурагтай гол гол үндсэн шинжээрээ ижилсэж байгаа тул зургийн сийлбэр, сийлсэн

арга барил, дүрсэлсэн амьтад зэргээр нь судлаачид эдгээр зургийг палеолитын дээд үед холбон үзэж байгаа юм.

Монгол орон түүний хөрш зэргэлдээ нутгаас урьд өмнө чулуун зэвсгийн үед холбогдох барын зураг олдож мэдэгдээгүй бөгөөд харин Ишгэн толгойн хаднаа дурдсан зэрлэг амьтдын хамт цөөн тоогоор барыг дүрсэлсэн нь сонирхолтой юм. Манай оронд палеолитын үед бар нутаглаж байснаас түүнийг үзсэн, мэддэг төдийгүй хад цохионоо дүрслэн үлдээжээ.

Хад үзүүрийн хадны зураг. Увс аймгийн Сагил сумын нутагт Монгол, Оросын хилийн заагаас 5 км орчим зайтай хойноос урагш сунаж тогтсон Хад үзүүр гэдэг хадтай жижиг хар толгойн чанх урд ба баруун урд талын хаданд янгир, буга, үхэр, адуу, чоно, хүн зэргийн зуу гаруй дүрсийг хонхойлон цохиж сийлсэн бөгөөд дүрслэлийн арга барил төдийгүй он цагийн хувьд өөр өөр үед холбогдох ажээ. Энд эртний зурган дээр хожуу үеийн зургийг давхарлуулан сийлсэн тохиолдол ч байна. Эдгээр зургаас зөвхөн палеолитын үед хамаарах цөөн зургийн тухай өгүүлэе.

Хад үзүүрийн урд талын хадны төв хэсэгт хамгийн тохиромжтой толигор хэсгийг эзлүүлэн нэгэн том үхрийн ерөнхий тэгийг хонхойлон цохиж бодит байдлаар дүрслэхдээ түүний сүүл, босоо эвэр, хоёр салаа омруу (хөөлүүр), эр хүйсийг цохон үзүүлсний гадна хэвлий дор нь зууван дугуй хонхор цохиж гаргасан байна. Энэ зураг бусдаас том бөгөөд дүрслэлийн арга барилын хувьд палеолитын үед холбогдоно.

Үхрийн дээд талд зүүн тийш явж буй таван үхрийг нэг эгнээ, тэдгээрийн дээгүүр баруун тийш явж буй хоёр үхрийг нэг эгнээ бүх талбайгаар нь хонхойлон цохиж дүрсэлжээ. Тус зургийн зүүн дээд талд зүүн тийш харсан нэг том үхрийн өөдөөс харсан хоёр үхрийг дүрсэлсэн байна. Эдгээр үхрийн салаа, омруу, эвэр зэргийг онцгойлон цохон үзүүлсний гадна тавыг нь нуруу ачаа буюу бөхтэй мэт дүрсэлсэн нь онц сонирхолтой бөгөөд харин дээрхи бухын зургаас хожуу үед холбогдох юм. Энэ зургийн баруун дээд талд хоншоороо чанх дээш өргөн хүзүүгээ нугалсан олон салаа эвэртэй том бугыг хэвтэж байгаагаар ихэд чадмаг урласан байна. Түүний дээрээс янгир, бугын жижиг дүрсийг хожим давхарлуулан хонхойлон цохиж дүрсэлжээ.

Хад үзүүрийн баруун талын ганц том хадны урд талын хавтгайд нэг том бугын дүрсийг бүх талбайгаар нь хонхойлон цохиж нилээд бодитой урлахдаа түүний хэвлий доор зууван хонхор цохиж гаргажээ.

Дурдсан үхэр, бугын хоёр том зураг бусдаас хэмжээгээр том төдийгүй тэдгээрийн зарим дээр нь хожуу (хүрэл зэвсгийн) үед буга, янгирын зургийг давхарлуулан сийлсэн, байршлын хувьд хадны хамгийн тохиромжтой зайг сонгон авсан зэрэг нь эдгээр зургийг сийлэхээс өмнө энэ хаданд өөр зураг сийлээгүй байсныг харуулахын зэрэгцээ бусад зургаас илүү эрт үед сийлсэн гэж үзэх боломжийг олгож байна.

Нөгөөтэйгүүр буга, үхрийн хэвлий доор зориуд зууван хонхор гаргаж дүрслэх нь палеолитын үеийн хадны зургийн тогтвортой нэг шинж билээ.

Бага Ойгор, Цагаан салаагийн зураг. Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Бага Ойгор, Цагаан салаа голын савд олон мянган хадны зураг байдаг бөгөөд үүний дотроос палеолитийн үед зарим зургууд холбогдоно.

Өөд өдөөсөө харсан хоёр арслан зааны дүрсийн гадна талаар нь хөвөөлөн цохиж хошууг дээш өлийлгөн богино хөлтэй, уртлаг биетэй дүрсэлжээ. Зүүн талын арслан зааны хажуу доор дугуй дүрс цохиж гаргажээ.

Эндээс холгүй өөр нэгэн хаданд, урт хошуугаа унжуулан зогсч буй арслан зааныг бөмбөгөр толгойтой, уртлаг биетэй, богино сүүлтэй дүрслэхдээ эр хүйсийг цохон үзүүлжээ. Түүний цээж өргөн урд хөл нь урт, хойд хөл нь богино юм.

Мөн Цагаан салаагийн нэгэн хаднаа урт хошуугаа унжуулан зогссон арслан зааныг дүрсэлжээ. Ийнхүү Монгол нутагт хуучин чулуун зэвсгийн үед амьдарч байгаад мөхөж сөнөсөн арслан зааны зураг шинээр нэмэн олдож буй нь энэ үеийн урлагийн дурсгалын тархцын хүрээг тэлж, улам баяжуулж байна.

Рашаан хадны зураг. Хэнтий аймгийн Батширээт сумын Хурх багийн нутаг Биндэр уулын зүүн урд хормойн цохиотой үзүүр болох Рашаан хад орчимд эртний булш олонтойн гадна түүний дэргэдээс палеолит ба неолитын үеийн чулуун зэвсэг, хүрэл, Хүннү, Кидан, Монгол гүрний үед холбогдох шавар сав, сумын зэв зэрэг олдвор элбэг олддог. Эндхийн хаднаа хуучин чулуун зэвсгийн үеэс эхлэн дундад зууны үеийг хүртэл ан амьтан, хүний зураг, хэдэн зуун тамга тэмдэг сийлж орхон-енисей, кидан, араб-перс, монгол, түвэд, манж зэрэг хорь орчим бичээс үлдээжээ.

Рашаан хаднаа түүхийн өөр өөр үед хамаарах хэдэн зуун тамга тэмдэг, хүн амьтны дүрс зураг нь байдаг бөгөөд хуучин чулуун зэвсгийн үед ч хамаарах зургууд байдаг. Рашаан хадны палеолитын үеийн зураг түүхийн хожуу үед холбогдох бусад зургаас дүрсэлсэн амьтан, дүрслэлийн арга барилаараа өвөрмөц юм. Үүнд, арслан заан, савгат хирс хожуу үеийн зургуудаас хэмжээгээрээ том төдийгүй, амьтдын дүрсний гадаад хүрээг харьцангуй өргөн гарган дүрсэлж, түүний ерөнхий төрхийг гаргахыг хичээснээс бус, түүнийг нарийн уртай, байгаа байдлыг яг хуулбарлан гаргахыг эрмэлзээгүй байдал ажиглагдаж байна.

Рашаан хадны баруун дээд наран талын ханан хаданд хэсэг амьтан дүрсэлсний хамгийн зүүн дээд талд өндөр сэрвээтэй, богино бүдүүн хөлтэй, урт хошуутай арслан зааны ерөнхий тэгийг

хөвөөлөн цохиж гарган зурсан байна. Тус хадны зүүнтэй хоорондоо давчиг зайтай хоёр том хавтгай ханан хад байгаагийн хойт талын хаданд богинохон модгор сүүлтэй, богино нарийвтар хөлтэй салаа туурайтай амьтны дүрсийг бүх талбайгаар хонхойлон цохиж сийлжээ. Энэхүү амьтны цээжин хэсгийг анхнаас нь огт дүрслэлгүй орхисон байна.

Рашаан хадны “олон зуун тамгат хавтангаас” зүүнтэй орших нэгэн том хавтгай хадны наран талын хавтгайд зүүн тийш сүрэглэн явж буй байдалтай гурван том амьтныг дүрсэлжээ. Эдгээр нь сүрлэг том биетэй, богино хөлтэй, хоншоороосоо дээш ээтийж гарсан соёо мэт эвэртэй савагт хирс бөгөөд тэд дөрөвдөгч галбын мөстлөгийн сүүлчийн үед манай оронд амьдарч байгаад мөхөж үгүй болсон юм. Монгол, Оросын эрдэмтэд Рашаан хадны палеолит, мезолитын үеийн сууринг малтан шинжлэх явцад 1,5 м гүнээс савагт хирсний шүд олдсон нь тэрхүү амьтан тухайн нутагт амьдарч байсныг давхар баталж байна.

Судлаачид, Рашаан хадны зургуудыг судлан палеолитын үед хамааруулан үзэж “Ази тивийн энэ хэсэгт их эрт үед хүн нутаглаж, орон нутгийн бат бэх уламжлалтай олон мянган жилийн турш хөгжсөн палеолитын соёлын нэгэн голомт байсан” хэмээх дүгнэлтэд хүрчээ.

§ 5. ПАЛЕОЛИТЫН ҮЕИЙН АЖ АХУЙ, НИЙГЭМ СОЁЛЫН АСУУДАЛ

Палеолитын үеийн түүхийн ээдрээтэй асуудлуудын нэг бол хүн төрөлхтний анхны нийгмийг түүхэн үүднээс сэргээн ойлгох асуудал юм. Энэ тухай шууд гэрчлэх баримт ховор байдаг тул, хөндлөнгийн баримтанд түшиглэн, тэдгээрийг харьцуулан жиших байдлаар төсөөлдөг ажээ. Олон орны эрдэмтдийн судалгаагаар хүй нэгдлийн хүмүүс эхлээд олон зуун мянган жилийн турш сүргээрээ амьдарч байсан гэж үздэг байна. Энэ үе нь хүн анх хөдөлмөрийн багаж зэвсгийг зохион хийх болсон үеэс эхлээд овгийн байгуулалтай болсон хүртлэх үеийг өөрөөр хэлбэл доод палеолитоос аваад мустьегээс дээд палеолитод шилжих үеийг хамардаг байна. Дээд палеолитын үед эхийн шугамаар төрөлсөх эхийн эрхт овог үүсч хөгжсөөр аажимдаа хүрэл зэвсгийн үед эцгийн эрхт овгоор солигдсон ажээ.

Палеолитын үеийн хүмүүсийн эрхлэх гол аж ахуй нь үр, үндэс түүх аж ахуй, ангийн аж ахуй хоёр байжээ. Том амьтадаас гадна хээр талын жижиг амьтадыг хүнс тэжээлдээ хэрэглэж байснаас гадна үр жимс зэрэг ургамлын төрлийн зүйлийг түүх ажил тэр үеийн хүмүүсийн амьдралд багагүй үүрэг гүйцэтгэж байв. Үр үндэс түүх аж ахуй урт удаан хугацаа шаардсан, ихэнх хүмүүс эрхэлж болох бөгөөд харьцангуй хялбар байсан байна. Доод палеолитын үеийн хүн мичин хүнээс хол тасарч орчин үеийн хүн болох шатанд байсан боловч түүний хөдөлмөрийн үйл ажиллагаа, дадлага туршлага тун ядуу байсан тул хамтран хөдөлмөрлөх, хөдөлмөрийн үр шим, багаж зэвсгээ хамтран хэрэглэх шаардлага аяндаа гарчээ. Энэ нь ганц нэгээрээ том амьтад тэр тусмаа сүрэг амьтдыг агнах бололцоогүй тул юуны өмнө ан амьтныг хамт олноороо агнах явдлаар илрэлээ олж байжээ. Дөрөвдөгч галавын үед хэдийгээр дэлхий нийтээр мөстлөг эхлэж хүйтэрч байсан боловч манай орны, ялангуяа төв, өмнөд, дорнод хэсэг одоогийнхоос харьцангуй их чийглэг, урин дулаан уур амьсгалтай, хаяагүй их бороо орж, олон гол горхи, нуур цөөрөм, өвс ургамал ихтэй тал ба ойт тал байсан бөгөөд байгалийн ийм таатай нөхцөлд амьдарч байсан арслан заан, савгат хирс, зэрлэг үхэр, адуу, буга, тэмээ, янгир зэрэг амьтад нутаглаж байжээ.

Ангийн аж ахуй, нэн ялангуяа их мах, бүтээгдэхүүн өгөх том анг агнах нь дандаа олз омогтой байдаггүй, ихээхэн хүнд амь дүйсэн ажил боловч, хэрвээ томоохон ан агнавал, олон хүн идэж цадах хоолтой болох харьцангуй илүү ашигтай байжээ. Эртний хүмүүс олуулаа нийлж том амьтныг зээглэн хөөж, дуу шуугиан гарган хашгирч, гал гаргах, чулуу, модоор шидэх зэргээр үргээж айлган хадан хясаа, хавцал, эрэг, ганга, зориуд ухсан гүн нүхэнд шахаж оруулах, унагах зэргээр хорьж, мод, чулуугаар цохиж алдаг байжээ. Олуулаа хийсэн ав хомрого нь махан хоолыг ахиухан олж авах гол арга байсан. Олуулаа нийлж томоохон ан агнаж их хэмжээний махан хоолтой болох нь хүй нэгдлийн хүн сүргийн гишүүдийг хөдөлмөрлөх явцдаа зохион байгуулалттай, нэгдэж хамтрах нь ашигтай болохыг харуулж байсан ажээ. Том амьтнаас гадна тарвага, зурам болон янз бүрийн шувуу, загас жараахай идэж болох бүхий л амьтдын махаар хооллож, арьс үсийг ашигладаг байжээ. Ангийн мах нь хүний биед онц чухал шаардлагатай уураг, өөх, нүүрстөрөгчийг агуулсан хоол болоод зогсохгүй, ялангуяа болсон махыг идсэнээр хүний өсөлт түргэсч амьдрах чадвар нь дээшилсэн болохыг эрдэмтэд тогтоожээ.

Монгол нутагт чулуун зэвсгийн үед амьдрагсад дөрөвдөгч галавын эхэн үед монгол нутагт амьдарч байгаад мөхсөн арслан заан, савагт хирс, тэмээн хяруул, хэд хэдэн төрлийн буга, үхэр, өнөөг хүртэл монгол нутагт амьдарсаар ирсэн тэмээ, тахь, хулан, аргаль, янгир, бөхөн, зээр, гөрөөс, тарвага, үнэг, хярс, мануул, ирвэс, шилүүс, хэрэм зэрэг ан амьтныг агнаж, тэдгээрийн махыг идэж, арьс үсээр нь дээл, гутал, хувцас хийж өмсч хэрэглэж байсан ба дээрх амьтдын нилээдийг палеолит, мезолит, неолитын үеийн хадны зурагт түгээмэл дүрсэлсэн байна. Тухайлбал, арслан зааныг Хойт Цэнхэрийн агуй Рашаан хад, Цагаан салаа, Бага ойгорын палеолитын үеийн хадны зурагт дүрсэлсэн байдаг бөгөөд манай улсын Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Төв, Булган, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгийн нутгаас түүний яс олдсон төдийгүй Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт буй Орхон-7

хэмээх хуучин чулуун зэвсгийн бууцыг малтахад арслан заан, буга, зэрэг амьтдын яс чулуун зэвсгийн хамт соёлт давхрагаас олдсон юм. Мөн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хадны палеолит, мезолит, неолитын үеийн олон соёлт давхрага бүхий сууринг малтаж шинжлэхэд 1,5 м гүнээс чулуун зэвсгийн хамт савагт хирсийн шүд олдсон ба тэндээс хэдхэн алхамын зайтай нэгэн хавтгай хаднаа зүүн тийш сүрэглэж яваа гурван савагт хирсийг ихэд бодитой дүрсэлсэн байдаг бөгөөд тэдгээрийг эртний хүмүүс агнаж иддэг байсан нь тодорхой. Хойт Цэнхэрийн агуйд амьдарч байсан хүмүүс агуйнхаа хананд тэмээн хяруулыг дүрсэлж зураад тэднийг өсч үржин олон болог гэсэн утга санаагаа олон зэрэгцээ толбоор дүрсэлсэн байна. Мөн палеолит ба мезолитын үед монгол оронд амьдарч байгаад мөхөж үгүй болсон одоо Австрали тивд амьдардагтай ижил тэмээн хяруулын өндөгний хальс эрт ба дундад чулуун зэвсгийн үеийн суурингуудаас элбэг олддог бөгөөд тэднийг хүнсэнд хэрэглэж байсан нь тодорхой. Тэр үед Монгол орны цаг агаар харьцангуй дулаан, чийглэг уур амьсгалтай, нуур гол мөрний ус элбэг, самар жимстэй мод, хүмүүсийн идэх боломжтой үр үндэс бүхий ургамлаар илүү баялаг байсныг палеолитын үеийн суурингуудыг малтан шинжлэхэд гарсан хөрсний шорооноос илрүүлэн судалсан ургамлын тоосонцорууд гэрчилдэг.

Палеолитын үеийн хүмүүс уул хадны нөмөр, агуй зэрэг нөмөр дулаан, уух устай, ан амьтан, идэх үр жимс элбэг, байгалийн тохиромжтой нөхцөл бүрдсэн газрыг олж тэндээ хэдэн үеийн турш урт удаан хугацаагаар аж төрөн суудаг байжээ. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам, Орхон-7, Хэнтий аймгийн Рашаан хад, Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг Чихэн агуй зэрэг газарт малтан шинжилсэн хуучин ба дундад чулуун зэвсгийн үеийн олон соёлт давхрага бүхий сууринд хүн урт удаан хугацаагаар олон үе дамжин сууж байсныг гэрчлэх олон мянган чулуун зэвсэг, амьтдын яс, гал голомтын ор мөр илэрч олдсон байна. Монгол орноос олдсон чулуун зэвсгийн дурсгалуудыг бусад орны мөн үеийн дурсгалуудыг судалж, гарсан үр дүнтэй харьцуулан үзэж төсөөлөхөд тэр үед өвгөд хөгшид, эмэгтэйчүүд хүүхдийнхээ хамтаар гал голомтоо сахиж, хүч чадалтай нь хол ойр явж, ан агнуур хийдэг байжээ.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

БНМАУ-ын түүх. 3 боть. 1-р боть. УБ., 1966.

Деревянко А.П., Дорж Д., Васильевский Р.С., Ларичев В.Е., Петрин В.Т., Девяткин Е.В., Малаева Е.М. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск., 1990.

Деревянко А.П., Олсен Д., Цэвээндорж Д., Петрин В.Т., Зенин А.Н., Кривошапкин А.И., Ривс Р.У., Девяткин Е.В., Мыльников В.П., Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1995 году. Новосибирск, 1996.

Деревянко А.П., Олсен Д., Цэвээндорж Д., Петрин В.Т., Зенин А.Н., В.П., Кривошапкин А.И., Николаев С.В., Мыльников В.П., Ривс Р.У., Гунчинсүрэн Б., Цэрэндагва Я. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1996 году. Новосибирск, 1998.

Деревянко А.П., Олсен Д., Цэвээндорж Д., Петрин В.Т., Гладышев С.В., Зенин А.Н., Мыльников В.П., Кривошапкин А.И., Брантингхем А.И., Гунчинсүрэн Б., Цэрэндагва Я. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1997-1998 годах. Новосибирск, 1999.

Деревянко А.П., Олсен Ж., Цэвээндорж Д., Петрин В.Т., Периодизация и хронология палеолита в Монголии // SA. t 18. f.2. - УБ., 1998, - тал 8-18.

Деревянко А.П., Цэвээндорж Д., Петрин В.Т., Ларичев В.Е., Васильевский Р.С., Гладышев С.В., Зенин А.Н., Девяткин Е.В. Палеолит и неолит Северного побережья Долины Озер Новосибирск, 2000

Дорж Д. Нижний палеолит Монголии и его место в древнем каменном веке Центральной Азии. ОУМЭ-ийн III их хуралд тавьсан илтгэл. // УБ., 1976.

Дорж Д. Монголын доод палеолитийн тухай асуудалд. // ШУАМ. '3. 1977.

Дорж Д. Из истории исследования палеолита Монголии. // SH. t. 24. f.8. - УБ., 1990. - тал 65-87.

Дорж Д., Цэвээндорж Д. Монголын палеолит. - УБ., 1978.

Дорж Д., Новгородова Э.А. Петроглифы Монголии. УБ., 1975

Доржсүрэн Ц. БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсэг судлалын байдал. -УБ. 1957.

Монголын түүх. 5 боть. 1-р боть. УБ., 2002 (хэвлэлд).

Окладников А.П. Новые данные по древнейшей истории Монголии // Вестник древней истории. -1951. 14

Окладников А.П. Первобытная Монголия. // SA. т.3. fasc. 8-10. УБ., 1964. -тал 3-23.

А.П.Окладников. Палеолит Центральной Азии. Мойлтын ам (Монголия). -Новосибирск 1981.

Окладников А.П. Палеолит Монголии. -Новосибирск, 1986.

Окладников А.П. Петроглифы Монголии. -Л., 1981.

Окладников А.П. Петроглифы Центральной Азии. -Л., 1980.

Окладников А.П. Древнейшие петроглифы Аршан-хада // Пластика и рисунки древних культур. Новосибирск, 1983. стр. 27-33

Окладников А.П., Васильевский Р.С. Новые исследования Аршан хаде в Монголии // Из.СО. АН.СССР.'16 вып.2 серия общественных наук. 1982. -С. 105-109.

Окладников А.П., Цэвээндорж Д. Монголын палеолитын урлагийн шинэ дурсгал // ШУАМ. 1 2. -тал 57-61

Ларичев В.Е. Палеолит Северной и Центральной Азии. -Новосибирск., 1967.

Цогтбаатар Б. Ханангийн чулуун зэвсгийн дурсгал. // SA. t 14. f.3. - УБ., 1994, - тал

Цогтбаатар Б. Дорнод Монголын чулуун зэвсгийн судалгаа (палеолитийн үе) // SA. t 15. f.2. - УБ., 1995, - тал 17-30.

Цогтбаатар Б. Буга Хайрханы хуучин чулуун зэвсгийн дурсгал // SA. t 18. f.4. - УБ., 1998, - тал 27-38.

Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал - УБ., 1983.

Цэвээндорж Д. Олон үеийн дурсгалт Рашаан хад // ШУА 1988. 11.- тал 64-66

Цэвээндорж Д. Ишгэн толгойн хадны зураг // АС. АС. t. X, f. 2. -УБ., 1982.-тал 6-21

Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх -УБ., 1999.

Цэрэндагва Я. Түйн голын хөндийн палеолитийн дурсгалуудын он цагийн хамаадлын асуудалд. // SA. t ХҮIII. f.3. - УБ., 1998, - тал 19-26.

МЕЗОЛИТ, НЕОЛИТЫН ҮЕ

§ 1. МЕЗОЛИТЫН ҮЕ

Хуучин чулуун зэвсгийн дараагийн үеийг дундад чулуун зэвсгийн үе буюу мезолит (12.000-7.000 жил) гэж нэрлэдэг ба палеолитоос неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед шилжих шилжилтийн үе болно. Мезолит гэдэг нь мезос-дунд, литос-чулуу гэсэн эртний грек үгнээс гаралтай. Палеолит, мезолит хоёрын зааг ялгаа, чухам яг хэдий үед мезолитод шилжив гэдэг асуудал дээр олон орны судлаачид санал зөрөлдөөнтэй байдаг. Гэвч энэ бол зөвхөн тухайн бүс нутгийн онцлогоос л үндэслэн гарч байгаа асуудал юм.

XIX зууны төгсгөл буюу 1887 онд Э.Пьет Францын Маз-д Азиль хэмээх агуйгаас өвөрмөц хэлбэрийн чулуун зэвсгийн дурсгалуудыг олж илрүүлснээс хойш мезолитын асуудал хүчтэй яригдах болжээ. Мезолитын үе нь бүхий л шинж чанараараа шилжилтийн гэдэг нь харагддаг. Мөстлөгө дуусч, цаг агаар дулаарч, ургамал, амьтны аймагт ч өөрчлөлт орж, ингэснээрээ хүмүүсийн амьдрал ахуйд ч тодорхой ахиц дэвшил гарсан байна. Мезолитын үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдаж, хүн төрлөхтний зэр зэвсгийн үйлдвэрлэлийн түүхэнд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн, модны уян хатан шинжийг ашиглаж хийсэн холын тусгалтай зэвсэг болох нум сумыг анх зохион бүтээж бий болгожээ.

Энэ үед Умард Ази, Өрнөд ба Дорнод Европод түрж орсон их мөстлөгийн үе нэгэнт дуусаж цаг агаар эрс зөөлөрч Умард Ази (Сибирь) их ойт бүс, Төв Азийн байгал газар зүйн байдал, амьтан ургамлын аймаг орчин үеийн төрхийг олсон байна.

Байгаль газар зүйн байдал өөрчлөгдөхийн зэрэгцээ чулуун зэвсэг хийх арга барил цаашид улам сайжирч дээд палеолитын үеийн баргил зэвсгийн хамт ур хийц сайтай бичил чулуун зэвсэг хийх явдал зонхилох болжээ. Бага хэмжээний үлдэцээс нарийн жижиг ялтас цуулан авч хажуу талыг нь зориуд ирлэн мод ясаар хийсэн ишинд түүнийг суулгаж бэхэлсэн зуулга зэвсэг, ялтас ба ялтсан залтсаар хийсэн хусуур, хутган ялтасаар хийсэн үзүүр мэс, сумны ялтсан зэв зэргийг хийж хэрэглэх болсон байна.

Мезолитын үед хүний эдийн болон оюуны соёл, аж ахуйд өмнөх үеэс чанарын шинэ өөрчлөлт гарч энэ үеийн хүн байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг эзэмшихээс гадна газар тариалан, мал аж ахуй буюу үйлдвэрлэх аж ахуйд дэвшин орох эх суурийг тавьсан байна. Тухайлбал, энэ үед гарсан нэг онцлог шинж нь дээр дурдсан зүймэл зэвсгээс гадна нум сумыг анх ухаалан зохиосон явдал болно.

Манай орны Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Дорнод аймгийн Халх гол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаан хад (II-III үе), Дорноговь аймгийн Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун, Зүүн хайрхан уул болон Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн зарим газраас мезолитын үеийн дурсгалыг илрүүлэн судалжээ.

Чихэн агуйн дурсгалыг Монгол-Орос-Америкийн чулуун зэвсэг судлаачид 1997-2000 онд малтан шинжилж чухал үр дүнд хүрсэн юм. Агуй нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төвөөс хойш 30 км-т, Баян-Өндөр сумын нутагт оршино. Агуйн ам нь зүүн өмнө зүг хандсан бөгөөд өдрийн ихэнх хугацаанд нарны гэрэл сайн тусах ба үүд рүүгээ налуу. Урт нь 9,5 м, өргөн нь 5 м, өндөр нь 2 м, харьцангуй том биш боловч уулын өвөр наран талд орших, дэргэдээ булагтай, ан амьтан шахаж агнах хадан хавцал ганганд ойр орших хүн амьдрахад туйлын тохиромжтой нөхцөл бүхий агуй юм. Эл агуйг малтан судлах явцад ихээхэн хэмжээний чулуун зэвсгийн зүйл, урт удаан хугацаанд гал түлж байсан ором, амьтны яс болон ургамлын үлдэгдэл бүхий хүний амьдралын ул мөрийг хадгалсан дөрвөн соёлт давхарга илэрсэн. Эдгээр давхаргаас анхдагч болон хоёр дахь шатны боловсруулалт хийгдсэн олон төрлийн, хэдэн мянган чулуун зэвсгийн олдвор олдсон юм. Тэдгээр нь өөрийн өвөрмөц онцлог, ангиллын хувьд бичил ялтсан зэвсгийн төрөлд хамаарах бөгөөд ер нь ялтсан зэвсгийн үйлдвэрлэл энэ суурингийн гол цөм байжээ. Цөөн тооны хусууруудыг хийхэд том хэмжээний ялтас болон ялтсан залтсыг ашигласнаас бусад тохиолдолд жижиг ялтсуудаар зэвсгээ хийж байжээ. Мөн энд амьдарч байсан хүмүүс зуулга ир бүхий зэвсэг хийхийг гол зорилгоо болгож, элсэрхэг цахиур чулуу, хас, маньг өргөн ашиглаж байсан аж.

Эхний гурван давхаргын он цагийг гал голомтны үлдэгдлээс авсан нүүрсэнд хийсэн радиокарбоны шинжилгээгээр тогтооход нэгдүгээр давхарга нь 8.055 ± 155 , хоёрдугаар нь 8.940 ± 100 , гуравдугаар нь 11.160 ± 160 жилийн өмнөх үед холбогдохоор тогтоогдсон нь эрдэм шинжилгээний их ач холбогдолтой юм. Учир нь урьд өмнө Монгол нутгаас олдож байсан Чихэн агуйн эдлэлүүдтэй адил арга технологийн үйлдсэн шаантган үлдэц, ялтсан зуулга иртэй зэвсэг бүхий нээлттэй суурингуудын дурсгалыг он цагийнх нь хувьд неолитын үед хамааруулан үзэж, 6-7 мянган жилээс хэтрүүлэхгүйгээр тогтоож байв. Харин Чихэн агуйд хийсэн малтлага судалгааны дүнд Монгол оронд бичил чулуун зэвсгийн үйлдвэрлэл палеолитын дээд шатны төгсгөлд бий болжээ гэж үзэх бололцоог олгосон билээ.

Монгол орны мезолитын үеийн дурсгал дотор Хэрээ уулын суурин онцгой байр суурь эзэлдэг болно. Хэрээ уулын бууцыг малтахад хүрэн ба цайвар хүрэн цахиураар хийсэн говийн үлдэц, түүнийг хийхэд зориулсан бэлдэц, ялтас ба ялтсан залтасаар хийсэн гөвгөр иртэй дөрвөлжиндүү хусуур,

хавтгай хар занарлаг чулуугаар хийж нэг талыг нь ирлэсэн нутгийн өвөрмөц эдлэл болох хутга (хянгар), хутган ялтасаар хийсэн булангийн ба шөвгөн эсгүүр, үлдэц чулууг засах үед хагарсан хажуу ба хотгор цуулдас, захыг нь сэлтлэн ирлэсэн буюу ирлээгүй гурвалжин хэлбэрийн том жижиг хутган ялтас, говийн үлдэцнээс цуулсан бичил ялтас, хугадас маягийн эдлэлүүд олджээ. Эдгээрээс огт өөр арга барилаар хийгдсэн зэвсгийн зүйл Хэрлэн голын IX бууцнаас илэрсэн бөгөөд түүнийг малтахад саарал, цайвар шар, ногоон өнгийн ялтасаар хийсэн нэлээд тооны сумны зэв гарсан байна. Ийм төрлийн сумын ялтсан зэв Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Гүрмийн нуур, Батхаан уул, Дорноговь аймгийн Дулааны говь зэрэг газраас олдсон байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын төвөөс баруун урагш 50 км-д Дулааны говь хэмээх элсэн довцгууд, загийн шугуйтай хотгор газар байх бөгөөд эргэн тойрон уулаар хүрээлэгдсэн энэ газар бол эртний нуурын сав байсан ажээ. Энэхүү дурсгалт газрыг судалсны үр дүнд археологи, палеонтологийн үлдэгдэл олдворыг агуулсан хөрсний 12 соёлт давхаргыг илрүүлэн олсон байна. Дээрхи давхаргууд янз бүрийн гарал үүслийн хурдас чулуулгийг агуулах ажээ.

Дулааны говиос олдсон чулуун зэвсгийг саарал, цайвар шар, ногоон өнгийн ялтасаар хийсэн байгаа бөгөөд тэдгээрийг төрөл зориулалтаар нь авч үзвэл, үлдэц, сумны зэв, чулуун шөвөг, ир бүхий ялтас, хусуур, хянгар, хутга, ооль хэлбэрийн зэвсэг, үзүүр мэс, залтас, тариа цайруулах зориулалтын нүдүүр, нухуур, самбар, чулуу (эдгээр нь Монгол нутагт эрт үеэс газар тариалан тодорхой хэмжээгээр хөгжиж байсны баталгаа болно), хүрэл хутга зэрэг болно.

Дулааны говиос олдсон чулуун зэвсгийн дотроос хамгийн олон тоотойгоор олдсон зэвсэг нь сумны зэв билээ. Эндээс нийтдээ сумын 20 ширхэг зэв олдсоныг хэлбэр төрхийн хувь ангилвал, ялтсан зууван урт зэв зургаа, навчин хэлбэрийн зэв нэг, гурвалжин хэлбэрийн зэв 13 ширхэг болж байна. Ялтсан зэвүүд нь нэг, хоёр талсттай нарийн урт хутган ялтасны үзүүр, мөн хоёр хажуу ирмэгийг ар талаас нь жигд ирлэж зассан бөгөөд хөндлөн огтлол нь гурвалжин ба дөрвөн өнцөгт хэлбэрийг үүсгэж байна. Ийм төрлийн зэвүүдийг үйлдсэн арга хэлбэрийнх нь хувьд мезолитын сүүлч, неолитын түрүү үе (М.Э.Ө V мянган жил)-д холбон үздэг байхад навчин хэлбэрийн зэв нь ялтасны хоёр талаас засаж хийсэн, хөндлөн огтлол нь ромбо хэлбэртэй. Ийм төрлийн зэвүүд М.Э.Ө III мянган жилийн эхэн үед хамаарах нь нэгэнт тогтоогдоод байгаа билээ.

Гурвалжин зэвүүд нь нимгэн ялтасны хоёр талын хоёр ирмэгээс нь маш нарийн жигд холтолж зассан, хөндлөн огтлол нь ромбо хэлбэртэй, суурь нь тэгш байна. Энэ төрхийн зэвтэй ижилсэх төрлийн олдвор он цагийн хувьд М.Э.Ө. III мянган жилийн сүүлч, II жилийн эхэн үед хамаарч байна.

Манай орны мезолитын үеийн бууц суурингаас олдсон олон төрлийн чулуун зэвсгийн дотроос дээд палеолитын эцэст бий болж, неолитын түрүү үеийг хүртэл хэрэглэгдэж байсан говийн үлдэц нь Монголын мезолитын үеийн үйлдвэрлэлийн өвөрмөц арга барилыг илэрхийлдэг юм. Говийн үлдэцнээс тархсан газар нутгийг үзэхэд тэр нь баруун зүгт Дорнод Памир, умар зүгт Якут, дорно зүгт Япон хүртэл тархсан байна. Өөрөөр хэлбэл, говийн үлдэц нь тус орны мезолитын өвөрмөц шинж чанартай эсгүүр, Хэрээ уулын хутга, хотгор хажуу цуулдас, бичил ялтас, хугадас маягийн зэвсгийн хамт Сибирь, Якут, Чита муж, Дорнод Тэнгисийн хавь нутаг, Камчатка, Сахалин, Алеутын арлууд, Аляск, Японы дээд палеолит, мезолит, түрүү неолитын үеийн бууц суурингуудад өргөн тархжээ.

Ийнхүү Монголын мезолитын соёлын үндсэн гол элементүүд дурдсан газар нутагт байгаа нь Төв Азийн гүнээс Сибирь, Берингийн хоолойг дамжин Умард Америк болон Японы арлууд хүртэл хүн нүүдэллэсэн буюу угсаатны шилжилт явагдсаны гэрч юм. Монгол нутгаас олдсон мезолитын үеийн чулуун зэвсгүүд Аляскийн Онион суурин болон Орегон, Аризоны нутгаас олдсон чулуун зэвсгүүдтэй ижил төстэй байгаа нь Төв Азиас Умарт Америкт хүн нүүдэллэн очиж нутагласан болохыг харуулж буй баримт болно.

Мезолитын үеийн хүн амын тодорхой хэсэг ингэж нутаг сэлгэн ойр хол газар нүүдэллэн суух болсон хийгээд үйлдвэрлэлийн хэрэгсэл болох чулуун зэвсэг хийх арга нь урьд үеийнхээс эрс сайжирсан нь тэр үеийн хүний нийгмийн амьдралд зохих нөлөө үзүүлсэн байна.

Шинэ газар нутаг эзэмшихтэй холбогдож хуучин овог задрах, шинэ овог үүсэх зэрэг хүй нэгдлийн овог бүлгийн бүтцэд зарим нэг өөрчлөлт гарснаас гадна зуулга эдлэл тогтонги нэг хэвийн болж, нум сум гарч, модон эдлэл хийх тусгай зориулалттай зэвсэг бий болсон нь агнуурын ажлыг ихэд хөнгөлж хүмүүс палеолитын үеийнхтэй адил бус зэрлэг үр үндэс түүж, ургамлыг гар хадуураар хадаж, ан амьтдыг нум сумаар агнах болжээ. Харин зарим нутагт мезолитын үед ан агнуурын шинэ хэлбэр болох загасчлах ажил илүү хөгжиж сөрөгт жад, сэрээ, дэгээ, амьтны сүүлний үсээр хийсэн тороор загас агнан суурин амьдралд шилжих болсонтой холбогдон хүмүүс дахин олон хүн бүхий овог болон нэгдэх болжээ.

Хэдийгээр ан агнах хөдөлгөөнт амьдралын эрхээр цөөн хүнтэй олон овог бүрдэж буй боловч нийгмийн харилцааны хувьд урьдын адил хамтын хөдөлмөрт үндэслэсэн нийтийн өмч бүхий харилцаа хэвээр зонхилж байв. Хамтын өмчид юуны өмнө үйлдвэрлэлийн гол хэрэгсэл болох ан амьтнаар баялаг тодорхой газар нутаг, загас элбэгтэй гол мөрөн нуур бүхий нутгийг сонгон нутаглаж орон сууц, зэвсэг зэрэг өдөр тутмын хэрэгцээний аливаа зүйлсийг хамт олноороо буюу ганц нэгээрээ олсон зүйлийг цөм адил тэгш хувааж эзэмшдэг зарчимтай байжээ. Мезолитын үе нь аж ахуйн хэв шинж, нийгмийн байгууллын хувьд дээд палеолитын үетэй адил бөгөөд энэ үеийн гол агуулга нь хүй

нэгдлийн байгууллын дараагийн шат болох неолитод шилжих, газар тариалан, мал аж ахуй үүсэх бэлтгэлийн үе болсонд оршино.

§ 2. МЕЗОЛИТЫН ҮЕИЙН УРЛАГ

Мезолитийн үеийн археологийн дурсгалууд дотор хадны зураг онцгой байр суурь эзэлдэг. Манай орны нутаг дэвсгэр дээрээс энэ үед холбогдох хэд хэдэн хадны зураг олноор байдаг.

Рашаан хадны тамга дүрс. Рашаан хадны зүүн ёроолд орших 6 м урт, 2-3 м өргөн, 60-70 см зузаан том хавтгай хадны өвөр талд 180-аад, ар талд 40-өөд, сэрвээн дээр нь 50-иад, нийт 270-аад тэмдэг дүрс сийлжээ. Түүнээс гадна тэр орчим хаданд энд тэнд хэсэг бүлгээр нь 220 орчим тамга буюу нийтдээ 500-гаад тамга сийлсэн байна.

Мөн Рашаан хадны хойт талд зэргэлдээ орших Үзүүр цохионы хаданд мөн 200 гаруй тамгыг хонхойлон цохиж үйлдсэн нь хийсэн арга барил, хэлбэр төрхөөрөө ижил төстэй. Энд хийсэн судалгааны явцад Рашаан хад нь археологийн 4 соёлт давхаргатай болох нь тогтоогдсон. Тэдгээрийн өнгөн хөрсний давхрага нь 20 см зузаан, нэг дэх соёлт давхарга 14-37 см гүн, хоёр дахь соёлт давхрага 65-160 см гүн, дээд палеолит, мезолитын чулуун зэвсгийг агуулсан ба Рашаан хадны олон зуун тамгатай чулуу самбарын тамга дүрсэлсэн хэсгийг бүрхсэн байлаа. Харин хамгийн доод буюу гурав дахь соёлт давхарга нь 160-220 см гүн хавтангийн доод ирмэг болох тамга дүрслээгүй хэсгийг хучсан байв. Иймээс Рашаан хадны тамган дүрсийг дээд палеолитын төгсгөл, мезолитын эхэн үед анх дүрслэгдэж эхлэн дараагийн олон үед уламжлагджээ.

Можоогийн хадны зураг. Увс аймгийн Сагил сумын Түргэний нурууны ар биеийн салбар уулаас эх авч Үүрэг нуурт баруунтайгаас цутгах уулын нарийн голыг Цагаан гол гэнэ. Цагаан голын нарийн хөндийн бараг эхэнд хойноос уруудсан хоёр салаа амны уулзварт буй хадтай хошууг Можоо гэж нэрлэнэ. Можоо нь ногоон саарал, саарал өнгийн хадтай бөгөөд тэнд аргаль, янгир, тэмээ, хүн, нохой, үхэр зэргийг ганц нэг ба хэсэг бүлгээр нь сийлсэн хэдэн зуун зурагтай. Эдгээр зургаас мезолитын үед хамруулан үздэг зургийн тухай өгүүлэе.

Можоогийн хадны зургийн дотроос хамгийн том тэгш талбай бүхий баруун тийш харсан хэвтээ хаданд (4 x 8 м) арав гаруй том үхэр, тэдний зай завсарт хожим хорь гаруй янгир, нохой зэрэг амьтныг дүрсэлсэн зураг байдаг. Энд гол төлөв данхар том эвэртэй эр үхрийг ихэд, бодит байдлаар дүрслэхдээ түүний эвэр, эр хүйсийг цохон үзүүлжээ. Зарим үхрийн хэвлий, цээжний доор “үржлийг” бэлэгдсэн утгатай дугуй хонхор цохиж гаргасан буй нь палеолитын үед өргөн тархсан дүрслэлийн нэг арга билээ.

Энэ зурагт данхар том эвэртэй үхрийг нум сумаар харваж буй хүн, үхэр хөтлөөд явж буй хүнийг дүрсэлсэн байгаа нь түүний он цагийг тогтоох чухал баримт юм. Модны уян хатан чанарыг хүн ашиглан сэдэж хийсэн анхны холын тусгалтай зэвсэг болох нум сумыг мезолитын үеэс эхлэн хийж хэрэглэж байсныг Евразийн олон газар, түүнчлэн манай орноос олдсон сумын чулуун зэвүүд гэрчилдэг билээ. Тэгвэл энд хүн үхрийг хөтлөөд явж буйгаас үзэхэд энэ зургийг зурах үед үхрийг гаршуулсан байжээ гэж үзэх үндэстэй юм.

Энэ зурагт “үржлийг” бэлэгдсэн тэмдэг бүхий палеолитын үеийн уламжлалт арга, нум сумаар зэрлэг үхэр агнаж буй болон ан агнуур, үхрийг эхлэж гаршуулсан дунд чулуун зэвсгийн аж ахуйн сэдэв хамт нэг дор тусгагдсанаас эрдэмтэд түүнийг мезолитын үед холбогдуулан үздэг.

Бага газрын чулууны хадны зураг. Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд сийлсэн зурагнаас нэгэн бугын зураг нь мезолитын сүүл неолитын эхэн үед холбогдоно. Бага газрын хадны зурагт гадаад тэгийг хөвөөлөн цохиж дүрсэлсэн хоёр том буга, урт сүүлээ дээш агссан шилүүс, ирвэс мэт хоёр араатны эх биеийн зураг зэрэг нь бусад зургуудаас хэмжээгээр том бөгөөд нэг буга, нөгөө шилүүс, ирвэс мэт хоёр амьтны зургийг анхнаасаа дутуу сийлээд орхисон байна. Ийнхүү амьтны зургийн зарим хэсгийг дутуу сийлээд орхидог уламжлал бүүр Ишгэн толгойн хуучин чулуун зэвсгийн үеийн зурагт бас байдаг бөгөөд уг зургийн насыг тогтооход харгалзууштай баримт боловч бугын эвэр, эх бие зэргийг бодитой нэлээд болхи дүрсэлсэн зэргээс нь дунд чулуун зэвсгийн үед холбогдуулан үздэг.

§ 3. НЕОЛИТИЙН ҮЕ

Олон мянган жил үргэлжилсэн чулуун зэвсгийн төгсгөлийн томоохон үе бол неолит юм.

Ойролцоогоор 7.000 жилийн тэртээгээс төмөрлөг зэвсэгт шилжих хүртэлх үеийг хамарсан энэ үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Ялтасыг шовгор үлдэцний бүх талаас уртааш нь цуулах болсон тул тэр нь зөв талт урт хутган хэлбэртэй болсон байна.

Дээд палеолит, мезолитын үед хөгжсөн сэлтлэн ирлэх арга барилаар хийж урьд өмнө өргөн хэрэглэж байсан хутга, эсгүүр, хянгар, хусуур, шөвөг, сумны зэв зэрэг зэвсэг хэвээр байсан боловч тэдгээрийн хэлбэр, төрөл олширч ур хийц нь эрс сайжран ир ирмэг нь хурц болжээ. Үүний зэрэгцээ жижиг дугариг бичил хусуур, тэгш суурьтай сумны зэв, тал дугариг ир, хутга ба жадны зуулга ир, дугариг ба зууван хэлбэртэй зээрэнцэг маягийн эдлэл, сүх, ооль, цүүц зэрэг зэвсгийн зүйлс шинээр бий болсон байна. Дээрх зэвсгүүдийг гол төлөв хаш, хас, мана болон төрөл бүрийн цахиураар, сүх зэрэг том эдлэлийг хаш чулуу, гүрмэн занараар хийх болсон нь тэдгээрийг бөх хатуу чанартай болгожээ.

Чулуун эдлэл хийгээд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, хөрөөдөж ховил гаргах, өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино. Олс, дээс зэрэгт нарийн ширхэгтэй элс шигүүлээд түүгээрээ хөрөөдөж чулуун эдлэлд ховил гуриу гаргах, модон өрөмний үзүүрт мөн нарийн ширхэгтэй элс шигтгэн өрөмдөж чулуун зэвсгүүдэд нүх гаргаж цоолох болжээ. Ийм аргаар гол төлөв сүх, ооль хийдэг байсан бөгөөд Монгол улсын нутгаас (Өмнөговь, Говь-Алтай, Баянхонгор, Дорнод) олдсон сүхний дундаж урт нь 11-12 см, өргөн нь 5-6 см, зузаан нь 2,5-3 см байна.

Неолитын үед тус оронд оршин суугчид чулуун зэвсгээс гадна ясаар хийсэн эдлэл өргөн хэрэглэж байжээ. Тухайлбал, зуулга ир суулгасан ховилтой ба ховилгүй ясан хутга, сумны зэв ба жадны гилбэр, төрөл бүрийн гоёл чимэглэлийн зүйл, оёдлын зүү зэргийг хийдэг болсноос гадна мал ба амьтны ясыг ямар нэг хэмжээгээр засаж янзлалгүй тодорхой нэг төрөл зэвсэг болгон ашиглаж байсан нь бууц суурингуудаас олдсон хавирганы олон ясны үзүүр хэсгийн элэгдэж мөлтийсөн байдлаас үзэхэд илт байна.

Неолитын үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм. Тус орны неолитын бууц суурингаас шавар сав суулганы үлдэгдэл нэлээд олддог бөгөөд тэр нь өндгөн ёроолтой, гол төлөв улбар шар гадаргуутай, гадаргуу нь нэлдээ сүлжмэл хээтэй байна. Неолитийн үеийн хүмүүс шавар савыг гурван үндсэн аргаар хийдэг байжээ. Үүнд, гар арга, туузан арга, нүхэн арга орно. Гар арга гэдэг нь шаварыг зуурч гараараа барьж шавар сав хийх арга юм. Шавраа зуураад гурил ганжиндаж буй мэт нимгэлэн хавтгай туузархуу болгоод савны хажуу хана, эх бие, ёроолыг тус тусад нь бэлдээд дараа нь залгаж сав хийх аргыг туузан арга гэнэ. Шавар ваар савныхаа хэлбэртэй нүх ухаад дотор талыг нь зуурмаг шавраараа шаваад хатсан хойно нь сугалж авч шавар ваар сав хийх аргыг нүхэн арга гэдэг. Сүүлийн аргаар сав хийгээд нүхнээс сугалж гаргахад хэцүү, зарим тохиолдолд хагарч эвдэрэх ч явдал байсан тул нүхнийхээ дотор талд нэхмэл тор хийж шавраа шавж ваар, саваа хийгээд хатсан хойно нь торноосоо татаж гаргаж авах болжээ. Иймээс нүхэн аргаар хийсэн шавар савны гадна талд сүлжмэл торны хээ үлдэж хоцорсон байдаг ба сав нь өндгөн хэлбэрийн ёроолтой байдаг. Неолитийн үеийн шавар ваар саван дээр түүнийг хийсэн хүний хурууны хээ дарагдаж үлдснийг судалж үзэхэд гол төлөв эмэгтэй хүний хурууны хээ байдаг нь тогтоогджээ. Иймээс шавар ваар савыг ихэнхдээ эмэгтэйчүүд хийдэг байсан гэж үздэг. Шавар ваарыг сэдэж хийснээр хүмүүс шингэн хоол ундыг түүндээ чанаж болгож иддэг болсон нь чухал дэвшил болжээ.

Неолитийн үед гарсан өөр нэг чухал дэвшил бол хүмүүс амьтны үс ноос, ургамал зэргийг ээрч утас хийгээд түүгээрээ бүдүүн ширхэгтэй даавуу хийж улмаар хувцас хийх болсон явдал билээ. Дээр дурдсан төрөл бүрийн зэвсэг, ваар сав бүхий тэр үеийн хүний бууц суурин Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий зэрэг ер нь тус орны ихэнх нутгаас олджээ. Эдгээрээс Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Дорнод аймгийн Тамсагбулагийн неолитын үеийн суурингуудын дурсгалуудыг төлөөлүүлэн авч үзэж болно.

Баянзагийн оршин суугчид неолитын үеийн гол шинж бүхий чулуун зэвсэг хийх бүх арга барилыг бүрэн эзэмшсэн байна. Тухайлбал: чулууг билүүдэн засаж чаддаг байсан ба гонзгой үлдэцнээс хутганцар нимгэн ялтас цуулан авч зуулга ир, нарийн ирлэсэн сумны зэв, төрөл бүрийн хэмжээ хэлбэрийн хусуур хийдэг байжээ. Ан гөрөө хийх гол зэвсэг нь нум сум байв. Гоёл чимэглэлийн зүйлээс тэмээн хяруулын өндөгний хальсаар хийсэн сувс мөн олдсон байна. Шавар ваар сав нь өндгөн хэлбэртэй, шувтан ёроолтой, гадаргыг улаан будгаар будаж, заримдаа улаан дэвсгэр дээр хар будгаар хээ угалз тавих болжээ. Мөн анхны болхи тариалан эрхлэж байсны баримт болох үр тариа цайруулах хавтгай самбар чулуу, нухуур, нүдүүр элбэг олдож буй нь неолитын сүүл үед тэнд оршин суугчдын аж ахуйд чанарын том өөрчлөлт гарсны гэрч юм.

Дорнод аймгийн Тамсагбулагт неолитын үеийн хүний булш, сууц бүхий суурингуудыг нээж судалсан нь манай орны төдийгүй Төв, Умард Азийн чулуун зэвсгийн судлалд онцгой байр суурь эзлэх дурсгал болно. Эндээс гол төлөв цахиур, хас, бөсөл, заримдаа манаар хийсэн олон талт шовгордуу үлдэц, үлдэц-хусуур, эсгүүр, хутга, ховилтой яс ба модонд суулгах зуулга ир, цоолтуур буюу шөвөг, хусуур, сайтар зүлгэж өнгөлсөн сүх, хоёр талаас нь зассан сумны зэв элбэг олдсон байна. Чулуун зэвсгээс гадна ясаар сумны зэв, жад, ховилтой ховилгүй хутга зэргийг хийж байжээ. Ваар сав нь нэлээд зузаан, хөх саарал өнгөтэй, гадна талд нь гүн нарийн хос зураас хээтэй байна. Ийм сав суулганы зүйл Төв, Умард, Дорнод Азийн мөн үеийн дурсгалуудад огт үгүй учир нутгийн хийц бололтой. Неолитын үед зарим овог аймгууд байгаль орчны тохиромжтой нөхцөл бүрдсэн нутагт удаан хугацаагаар суурин амьдрах болжээ. Үүний тодорхой гэрч нь Тамсагбулагийн суурин бөгөөд

тэнд хэд хэдэн сууц бүхий овгийн суурин буй болсон явдал юм. Энд 5 сууцны орыг малтсаны нэг нь харьцангуй бага эвдэрч хэлбэр төрхийг тогтоох боломжтой байсан ба урт нь 7 м 60 см, өргөн нь 5 м 60 см буюу нийт 42,5 м² талбайтай зууван дөрвөлжин хэлбэртэй байв.

Ийм сууцыг эхлээд сууцныхаа хэмжээний зууван дөрвөлжин нүх ухаад дотор талаар тойруулан хэдэн модон багана босгож хананы яс мод болгосон ба төв дунд нь хэдэн багана босгосон байжээ. Эдгээр багануудын орой дээгүүр сууцныхаа дээврийг тавьж байсан байна. Шал нь тэгшхэн, дөрвөлжин хэлбэртэй. Сууцанд үүд байгаагүй нь дээврийн гол оройд нүх гаргаж төв дунд буй багануудад түшиглэн тусгайлан бэлдсэн шатаар орж гарч байсан бололтой.

Төрөл бүрийн чулуу, ясан эдлэлээс гадна сууцыг малтахад гарсан хамгийн сонин олдвор нь хүний булш юм. Тэрхүү хүнийг сууцны хойд хананы шалны дор хоёр хөлийг нь өвдгөөр нь ихэд атийлган, гарыг нь унжуулан явган суугаа байдлаар оршуулжээ. Энд МЭӨ IV-III мянган жилд холбогдох 15 орчим насны, 1,20 м өндөр, монгол төрхийн эмэгтэй хүнийг оршуулахдаа 200 гаруй сувсан зүүлт, 20 гаруй бугын соёогоор хийсэн зүүлт, бог малын чөмөгний ясан гэртэй, дотроо 1 ширхэг нарийн хурц үзүүртэй ясан зүү, 20 см урт, 2,5 см өргөн ясан хутга хоёрыг (нэг нь хажуу ирмэгээрээ зуулга ир суулгах нарийхан ховилтой) тус тус дагалдуулан тавьжээ.

Манай улсын нутагт анх удаа олдсон хоёр дахь сууц Чойбалсан хотын баруун талд Овоот толгойн чанх урд Хэрлэн голын хойд эрэг дээр оршино. Уг сууц нь хагас газар гэр бөгөөд 14 м урт, дөрвөлжин хэлбэртэй, ойролцоогоор 120 м² талбайтай байна. Сууцны гүн нь төв хэсгээсээ 1,20 м. Хананы хажуугаар баганы ор болох дугариг хос нүхнүүд, ханз маягийн өргөн урт тавцан, төв хэсгээр нь гал түлж байсан таван голомтын ором тус тус байв. Сууцнаас ээрмэл олсны эрчин хээтэй ваар савны хагархай, гонзгой ба шовх чулуун үлдэц, хутган ялтас, залтас, төрөл бүрийн том жижиг хусуур, цоолтуур, хоёр ба нэг талаас нь холтчин ирлэсэн зуулга ир, үр тариа цайруулах самбар чулуу ба дундаа нүхтэй дугуй чулуу, гахайн соёогоор хийсэн гоёл чимэглэлийн бололтой зүйлийн хугархай зэрэг тэнд амьдарч байсан хүмүүсийн аж ахуй, оюуны амьдралтай холбогдох хэрэглэгдэхүүн нэлээд олдсоны дотор загас агнах сөрлүүрт ясан жад онцгой сонирхолтой юм. Эдгээрээс гадна адуу, үхэр, бор гөрөөс, зэрлэг гахай болон түлэгдэж шатаагдсан жижиг малын яс, мөн том малын чөмөгний ясыг цуулж орхисон байв. Сууцнаас гарсан ваар савны хээг ажиглахад тэдгээр нь неолитын түрүү үеийн буюу Тамсагбулагийн сууцны өмнөх шатанд холбогдох бололтой байна. Бусад сууцнууд нь хэмжээгээр бага бөгөөд ихэд гэмтсэн байна. Гэвч тэдгээрээс олдсон олдвор нь дурдсан сууцнуудаас гарсан зүйлтэй адил боловч зарим нэг сууц, тухайлбал 2-3-р сууцанд үр тариа цайруулах самбар чулуу, нүдүүр, нухуурын хагархай нэлээд байжээ.

Дээр дурдсан Тамсагбулаг дахь сууцны шалан дор олдсон хүний булшнаас гадна Дорнод аймгийн Булган сумын Норовлин уул, Чойбалсан хотын эсрэг талд Хэрлэнгийн баруун эрэг дэхь Мөргөцөг, Зүүн Өлзийт уулын хооронд, мөн тэнд орших Баруун Өлзийт ууланд тус бүр нэжгээд булш олдсоноос бүхий л тохиолдолд хүнийг цооног нүхэнд суугаа байдлаар оршуулсан байв. Зарим булшинд үхэгсэдийг дагалдуулан эд өлгийн зүйл тавьсан байхад зарим булшинд тийм зүйл үгүй байна.

Эдгээр булшнаас нэлээд баялаг олдвортой нь Дорнод аймгийн Булган сумын нутагт орших Норовлингийн булш юм. 1,6 м-ийн гүнд өвдгөөр нь атийлгаж, суугаа байдлаар, монгол төрхийн хүнийг оршуулжээ. Түүний толгой хавьд нь 1,5-2 мм голдоч бүхий 3000 орчим сувс байсан нь уг хүний дээл малгайд хадаж байсан бололтой. Мөн оршуулганд хүний нүүрний дүрс бүхий цайвар өнгийн чулуугаар хийсэн 22,5 см урт чулуун онго, 43 см урт хоёр талдаа зуулга чулуун иртэй ясан хутга, гахай, тарвага, хүдрийн соёогоор хийсэн ясан зүүлт, гахай, зарааны дүрстэй танан чимэг, дугуй ба сар хэлбэрийн гоёл чимэглэлийн зүйл, 10,5 см урт захыг нь ирлээгүй хос хутган ялтас, хоёр захыг нь сэлтлэн ирлэж зассан 6 ш жижиг хутган ялтас зэргийг дагалдуулан тавьсан байжээ.

Норовлингийн булшны оршуулгын зан үйлтэй холбоотой бас нэг сонирхолтой зүйл бол хүнээ оршуулахын өмнө ухсан нүхэнд болон хүнээ оршуулсны дараа түүний дээр их хэмжээний улаан зосон будаг цацсан явдал юм. Ийнхүү неолитын үеийн оршуулганд зос хийсэн тохиолдол Дорнод аймгийн Зүүн Өлзийт уулын булшинд мөн ажиглагдсан бөгөөд энэ нь зосоор цусыг төлөөлүүлсэн ба хүний хойд насны тухай ойлголттой шууд холбоотой болно.

Неолитын үед тус оронд оршин суугчид нас барсан хүнээ булж оршуулдаг ба оршуулгын зан үйл нь өвөрмөц байсаныг дээр дурдсанаас харж болно.

§ 4. НЕОЛИТЫН ҮЕИЙН УРЛАГ

Неолитын үеийн урлагийн дурсгалд Монгол орны нутгаас олддог хадны зосон зургууд, чимэглэх урлагийн дурсгалууд багтана.

Судлаачид Зураагийн Улаан хадны төрлийн зосон зургийг неолитын үед холбогдуулан авч үздэг. Энэ төрлийн зургийн гол илэрхийлэх шинж нь “Х” маягийн солбисон хоёр зураасан тэмдэг, ганц ба хэд хэдэн эгнээ босоо зураасан тэмдгүүд, дугуй, гурвалжин хэлбэрийн тэмдгүүд юм.

Энэ төрлийн “Х” маягийн солбисон хоёр зураас, босоо зураасан тэмдэг бүхий зосон зураг Өвөрхангай аймгийн Дэлгэрэх сумын Цоорхойн агуй, Уянга сумын Шурангийн улаан хад, Арвайхээр хотоос баруун урагш 32 км-т орших Баглуур хад, Төв аймгийн Зуун мод, Дундговь аймгийн нутаг Гэр

чулуу, Архангай аймгийн Жаргалант сумын Улиастын гол, Дулааны үзүүр, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Зоргол хайрхан, Хэнтий аймгийн Биндэр сумын Бичиг хад, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Баян-Өндөр сумын Саальтын агуй, Цагаан магнайн агуйгаас тус тус олдоод байна.

Баглуур хадны зурагт бараг бүхэлдээ “Х” маягийн солбисон хоёр зураас босоо зураасан тэмдгүүдийн хослолоос бүрдсэн бол, Зуун модны зурагт дээрхи хоёр тэмдэг хоёул харьцангуй цөөн тоогоор байхын зэрэгцээ зууван дугуй, хагас саран, ац маягийн, зууван дөрвөлжин, нэг тал нь задгай зууван дөрвөлжин тэмдгүүд, янгирын дүрс зэрэг харьцангуй олон төрлийн тэмдгүүд байна. Улиастын голын зурагт эгнэсэн босоо зураас, “Х” солбисон хоёр зураас, хүн, салаа оройтой малгайтай хүнийг тоймлон дүрсэлсэн зургууд зонхилж байхад, Дулааны Үзүүрийн зурагт эгнэсэн олон босоо зураас гурвалжин цээжтэй хүнийг тоймлосон зураас голчилж байна. Гэр чулууны зурагт мөн эгнэсэн босоо зураасууд, “Х” маягийн сольбисон хоёр зураасан тэмдэг, цөөн янгирын дүрсүүд байгаагийн зэрэгцээ онц сонирхолтой нь хүний гарын алганы хоёр дүрс байгаа явдал юм. Үүнийг дүрслэхдээ гарын хурууг сарвайлган алгаар нь хадан дээр тавиад хуруу болон алгаа тойруулж зосоор будаж зуржээ. Эдгээр гарын алганы зургийг судлаачид “цэвэр палеолитын аргаар” дүрсэлсэн хэмээн үздэг билээ. Цагаан агуй, Саальтын агуй, Цагаан магнайн агуйн зурагт “Х” маягийн солбисон хоёр зураасан тэмдэг, босоо зураас голчилох ба хоёр гараа дэлсэн хүний зураг бас тааралдаж байна.

Монголын неолитын үеийн урлагт чимэглэх урлагийн дурсгал тодорхой байр суурь эзэлдэг. Чимэглэх урлаг нь гол төлөв ахуйн хэрэгцээний янз бүрийн сав суулга, тавилга, зэр зэвсэг, бөс даавуу, хувцас хунар, төрөл бүрийн гоёл чимэглэл зэрэг уран хийцтэй эд юмс бүтээдэг уран бүтээлийн олон салбарыг хамаардаг бөгөөд түүнчлэн материаллаг ба оюун санааны үнэт бүтээлийг бүтээх хүрээнд давхар багтдаг байна.

Одоогийн байдлаар монгол нутгаас олдоод байгаа неолитын үеийн чимэглэх урлагийн дурсгалууд дотор Норовлин уулын булшны хэрэглэгдэхүүнүүд онцгой байр суурь эзэлдэг.

Чулуун онго. Энэхүү онго зууван урт, бүтэн баримал хэлбэртэй, хүний нүүрний дүрсийг зууван байдалд зохицуулан маш нарийн уртай сийлж, дараа нь сайтар зүлгэж өнгөлсөн байна. Хүнийг нарийн саран хөмсөгтэй, дүгрэг том нүдтэй, урт шулуун, хамартай, жижигхэн цомбогор уруул, амтайгаар дүрсэлжээ.

Онго нь хөндлөн огтлолоороо зууван хэлбэртэй бөгөөд түүний дээд үзүүрт зүүх тусгай нүхтэйн дээр, доод хэсгийн хоёр хажууд тус бүр дөрөв, нийт найман хэрчлээс гаргасан байна.

Ясан зүүлт. Амьтны соёогоор хийсэн, хоёр үзүүртээ нүх бүхий саран хэлбэртэй чимэг зүүлт.

Гахайн дүрстэй танан чимэг. Бөөрөнд нь хадах хоёр нүхтэй хийсэн бөгөөд тэрхүү хоёр нүхний хооронд элэгдэж ховил гарснаас үзэхэд нэлээд урт хугацаагаар эдэлж байсныг гэрчилнэ. Гахайг том хоншоортой, богино хүзүүтэй, бүдүүн богино хөлтэй дүрсэлжээ.

Зараа хэлбэрийн чимэг. Нимгэн хавтгай танын хажуу ирмэгт нэг дөрвөлжин, түүнээс залгуулж эргэн тойрныг хөрөөний шүд мэт хошуу гарган урлажээ. Энэхүү чимгийн дээд хэсэгт хадах хоёр нүх гаргасан байна.

Хэрлэн голын Устын дэнжээс олдсон дугуй чулуун эдлэл. Энэ эдлэл Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Хэрлэн голын дээд гүрний орчимд хийсэн малтлагын явцад илэрч олсон юм. Тэрээр 8,3 см голдочтой голдоо 2,5 см голдочтой нэвт нүхтэй, 2,6 см зузаан. Голын нүхнээс дугуйн гадаад хөвөө рүү 12 нарийн зураасыг хоёр хоёроор нь үзүүрийг солбиж хээлэн сийлжээ.

Тойруулж зурсан хээ нь Дорнод аймгийн нутаг Тамсагбулгийн суурингаас гарсан зүүний ясан гэрэн дээр зурсан хээтэй ижил төстэй байгаа бөгөөд нүүрэн тал болон хажуу талын аль алинд 12 зураас гаргасан нь нэлээд сонирхолтой төдийгүй эртний цагалбар байж болох талтай ба ямар ч атугай чимэглэх урлагийн дурсгал болох нь маргаангүй. Урьд нь үүнтэй төстэй дундаа нүхтэй чулуун эдлэлүүдийг Туул, Хэрлэн голын сав, Хэнтий аймгийн Рашаан хад, Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэн Баян Улаан уулын өврөөс олж байжээ.

Эдгээр эдлэлийг модон царилын хүндрүүлэгч ачаа, загасны торны ачаа болгон ашиглаж байжээ.

Дээр дурдсан эдлэлүүдээс гадна Загасны чулуун дүрсний хугархай, загасны хэлбэртэй үр тариа цайруулах самбар чулуу Дорноговь аймгийн Дулааны говь, Сүхбаатар аймгийн нутгаас олдсон байна.

Неолитын үеийн чулуун онго, гоёл чимэглэл, гахайн дүрстэй хадмал, загасны хэлбэртэй самбар чулуу зэрэг нь нэг талаас урлагийн бүтээл төдийгүй, нөгөө талаас эд зүйл, гоёл чимэглэл бөгөөд бүхэлдээ орон зайн чимэглэх урлагийн дурсгал болно.

§ 5. МЕЗОЛИТ, НЕОЛИТЫН ҮЕИЙН АЖ АХУЙ, НИЙГЭМ СОЁЛЫН АСУУДАЛ

Мезолитын үед дэлхийн бөмбөрцгийн хойт хэсэгт мөсөн бүрхүүл хайлж, байгаль, цаг уур, хүрээлэн буй орчинд ихээхэн өөрчлөлт орж, хүн амьтны аль алин нь шилжин нүүх их хөдөлгөөнд орсон юм. Төв Ази, Монгол, Сибирийн нутагт арслан заан, савагт хирс мөхөн үгүй болж, цаа бугын сүрэг хойт туйлруу нүүдэллэн оджээ. Умар зүг нүүдэллэж одсон амьтдын нүүдлийг дагаж хүмүүсийн их нүүдэл болж, Төв Азиас Умард Америк хүртэл хүн нүүдэллэн очиж суусан байна. Палеолитын үеийн

хүмүүсийн агнаж, их мах авдаг байсан том ангууд ийнхүү үгүй болсон нь тэдэнд арга буюу олон тооны жижиг ан агнаж урьд нь том ан агнахдаа хэрэглэж байсан шигээ их хэмжээний мах олж авах шаардлагатай болжээ. Үүнтэй уялдан тэд ан агнадаг зэвсгээ илүү дэвшилттэй сайн зэвсгээр өөрчлөх шаардлага гарч иржээ. Урьд нь палеолитын үеийн анчид байгалийн чулуу, мод болон бороохой, жад зэргийг ан агнуурт хэрэглэж байсан бол мезолитын үед модны уян хатан чанарыг мэдэж, ашиглан сэдэж хийсэн хамгийн анхны механик хүчийг ашигласан зэвсэг болох нум сумыг зохион бүтээж хэрэглэсэн байна. Нум сумын мөсийг модоор зэвийг чулуу, ясаар хийдэг байжээ. Мезолитын үеийн сумын чулуун зэв Хэнтий аймгийн Рашаан хад, Өвөрхангай аймгийн Мойлтын ам зэрэг олон соёлт давхрага бүхий суурингуудын дээд давхрагууд болон Дорноговь аймгийн Дулааны говь зэрэг суурингуудаас элбэг олддог бөгөөд хэлбэр төрхийн хувьд хэд хэдэн янз байдаг. Нум сумыг хэрэглэх болсноор ангийн аж ахуйн хөгжилд чухал түлхэц болж, цөөн хэсэг хүмүүс ан агнуур хийж амьдрах чадварыг эзэмшсэн нь цаашдаа овгийг жижигрүүлэн цөөн хүнтэй, хөдөлгөөнтэй, овгийн тоог олон болгож улмаар өөрчлөхөд хүргэсэн байна.

Олон мянган жилийн турш эртний хүмүүсийн эрхэлж ирсэн ангийн аж ахуйн хөгжлийн үр дүнд мал аж ахуй үүсч буй болох урьдчилсан нөхцлүүд бүрэлдэж эхэлсэн юм. Түүхэн урт хугацаанд хүмүүс аливаа ан амьтдын амьдрах орчин, тарга хүчээ авах цаг үе, амьтан сүрэг дотроо болон өөр амьтдын сүрэгтэй харьцах байдал, зан төрхийн талаар арвин их мэдлэгтэй болсон нь тэднийг гаршуулж, гэршүүлэх арга ухааныг сэдэж буй болгосон бөлгөө. Мал аж ахуй үүсч буй болох түүхэн үйл явц нь малыг гаршуулах, гэршүүлэх гэсэн хоёр үе шаттай түүхийн урт удаан хугацааг дамжсан юм.

Эртний хүмүүс ан амьтадтай зэрэгцэн нутаглаж тэднийг өөртөө дасгах, үр төлийг нь суурин буудалдаа олж авч ирж, тэжээх, амьтдыг сүргээр нь ганга, хавцал хясаанд хөөж оруулан хашиж шахаж агнах, тэднээс барьж авах, удаан хугацаагаар хашин дасгах зэрэг боломжтой бүхий л аргаар амьтдыг гаршуулж эхэлсэн ажээ. Гэвч амьтдыг гаршуулах улмаар гэршүүлэх үйл явц нь тэр бүр санасанчлан амжилтанд хүрдэггүй төвөгтэй үйл ажиллагаа байжээ. Дэлхий дахинд мал аж ахуй бие даан үүсч буй болсон цөөн хэдэн том голомт байсны нэг нь Монгол орон байсан юм.

А.П.Окладников, А.П.Деревянко, Д.Дорж нар амьтдыг гэршүүлэх үйл явц болон Монгол оронд мал аж ахуй үүссэн он цагийг неолитын үед холбогдуулан үзэж байсныг түүнээс хойш хийсэн судалгааны дүнд бид урагшлуулан мезолитын үед холбогдохыг тогтоосон юм. А.П.Окладников Монголын неолитын дурсгалууд, тухайлбал, амьтдын ёслолын оршуулга-Хэрлэн, Халх голын савд оршуулсан үхрийн толгой, адууны яс, Монголын хадны зураг зэргийг судалж, Төв Азийн неолитын үеийн аймгууд адуу, үхрийг бие даан гэршүүлсэн гэдэг дүгнэлтэд хүрчээ. Дараагийн алхамыг тэд хүрэл зэвсгийн үед хийж, Төв Азийн нүүдэлчин аймгуудын мал аж ахуйн соёлын өвөрмөц өндөр хөгжилтэй бүхэл бүтэн цогцыг бүтээсэн юм.

Монгол орон эрт цагт төрөл бүрийн ан амьтан түүний дотроос таван хошуу мал болон цаа бугын өвөг зэрлэг амьтдаар нэн баялаг байсан билээ. Монгол адууны өвөг тахь, илжигний өвөг хулан, тэмээний өвөг хавтгай, хонины өвөг аргаль, ямааны өвөг янгир, цаа бугын өвөг зэрлэг цаа буга одоо хир Монгол оронд зэрлэг хэвээрээ идээшин амьдарч байна. Харин сарлаг ба монгол үхрийн өвөг одоо зэрлэгээрээ уламжлагдаж ирсэнгүй, Монгол нутагт эрт цагт амьдарч байсан энэ хоёр төрлийн зэрлэг үхрийг бүгдийг нь гаршуулж гэршүүлчихсэн ч байж болох юм. Монголын мезолит, неолитын үеийн овог, аймгууд амьтдыг байгалийн билчээрт нь идээшлүүлэн хадлан тэжээл бэлдэлгүйгээр гаршуулж, гэршүүлсэнд Монголын мал аж ахуйн үүсэл гарал, цаашдын хөгжлийн гол онцлог нь оршино.

Дорнод аймгийн Тамсагбулаг, Овоот, Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Зуух, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Билүүт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Устын дэнж, Батширээт сумын Өглөгчийн гол, Рашаан хад зэрэг неолитын сууринд хүмүүс урт удаан хугацаагаар амьдарч байсан болох нь тогтоогдсон юм. Тамсагбулаг, Овоотын сууринд хүмүүс зууван дөрвөлжин хэлбэрийн орой дээвэртээ гаргасан нүхэн өрхөөр орж гардаг том хагас газар сууц барьж суудаг байсны ор улбаа хадгалагдан үлджээ. Баянзаг, Зуухын сууринд суугчид хөнгөн маягийн урцархуу сууцанд суудаг байжээ. Тэр урцны үлдэгдэл болох гуч гаруй гал голомтыг тойрч дугуй талбайд хаягдсан хэдэн мянган чулуун зэвсэг Зуухын суурингаас олдсон билээ. Дорнод аймгийн Тамсагбулаг, Овоот, Норовлин уул неолитын үеийн суурин ба булшийг малтахад бүгдээс нь монгол төрхийн хүний яс олдсон бөгөөд неолитоос өмнө үед холбогдох хүний яс Монгол нутгаас хараахан олдоогүй байна. Неолитын үеийн аймгуудын нэг хэсэг нь ус нутаг сайтай газар удаан хугацаагаар сууж амьдарч байхад нөгөө ихэнх хэсэг нь жижиг жижиг овгоороо нүүдэллэн явж амьдардаг байсныг гэрчлэх түр зуурын буудлууд Монгол нутгаас олон арваараа олдсон билээ. Неолитын үед анхны зээтүүт газар тариалангийн эх үүсвэр тавигдсан юм. Гэвч эх газрын эрс тэс уур амьсгалтай Монгол оронд газар тариалан далайцтай хөгжиж чадаагүй юм. Үр үндэс, нунтаглаж боловсруулах зууван дөрвөлжин хэлбэрийн самбар чулуу, бөөрөнхий урт гулууз маягийн нухуур, том бөөрөнхий толгойтой, бариулыг нарийсган зассан нухуур чулуу неолитын үеийн суурингаас олонтой олддог нь мөнхүү үр үндэс түүх аж ахуй болон эгэл зээтүүт тариалан эрхэлж байсныг гэрчлэх хэрэглэгдэхүүн юм.

Монгол оронд оршин суугчид наанадаж МЭӨ III мянган жилийн тэртээгээс тариалан эрхлэж байсны баримт болох амуу будаа цайруулах самбар чулуу, чулуун нүдүүр, нухуур, хөрс сийрүүлэх чулуун зээтүү, газар сэндчиж ухахад хэрэглэж байсан мод буюу ясан царилыг хүндрүүлэхэд

зориулсан ачаа болох голдоо нэвт нүхтэй 10-15 см-ийн хэмжээтэй дугариг чулуун эдлэл зэрэг зүйлс Тамсагбулагийн суурингаас нэлээд хэмжээгээр олдсон байна. Газар тариалантай холбоотой ийм төрлийн зүйл Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг аймгийн нутагт мөн багагүй бий бөгөөд тэр үеийн цаг агаарын таатай нөхцөл болон Монголын эртний шүхэр ба толгойт будааны өсгөврийн төрлөөс эх авсан нутгийн бэлэн үр тарианы үндсэн дээр МЭӨ III мянган жилийн дундуур эгэл зээтүүт тариаланг үүсгэн эрхэлж байсны тодорхой гэрч мөн болно. Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгаас загасны хэлбэртэй (ам, заламгай, сүүлийг дүрсэлсэн) том хэмжээний үр үндэс, тариа цайруулах хавтгай самбар чулуу олдсон нь газар тариалан, загас агнуур хоёр суурьшмал аж ахуйн холбоог илэрхийлсэн маш ховор, сонин дурсгал юм. Энэ самбар чулуу нь дээрх хоёр аж ахуйг эрхлэгчдийн нэгдмэл үзэл, сүсэг бишрэл, урлагийн таашаалыг илэрхийлж буйд түүний онцгой ач холбогдол оршино.

Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Цэнхэрмандал сумын Устын дэнж зэрэг газар малтан шинжилсэн неолитын үеийн суурингуудаас болон Онон, Хэрлэн, Туул, Орхон, Онги, Сэлэнгэ, Дэлгэр мөрөн зэрэг томоохон голуудын хөндийгөөс чулууг дугуй хэлбэртэй засч, голд нь нэвт нүх гарган хийсэн модон царилны хүндрүүлэгч чулуун ачаа олон тоогоор олдсон билээ. Тиймэрхүү чулуун ачаагаар хүндрүүлсэн модон царилаар газар сэндийлэн нүх ухах зэргээр тариалангийн газрыг боловсруулдаг байсан бололтой. Мөн тийм ачааг загасны торны ачаа, юм нүхлэх, гал гаргах гар өрөмний хүндрүүлэгч ачаа болгон хэрэглэдэг байжээ.

Ан гөрөөнөөс гадна загасчлах явдал неолитын үеийн хүмүүсийн аж ахуйд багагүй үүрэг гүйцэтгэж байжээ. Үүний жишээ нь Дорнод аймгийн Овоот уулын урд хормойд малтсан сууцнаас гарсан загас агнах сөрлүүр ясан жад, Дорноговь аймгийн Дулааны говь, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Өмнөговь аймгийн Баянзаг, Увс аймгийн Зүүнговь сумын нутаг зэрэг газраас олдсон чулуун илбээс загас, Дулааны говиос чулуугаар хийсэн загасны дүрс, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгаас олдсон загасны хэлбэртэй үр тариа цайруулах том самбар чулуу юм.

Неолитын үеийн хүмүүсийн аж ахуйд загас агнах явдал бага бус үүрэгтэй байсан нь тодорхой боловч үүнийг давхар гэрчлэх эд мөрийн ийм шууд баримт урьд өмнө Монгол орноос огт олдоогүй байсан билээ.

Овоот толгойгоос олдсон сөрлүүрт жадны бариул тал нь хугархай. Урт нь 14 см, өргөн нь төв хэсгээрээ 0,7 см, үзүүрээрээ 0,5 см, зузаан нь 0,8 см байна. Гурван сөрлүүрийн үзүүрүүд нь бүгд хугарч эвдэрчээ.

Ингэж газар тариалан, мал аж ахуй, ан агнуур, загасчлах энэ бүхнийг нэгтгэн авч үзэхэд Монголд неолитын аж ахуйн бүрэн цогцолбор бүрдсэн нь илт байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

Дорж Д. Мезолит Монголии и проблема этнической общенности Центральной и Северной Азии // ОУМЭ-ийн IV их хурал. - УБ., 1985.

Дорж Д. Дорнод монголын неолитын үеийн булш, сууц // ШУАМ. 1969. '3. - тал 43-53.

Дорж Д. Неолит Восточной монголии. -УБ. 1971.

Дорж Д. Тамцаг-Булагская культура и ее место в древней истории Центральной Азии // Роль кочевых народов Цивилизации Центральной Азии. УБ. 1974, стр. 127-131.

Дорж Д. БНМАУ-ын нэн эртний түүхийн зарим асуудал // ШУАМ. 1975. '4. -тал 16-23.

Дорж Д. Деревянко А.П. Новое в изучении неолита Восточной Монголии // АС. т. VIII, f. 13-14. УБ. 1970. тал155-170.

Нохрина Т.И., Усачёва И.В., Гүнчинсүрэн Б. Новые данные о территории распространения "ютюжков" и некоторые проблемы их изучения // СА. т 16. f.5. - УБ., 1996, - тал 76-81.

Нохрина Т.И., Цэвээндорж Д., Петрин В.Т., Гүнчинсүрэн Б. Коллекция каменного инвентаря из темной кремнистой породы памятника "Зуух-1" // СА. т 18. f.5. - УБ., 1998, - тал 39-55.

Окладников А.П. Неолит и бронзовый век Прибайкалья //МИА. '18

Окладников А.П. Центрально-Азиатский очаг первобытного искусства. Новосибирск. 1971.

Окладников А.П., Деревянко А.П. Тамцак-Булак-неолитическая культура Восточной Монголии // Материалы по истории и филологии Центральной Азии: Тр. Бурят. Ин-та обществ. Наук Бурят филиала СО АН СССР. Улан-Удэ, 1970. Вып. 13.

Сэр-Оджав Н. Монгол орны неолитын үеийн тухай // ШУХ. ЭШБүтээл. '1. УБ. 1956. -Тал 3-6.

Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал. -УБ., 1983

Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. -УБ., 1998.

Цэвээндорж Д., ХосбаярП. Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан нь // АС. т.X. f.3. УБ., 1983.

Цэвээндорж Д., Деревянко А.П., Петрин В.Т., Гүнчинсүрэн Б. Неолит Юго-Восточного фаса Гобийского Алтая (по материалам памятника Зуух-1). -УБ., 1999.

ХҮРЭЛ БА ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕИЙН АРХЕОЛОГИ

§ 1. ЭНЕОЛИТИЙН ҮЕ

Хүмүүс эртнээс өөрсдийн хэрэглэж байсан багаж зэвсгийг улам сайжруулан хөгжүүлсээр ирсэн бөгөөд неолитийн сүүл үеэс зэвсээр багаж зэвсэг хийх болжээ. Зэс зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрсэн энэхүү зурвас үеийг хүн төрлөхтний түүхэнд энеолитийн буюу зэс чулууны үе хэмээн нэрлэдэг. Энеолит гэдэг нь энус (aeneus)- зэс, литос-чулуу гэсэн эртний грек үгнээс гаралтай.

Энэ үед Ази Европын тал хээрийн бүс нутагт мал аж ахуй, газар тариалан дээр суурилсан үйлдвэрлэх аж ахуйн хүрээ улам өргөжиж, хөгжилтөд нь чанарын ахиц дэвшил гарчээ. Мал аж ахуй голлох аж ахуй болж Ази Европын өргөн уудам тал хээрийн бүс нутгийг бүрэн төгс эзэмших боломжийг олгосон байна.

Монгол оронд оршин суугчид Евразийн нүүдэлчдийн нэгэн адил ойролцоогоор МЭӨ III мянган жилийн эхэнд энеолитын үеийг дамжсан.

Манай орны Өмнөговь, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Төв зэрэг аймгийн нутгаас эртний зэс малтаж байсан уурхай, ухмалууд олджээ. Үүний зэрэгцээ Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой, Зэлт зэрэг газруудад буй эрт үед зэс малтаж байсан ухмалуудын орчмоос зэсийн хүдэр ухаж авахдаа ашиглаж байсан голоороо гурив ховил бүхий чулуун муна, алх, бахим нүдүүр олноор олдсон нь тухайн үеийн зэсийн хүдэр олборлолтын дүр зургийг нэхэн сэргээхэд ач холбогдол болохуйц эд өлгийн зүйлс билээ. Өмнөговийн Баянзаг, Гурван тэс сумын төв орчим, Дорнод аймгийн Хүйтэн булаг, Баянхонгор аймгийн Зоог, Зуух зэрэг газруудаас неолитийн үеийн чулуун зэвсгүүдийн хамт зэс, зэсийн хүдрийн хайлш гарсан байна.

Зоог, Зуухын суурингаас неолит, энеолитийн үед хүн удаан хугацаагаар амьдарч байсны баримт болох 30 гаруй гал голомтын ор, 4000 гаруй эд өлгийн зүйлс, түүний дотор чулуун зэвсэг, шавар ваарны хагархай, зэс хайлуулж байсан жижиг чулуугаар барьсан хоёр зуух, зэсийн хайлш, загийн нүүрс зэрэг илэрчээ.

Ховд аймгийн Манхан сумын нутгаас энеолитийн үед холбогдох аргаль угалзны толгойг маш урнаар сийлсэн том жижиг хоёр чулуун эдлэл олдсон нь тухайн үеийн урлагийн ховор сонин дурсгал юм. Нэг том эдлэл нь одоо Манхан сумын орон нутгийг судлах кабинетад хадгалагдаж байгаа бөгөөд 31,5 см урт, 4 см өргөн, 1,4 см зузаан (хөндлөн огтлолоороо зууван хэлбэртэй) хүрэн бор өнгийн нарийн ширхэгтэй чулууг зүлгэж засч хийсэн эдлэлийн нэгэн үзүүрт аргалийн толгойн дүрсийг сийлэхдээ нүд, зовхи, чих, эрүү хоншоорыг товойлгон урлаж, хамар, амыг цэг, нарийн зураасаар маш их уртай дүрсэлсэн байна. Үүнээс гадна Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа хар өнгийн урт нарийн чулуун эдлэлийн нэг үзүүрт аргалийн толгойн дүрсийг бүтэн барималаар сийлэхдээ түүний нүд, чих, эврийг товойлгон гаргаж ам, хамрыг зөвхөн нарийн зураас цэгээр гарган их л бодитой дүрсэлсэн чулуун эдлэлийг энеолитийн үед холбогдуулан авч үздэг.

Энеолитын үед холбогдох хадны зургууд дүрслэл, дүрсэлсэн арга барилын хувьд өвөрмөц байдаг. Энэ үед холбогдох зургын тоонд Архангай аймгийн нутаг Чулуут голын хөндийн хаданд дүрслэгдсэн зургууд багтана. Эндхийн хаднаа олон цацаг бүхий хормойтой хувцас өмссөн хүмүүс, шовх оройтой малгайтай хүмүүсийн тоймлон зурсан зургууд, мөн данхар эвэртэй үхэр, буга зэрэг амьтдыг сийлсэн байдаг.

§ 2. ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ҮЕ

МЭӨ II мянган жилийн тэртээгээс Евразийн хээр тал нутагт хүрлээр хийсэн эдлэл өргөн тархаж эхэлжээ.

Ойролцоогоор МЭӨ II мянган жилийн тэртээ зэсийг цагаан тугалга, хар тугалгатай хольж хайлуулан хүрэл гэдэг шинэ холимог төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүрэл зэвсгийн үе эхэлсэн. Хүрэл зэвсэгт шилжсэн үе нь эдийн соёлд гарсан хувьсгал байгаад зогсоогүй аж ахуй, нийгмийн харилцаанд ч үндсэн өөрчлөлт гаргасан юм.

Шинэ металл болох хүрэл нь зэсээс хэд хэдэн давуу талтай байлаа. Юуны түрүүнд зэсийг бодвол хүрэл нь бага хэмийн халуунд хайлдаг. Зэс 1084 хэмд хайлдаг байсан бол, хүрэл 700-900 хэмд хайлдаг. Зэсээр хийсэн багаж зэвсэг хурдан мохож мөлийж элэгддэг бол хүрэл зэвсгүүд харьцангуй удаан элэгддэг байна.

Хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсны дурсгал болох хүдэр авдаг уурхай, хүрэл хайлуулдаг байсан зуух, хүрэл эдлэл цутгадаг хэв манай орны нутгаас нэлээд тоогоор олддог нь Монгол орон нь Төв Ази дахь хүрлийн үеийн төвүүдийн нэг байсныг нотлох баримт болж байгаа юм.

Тухайн үед ихэвчлэн хүхэржсэн хүдэрийг гарган авч боловсруулдаг байжээ. Хүдрийн нөөцөөсөө шалтгаалан уурхайн хэлбэр хэмжээ нь харилцан адилгүй байв. Хүдрийг юуны түрүүн алхаар цохиж жижиглэж авдаг байсан бололтой. Хагалагдахгүй хатуу газрынхыг гал түлж халаагаад, усаар хөргөж хагалж авдаг байсан. Гаргаж авсан энэ хүдрээ дараа нь тусгай хавтгай чулуун дээр тавьж, бөөрөнхий хэлбэрийн бахим том алхаар бутлаж, металлийг гаргаж авдаг байв. Дараа нь

металлаа тусгай нүхэнд хийж хайлуулдаг байв. Хожим тусгай зориулалтын чулуун шанага, зууханд хайлуулдаг болсон. Нүхэндээ нүүрс, металл хоёроо үелүүлэн хийж шатаана. Шаталтын дүнд хайлсан хүдэр зориуд гаргасан тусгай жижиг нүхээр урсан гарч бэлтгэсэн жижиг нүхэнд орж хайлмагтан тогтсоны дараа гарган авч цэвэрлэн хэвэнд цутган багаж зэвсэг хийдэг байжээ. Цутгах хэвээ сланц, шохойн чулуу, элсэн чулуу, шавар, зарим үед металаар ч хийдэг байв. Хэвээ бэлтгэхдээ хийх гэж буй багаж зэвсгийнхээ хэлбэр хэмжээ, хээ чимэглэлийг нарийн ухаж гарган сайтар зүлгэдэг байжээ. Гол төлөв нэг талт хэвээр цутгадаг байсан боловч ур хийц нарийн, овор томтой зүйлийг 2 болон түүнээс дээш талтай хэвээр цутгадаг байв.

Ийнхүү металл зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрсэн нь тухайн үеийн хүмүүсийн амьдрал төдийгүй нийгмийн хөгжилд гарсан түүхэн үйл явц байлаа.

§ 3. ДӨРВӨЛЖИН БУЛШ

Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг. Дөрвөлжин булш дорнод Монголын талаас Алтайн уулс, Байгал нуураас Говь хүртэл өргөн тархсан археологийн томоохон дурсгал юм. Энэхүү булшийг үлдээгсэдийг бүхэл бүтэн нэгдмэл соёлд хамруулан авч үзсэн нь ч байдаг. Монгол орны нутаг дэвсгэр дээр ихээхэн элбэг байх нутгийн өвөрмөц шинж бүхий энэхүү булш судлаачдын анхаарлыг эртнээс татаж ирсэн төдийгүй, малтан шинжлэх, судлах ажил өнгөрсөн зууны сүүлийн хагасаас эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна.

Дөрвөлжин булшийг гаднах зохион байгуулалтын хувьд үндсэн 4 хэлбэрт хуваан авч үздэг:

Дөрвөн буланд аа өндлөр чулуутай, дөрвөн өнцөг хүрээтэй булш;

Дөрвөн талын хүрээ нь намхавтар хавтгай чулуун дараас бүхий булш;

Онцгой өндөр ханатай булш;

Дөрвөн тал нь дотогшоо хотгар ханатай булш;

Дөрвөлжин булшийг оршуулгын зан үйл, ёслолын зориулалтаар нь а/ оршуулгын байгууламж, б/ тахилгын байгууламж гэж ерөнхийд нь хоёр ангилан авч үздэг.

Дөрвөлжин булшийг тусгай хэмжээтэй, тогтож заншсан хэлбэрээр тодорхой дэс дараатай нарийн зохион байгуулалттай үйлддэг байжээ.

Дөрвөлжин булшны зохион байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг. Хүнийхээ толгойг ихэвчлэн нар мандах зүг буюу зүүн зүг харуулан цэх байдалтайгаар дээш харуулан 50-150 см-ийн гүнд оршуулж, зарим цахиур чулуун зэвсгийн зүйл, хүрэл хутга, сумны зэв, хүрэл товч, товруу, морь малын дүрстэй хүрэл чимэг, хагас товгор хүрэл чимгүүд, модоор сийлсэн шувууны толгой, үсний алтан сүлбээр, шавар ваар, зэс, хүрэл хайлуулдаг чулуун шанага зэрэг олон төрлийн эд өлгийн зүйлс, малын толгой, чөмөг, дал болон бусад зүйлийг дагалдуулан тавьсан байдаг. Гол төлөв хүнийхээ толгой дор дэр болгон хавтгай чулуу тавьдаг байжээ. Дөрвөлжин булшны гаднах ерөнхий хэмжээ дундажаар 1,5 х 2,5 м-ээс 2,5 х 4,5 м байдаг. Харин Монгол орны төвийн бүс нутагт энэхүү дундажаас харьцангуй том булш ч тааралддаг байна. Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшнаас илрэн олдож буй эд өлгийн зүйлсийг ерөнхийд нь зэр зэвсэг, байлдааны хэрэглэл, аж ахуй, хөдөлмөрийн багаж хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлс хэмээн төрөлжүүлэн хуваан авч үздэг.

Дөрвөлжин булш нь Монгол улсын нутаг болон Өвөр Байгалийн нутагт голчлон тархсан дурсгал бөгөөд Манжуур, Өвөрмонгол, Шинжааны нутагт бас тодорхой хэмжээгээр мэдэгдэж байна. Дөрвөлжин булшийг малтан шинжлэх ажлыг манай улсын нутагт Төв аймгийн Хэрлэн Туул голын сав газар, Өвөрхангай аймгийн Орхоны хөндий, Богд сумын Тэвш уул, Дундговь аймгийн өмнөт хэсэг, Хэнтий аймгийн Хэрлэн, Онон, Хурх голын сав, Булган аймгийн Эгийн голын сав, Дорнод Монголын тэгш тал болох Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын нутаг, Дорнод аймгийн Баяндун, Цагаан овоо, Сэрэглэн, Гурван загал, Баян-Уул, Дашбалбар сумдын нутагт явуулж, одоогийн байдлаар ойролцоогоор 500 гаруй дөрвөлжин булшийг малтан судалжээ. Эдгээрээс зөвхөн 3 булшнаас гарсан зарим олдворт радиокарбоны арга хэрэглэн холбогдох он цагийг нь тогтоосон байна. 1970 онд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Залаа гэдэг газарт малтсан I дөрвөлжин булшнаас гарсан модны нүүрсний үлдэгдэлд хийсэн радиокарбоны шинжилгээгээр 2610±50 жилийн өмнө буюу МЭӨ III зууны үед, 1993 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Устын амны I дөрвөлжин булш 2300±70 жилийн өмнө буюу МЭӨ III-II зуунд, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын дөрвөлжин булш МЭӨ 845-805 оны үед тус тус холбогдож байна.

Сүүлийн жилүүдэд явуулсан археологийн малтлагаас гарсан, хүрэл зэвсгийн үеийн зэр зэвсэг, байлдааны хэрэгсэлийн талаар цоо шинэ мэдээлэл өгсөн олдворууд бол Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын 2 дөрвөлжин булшийг малтахад олдсон хоёр хүрэл дуулга юм.

Нэгдэх дуулга нь 22 см өндөртэй, 22 см урт, 16 см өргөнтэй сэнж бүхий ажээ. Хоёр шанаавчны доод ирмэг нь бүч сүвлэж болохуйц нүхтэй, дуулганы ирмэг захыг товойлгон эмжэн хүрээлсэн. 1 кг орчим жинтэй юм. Хоёрдахь дуулга нь яльгүй том хэмжээтэй хийцийн хувьд онц ялгагдах зүйлгүй байна.

Монгол орноос ихээхэн хэмжээгээр олддог зэр зэвсгийн төрлийн нэг сумны хүрэл зэв дөрвөлжин булшны малтлагаас цөөвөр тоотой олдсон ба харин түүврээр олон тоотой олджээ. Зэвийг хоёр ба гурван хянгат, хавтгай онгит, шилбэт гэх мэтээр хэлбэр төрхөөр нь ангилан үздэг. Хүрэл зэвүүд нь олон төрөл байдаг бөгөөд хол, ойрын, хөнгөн, хүнд, шархдуулах зэрэг ялгаатай байжээ. Мөн түүнчлэн хүрэл зэвсгийн төгсгөл үед хүрэл толгойтой төмөр шилбэтэй зэвийг хийх болсон байна. Үүнээс гадна мөн ясаар хийсэн зэвүүд дөрвөлжин булшнаас олддог байна.

Дээр дурдсан дайн байлдааны зориулалттай зэр зэвсгийн олдворууд нь зэр зэвсгийн төрөл зүйл зэргийг илтгэн хааруулаад зогсохгүй хүрэл зэвсгийн үеийн оршин суугчдын оюуны соёл, металл боловсруулалтын түвшин, арга ажиллагааны хөгжилтийг харуулах баримт юм.

Монгол орны хүрлийн үеийн гоёл чимэглэлийн зүйлсийн олдвор дотроос хамгийн сонин содон олдвор бол Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд малтсан дөрвөн хажуу хана нь дотогшоо хүнхэр дөрвөлжин булшнаас гарсан аргалийн толгойн хэлбэртэй хоёр алтан сүлбээр юм. Энэхүү хоёр сүлбээр ур хийцийн хувьд тун ойролцоо боловч нэгэнд нь 6, нөгөөд нь 8 шигтгээний нуух байна. Аргалийн толгой хүзүүг нилээд загварчлан дээш өлийлгөж хоншоорыг монхор нарийнхан, нүдийг том дугуй, эврийг данхар махир гаргасан ба түүний ар шилнээс сүлбээрийн их биеийг залгуулан ихэд нарийн уялдаатай урлажээ. Сүлбээрийн их биеийн дээд хэсгийг хэдрэгний ир мэт биржгэрээр хоёр хажууг шаталсан биржгэрээр, тус тус чимсэний гадна аргалийн нүд чих сүлбээрийн нууханд ногоон оюу шигтгээ суулгаж гоёл чимэглэлийн өнгө хорших аргыг хэрэглэсэн байна. Энэ нь алт, мөнгөнд үнэт чулуун шигтгээ суулган өнгө хорших арга Монгол нутагт хүрэл зэвсгийн үед үүсч улмаар Хүннү улсын үед ихэд дэлгэрэн чимэглэх урлагийн нэгэн бие даасан нарийн арга болтлоо хөгжснийг харуулах бодит баримт юм.

Дөрвөлжин булшнаас олон тоотойгоор олдсон эдлэл бол янз бүрийн хэлбэр хэмжээ дүрслэлтэй хүрэл товруунууд юм. Хувцасны болон бүсний чимэг болох хүрэл товруунууд нь хийгдсэн байдлаараа чимэглэлтэй, чимэглэлгүй хэмээн хоёр хуваагддаг. Чимэглэлтэй товруунуудад голчлон ан амьтан, буга, баавгай, морь, чоно, шувуу зэргийг дүрсэлсэн байхаас гадна төрөл бүрийн хээ угалзыг чимэг болгон дүрсэлж байжээ. Хүрэл товруунуудын хэмжээ дунджаар 5-50 мм байдаг. Араатан амьтдыг бодит байдлаар болон загварчилан дүрслэх үндсэн хоёр аргаар дүрсэлсэн байдаг.

Дүрслэлийн хоёрдахь аргыг нь амьтныг загварчилан дүрслэх арга хэмээн нэрлэдэг. Евразийн хээр талын бүс нутагт хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дүрслэх урлагт амьтныг загварчилан дүрслэх арга өргөн тархжээ. Энэ аргын онцлог нь хэд хэдэн зүйлийн амьтдыг бүтнээр нь буюу тэдгээрийн биеийн зарим хэсгийг тогтсон нэг барилаар гол шинжийг тодруулан гаргаж бодит ба загварчлалын аль алиныг хослуулан хэрэглэж амьтдын дүрийг бүтээдэгт оршино.

Дөрвөлжин булштай төстэй боловч хүний оршуулгагүй, тахилга ёслолын байгууламж тааралддаг. Тахилгын энэхүү байгууламж нь олон тоогоороо байгаа дөрвөлжин булшны ойролцоо голчлон байдаг байна. Энэхүү байгууламжид адуу малыг хойлоглон тавьсны зэрэгцээ зарим эд өлгийн зүйлс тухайлбал ваар сав суулга зэргийг тавьдаг байжээ. Хойлго үйлдсэн малын толгойн тавьсан чиг нь дөрвөлжин булшинд нас барагчтай хамт тавьсан малын толгойн чигтэй адил байдаг байна. Тахилгын ийм байгууламжийг Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Элст хөтөл, Бөгсийн гол; Өвөрхангай аймгийн Хужирт сумын Майхан толгой; Төв аймгийн Алтанбулаг сумын Жаргалантын гол зэрэг газруудад малтан шинжилсэн байна.

§ 4. ХИРГИСҮҮР

Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Манай орны нутаг дэвсгэрт хиргисүүр маш өргөн хэмжээгээр тархсан байдаг бөгөөд харин бусад булшуудыг бодвол харьцангуй бага малтан судлагдсан ажээ. Энэ нь хэд хэдэн учир шалтгаантай юм. Нэгдүгээрт, хиргисүүрийг цогцлон бүтээхдээ маш их хүч хөдөлмөр зарж, асар олон чулууг овоолон, том дугуй чулуун дараас үүсгэн байгуулсан байдаг учир малтан судлахад их хүч хөдөлмөр, цаг хугацаа шаардагддаг. Хоёрдугаарт хиргисүүрийн ихэнх нь тахилга тайлгын зориулалттай учир шинжилгээний хэрэглэгдэхүүн болохуйц эд өлгийн зүйлс маш ховор гардаг. Эдгээр учир шалтгааны улмаас хиргисүүрийг тэр бүр нарийвчлан судлалгүй явсаар ирсэн байна.

Хиргисүүрийг үйлдэгчид нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчид байсан гэдэг нь түүний дөрвөлжин булш, буган хөшөөтэй нэг дор нэгэн цогцолбор болон оршин байдгаас илэрхий. Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд янз бүр байдаг. Судлаачид Монгол орны Төв болон Баруун бүс нутаг даруй гуч орчим төрлийн хиргисүүр байгааг тэмдэглэсэн байна. Гэхдээ энэ бүгдэд зохион байгуулалтын нэгдмэл арга ажиглагддаг. Энэ нь юуны түрүүнд бүх хиргисүүрүүд том хэмжээний дугуй овгор чулуун дараастай байдагт оршино. Уг дараасаа тойруулан чулуу эгнүүлэн зоож дугуй, дөрвөлжин хүрээ татсан байдаг бөгөөд энэ хүрээний дотор болон гадна талаар чулуу овоолон шигтгэсэн олон тооны дөрвөлжин, дугуй

жижиг байгууламжуудыг байгуулсан байдаг. Зарим хиргисүүрүүдийн хүрээ нь давхар байх ч тохиолдол байдаг. Мөн зарим хиргисүүрүүдийн голын овгор дараасаас эхлэн хүрээ хүртэл дөрвөн зүгт нь чулуу шигтгэн суулган зам буюу цацраг гаргасан тохиолдол ч байна. Хиргисүүрүүд хэмжээний хувьд харилцан адилгүй байдаг бөгөөд зарим газарт 100 гаруй м голдоч бүхий хиргисүүрүүд ч таараллдаг. Одоогийн байдлаар манай орны нутаг дэвсгэрт цөөн тооны хиргисүүрийг малтан судлаад байна. Тухайлбал 1988 онд МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дурсгал судлах анги Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ойролцоо 5 хиргисүүрийг малтан судалжээ. Эдгээрийн хоёр нь гадуураа дөрвөлжин хүрээтэй, уг хүрээний дөрвөн буланд чулуун жижиг дараастай, үлдсэн гурав нь гадуураа хүрээгүй байсан байна. Гурван булшнаас оршуулгын шинж тэмдэг илэрсэн бөгөөд нөгөө хоёр нь тахилга тайлгын байгууламж байсан байна.

Монгол-Францын хамтарсан экспедиц 1997 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын савд 3 хиргисүүр, Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедиц 1999 онд Увс аймгийн Бөхмөрөн сумын Байрамын шилд нэгэн том хиргисүүрийг малтан шинжилсэн нь мөн нь л тахилга тайлгын байгууламж байжээ. Байрамын шилийн хиргисүүр 3 м өндөр, 22 м голдоч бүхий чулуун дараастай, дарааснаас дөрвөн зүгт дөрвөн өргөн зам татаж 60 м голдоч бүхий гаднах дугуй цагираган хүрээтэй холбосон байна. Хүрээ ба замын өргөн нь 3 м болно.

2001 онд Монгол-Бельгийн хамтарсан археологийн экспедици булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Харбухын голны баруун эрэгт нэгэн хиргисүүрийг малтан шинжилсэн байна. Энэ хиргисүүр нь гадна талаараа 25х27 м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй. 9 м голдоч бүхий овоолсон чулуун дараастай байсан бөгөөд гадна хүрээний зүүн талд хоёр эгнээ 8 чулуун дагуул байгууламжтай. Зүүн талд мөн 5 дагуул байгууламжтай байжээ. Зүүн талын дагуул байгууламжуудыг малтан үзэхэд 30-50 см-ийн гүнд нэг нэг адууны толгойг хиргисүүр лүү харуулан тавьсан байна. Хиргисүүрийг малтах явцад дараас чулууны дороос газар ухалгүй өнгөн хөрсөн дээр тавьж дээрээс нь чулуугаар дарсан хүний оршуулга илэрчээ. Хүнээ толгойг нь баруун тийш хандуулан тэнэгэр байдалтай дээш харуулан хэвтүүлж оршуулсан байна. Хүнээ дагалдуулан тавьсан ямар нэгэн эд өлгийн зүйлс олдоогүй боловч дараас чулууг цэвэрлэх явцад чулууны завсар хоорондоос гайхалтай сайн хадгалагдсан хүрэл ооль олдсон ажээ.

Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед холбогдуулан авч үздэг бөгөөд бүтэц зохион байгуулалтыг нь авч үзвэл, нас барагсадаа гол төлөв баруун болон баруун хойд зүг рүү чиглүүлэн тавьдаг байсан нь тодорхой байна. Мөн ихэнх тохиолдолд булшны нүх ухалгүй газрын хөрсөн дээр хүнээ тавин чулуугаар дарж оршуулдаг байсан нь тогтоогдсон.

§ 5. БУГАН ХӨШӨӨ

Буган хөшөө бол Монгол болон Төв Азийн нутаг дэвсгэр дээр хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин сууж байсан овог аймгийн түүх соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ.

Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг. Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бугын дүрсний оронд буюу завсар зайд адуу ирвэс, янгир, зээр зэрэг амьтад хааяа дүрсэлсэн байдаг. Ази, Европ тивийн хээр талын бүс нутагт хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед өргөн тархсан түүх соёлын гайхамшигт дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судлаж энэ завсар 700 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

Буган хөшөө голдуу 1-4 м м гаруй өндөр, 20-50 см зузаан, 30-80 см өргөн хэмжээтэй бөгөөд түүнийг үйлдэхдээ цоолбор, сийлбэр, уран баримлын аргуудыг хэрэглэсэн гэж хэлж болно. Бугаан хөшөөг хэд хэдээр нэг дор босгож, тэднийг тойруулан хэдэн арваас хэдэн зуу хүртэлх тахилгын жижиг чулуун өрлөг байгууламж, том дугуй далантай хиргисүүр, булш, дөрвөлжин булш зэргийг байгуулж, бүхэл бүтэн цогцолбор дурсгалыг бүрдүүлсэн байх нь олонтоо. Мөн буган хөшөөг, булш үйлдэхэд ашигласан зэргээс үзэхэд оршуулгын зан үйл, өвөг дээдсийг шүтэх шүтлэгтэй холбоотой нь маргаангүй харагдаж байна. Буган хөшөөг хэлбэр төрхийн хувьд үндсэн гурван төрөлд хуваан авч үздэг. Үүнд:

Нэгдүгээрт: Монгол-Өвөрбайгалын бугын загварчилсан дүрст бүхий буган хөшөө

Хоёрдугаарт: Саян-Алтайн амьтны “бодит” дүрст буган хөшөө

Гуравдугаарт: Ази-Европын амьтны дүрсгүй буган хөшөө хэмээн ангилдаг байна.

Эхний төрөлд хамаарах буган хөшөө тооны хувьд хамгийн олон байдаг бөгөөд манай орны Архангай, Өвөрхангай, Завхан, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт олдоод байгаа боловч гол шигүү тархсан төв нь Хангай, Хэнтийн уулсын орчны нутаг юм.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Хануй багийн (хуучин сум) төвөөс зүүн тийш Хануйн голын хойт дэнжид олон жижиг, 2-3 м голточтой дугуй далангаас бүтсэн том дөрвөлжин дугуй хэлбэрийн тахилын байгууламжууд хиригсүүр, том дөрвөлжин хашлага болон бусад байгууламж арван буган хөшөө бүхий ёслол оршуулгын цогцолбор дурсгал байдаг. Энд буй бүх хөшөөнөө бугыг загварчилан дүрсэлсэн бөгөөд нар, сар, зэр зэвсэг, гоёл чимэглэлийг сийлжээ. Эдгээр хөшөөнөөс жишээ болгон нэгийг авч үзвэл, хөшөөг 2,5 м өндөр, 0,48 м өргөн, 0,2 м зузаан саарал өнгийн боржин чулуугаар үйлджээ. Хөшөөний орой ташуу бөгөөд хөшөөг дээгүүр нь нэг эгнээ олон хонхор гаргаж, доогуур нь өргөн бүс сийлж гурав хуваажээ. Хөшөөний өргөн нүүрэн талын дээд оройн хэсэгт том жижиг хоёр онги (нар, сар), дунд хэсэгт арван бугын дүрсийг загварчилан урласны дотор гурван бугын цээжин хэсэг, нэг эх бие бусад нь бүтэн буга байна. Бугануудын дүрсний дунд хир нэг дугираг дүрсийг (толийг) бүх талбайгаар нь хонхойлон цоолборложээ. Бугануудыг хоншоороор нь хөшөөний зүүн дээд тал руу жишүүдүү хандуулж дүрсэлсэн ба харин хамгийн зүүн доод өнцгийн зайд дүрсэлсэн жижиг бугыг хөшөөний хажуу ирмэг рүү хоншоороор нь хандуулан эврийг эгц дээш босгон салаалуулж дүрсэлжээ. Эдгээр буганы доогуур 6 см өргөн бүс татаж нэгэн жижиг зууван эдлэлийг зүүж дүрсэлжээ. Бүснээс доош нэг бүтэн буга, хоёр дахь бугын цээжин бие, гуравдахь бугын эврийн хэсгийг дүрсэлжээ.

Хөшөөний баруун хажуугийн дээд оройн хэсэгт дүрс урлаагүй ба харин дунд хэсэгт долоон бугын дүрсийг урласнаас хоншоорыг зүүн дээш жишүүдүү хандуулан дүрсэлсэн дөрвөн бүтэн буга, нэг бугын цээжин хэсэг, нэг бугын эх бие, өөр нэг бугын бөгсөн бие (нүүрэн талд буй бугын) байна тэдгээрийн доогуур өргөн бүс татаж бөтгөр мөртэй хүрэл хутга, билүү зүүж дүрсэлжээ.

Хөшөөний өргөн ар талын дээд оройн хэсэгт том жижиг хоёр онги (нар, сар) дүрслээд доогуур нь нэг эгнээ олон хонхор гаргаж зааглан дунд хэсэгт есөн бугыг дүрсэлсний дотор хөшөөний орой руу хоншоороор нь жишүүдүү хандуулсан зургаан бугыг хос хосоор нь зэрэгцүүлж, хоёр бугын цээжин хэсэг нэг бугын эх биеийг дүрсэлжээ. Бугануудын зайд нум сум дүрсэлжээ. Тэдний доогуур өргөн бүс татаж, байлдааны алхан зээтүү, чинжаал, хоромсог зэргийг зүүж дүрсэлжээ.

Хөшөөний баруун хажуугийн нарийн талын дээд орой ба доод хэсэгт дүрсгүй ба дунд хэсэгт таван бугыг хоншоороор нь хөшөөний оройруу жишүүдүү хандуулан дүрсэлжээ. Бугануудын доор бүснээс дээш таван талтай зууван хэлбэрийн бамбай дүрсэлсэн байна. Энэ бүхнээс үзэхэд тухайн хөшөөний эх биеийн зайг бүхэлд нь бугын дүрсээр (22 буга) битүү бүрхэхийг эрмэлзэхдээ зөвхөн бүтэн бугын дүрсийг хөшөөний нэг талд, заримдаа хоёр талыг дамнуулан, жижиг цулгүй зайд бугын цээжин хэсэг, эврийг, эсхүл жижиг бугыг багтааж дүрсэлжээ.

Хөшөөнөө бугыг заавал хажуугаас харж ихэд гоёмсогоор урт хүзүүтэй, шовх өндөр сэрвээтэй, дугуйдуу бөмбөгөр хондлойтой, богинохон сүүлтэй, урт нарийхан хөлтэй дүрсэлдэг байжээ. Түүнчилэн бугын хоншоорыг шувууны хошуутай адил урт нарийн, эврийг хээ угалз мэт олон салаалуулан ар тийш нурууг дагуулан ихэд налуулж, зөвхөн хоёр салааг урагш гарган үзүүрийг өөд нь ээтийлгэн дүрсэлсэн байдаг. Бугын нүдийг томоор урлаж, эвэр хүзүү хоёрын хооронд нарийхан урт чихний дүрс цохиж гаргадаг бөгөөд хоёр хөлийг нугалан дүүлж харайж буй мэт хөдөлгөөн оруулж дүрсэлдэг. Хөшөөний их биеийг ороолгон сүрэг бугын эврийг ар тийш налуулж, хошууг өөд нь өлийлгөн бүгдийг харайж дүүлж буй мэт загварчлан дүрсэлснээс тэднийг хөнгөн хөдөлгөөнтэй ихэд тэмүүлэл бүхий дүртэй болгодог ажээ.

Буган хөшөөний нэг талд бугын оронд адууг дүрсэлсэн хөшөө Архангай аймгийн нутаг Алтан сандлаас олдсон. Буган чулуун хөшөөний бүснээс зүүж хутга, билүү, чинжал хутга, жад, нум, сум, саадаг, байлдааны зээтүү, сүх, бамбай зэрэг зэр зэвсгийн зүйлсийг дүрслэх бөгөөд тэдний заримыг гоёж чимэн дээр нь хээ зураас, дугуй, дөрвөлжин, хонхортой цохиж гаргасан байдгийг нарийвчлан үзэх нь чухал юм. Жишээ нь, Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Баянцагааны голын хөндийгөөс олдсон нэгэн буган чулуун хөшөөнөө байлдааны зээтүү мэт зэвсэг дүрслэн, түүнийхээ дээр 7 ба 31 дөрвөлжин хонхор цохиж гаргасан монгол нутагт эрт цагаас хэрэглэгдэж ирсэн цагалбарын нэгэн хэлбэр байж болох талтай юм.

Хоёрдахь төрлийн буган хөшөө Монгол улсын баруун талын Увс, Хөвсгөл, Ховд, Баян-Өлгий аймгуудын нутагт илүү тархсан байдаг. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын нутаг Дөрөлжийн ам, Цагаан уул сумын нутаг Хөшөөт, Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Алтансандаг уул, Тариат сумын Хурын ам, Ховд аймгийн Дарви сумын нутаг Чулуутын огтрох, Мөнххайрхан сумын Телегин ам, Мөст сумын Бодончын гол, Увс аймгийн Бөхмөрөн сумын Наран бэл, Баадайн ам зэрэг газруудаас олджээ.

Дөрөлжийн амны өргөн хөндийд том хиригсүүрийн дунд босгосон дөрвөн буган хөшөөний нэгийг цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн, 3 м өндөр, 0,4 м өргөн хэмжээтэй бөгөөд түүний оройн хэсэгт төвгөр гарган малгай мэт зүйлийг дүрсэлсэн ба хөшөөний оройн хэсгийг эргэн тойрон нэг эгнээ олон хонхор гаргаж доод талаар нь нарийвтар бүс татаж гурав заагласан байна. Хөшөөний баруун хажуугийн дээд оройн хэсэгт хоёр ташуу зураас, бүснээс зүүсэн хоёр үзүүр нь дээш тахийж ээтийсэн эдлэл, нүүрэн өргөн талын дээд хэсэгт онги (нар), дунд хэсэгт дөрвөн бугын нэгийг нь хөндлөн, гурвыг нь хөшөөний орой руу хандуулан цувуулж бодит байдлаар дүрсэлжээ. Зүүн хажуугийн дунд хэсгийн дээхнэ талд зогсч буй ганц буга, арын өргөн хажуугийн оройн хэсэгт онги /нар/, дунд хэсэгт таван бугыг хөшөөний оройруу хандуулан цувуулж, бодит байдлаар дүрсэлсэн ба бүсний доод талд чинжаал дүрсэлжээ.

Энэ төрлийн хөшөөний өөр нэг өвөрмөц дурсгал бол Алтан сандлаас олдсон хөшөө юм. Түүний нүүрэн талын дээд хэсэгт онги (нар) нүүрэн ба баруун хажууг ороолгон эзлүүлж хоёр бугыг загварчилан дүрсэлсэн ба баруун талын нарийн хэсэгт эвхэрч цагирагласан ирвэс, хоромсого, арын өргөн талд дороо үзүүр нь хоёр салаалсан иштэй онги, нум сум, хоромсого, дугуй толь, жадны гилбэр зэргийг гурван адууны бодит байдлаар дүрсэлсэн зургийн хажуу завсаруудад цоолборолжээ. Энэ хөшөөний онцлог бол буган хөшөөний хоёр төрлийн шинжийг (бугыг загварчилан, амьтныг бодитой дүрсэлсэн) хамтад нь агуулж буйд оршино.

Ийнхүү одоогийн байдлаар Монгол улсын нутгаас амьтныг бодит байдлаар дүрсэлсэн буган хөшөө нийтдээ 10 орчим олдод байна.

Буган хөшөөний гуравдах, өвөрмөц төрөл болох буга болон амьтдын дүрсгүй, харин нар сар, зэр зэвсэг, бүс зэргийг дүрсэлсэн хөшөө Монгол улсын баруун аймгуудын нутгаар цөөвтөр боловч тархсан байдаг.

Энэ төрлийн хөшөөг төлөөлүүлэн Увс аймгийн Түргэн сумын Дэлгэр мөрөн багийн төвд буй 1,1 м өндөр, 0,4 м өргөн, 0,25 м зузаан хөшөөг авч үзье. Хөшөөний дээд хэсгээр нарийн ховилон хонхор тойруулан татаад нүүрэн ба ар талын дээд хэсэгт тус бүр нэг онги, хажуу нарийн талд ташуу гурван зураас зуржээ. Хөшөөний дунд хэсгийн урд талд алхан зээтүү, дунд талд тахир эдлэл, арын өргөн талд саадганд буй нум дүрсэлжээ. Дээрхтэй адил хөшөө мөн сумын Бурхутайн өвөр, Улаангом хотын хойт талаар урсах Хархираагийн голын Цагаан сай, Тариалан сумын Чигээчний голын баруун дэнж, Завхан аймгийн Тэлмэн сумын нутаг, Сонгино сумын Айраг нуурын орчим, Увс аймгийн Хяргас сумын Ширгэн хөндийгөөс, Баянхонгор аймгийн Пунцаг овооноос тус тус олдсон байна.

Эрдэмтэд Төв Азийн нутагт өргөн тархсан дөрвөлжин булштай, буган хөшөөг он цагийн хувьд холбогдуулан авч үздэг хэдий ч дөрвөлжин булшийг үйлдэхэд буган хөшөөг авч ашигласан тохиолдол элбэг байгаа нь энэ хоёр дурсгалын он цагийн ялгааг харуулах чухал хэрэглэгдэхүүн болно. Тухайлбал, Архангай аймгийн Их Тамир сумын Баянцагаан голын адаг, Алтан сандал уулын бэл, Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын Хөшөөн тал, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Хядагийн эх, Мөрөн хотын орчим Дэлгэр мөрний хөндий, Галт сумын Нүхтийн ам, Булган аймгийн Орхон сумын төв, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол зэрэг олон газар буй дөрвөлжин булшны өнцөгт буган хөшөөг босгож байсан төдийгүй, булшны хана болгон түүний сийлбэрүүдийг далд ортол булж суулган, бүр хэвтүүлэн ашигласан нь илэрчээ. Түүгээр ч барахгүй Шивэртийн амны 2-р дөрвөлжин булшийг хийхэд арван буган хөшөө, хоёр зурагтай чулуун хавтанг ашигласнаас дөрвөөр нь булшны гадна талын (хойт урд) хана босгож, зургаагаар нь булшны доторхи (газрын гүнд) авсны таг, хана, бүр шал хийжээ. Мөн Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутаг Тэмээн чулууны аманд буй дөрвөлжин булшны өнцөгт нэгэн буган хөшөөний толгойг уруу харуулан босгосон байна. Эдгээр баримтаас хүрэл зэвсгийн эцэс, төмөр зэвсгийн түрүү үед хамаарах дөрвөлжин булшны өнцөгт хүрэл зэвсгийн дунд үед үүсч бүтээгдэж байсан буган хөшөөг түүний булангийн хөшөө болгон босгожээ гэж үзэхэд, түүний хажуу хананд сийлбэрийг далд ортол булсан, эсхүл бүр булшны нүхэн дэх авс хийсэн, толгойг уруу нь харуулж босгосон буган чулуун хөшөөг тэрхүү булшийг хийж үйлдэхэд зориулан жирийн материал болгон ашиглажээ хэмээн үзэхэд хүргэж байна. Энэ саналыг давхар бататгах бас нэгэн баримт бол булшны хажуу хана авсанд авч ашигласан буган хөшөө гол төлөв хугархай байгаагаас ч тодорхой.

Булган аймгийн Орхон сумын Баруун могой, Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөрөөгийн үзүүр, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Бат-Өлзий сумын нутаг, Баянхонгор аймгийн Жаргалант сумын Бугат зэрэг олон газраас олдсон хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт буган хөшөөн дээр бугыг дүрсэлдэгтэй адил амьтныг загварчлан дүрслэх аргын хэд хэдэн барилаар бугыг дүрсэлсэн байгаа нь буган хөшөөний он цагийг урагшлуулан авч үзэх бас нэг чухал хэрэглэгдэхүүн юм.

Буган хөшөөний он цагийг тогтооход хамгийн чухал үндсэн тулгуур хэрэглэгдэхүүн бол түүн дээр сийлсэн зэр зэвсгийн зүйлс бөгөөд тэдний хэлбэр төрхийг нарийвчлан үзвээс буган хөшөө зарим эрдэмтдийн үзэж байснаас нилээд эрт үүссэн бололтой.

Тухайлбал, Архангай аймгийн Их тамир сумын Арцтын амны буган хөшөөнөө сийлсэн бөгтөр мөртэй цагирган сэнжтэй хутга, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын орчим Дэлгэр мөрний хөндий, Уушгийн өвөр, Галт сумын төв, Булган аймгийн Орхон сумын төв зэрэг нилээд хэд хэдэн газраас олдсон зарим буган хөшөөнөө сийлсэн янгир, араатан амьтны толгойн хэлбэртэй иш тольт бүхий чинжаал хутгууд зэрэг зэр зэвсгийн зүйлс хүрэл зэвсгийн дунд үед ойролцоогоор МЭӨ II-I мянган жилд буюу МЭӨ XII-МЭӨ III зуунд холбогдох нь маргаангүй билээ.

Буган хөшөөнөө буганаас гадна металл зэр зэвсгийг олонтой дүрсэлсэн байдгаас түүнийг металл зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрч, үйлдвэрлэхүй хүчин улам эрчимтэй хөгжсөнөөр, хүй нэгдлийн овгийн байгууллын дотоод зохион байгуулалтанд үндсэн өөрчлөлт оруулж, эцгийн эрхт ёс тогтсон тэр үед дайчин эр хүнд зориулан босгосон хөшөө гэж үзэх онолын үндэслэл байна.

Буган хөшөөг хүрэл зэвсгийн эцэс төмөр зэвсгийн түрүү үеийн дөрвөлжин булшийг үйлдэхэд хөшөөг жирийн материал болгон өргөн ашигласан, түүн дээр хүрэл зэвсгийн дунд үед холбогдох зэр зэвсгийн зүйлсийг дүрсэлсэн, түүнийг баатар дайчин эр хүнд зориулан босгосон зэргээс манай ард түмний эртний түүх, урлаг, соёлын гайхамшигт дурсгал энэхүү сүрлэг баримал (монументальный скульптур) хүрэл зэвсгийн дунд үед үүсч төмөр зэвсгийн эхэн үеийг дуустал бүтээгдэж байжээ.

Буган хөшөөний гарал үүслийн асуудал нэг мөр шийдэгдээгүй боловч хүрэл зэвсгийн дунд үед Монгол улсын нутагт үүсэн бүтээгдэж цаашид Тува, Байгалийн наад бие нутгаар тархсан нь буган хөшөөний тархалт зэргээс тодорхой харрагдаж байна. Түүнчилэн Төв Азийн нутагт 700 орчим буган чулуун хөшөө мэдэгдэж байгаагийн 80 орчим хувь нь Монгол улсын нутагт байгаа явдал нь ч үүний баталгаа болох юм.

Буган хөшөө хэмээх гайхамшигт дурсгал анх Монголын төв нутагт хүрэл зэвсгийн дунд үед үүсч төмөр зэвсгийн түрүү гэхэд Монгол нутаг даяар түгэн дэлгэрч цаашдаа одоогийн Тува, Байгаль нуурын наад бие хүртэл өргөн тархсан ба улмаар Казакстан, Дундад Ази, Оренбургийн муж, Умарт Кавказ, Эльба мөрөний сав хүртэл цөөн тоогоор нэвтэрсэн суурьшмал иргэдийн дунд олон арваар бүтээгдэж байгаагүй нүүдэлчдийн дурсгал юм.

§ 6. ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ҮЕИЙН ХАДНЫ ЗУРАГ

Монгол орны нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн үлдээсэн өөр нэгэн хосгүй дурсгал бол хадны зураг юм.

Энэ үед холбогдох хадны зургийг улаан зосон, сийлмэл хэмээн ангилан авч үздэг. Улаан зосон зураг бол Монголын хүрэл зэвсгийн үеийн түүх соёлын нэгэн өвөрмөц дурсгал юм. Улаан зосон зургийг өөр өөр үед зурсан бөгөөд дүрс, утга агуулгаараа хорондоо өвөрмөц ялгаатай байдаг тул судлаачид хэдэн төрөл болгон ангилан судалж иржээ. Монгол орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь “Сэлэнгэ”-ийн төрлийн зосон зураг юм.

Монголын хадны улаан зосон зургийн хамгийн өргөн тархсан дурсгал болох “Сэлэнгийн” төрлийн зосон зураг Улаанбаатар хотын дүүрэг Богд хан уулын Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Гачуурын бичиг, Улаан-уул сумын нутаг Толжийн боом, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Зэлтэрийн голын Цагаан Оломын гарамны дэргэдээс, Хүйтний голын бичигт хад, Шарын голын Цагаан нуур, Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн хавцгай, Булган аймгийн Орхон сумын Баруун могой гол, Орхон гол, Бугат сумын Бичигт хад зэрэг газраас олджээ. Эдгээр зургууд нь ерөнхий сэдэв урласан арга барилын хувьд нэгдмэл байдаг гол онцлог нь оршдог. Энэ төрлийн зургийн бүхий л талын шинжийг агуулсан хамгийн сонгодог зураг бол Их тэнгэрийн амны зураг билээ. Эдгээр зургаа харахад дүрслэлийн төв хэсэгт нь дотроо олон дугуй толбо бүхий дөрвөлжин хашлага болон дугуй хүрээг зурсан байдаг ба түүний дээд талд далавчаа дэлгэсэн бүргэд шувуу, доогуур болон хажуу талаар нь хөтлөлцсөн хэдэн хүн, зэрэгцээ хоёр замаар адуу хөтлөн явж байгаа хүн зэргийг голчлон дүрсэлсэн байдаг. Энэ зураг нь хүрлийн үеийн овгийн нэгдлийг харуулсан баримт хэмээн судлаачид үздэг. Тэд дөрвөлжин хашлага буюу дугуй хүрээгээр овог аймгийг, түүний доторх олон толбоор овгийн гишүүдийг билигдсэн бөгөөд далавчаа дэлгэсэн шувуугаар тухайн овгийг хамгаалуулах гэсэн санааг илэрхийлсэн байж магадгүй хэмээн үзжээ.

Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөлийн Бичигт булаг, Шарын голын Цагаан нуурын орчмоос олдсон зосон зурагт хоёр зэрэгцээ замаар цувж яваа адуу, морь хөтөлсөн хүнийг дүрсэлсэнтэй ижил сэдэв зохиомж бүхий сийлмэл зурагтай чулуун хавтанг хожим авч ашиглан хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны доторхи чулуун авсны таг хийсэн нь Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Шивэртийн амнаас олдсон билээ. Энэ нь улаан зосон зураг их эртний үүсэлтэй болохыг харуулах сонирхолтой баримт юм.

Монголын хүрэл зэвсгийн үеийн хадны улаан зосон зургийн өвөрмөц нэгэн төрөл бол “Тэмээн чулууны ам”-ны төрлийн зураг юм. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутаг Тэмээн чулууны амны дөрвөлжин булшны ханын хавтгай чулуун дээр өрөөсөн гараа өргөөд эгнэж зогссон олон хүнийг дүрсэлсэн ба үүнтэй ижил эгнэж зогссон олон хүний зургийг Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэрьяа уулын Дугана хадны нэгэн дөрвөлжин булшны хананд зурсан байдаг. Энэ хоёр дурсгал хоорондоо хэдий хол зайтай боловч хүрэл зэвсгийн үед Монгол нутагт амьдарч байсан дөрвөлжин булшт овог аймгийнхны нэгэн ижил зан заншилтай байсныг харуулж байна.

Монгол нутагт амьдарч байсан хүрлийн үеийн овог аймгийн гишүүдийн оюун санааны хөгжилтийг харуулах өөр нэгэн томоохон дурсгал бол хадны сийлмэл дурсгал юм. Энэ төрлийн дурсгал монгол нутгийн хад чулуунд харьцангуй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг. Иймд чухам ямар зураг нь аль үед холбогдохыг тогтоох нь чухал байдаг. Хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үед Монголын хадны зураг хөгжилийнхөө дээд түвшинд хүрсэн төдийгүй манай орны ихэнх хадны зураг энэ үед холбогддог. Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зургууд зохиомж, сийлсэн арга барилын хувьд тод ялгагдана. Юуны түрүүнд ямар нэгэн амьтныг дүрслэхдээ загварчилан дүрсэлсэн байх явдал ажиглагддаг. Буга зэрэг амьтныг ийнхүү гаж загвар оруулан дүрслэх явдал хүрэл зэвсгийн дунд үеэс эхэлж төмөр зэвсгийн түрүү үе хүртэл үргэлжилсэн байдаг. Ан амьтдыг ганц нэгээр нь дүрслэхээс гадна олон сүргээр нь үйл явдлын өрнөл дунд дүрслэх явдал ихэд дэлгэрсэн байна. Мөн ан хийж байгаа анчид, хоорондоо дайтаж байгаа дайчид зэргийг ч олонтоо дүрсэлсэн нь бий. Голчлон дүрслэгдсэн араатан амьтад гэвэл янгир, буга, аргаль угалз, гахай үхэр, адуу тэмээ, морь, чоно, нохой болж байна.

Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зурагт тэргийг дүрслэх явдал олонтоо байдаг. Архангай аймгийн Чулуут голын сав дагуух хаданд хос морь хөллөсөн тэрэг, Хөвсгөл аймгийн цэцэрлэг сумын Модтой толгойн хаданд замын хоёр талаар цуварч яваа хэд хэдэн морин тэргийг дүрсэлжээ. Ийнхүү тэргийг моринд хөллөсөн байдалтайгаар дүрслэхээс гадна дангаар нь дүрслэх явдал ч бас тааралддаг. Манай орны Баянхонгор аймгийн Баянлиг сумын Их Баян уулын Бичигтийн ам, Шинэжинст сумын Цагаан хаалга, Гэцэлийн ус, Сонгинот, Бууцагаан сумын Гурван Мандал, Баян-Өлгий аймгийн Цагаан салаа, Бага Ойгор, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Өвгөнт, Үүдэнт, Хөтөл өтгө, Орхон сумын Орхон гол, Баруун могойн гол, Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хонгоржин, Ховд аймгийн Үенч сумын Ямаан ус, Хэнтий аймгийн Батширээт сумын Үзүүр цохио, Рашаан хад, Өмнөговь аймгийн Ноён сумын Аравжих, Булган сумын Хавцгайт, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Гучин ус сумын Их дөрөлж, Паалуу, Увс аймгийн Сагил сумын Гурван турга, Хандгайтын гол, Можоо, Бужаа, Төмөр цорго, Эхэн хүзүүвч, Өмнөговь сумын Шар булгын онц зэрэг олон газрын хаднаа хүрэл зэвсгийн үеийн хүмүүс өөрсдийн бүтээлээ мөнхлөн үлдээжээ.

§7. ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕ

ЧАНДМАНИЙ СОЁЛ

Хүн төрөлхтөний дамжин туулж ирсэн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийг бодоход төмөр зэвсгийн үе богино юм. Үнэн хэрэгтээ төмөр одоо хүртэл үйлдвэрлэлийн чухал үндсэн түүхий эд хэвээрээ байгаа бөгөөд түүний төрөл бүрийн хайлшаар хүн төрөлхтөн ихэнх хөдөлмөрийн багаж зэвсгээ үйлдвэрлэсэн хэвээр тул төмөр зэвсгийн үе одоо хүртэл үргэлжилсээр байна гэж үзэж болно. Гэвч энеолит болон хүрэл зэвсгийн үед эртний боолын нийгмийн соёл иргэншил үүссэн (Месопотами, Египет, Грек, Энэтхэг зэрэг) орнуудаас бусад нутагт амьдарч байсан хүй нэгдлийн үеийн овог аймгуудын түүхийг ангилан судлахад төмөр зэвсгийн түрүү үе гэдэг нэр томъёо хэрэглэдэг. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл дэлхийн орон бүрт харилцан адилгүй өөр өөр хугацаанд тархсан байна. Монгол нутагт оршин сууж байсан овог аймгууд МЭӨ VII-III зууны үед төмөр зэвсгийн түрүү үеийг дамжин туулсан юм. Энэ үед хүмүүс төмрийн хүдрийг хайлуулах аргыг эзэмшиж төмрөөр хөдөлмөрийн багаж зэвсэг, байлдааны зэр зэвсэг хийх болжээ. Хүрэл зэвсгийг хийдэг зэс, ялангуяа түүний найрлаганд ордог цагаан тугалганы орд ховор байдаг бол төмрийн хүдрийн орд тэр тусмаа төмрийн бор хүдрийн орд элбэг тархсан байдаг байна. Монгол нутагт төмрийн хүдрийг болхи аргаар хайлуулан байсан эртний орд үлдэц, тус орны төв, өмнөд захаар болон баруун аймгуудын нутгаас олдож байна. Харин төмрийн хүдрийг хайлуулж төмөр гаргаж авах нь зэсийн хүдрийг хайлуулахаас хэцүү бөгөөд үүний тулд 1350⁰ хэмийн илчтэй дулааныг гаргаж хайлуулах хэрэгтэй болдог байна..

Археологич Х.Пэрлээ Монголын аман ярианд тааралддаг “бух дарах” гэдэг нэр томъёо төмрийн үед Монгол нутагт хүдэр хайлуулж байсан арга, барилаас улбаалан ирсэн байж болох талтай хэмээн үзсэн бөгөөд бух дарах гэгч арга нь: үргэлж салхитай байдаг уулын онь хөтөл дээр, галлах амы нь салхи өөд харуулсан зуух барьж, түүнд илч ихтэй түлш хийж тэр түлшийн дээр төмрийн хүдэр овоолоод гал оруулж орхидог байжээ. Тэр зуух доторхи гал нь аяндаа салхинд үлээгдэн хөгжин түлш нь шатаж хүдрээ хайлуулахад төмөр нь ялгаран зуухны ёроолд тунадаг байжээ. Монгол нутагт дэлгэрсэн энэхүү хуучин арга нь төмрийн хүдрийг задгай галд ил хайлж байсан аргыг улам ахиулсан нь мэдээж ажээ. Дээрх арга төмөр хайлах, улайтгахдаа байгалийн салхийг ашиглахаа больж, хиймэл үлээгүүр-тулман хөөрөг ухаалан зохиож, төмөр дархлах голомт “хяс” хэрэглэх санаа сэдэхэд урьдчилал бэлтгэл болсон бололтой.

Монгол оронд төмөр зэвсэг үйлдвэрлэлд нэвтрэн, аж ахуйн багаж, байлдааны зэр зэвсгийг хийхэд эхлээд хүрэл төмрийг хослон хэрэглэж байгаад сүүлдээ гол төлөв төмрөөр хийх болсон боловч хүрлээр хийсэн зэвсэг багажийг хэрэгцээнээс бүрэн шахан гаргаж чадаагүй байжээ. Тухайлбал Өмнөговь аймгийн нутаг Борзонгийн говиос үзүүр талыг хүрлээр, шилбийг төмрөөр цутгаж хийсэн сумын зэв олонтоо олдож байгаа нь эртний хүн төмрийг хайлуулж хэрэглэх болсон боловч хүрлийг мөн хайлан хэрэглэж байсныг харуулж буй дурсгал юм.

Төмөр зэвсэг хүрэл зэвсгээс илүү бат бөх, хурц, уян хатан чанартай, төмрийг давтаж болдог зэрэг олон талаараа давамгайл ашигтай төдийгүй, төмрөөр зэвсэг багаж хийхэд хямд төсөр, хүдэр нь зэсийн хүдрээс элбэг тархсан байдаг.

Төмөр зэвсэг үйлдвэрлэлд нэвтрэхэд гарсан өөрчлөлтүүд нь хүн байгалийг эзэмших боломжийг ихээхэн өргөсгөж өгчээ. Тухайлбал, газар тариалангийн хөгжил бүхий л талаараа сайжрах боломжтой болж, гар урлал, нэн ялангуяа төмрийн дарх, зэр зэвсгийн хөгжил ихэд түргэссэн бөгөөд гэр, сууц болон тэрэг, чарга зэрэг тээврийн хэрэгслэл, янз бүрийн модон эдлэлийг хийх ажил ихээхэн боловсорчээ.

Төмөр зэвсгийн түрүү үед энгийн гутал хувцас оёхоос эхлээд мод, чулуу засч янзлах түүнчлэн хүдэр малтахад урьдаас илүү хурц, бат бөх, боловсронгуй хөдөлмөрийн багаж зэвсэгтэй болжээ. Энэ үед үйлдвэрлэл ба аж ахуйд чухал ач холбогдолтой төмөр сүх, зээтүү, чинжаал, хутга, хадаас зэрэг зүйл гарчээ.

Төмөр багаж зэвсэг, зэр зэвсэг хийж, төмөр боловсруулан үйлдэх болсон нь үйлдвэрлэх хүчний хөгжилд чухал ач холбогдолтой болжээ. Хүрлээр багаж зэвсэг цутгах ажлыг бодвол төмрийн хүдэр боловсруулж, төмөр дархалж, жирийн юм хийхэд ч нарийн барил-мэргэжил шаарддаг тул гар үйлдвэр эрхлэх мэргэжилт-гар дархчууд бий болсон байна. Гэвч гар үйлдвэр Монгол газарт бие даан хөгжиж чадаагүй, мал аж ахуйтай уялдан түүний нөхвөр туслах шинжтэй хөгжиж ирсэн онцлогтой.

Монгол нутагт амьдарч байсан овог аймгууд төмөр зэвсгийн үед аажмаар шилжин орсон ба хуучин хүрэл зэвсгийн үед үйлдэж байсан буган хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр, хадны зураг бүтээдэг заншлаа уламжлуулж, үргэлжлүүлж байсны зэрэгцээ зарим шинэ дурсгалыг үйлдэх болжээ.

Монгол оронд төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан хүмүүсийн аж ахуй, соёлын олон талт асуудлыг улируулан тодруулан судлахад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулнаа малтан шинжилсэн өвөрмөц хэлбэрийн булшууд онцгой ач холбогдолтой юм. МЗТСХЭ-ийн хүрэл төмөр зэвсгийн үеийн дурсгал судлах ангийнхан 1972-1974, 1981 онуудад энд 60 гаруй булшийг малтаж шинжилсэн байна. Эдгээр булш нь тодорхой нэгэн овог аймгийн дурсгал болох тул Монголын археологийн судалгаанд тусгай соёл болгон авч үздэг. Чандмань уулын булш гадаад хэлбэр төрх, үхэгсдийг оршуулсан зан үйлээрээ том дөрвөлжин чулуун далантай, чулуун далантай авсгүй, жижиг чулуун австай, дүнзэн бунхантай шороон булш гэсэн үндсэн дөрвөн төрөлд хамаарах ажээ.

I. Том дөрвөлжин чулуун далантай булш. Энэ төрөлд хамаарах булш Чандмань уулнаа арав гаруй байгаа бөгөөд эдгээрээс нэг булшийг малтаж шинжилсэн байна. Энэ булш нь дөрвөлжин хэлбэрийн 10 x 10 м хэмжээтэй чулуун далантай бөгөөд овоолсон далан чулууны хэмжээ нь гол хэсэгтээ 1 м-ийн өндөртэй. Уг булшны баруун талд дөрвөн хавтан чулууг ирмэгээр нь босгон үйлдсэн авсанд хоёр хөлийг атийлган толгойгоор нь баруун хойд зүг хандуулан, зүүн хажуугаар нь хэвтүүлэн тавьсан хүүхдийн оршуулга илэрсэн юм. Түүний толгойн харалдаа намхан хүзүүтэй хавтгай ёроолтой хар өнгийн жижиг шавар ваар дагалдуулан тавьжээ.

Мөн түүнчлэн төв хэсэгт 1 м-ийн гүнд бүдүүн шургааг модоор зангидаж хийсэн бунханд хэд хэдэн хүнийг оршуулсан байлаа. Малтлагын явцад хүн, амьтны эмх замбраагүй байрлалтай болсон яс олон тоогоор гарсан бөгөөд анхныхаа байрнаас хөдлөөгүй бололтой нэгэн араг ясыг цээжээр нь баруун урд зүг хандуулан зүүн хажуугаар нь хэвтүүлэн тавьсан байв. Энэхүү бунхныг тонуулчид туйлын их бусниулсан тул үхэгсэдээ чухам яаж оршуулсан нь тодорхойгүй авч хэд хэдэн хүн нэг дор оршуулсан болох нь булшнаас гарсан хүний яснаас мэдэгдэж байна. Эндээс хоёр талдаа нэвт нүхтэй хар шахмал (богхед) чулуурхуу зүйлээр хийсэн эдлэл хоёр ширхэг олдсон юм.

II. Чулуун далантай авсгүй булш. Энэ төрлийн булш хоёрыг Чандмань уулнаа малтсан бөгөөд эдгээр нь 10, 13-р булш юм. Эдгээр булшийг эрт үед тонуулчид тонон ихэд бусниулан, дагалдуулан тавьсан эд өлгийн зүйлсийг авсан бөгөөд адууны толгойн яс, хар, улаан хоёр өнгийн, хоёр төрлийн шавар ваар төдийхөн үлдсэн байлаа.

III. Жижиг чулуун австай булш. Чандмань уулнаа 20 гаруй жижиг чулуун австай булшийг малтан шинжилсэн юм. Газрын хөрсөнд ил иэдэгдэх далан чулуугүй, харин газрын хөрснөөс авсыг таглаж тавьсан зарим таглаа чулуу цухуйж мэдэгдэх төдий 0,8-1 м-ийн гүнд хүнээ оршуулсан байна. Чулуун авсны толгой тал нь баруун хойд зүг хандсан байх бөгөөд хажуу ханыг хавтан чулууг хажуу ирмэгээр нь босгож үйлдсэн ба хэд хэдэн хавтгай чулуу зэрэгцүүлэн тавьж тагласан байна. Мөн 3-10 ширхэг гонзгой урт чулууг босоогоор нь зэрэгцүүлж тавьж үйлдсэн худгархуу дугуй хэлбэртэй чулуун австай булш ч тохиолддог. Булшинд гол төлөв 1-2 хүнийг хоёр хөлийг нь атийлган баруун болон зүүн хажуугаар нь хэвтүүлж, толгойгоор нь баруун хойд зүг хандуулан тавьсан байдаг.

Эдгээр булшны ихэнх нь тоногдож, үхэгсэдийг дагуулж тавьсан эд өлгийн зүйлс үгүй боловч дутуу тоносон буюу огт хөндөгдөөгүй булшнаас хүрлээр хийсэн бэл, арал, хутга, чинжаал хутга, байлдааны зээтүү, гурван хянгатай шөрөгт зэв, гоёл чимэглэл, саадагны гох, ясаар хийсэн шөрөг, хавтгай ясан ялтас, сумын ясан зэв, төмөр хутга, шөрөг, хадаас, явуу, алаг бөөртэй шилэн эрих, шавар ваар сав зэрэг эд өлгийн зүйлс гарчээ.

IV. Дүнзэн бунхантай шороон булш. Энэ төрөлд хамаарах 20 гаруй булшийг малтан шинжилсэн байна. Энэ төрлийн булш нь газрын хөрсөн дээр мэдэгдэх тодорхой шинж тэмдэггүй бөгөөд 0,8-1 м-ийн гүнд 3-4 м урттай 3-4 гуалинг өнцгөөр нь зөрүүлж зангидан үйлдэж, мод болон чулуугаар шалласан бунханд олон хүнийг нэг дор оршуулсан байжээ. Бунхандаа хүнээ хоёр хөлийг нь ихэд атийлган баруун болон зүүн хажуугаар нь хэвтүүлэн толгойгоор нь баруун ба баруун хойд зүг хандуулан толгой дор нь чулуун дэр тавьж оршуулж, 10-12 гуалингаар тагласан байна.

Бунхныг хийсэн дүнз модыг ажиглахад хөрөөдөж огтлоогүй харин маш тэгшхэн их чадварлагаар цавчиж тасдсан бөгөөд Чандманьчууд хөрөө хараахан хэрэглэж байгаагүй бололтой.

Дүнзэн бунхантай шороон булш нь газрын хөрсөн дээр ил гарч ялгарсан тодорхой шинж тэмдэггүй учир тоногдож буснигдсан нь цөөн, гол төлөв анх оршуулсан янзаараа бүрэн бүтэн байдаг тул үхэгсэдийг дагалдуулан тавьсан эд өлгийн зүйлсээрээ харьцангуй баялаг байдаг. Эдгээр булшинд шавар ваар, толгойн орчмоос тугалган ба алтан ээмэг, хүзүүнд нь зүүж тавьсан бололтой алаг бөөртэй (нүдтэй) шилэн эрих, шилэн зүүлт, сувс явуу, тарваганы соёо, бугын араан зүүлт, бүсэлхий ташаа орчмоос хүрлээр хийсэн сумын зэв, чинжаал, байлдааны зээтүү, хутга, толь, арал, товруу, саадагны гох, унжлага, шөвөг, хадаас, амьтны дүрстэй баримал, гоёл чимэглэлийн зүйлс, ясаар хийсэн сумын зэв, товруу, бугын эврээр хийсэн бүсний ясан нүүр, жижиг ясан ялтас, ясан болцуу,

төмрөөр хийсэн чинжаал хутга, байлдааны зээтүү, модон сум, сумын мөс, сам, сав зэрэг олон нэр төрлийн эд өлгийн зүйлс олддогоос гадна булшнаас адуу, үхэр, хонь, ямаа, зээр, нохой зэрэг амьтдын яс гарчээ.

Чандмань уулын 2-р булшны шалыг нарийн сургааг болон чулуугаар хоёр хэсэглэн шалласан байх ба шал хийсэн сургаагнуудын хоёр үзүүр бунхны хоёр талын ханан доогуур орсон, өөрөөр хэлбэл, бунхныг барихаас өмнө модон шалыг тавьсан байхад нөгөө шал чулууны нэг нь ч хажуу ханан доогуур ороогүй бөгөөд чулуун шалыг бунхныг барьснаас хойш үйлдсэн байна. Үндсэндээ заавал шалан дээр оршуулдаг байжээ.

Зарим нэгэн модон бунхныг ханандаа үүдтэй (16-р булш) цонх мэт жижиг дөрвөлжин нүхтэй хийсэн ажиглагдана. Дээр дурдсан ажиглалтуудаас үзэхэд дүнзэн бунхантай шороон булшинд үхэгсэдийг увуу цувуу хооронд нь тодорхой зайтай оршуулж байжээ гэж бид үздэг.

Чандмань уулын үндсэн дөрвөн төрлийн булш нь үхэгсэдийнхээ дурсгалд зориулан бүтээсэн барилга байгууламжийн нарийн зохион байгуулалт бүтэц бүхий дурсгал бөгөөд тэдний бүтэц зохион байгуулалтыг нарийвчлан судалснаар зөвхөн оршуулгын зан үйлийг мэдээд зогсохгүй, Чандманьчууд аж ахуй, барилга байгууламжийн үлэмжхэн туршлагатай байсан болохыг давхар мэдэж болох юм.

Чандмань уулын булшнаас олдсон эд өлгийн зүйлсийг одоо авч үзье

Чинжаал хутга. Чандмань уулын булшнаас хүрэл ба төмрөөр хийсэн чинжаал хутга арав гаруй олдсон юм. Хүрэл чинжаал нь хэлбэр төрхөөрөө, эрвээхэйн далавч маягийн ааг бүхий зууван хэлбэрийн тольттой; товойлгон үйлдсэн шулуун аагтай, зууван хэлбэрийн тольттой; гүдгэрдүү аагтай, ишээ дагасан зэрэгцээ хоёр ховилтой, зууван хэлбэрийн тольттой; мөлгөрдүү давхар аагтай, ишнийхээ дотор талаар гүн ховиилтой, ховилынхоо хоёр талд хоёр тусгай сэнжтэй мөөг хэлбэрийн тольттой; ир нь угаадаа өргөсч ааг болсон цагирган сэнжтэй; эрвээхэйн далавчны маягийн аагтай ишээ дагасан ховил бүхий цагирган тольттой; нэг талдаа иртэй эрвээхэйн далавчны маягийн аагтай домгийн хоёр шувууны толгойг өөд өөдөөс нь харуулан товойлгон цутгаж урласан тольттой. Төмөр чинжаал нь, шулуун аагтай цагирган тольттой; ир нь угаараа өргөсч ааг болсон ишээ дагасан урт нэвт нүхтэй зууван дугуй хэлбэрийн тольттой гэсэн нийт есөн төрөл байна.

Зууван хэлбэрийн тольттой 1-3-р төрлийн хүрэл чинжаал Ази-Европын хээр тал нутагт төмөр зэвсгийн эхэн үед өргөн хэрэглэгдэж байсан ба үүнтэй ижил төстэй чинжаалыг Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт, Архангай аймгийн Батцэнгэл сумын Шивэртийн ам, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Хядагийн эх зэрэг нилээд газраас олдсон буган чулуун хөшөөнөө сийлж дүрсэлсэн байна. Хүрэл чинжаалын бариулыг дагасан нэвт нүхтэй хийдэг заншил монгол нутгаас олдсон хүрэл зэвсгийн үеийн чинжаалнаа ажиглагдаж байна.

Төмөр чинжаал нь хэмжээний хувьд хүрэл чинжаалаас харьцангуй том бөгөөд Монгол болон түүний хөрш зэргэлдээ нутгийн археологийн малтлагаас цөөн тоогоор олддог авч төмөр нь амархан исэлдэж булшинд удаан байхдаа зэвсгийн хэлбэр төрх нь эвдэгдэж мэдэгдэхгүй болоход хүрдэг.

Чандмань уулын 36-р булшнаас гарсан ширэн хуйтай хүрэл, төмөр чинжаал, 53-р булшнаас ширэлсэн модон хуйтай хүрэл хутга, хүрэл чинжаал хоёрыг хамт хийж тавьсан нь олдсон байна. Ийнхүү нэгэн хуйнд том жижиг хоёр хутга хийж зүүдэг заншил одоо хэр манай ард түмний дунд хадгалагдаж үлджээ.

Чандмань уулын булшнаа үхэгсдийн бүсэлхий орчмоос хутгууд олддог, мөн хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үеийн буган чулуун хөшөөний ар, өвөр, баруун, зүүн хажуугийн аль нэгэнд нь чичлүүр хутга зүүж дүрсэлсэн тохиолдол олонтоо байдгаас чандманьчууд чичлүүр хутгаа ширэн буюу ширэлсэн модон хуйнд хийж бүснээсээ зүүдэг байжээ.

Байлдааны зээтүү - Чандмань уулын булшнаас байлдааны хүрэл ба төмөр зээтүү (алх) арав орчим олдсон бөгөөд анхаарууштай нь чичлүүр хутга, байлдааны зээтүү хоёр гол төлөв нэгэн булшнаас хамт олдож байгаа тохиолдол юм.

Чандмань уулын булшнаас олдсон байлдааны хүрэл зээтүүнүүд хэмжээгээрээ ойролцоо 15-20 см урт, дугуй онгитой их бие нь бөөрөнхий хэлбэртэй бөгөөд хоёр торгон үзүүрийг шовхлож ирэлсэн байх ба зарим зээтүүний хоёр үзүүр нь тэнцүү биш байх боловч үндсэндээ нэгэн төрөлд оруулан үзэж болох юм. Чандмань уулын булшнаас гарч буй байлдааны хүрэл зээтүү нь элдэв чимэг үгүйн гадна, хоёр талдаа үзүүртэй тусгай илүү гарсан углуургын онги гараагүй байдгаараа бусад газраас олдсон ижил төрлийн зэвсгээс онцлог юм.

Чандманьчууд байлдааны зээтүүгээ 60 см орчим урт модоор ишлэж ишнийх нь үзүүрт хамгаалалт хүрэл үзүүр хийж байсан нь бас олдсон билээ. Энэ “үзүүр” нь зөвхөн байлдааны зээтүүний модон ишийг эвдрэлээс хамгаалаад зогсохгүй, түүнийг бүлж, цохих зэвсэг болгон ашигладаг учир үзүүрийг нь шовх хурц хийдэг байна.

Байлдааны зээтүү нь гол төлөв үхэгсдийн бүсэлхий орчмоос олдох ба мөн Төв Азид өргөн тархсан хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед хамаарах буган чулуун хөшөөнөө байлдааны сүх, зээтүү түүний бүснээс зүүж дүрсэлсэн байдгаас ч энэхүү зэвсгийг Чандманьчууд бүсэндээ зүүж явдаг байжээ. Эл зэвсгийг байлдаанд хэрэглэж байсныг Чандмань уулын булшнаас гарсан зарим хүний гавлын ясанд мөнхүү зэвсгээр цохиж алсан цөмөрхий ул мөр үлдсэнээс харж болно. Түүгээр ч үл барам, Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан ус хэмээх газарт буй хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт нэгэн

хүн эсрэг этгээдийн толгой руу байлдааны зээтүүгээр цохиж буйг дүрсэлснээс үзэхэд Чандмань уулын булшнаас гарсан хүрэл ба төмөр зээтүү зэвсгийг байлдаанд хэрэглэж байжээ.

Нум сум. Чандманьчуудын ан агнуур ба байлдаанд хэрэглэдэг хурдан зэвсэг нь нум сум байв. Чандманьчуудын нум одоогоор бүтнээрээ олдоогүй бөгөөд зөвхөн нумны эвдэрч өмхөрсөн жижиг хэсэг олдсон тул түүнийг бүхэлд нь сэргээн босгох боломжгүй байна. Гэвч монгол нутаг хүрэл, төмөр зэвсгийн үед өргөн тархсан буган чулуун хөшөөнөө дүрсэлсэнтэй ижил хэлбэрийн жижиг нумыг хэрэглэдэг байсан бололтой. Буган чулуун хөшөөнөө нумыг түүний бүснээс зүүсэн байдалтай дүрсэлдэг. Чандмань уулын булшнаас нумны үлдэгдэл үхэгсдийн бүсэлхий орчмоос олддог зэргээс үзэхүл чандманьчууд нумаа бүсэлхий орчмоосоо зүүж явдаг байжээ. Чандмань уулын булшнаас харвуулын сумны хүрэл ба ясан зэв олон тоогоор олдсон бөгөөд хийсэн эд хэлбэр төрхөөр хэд хэдэн төрөл юм.

Чандмань уулын булшнаас олдсон харвуулын сумны хүрэл зэв нь бүгд гурван хянгатай бөгөөд дотроо шөрөгт, онгит хоёр янз юм. Зарим хүрэл зэвийн мөс суулгадаг хөндий хэсгийн хажууд мөс хугарахад авч байхад зориулан зууван хэлбэрийн жижиг нүх гаргасан байна.

Чандмань уулын булшнаас ясаар /бугын эврээр/ хийсэн сумны зэв цөөн тоогоор олдсон боловч хэлбэр төрхөөр нь гурван талтай шөрөгт, гурван талтай онгит, дөрвөн талтай онгит, гурван талтай зуулгат, ганц сөрөгтэй шөрөгт гэж тав ангилан үздэг.

Чандманьчууд сумаа хүрэл буюу төмөр гохтой, амьтан ургамлын гаралтай ширэн, модон, үйсэн саадганд хийж бүснээсээ зүүж авч явдаг байжээ. Чандмань уулын булшнаас бүтэн саадаг нэг ч олддоогүй тул түүний хэв хийцний тухай тодорхой өгүүлэх боломжгүй, харин үйсэн саадагны тасархай олдсон бөгөөд Чандманьчууд Төв Азийн нутагт өргөн тархсан хүрэл, төмөр зэвсгийн эхэн үед холбогдох буган чулуун хөшөөний бүснээс зүүж дүрсэлсэн саадагтай ижил төстэй саадаг хэрэглэж байсан хэмээн үзэж болно. Чандмань уулын булшинд үхэгсэдийн бүсэлхий орчмоос үзүүрээрээ нэгэн зүг хандсан сумны зэв багцаараа нэг дороос саадагны гохны ойролцоо олддог, мөн хүрэл, төмөр зэвсгийн эхэн үеийн буган чулуун хөшөөнаа саадгийг бүснээс зүүж дүрсэлдэг зэргээс Чандманьчууд саадгаа хүрэл буюу төмөр гохоор бүснээсээ зүүж явдаг байжээ хэмээн үзэж болно.

Саадагны гох-Чандмань уулын булшнаас хүрэл, төмрөөр хийсэн саадагны гох нилээд олдсоныг хийсэн арга, хэлбэр төрхөөр нь:

Хавтгай хүрлийн үзүүрийг махийлган дээд талд нь дугуй буюу дөрвөлжин нүхэлж хийсэн, нимгэн хавтгай хүрлийн нэг үзүүрийг махийлган нөгөө үзүүрийг эсрэг тал руу нь хуйлж сэнж болгосон, цагирган сэнжтэй хүрэл буюу төмөр саадагны гох, барсын төрлийн амаа ангайсан амьтны толгойн цутгавартай, хажуудаа сэнжтэй саадагны хүрэл гох олджээ.

Хутга. Чандмань уулын булшнаас хүрэл ба төмрөөр хийсэн хутга арав гаруй олдсон боловч төмөр хутга нь ихэд зэвэрч муудсан тул түүний хэлбэр төрхийг нарийвчлан авч үзэх боломжгүй юм. Хүрэл хутга нь бүгд тэгш мөртэй ба харин түүний ишний тольт нь өөр өөр хэлбэртэй юм.

Хутгыг ширэн буюу ширэлсэн модон хуйнд хийж бүснээсээ зүүж явдаг байсан бололтой. Жишээ нь 53-р булшнаас чичлүүр хутга, жирийн жижиг хүрэл хутга хоёрыг ширэлсэн модон хуйнд хийж тавьсан нь оршуулсан хүний бүсний орчмоос олджээ. Мөн 4-р булшнаас ширийг нарийн шөрмөс утсаар үдэж хийсэн хуйтай хүрэл хутга олдсон ба хуйг нь зөвхөн түүний ирийг хамгаалж хийсэн байна. Хүрэл хутганы сэнж ихэд элэгдсэн байх нь сэнжтэй хүрэл хутганы зөвхөн ирэнд нь хуй хийж сэнжнээс нь зүүж явдаг байсан бололтой гэж үзэхэд, буган чулуун хөшөөнөө сэнжтэй хүрэл хутганы зөвхөн ирэнд нь хуй хийгээд сэнжнээс нь биш, хуйнаас нь бүсэндээ зүүсэн дүрсэлдэг нь сонирхолтой. Чандмань уулын булшнаас хүрэл, ясаар хийсэн шөвөг хэд хэд олдсон билээ.

Чандмань уулын булшнаас хар бараан өнгийн гонзгой хайрган чулууны дээд талд нүхлэж хийсэн билүү олдсон бөгөөд түүнд зэр зэвсэг ирлэж байснаас хоёр тал нь ихэд элэгджээ. Билүүг Монголын хүрэл, төмөр зэвсгийн эхэн үеийн буган хөшөөнөө бүснээс зүүж дүрсэлсэн байдаг. Чандмань уулын булшнаас одоогоор үхэгсэдийн хамт морь малыг бүтнээр нь оршуулсан оршуулга олддоогүй, харин үхэгсэдийг дагалдуулан малын толгой, зарим яс зэргийг тавьсан байдаг.

Чандмань уулын булшнаас олом, хазаар, бүс, тэлээний хүрэл арал нэлээд олдсон нь бүгд гадна талдаа хөдөлдөггүй хэлтэй, ихэнх нь дундуураа хөндөлтэй юм.

Чандмань уулын 11-р булшнаас бугын эврээр хийсэн нүүрэн талдаа буга, согоо бас өөр нэгэн амьтны дүрс сийлсэн бүсний нүүр (арал) олдсон бөгөөд одоогоор манай орон болон хөрш зэргэлдээх нутгаас одоо хэр үүнтэй ижил бүсний нүүр олддоогүй байна.

Чандмань уулын булшнаас морь малын элдэв тоног хэрэгсэлд хамруулан авч үзэж болох суран эдлэлийн үзүүрт хийж байсан бололтой хүрэл шахуурга (бөгж) ясан шахуурга, төмөр гархи, хүрэл, төмөр товруу зэрэг эд өлгийн зүйл нилээд олдсон юм. Хүрэл толь нилээд олдсон ба тэдний зарим нь эсгий, давуу гэртэй байжээ. Толь нь булшинд эр, эм алиных нь ч дэргэдээс олдох ба тэдний сэнж нь ихэд элэгдснээс үргэлж хэрэглэж, байнга зүүж явдаг байсан нь илэрхий. Эдгээр толь бүгд дугуй хэлбэртэй хажуудаа бариул сэнжтэй юм. Толийг чухам хаанаасаа зүүж явдаг байв гэдэг нь жижиг боловч сонирхолтой асуудал билээ. Булшнаас хүрэл толь гол төлөв үхэгсдийн бүсэлхий орчмоос олдох тул түүнийг бүснээсээ зүүж явдаг байжээ хэмээн үзэхэд буган чулуун хөшөөнөө зөвхөн зэр зэвсгийн зүйлийг бүснээсээ зүүж дүрсэлдгээс, харин толийг бүснээсээ зүүж дүрсэлсэн нь огт үгүй бөгөөд түүнийг хөшөөний эх биеэнд бүснээс дээш бугануудын дүрснүүдийн завсар хооронд

хонхойлгон цохиж урласан байдаг билээ. Үүнээс үзэхэд тэр үеийн хүмүүс толийг хувцасныхаа энгэрт хадаж зүүдэг байсан бололтой. Чандмань уулын булшнаас олдсон эд өлгийн зүйлсийн дотор гоёл чимэглэлийн зүйл чухал суурийг эзлэх бөгөөд тэднийг хүрэл, яс, бугын эвэр, хар тугалга, алтаар хийсэн ба зарим зэр зэвсэг, сав суулгыг хээ угалзалж эсхүл тэдний дээр амьтны дүрс урлаж гоёж чимсэн байна. Эндээс задгай цагирган сэнжтэй мушигмал унжлагатай алтан шармал, дэгрээ маягийн хар тугалган, дөрөөн хэлбэрийн хар тугалган, ердийн хар тугалган гархи дөрвөн төрлийн ээмэг олдож мэдэгдээд байна. Мөн буга маралын араан зүүлт, тарваганы соёон зүүлт, цагаан сувс, хөх буюу ногоон өнгийн шилэн зүүлт, оюу зүүлт, алаг бөөртэй (нүдтэй) шилэн эрхи, явуу, хүрлээр хийсэн явуу, ясан ба занарлаг чулуулаг (богхед)-аар хийсэн жижиг ялтас, хүрэл товруу бүхий чимэглэл, хүрэл товч, товруу, богийн шагай, амьтны сийлбэртэй бүсний ясан нүүр, хүрлээр хийсэн адуу, тэмээний толгой, шар шувууны толгойн дүрстэй товруу, даруулга, модон сам зэрэг олон төрлийн гоёл чимэглэлийн холбогдолтой дурсгал олдсон билээ.

Буга, маралын араа, тарваганы соёо, цагаан сувсаар (цагаан өнгийн зуурмагаар) гоёл чимэглэл хийж түүнийг хүзүү бугуйндаа зүүх буюу хувцсандаа хаддаг заншил Монгол нутагт эрт цагаас уламжлалтай бөгөөд түүнийг нилээд хожуу үе хүртэл хэрэглэж байжээ. Явуу нэн эрт цагт Энэтхэгийн далай ба Номхон далайн баруун сав нутгаас дамжиж манай оронд иржээ.

Алаг бөөртэй шилэн эрхийг эрдэмтэд Египет нутагт анх гарсан эд хэмээн үздэг бөгөөд тэр нь Умард Кавказ, Дундад Азийн нутгаас хүрэл, төмөр зэвсгийн эхэн үеийн булшнаас цөөн тоогоор олддог бөгөөд Чандмань уулын булшнаас хөх, ногоон, цагаан, бор өнгийн алаг бөөртэй шилэн эрхи олон тоогоор олдсон нь урьд өмнө манай орны хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үеийн дурсгалаас олдож байгаагүй шинэ олдвор юм.

Чандмань уулын булшнаас шавар, мод, хүрлээр хийсэн сав суулгын зүйлс олдсон бөгөөд сав суулганы ихэнхийг шавар сав эзлэх ба хүрлээр хийсэн тогоо нэг гарсан юм. Модон сав суулганы хэсэг хэд хэд олдсон боловч ихэд ялзарч муудсан тул нарийвчлан судлах боломж бараг үгүй юм. Чандмань уулын булшнаас олдсон шавар сав нь гол төлөв хар саарал, хурц улаан шаргал хоёр төрлийн өнгөтэй бөгөөд шавар зуурмаг нь нарийн ширхэгтэй, шатаалт маш сайтай гараар хийсэн, хавтгай ёроолтой бөгөөд тэр үед ваар хийх хүрдийг сэдэж хэрэглэж хараахан амжаагүй байжээ.

Шавар савыг бариад дараа нь гадна талыг нь маш сайн өнгөлж шатаадаг байжээ. Чандманьчуудын өдөр тутам хэрэглэх аж ахуйн үйл ажиллагаатай уялдан шавар сав суулгыг хэрэглээний зориулалтаас нь хамааран хэд хэдэн төрлийн хэлбэртэй хийдэг байжээ. Чандмань уулын булшнаас олдсон шавар савыг хэлбэр төрхөөр нь нь ангилаж үзэхэд:

1. Өндөр нарийхан хүзүүтэй цүлхэн бөөртэй шавар сав. Энэ төрлийн шавар сав Чандмань уулын булшнаас бусад төрлийн савнаас олон олдсон ба гол төлөв амсар, мөрөөрөө хааяа бөөрөө тойруулж урласан хэд хэдэн гүвгэртэй, эсхүл мөрөөрөө тойрч ханалж сараачсан хээтэй байдаг. Мөн энэ төрлийн шавар ваарны заримынх нь мөрөөр хээлж, хажуу бөөрөнд нь хар өнгийн будгаар элдэв тамга, дүрс урласан байх нь тохиолдоно. Чандмань уулын булшнаас гарсан нэгэн шавар ваарны бөөрөн дээр хоёр буга, нэг янгирын дүрсийг маш гайхамшигтай товойлгон дүрсэлсэн байна. 2. Умгар амтай, хажуудаа сэнжтэй хавтгай ёроолтой жижиг шавар сав. Эдгээр савны зарим нь амсараараа тойрсон ганц гөвгөртэй, эсхүл цулгуй, мөн бөөрөө олон давхар гүдгэр зураасан чимэгтэй байна. 3. Хавтгай ёроолтой хувилхуу маягийн шавар сав. Эдгээр савны зарим нь бөөрөөрөө тойрсон хэдэн гөвгөртэй байхаас гадна гол төлөв амсарынхаа хажууд хоёроос дөрвөн товгор бариул (чихтэй)-тай. 4. Хажуудаа бариул сэнжтэй аяга маягийн шавар сав. 5. Өргөн намхан хүзүүтэй, хавтгай ёроолтой элдэв гоёл чимэггүй шавар сав. 6. Бумбархуу маягийн хажуу бөөрөндөө товгортой шавар сав. 7. Дашмагархуу маягийн шавар сав. Энэхүү сав нь зууван хэлбэртэй бүдүүн зууван хүзүүтэй бөгөөд түүний хажуу хоёр бөөрийг арьсан дашмагны оёо мэт хэрчлээстэй гөвгөр гаргаж чимсэн байна. 8. Хавтгай ёроолтой, дөрвөлжин хэвтэй, намхан ханатай хайруул маягийн шавар сав. Чандмань уулын булшнаас дээрхи найман төрлийн ихэнх нь эвдэрч хагараагүй бүтэн 60 гаруй шавар сав олдсон бөгөөд тэдний ахуй амьдралд шавар сав суулга чухал хэрэгцээтэй байжээ.

Чандманьчууд эр, эм, хүүхэд гэж ялгалгүй үхэгсдийн толгойн зулайн харалдаа дээд талд, мөн нүүрний тушаа шавар сав тавьдаг заншилтай байсан байна. Өндөр нарийхан хүзүүтэй цүлхэн бөөртэй дашмагрхуу маягийн хоёр төрлийн шавар савыг ихэд гоёж чимсэн ба тэдний гадаад хана нь хөө тортог болоогүй мөн түүнчлэн нарийхан өндөр хүзүүтэй зэргээс үзэхэд эдгээр саванд юм чанадаггүй, харин шингэн, нунтаг зүйлийг хадгалдаг байжээ. Бусад таван төрлийн савны хана нь ихэд хөө тортог болсон, гадна талд нь зузаан хөө дагтаршин тогтсон, зориуд чих, бариул, дүүжлэх сэнж гаргаж, харьцангуй том амтай үйлдсэн зэргээс эдгээр саванд хоол унд чанадаг байжээ. Чандмань уулын 33-р булшнаас цөгцөн хөлтэй ирмэгтээ босоо, зууван хоёр сэнжин бариултай, их биеийг нь тойруулан хонхойлгон гаргасан зэрэгцээ хоёр бүстэй цутгамал хүрэл тогоо олдсон бөгөөд түүнтэй ижил төстэй хоёр хүрэл тогоо Монголын үндэсний түүхийн музейд хадгалагдаж байдаг.

Чандмань уулын булшны судалгаанаас үзэхэд, Монгол улсын нутгийн баруун хойт хэсэгт тухайн үед Төв Азийн хээр тал нутагт амьдарч байсан аймгуудтай ерөнхий шинжээрээ ижил боловч орон нутгийн биеэ даасан шинж чанар бүхий соёлтой нэгэн аймаг байжээ. Гэвч Чандманий аймгийн оршин тогтнож байсан газар хир зэрэг өргөн цар хүрээтэй байсан, түүнчлэн зүүн, баруун урд зүгтээ чухам аль орчмоор зааглагдаж байсан нь одоогоор тодорхойгүй. Монгол нутагт Чандмань уулын

дөрвөн төрлийн булштай ижил булшыг урьд хожид малтан шинжилсэн нь үгүй учир энэхүү соёл зөвхөн Чандмань уулын орчим хэсэгхэн газар олон аймгуудын залгаа нутагт тархаж уу, эсхүл монгол орны баруун хэсэгт ихээхэн газар нутагтай байв уу гэдэг асуудалд одоогоор хариулах боломж үгүй байна.

Чандманьчуудын аймаг Төв ба Дорнод Монгол, Байгаль нуурын наад бие нутаг, Тува, Алтайн оршин суугчидтай эдийн боловсрол, дүрслэх урлагийн хувьд ижил төстэй байгаа нь түүх, нийгмийн хөгжлийн нийтлэг байдал, түүнчлэн газар зүйн байршлаараа хөрш зэргэлдээ нөхцлөөс шууд хамаарах билээ. Чандмань уулын дөрвөн төрлийн булшны нэгээс хоёр төрөл нь хөрш зэргэлдээ нутгийн төмөр зэвсгийн үеийн дурсгалд байх авч дөрвүүлээ хамт тохиолдсон нь үгүй билээ. Энэ талаараа Төв Азийн дөрвөлжин булштан, Алтайн маймир-пазрыкууд, Минусын хотгорын тагаруудтай төстэй тал байвч онцлог ялгаатай, дүнзэн бунхантай шороон булшны бүтэц зохион байгуулалт түүний дотор үхэгсэдийг бүлгээр оршуулсан зан үйл зэргээрээ Тувагийн уюукуудын дурсгалтай бусдаас илүү ойр нягт холбоотой нь харагдаж байна. Түүнчлэн Чандмань уулын жижиг чулуун австай булш уюукийн “чулуун хайрцагтай” хэмээн нэрлэгдэх булштай мөн Монголын төв ба дорнод хэсгээс олдох ижил зохион байгуулалттай зарим булш, улмаар дөрвөлжин булшны зарим нэгтэй ижилсэж болох талууд бас ажиглагдаж байна.

Дөрвөлжин чулуун (том) далантай модон бунхан, чулуун австай булштай ижил гадаад зохион байгуулалттай булш Монголын төв нутагт тохиолдох ба энэ төрлийн булш доторхи зохион байгуулалтаараа Тувагийн дугуй далантай дүнзэн бунхантай булштай нилээд ижилсэж болох юм. Чулуун далантай авсгүй нүхэнд хүнээ оршуулсан булш Монголын өмнөд ба төв нутагт мөн Тувагийн нутгаас ч бас олддог. Чандманьчуудын дөрвөн төрлийн булшнаас гурав нь зохион байгуулалтын зарим шинжээрээ Монгол ба Тува нутгийн алинаас ч олдож буй хосолмол шинжтэй болохыг бид дурьдлаа. Үхэгсэдээ баруун буюу зүүн хажуугаар нь хэвтүүлэн гар хөлийг нь ихэд атийлгаж оршуулдаг заншил Тува, Алтай, Тянь-Шань, Памирын нутагт мөн үед амьдрагсадын дунд өргөн дэлгэрсэн ажээ. Гэтэл үхэгсэддээ чулуун дэр тавих ёс Тувагийн уюукчуудын нэгэн адил Төв Азийн дөрвөлжин булштанд байсан төдийгүй Чандмань уулын булшинд үхэгсэдийг оршуулсан байдал, оршуулгын зарим зан үйл хожмын Монгол угсаатны үхэгсэдээ оршуулж байсан зан үйлтэй зарим талаараа ижил байна.

Чандмань уулын булшнаас гар дамжин шаталсан худалдааны замаар ирсэн бололтой Египетийн гаралтай алаг бөөртэй (нүдтэй) шилэн эрих, зөвхөн Энэтхэгийн далайн баруун хойт эрэг, Номхон далайн баруун эргээр байдаг явуу зэрэг харь орны гаралтай зүйлс ч байна. Иймээс Чандманьчууд өөрийн хөрш зэргэлдээ орны болон нилээд хол нутгийн аймгуудтай худалдаа, соёлын харилцаатай байжээ хэмээн үзэж болох юм. Энэхүү харьцаа хир зэрэг тогтмол ямар замаар явагдаж байсан тухай баримт хомс байна. Монгол улсын баруун зах нутагт төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан Чандманьчууд өөрийн бие даасан соёл бүхий нэгэн аймаг байжээ. Энэхүү аймаг нэг талаас Монголын ихэнх, Байгаль нуурын наад бие нутгийн дөрвөлжин булштан, Алтай Маймир-Пазрык зэрэг нүүдэлчид нөгөө талаас Тувагийн уюукууд, Минусын хотгорын тагарчууд зэрэг хагас нүүдэлчин аймгуудын хооронд оршиж тэдэнтэй аль алинтай нь ойр харьцаатай, хөрш зэргэлдээ амьдарч байсан учир энэхүү дөрвөн аймгийн аль алиных нь нөлөө тэдний археологийн дурсгалаас тодорхой харагдаж байна. Иймээс Чандманьчууд, дурдсан дөрвөн аймгийн завсар нүүдэлчид хагас суурьшмал иргэдийн соёлын аль алины тусгалыг агуулсан тийм нэгэн жижиг аймаг байсан бололтой.

Угсаа гарлын судалгаа бол түүхийн шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлуудын нэг бөгөөд энэ асуудлыг археологи, антропологи, лингвистик ба аман зохиол судлал зэрэг олон салбар ухааны оролцоотой шийдвэрлэдэг билээ. Гэтэл бид одоо зөвхөн археологи, антропологийн судалгаанд тулгуурлан Чандманьчуудын угсаатны түүхийн зарим асуудлыг боломжийн хирээр хөндөн авч үзэж болох юм.

1972-1974 онд малтсан булшнаас гарсан Чандманьчуудын 141 хүний толгойн ясанд хийсэн палеоантропологийн судалгаанаас тэдний дунд цэвэр монгол, цэвэр европ төрхийн хүмүүс цөөн тоогоор байгаа авч тэдний ихэнх нь энэ хоёр төрлийн завсрын шинжтэй байна гэж үзжээ.

Чандманьчуудын толгойн ясны антропологийн судалгааны хэмжээсийг мөн үеийн Тува, Алтай, Казахстан, Минусын хотгорынхоос ихээхэн ялгаатай, харин Тувагийнхаас хэдийгээр ялгагдах боловч ерөнхийдөө бусдаас ойролцоо төстэй байжээ.

Чандмань уулын орчимд өөрийн соёлтой антропологи болон археологийн бүх хэрэглэгдэхүүнээрээ Тувагийн уюукчуудтай бусдаас илүү төстэй тэдний ойр төрлийн нэгэн аймаг төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байжээ.

Чандманьчуудыг түүхэн сурвалжид нэр нь хдгалагдаж үлдсэн “Динлин” аймгийнхан болов уу гэсэн урьдчилсан таамаглалыг зарим антропологич гаргасан байдаг. Гэвч Динлиний асуудлаар Оросын эрдэмтэн Г.К.Грум-Гржимайло, В.В.Радлов нараас эхлэн түүхч, археологич олон судлаачид саналаа гаргасан байдаг билээ. Минусын хотгорт МЭӨ VII-III зууны үед байсан тагарын соёлынхныг түүхэн сурвалж бичигт үлдсэн динлинүүд хэмээн С.А. Теплоухов, Г.Ф. Дебев, С.В. Киселев, Л.Р. Кызласов, Н.Л. Гумилев нарын зэрэг олон эрдэмтэд үздэг ба энэ санал нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ. В.В.Волков динлинчүүдийг европ төрхийн хүмүүс байсан гэдэг нь батлагдахгүй байна гэж үзжээ. Динлиний оршин байсан нутгийн тухай Н.Я.Бичурин “Динлинчүүд Енисейгээс дорно зүгт Байгаль

хүртэл Ангарын зүүн гар талын нутгийг эзлэж байлаа” хэмээн бичсэнээс үзэхэд Чандманьчуудын нутаглаж байсан нутаг динлиний нутагт багтан орохгүй байна.

Эрдэмтдийн үзэж байгаагаар тагарын соёлынхон Динлинчүүд бол Чандманьчууд бас адил динлинчүүд байх нөхцөлгүй өөр аймаг байж болох юм. Түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдсэн динлиний нутаг багтаж орохгүй байгаа бөгөөд Чандмань уулын булш Динлин нарынх биш бололтой. Харин Чандмань уул нь эртний гяньгун нарын нутагт багтах бөгөөд тэдний өвөг дээдсийн дурсгал ч байж болох авч энэ асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

§ 8. ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕИЙН ТҮҮВЭР ОЛДВОР

Төмөр зэвсгийн түрүү үед холбогдох эд өлгийн зүйлс булшнаас олдохоос гадна түүвэр маягаар манай орны нутгаас олддог байна.

Төмөр зэвсгийн эхэн үеийн түүвэр олдвор нь хэрэглэгээнийхээ зориулалтаараа болон хэлбэр төрлөөрөө олон янз байдаг учир эрдэмтэд тэднийг ангилан судалдаг юм.

Төмөр зэвсгийн эхэн үед холбогдох хүрэл хутга нь төмөр зэвсгийн хүрэл зэвсгийн үеийн хутгуудыг бодвол хэмжээгээрээ харьцангуй жижиг ба мөр нь үндсэндээ шулуундуу байдгаараа ялгаатай. Эдгээр хутгыг судлаачид тольт, сэнж, ишинд нь гаргасан нүхний хэлбэрээр олон төрөл болгон ялгаж үздэг боловч бидний үзэж буйгаар төмөр зэвсгийн эхэн үед холбогдох хүрэл хутгыг:

1. Ишнийхээ үзүүрт нэвт нүхтэй 2.Цагирган тольттой 3. Ишнийхээ үзүүрт хажуугаас нь гаргасан товхтой 4. Тусгайлж гаргасан тольттой 5. Ишин дээрээ амьтан буюу амьтны толгойн хэлбэрийн дүрстэй тольттой гэж 5 үндсэн төрөл болгон ангилж үздэг.

Сүхбаатар аймгийн нутгаас олдсон хүрэл хутганы ишний нэг тал дээр цуварч яваа хоёр адуу, нөгөө тал дээр нь нисч яваа зургаан шувууг дүрсэлсэн бол Баянхонгор аймгийн Галуут сумын нутгаас олдсон хүрэл хутганы ишний нэг талд цуварч яваа гурван адуу, нөгөө талд таван тэхийн толгойг урласан байдаг зэргийг жишээ болгон дурдаж болно.

Төмөр зэвсгийн эхэн үед холбогдох хүрэл зэв Монгол нутгаас хэдэн зуугаар олдсон бөгөөд тухайн дархны болон орон нутгийн онцлог, холбогдох он цаг зэргээс хамаарч өөр өөр хийц хэлбэртэй байдаг.

Зэвийг сумын мөсөнд бэхлэх байдлаар нь онгит (бөгжит) ба шөрөгт (шилбэт) гэж хоёр үндсэн төрөлд хуваан үзэхийн зэрэгцээ дотор нь: 1.Навчин хэлбэрийн 2. Гурван хянгат 3. Гурван талт гэж зэвийн толгойн хэлбэрээр нь бас хэд хэдэн том төрөл болгон үздэг төдийгүй хянга, дэлбээ, талын хэлбэр, онгины онцлог болон шөрөгтэй эсэхээр нь хүртэл бүр нарийвчлан 25 хүртэл төрөл болгон ангилж үздэг байна.

Төмөр зэвсгийн эхэн үед холбогдох цөөн тооны хүрэл тогоо манай улсын нутгаас олдсон нь Улсын төв музей, Завхан аймгийн ОНС музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Эдгээр тогоо нь цөгцөн суурьтай, гурван хөлтэй хоёр төрөл бөгөөд үүнтэй ижил төстэй хүрэл тогоо Увс аймгийн Чандмань ууланд малтсан МЭӨ YII-III зууны булшнаас олдсон бөгөөд Өвөр Байгаль, Якут, Дундад Ази, Минусын хотгор зэрэг газраас олонтоо олддог байна. Ардаа товчин бариултай амсраа дагасан гүвгэр хүрээтэй, хажуудаа бариултай /медаль хэлбэрийн/ хоёр төрөлд хамаардаг нэлээд хэдэн хүрэл толь манай улсын нутгаас олдсон нь МЭӨ YII-III зууны үед Хар тэнгис, Кавказ, Алтай, Сибир, Минусын хотгор, Тува зэрэг Ази Европ тивийн хээр талын бүсэнд өргөн тархсан тольнуудтай хэлбэр хийцээрээ ижил төстэй байна. Тус улсын Төв музей болон аймгуудын ОНС музейн үзмэрт манай орноос олдсон төмөр зэвсгийн эхэн үед холбогдох цөөн тооны хүрэл ооль хадгалагдаж байна. Эдгээр ойл нь хоёр хажуудаа хос чихтэй буюу ардаа наалдсан ганц чихтэйн гадна зарим нь гол төлөв амсраараа 1-3 эгнээ товгор хөвөөтэй байна. Мөн төмөр зэвсгийн эхэн үед холбогдох дугуй болон мөөгөн хэлбэрийн толгойтой, амьтны толгойн дүрс бүхий оройтой хүрэл шөвөг хэдэн арваар олдож аймгуудын музейн үзмэрт хадгалагдаж байна.

Дөрөө ба дугуй цагирган амгай, шулуун ба тахир нуман зуузайтай хүрэл амгай манай улсын нутгаас нэлээд олдсоныг хөрш зэргэлдээ нутгийн ижил төстэй олдворуудтай харьцуулан судлаж МЭӨ YII-III зуунд холбогдоно гэж эрдэмтэд үздэг байна. Мөн түүнчлэн энэ үед холбогдох оломны хөдөлдөггүй хэлтэй хүрэл арлууд олддог нь Увс аймгийн Чандмань уулын булш, Тува, Өмнөд Сибирийн МЭӨ YII-III зууны булшнаас олддог хүрэл аралтай ижил төстэй байна. Мөн хүрлээр цутгаж хийсэн янз бүрийн араатан амьтан, мал, жигүүртний дүрстэй эдлэлүүд гоёл чимэглэлийн зүйлс энэ үеийн түүвэр олдворт чухал суурийг эзэлнэ.

§ 9. ХҮРЭЛ БА ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕИЙН АЖ АХУЙ, НИЙГЭМ СОЁЛЫН АСУУДАЛ

МЭӨ II-I мянган жилд Ази, Европын хээр талын бүс нутагт амьдарч байсан овог аймгууд тал хээр, ой-хөвч, говь цөлд шинэ шинэ нутгийг эзэмших болсон нь юуны өмнө тэдний аж ахуйд шинэ хэлбэрийн мал аж ахуй буй болсонтой холбоотой.

Бүр МЭӨ II мянган жилийн хоёрдугаар хагас, I мянган жилийн эхэн гэхэд Монгол оронд нүүдлийн мал аж ахуй ноёлох болсон юм. Эртний аймгууд үйлдвэрлэлээ түргэн хугацаанд боловсронгуй болгож чадахгүй байсан бөгөөд эдийн засгийн энэхүү хүнд байдлаас гарах арга зам бол эзэмшиж буй нутгаа өргөсгөн тэлэхээс өөр аргагүй болжээ. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, хээр талын хатуу хөрстэй, хур тунадас бага унадаг Монголын ихэнх нутагт үйлдвэрлэхүй хүчний хөгжил дорой, хөдөлмөрийн багаж зэвсэг боловсронгуй бус байсан тэр үеийн нөхцөлд газар тариаланг далайцтай хөгжүүлэх боломжгүй байсан бөгөөд эдийн засгийн хөгжлөөс хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах ганц боломж нь нүүдлийн мал аж ахуйг эрхлэх зайлшгүй нөхцөлийг төрүүлжээ.

Арвин их бэлчээр нутагтай Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй хөгжих нэн боломжтой юм. Монгол нутагт амьдарч байсан овог аймгууд нүүдлийн мал аж ахуйг эрхлэх болсон нь хээр талын аймгуудын амьдралд болон хүй нэгдлийн нийгмийн үйлдвэрлэхүй хүчний хөгжилд гарсан эдийн засгийн томхон дэвшил юм.

Нүүдлийн мал аж ахуй бүрэлдэн тогтсоноор мал, мах, сүү, арьс шир, ноос үс зэрэг нэмүү бүтээгдэхүүн үйлдвэрлэх өргөн боломжийг нээж, хүний хөдөлмөр илүү их үр бүтээлтэй болжээ. Нэмүү бүтээгдэхүүнийг хуримтлуулах, түүнийг эзэмших болов. Мал ба малын бүтээгдэхүүн арилжааны өртгийг түргэн олж малчид, тариаланчдын хооронд арилжаа үүсэх бүхий л нөхцөлийг буй болгожээ.

Өргөн уудам хээр тал нутгийг аж ахуйн талаар эзэмших үйл явц МЭӨ I мянган жилд өргөн далайцтай өсч ирсэн адуу үржүүлэх ажил ихээхэн дөхмийг үзүүлжээ. Адууг унаа, хөсөгт өргөн хэрэглэх (морин тэрэг) болсноор тухайн орон бүрийн түгжигдмэл явцуу байдлыг эвдэж хөрш зэргэлдээ ба алс холын овог аймаг, ард түмэн улстай харьцах эдийн засаг, соёлын холбоо ихээхэн өргөсжээ.

Түүхийн сурвалж бичигт манай эриний өмнөх I мянган жилд Төв Азийн нүүдэлчид “өвс, усны ая даган нүүдэг” гэж ерөнхий дурьдсан байх нь мал аж ахуйн олон талт үнэн байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй.

Археологийн олдвор хэрэглэгдэхүүн тэр үед нүүдлийн мал аж ахуй нэгэнт бүрэлдэн тогтсон гэдгийг харуулж байна. Харин мал аж ахуйн шинжээс болж аж ахуйн бусад хэлбэрүүд хэр зэрэг үүрэгтэй байх нь хамаарч өөрчлөгддөг. Нүүдлийн мал аж ахуй хээр тал, цөл говьд дөрвөн улиралын турш нүүдэг байсан бөгөөд түүний зэрэгцээ газар тариалан хөгжүүлэх боломж бараг байсангүй. Тэд хонь, адуу, үхэр, тэмээ, ямааг үржүүлдэг ба нүүдэлчид өөрийн малтайгаа холын ба ойрын нүүдлээр (уртраг ба өргөргийн дагуу) нүүдэг байв. Холын буюу уртын нүүдэл говь хангай дамжиж сэлгэнэ. Богиных нь өвөлжөө хаваржаа, зуслан намаржаа нь тодорхой нэгэн хүрээнд эргэлддэг. Өвлийн хүйтэн цагт нүүдэлчид нөмөр дулаан, цас бага хунгарладаг нэгэн өвөлжөөнд өвөлждөг байжээ. Энэхүү өвөлжөө нь байнгын хашаа хороо гэхээр юмгүй байсан бололтой.

Уулын орой руу халуунд, тал говьд сэрүүн улиралд нүүдэг. Гэвч эдгээр нүүдлийн хэлбэрт хожуу үеийн нэгэн адил хоорондын эрс ялгаа байхгүй. Харилцан нөлөөлөх байнгын нарийн үйл явц нэг талаас аж ахуйн янз бүрийн хэлбэрийн хооронд, нөгөөтэйгүүр тухайн байгаль цаг уурын бүс бүрийн дотор буй аж ахуйн хэлбэрүүдийн хооронд явагдаж байв. Нүүдлийн мал аж ахуйн үндсэн шинж нь нийт мал сүрэг нь байгалийн бэлэн бэлчээрийг жилийн турш явж эдлэхэд оршино. Эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны мал нь тэсвэр хатуужил сайтай, алс холын нүүдэл даадаг, хунгар цасан дороос өөрсөдөө өвсөө малтаж идэж чаддаг шинжтэй болсон нь түүний хэдэн мянган жилийн турш байгалийн шалгаралыг давж туулж шалгарч гарч ирснийх юм.

Хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед Монгол нутагт амьдарч байсан аймгуудын үндсэн аж ахуй болох мал аж ахуйн тухай авч үзэхэд тэр үеийн булшнаас гардаг малын яс, малын дүрстэй эдлэлүүд, хадны зураг гол тулгуур хэрэглэгдэхүүн болдог.

Монгол нутагт малтан шинжилсэн дөрвөлжин булшинд малын яс 18 удаа, зэрлэг амьтадын яс 9 удаа дайралдаж байснаас адууных 8 булшинд, хонь, ямааных 5 булшинд, үхрийнх 5 булшинд байсан гэж В.Волков зохиолдоо дурьджээ. Гэтэл үүнээс хойш Дорнод монголын нутагт малтсан 46 дөрвөлжин булшнаас адууны яс 42, үхрийн яс 12, хонь, ямааны яс 9 удаа, бусад зэрлэг амьтадын яс 3 удаа тохиолдож байжээ.

Увс аймгийн Чандмань уулын булшнаас адуу, хонь, ямаа, үхрийн яс гарсны гадна адууны дүрстэй, тэмээний толгойн дүрстэй хүрэл даруулга олдсон юм. Булшнаас гарч буй эдгээр малын яснаас олонтой дайралдах нь адууны толгой, дал, шүд, хонины шаант, үхрийн шүд юм. Харин тэмээний яс булшнаас бараг гардаггүй нь тэр үед тэмээ гэрийн тэжээмэл болгоогүйнх биш, харин тэмээг өсгөн үржүүлдэг байсан боловч түүнийг оршуулганд дагалдуулан тавьдаггүй байсных бололтой. Манай говийн аймгуудын орон нутгийн судлах музейн үзмэрт хадгалагдаж буй олон тооны тэмээний дүрстэй хүрэл товруу, даруулга, мөн булшнаас гарсан тэмээний дүрстэй хүрэл эдлэл болон хаданд сийлсэн тэмээ унасан хүний зураг зэргээс үзэхэд хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед Монгол нутагт амьдарч байсан овог аймгууд тэмээг өсгөн үржүүлж түүнийг уналга, ачилгад хэрэглэж байсан

байна. Дээр дурьдсан баримтаас үзэхэд хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед Монгол оронд адуу, хонь, ямаа, үхэр, тэмээ үндсэн таван хошуу малыг өсгөн үржүүлж байжээ.

Мал аж ахуйн хөгжлийг гэрчлэх нэг төрлийн баримт бол манай нутгаас олдож буй хазаарын амгай, зуузай, шахуурга, бөгж, оломны арал, янз бүрийн хүрэл даруулга зэрэг тоног хэрэгсэл, морь малд хөллөсөн тэрэг, анжисны зэрэг юм. Нүүдлийн мал аж ахуйн нь унааны морьгүйгээр хөгжих ямар ч боломжгүй юм. Монголын эртний нүүдэлчдийн мал сүргийн чухал салбар нь адуу юм. Тэд одоогийн монгол адуу шиг намхан биетэй тэсвэр хатуужил сайтай адууг өсгөн унаж эдэлдэг байжээ. Тэд үхэгсэдээ дагуулан морины толгой, адууны дал, шүд зэргийг тавьсан байх ба морьтой хүн, морин тэрэг зэргийг хадны зурагт олонтоо дүрсэлсэн байдаг.

Увс аймгийн Чандмань уулын булшнаас хөдөлдөггүй шулуун ба махир хэлтэй оломны хүрэл ба ясан арал, хазаарын шахуурга бөгж олдсон юм. Архангай аймгийн Чулуут гол, Цэцэрлэг сумын Хонгоржин, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Модтой толгой, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Говь-Алтай аймгийн Цагаан гол, Ховд аймгийн Ямаан ус, Төв аймгийн Эрдэнэсант сумын Уянгын үзүүр, Увс аймгийн Сагил сумын Тушаат, Давс сумын Хандгайт зэрэг олон газраас хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед холбогдох морин тэрэг, энгийн тэрэгний зураг хэдэн арваараа олдсоны гадна мөн энэ үед холбогдох морьтой хүмүүс, мориор ан гөрөө хийж яваа хүмүүсийн зураг ч элбэг тархсан байдаг.

Нүүдэлчдийн ахуй амьдралд адууны үүрэг асар их бөгөөд түүнийг уналга хөсөгт өргөн хэрэглэх болсноор тухайн нутаг бүрийн түгжигдмэл явцуу байдлыг эвдэж хөрш зэргэлдээ ба алс холын овог аймаг, ард түмэнтэй харьцах эдийн засаг, соёлын харьцаа холбоо ихээхэн тэлжээ. Булшинд малын махыг шавар сав, хүрэл тогоо зэрэгт хийж тавьдаг байснаас эдгээр сав суулганд яс нь үлдсэн байх ба оломны арал, хутганы хуй, толины сэнжинд арьс шир, сурны тасархай барилдаж хадгалагдсан байдаг. Мөн түүнчлэн чинжаал хутганы хуйг модоор хийж гадуур нь давхар ширлэсэн байхаас гадна сураар морь малын тоног хэрэгсэлийг зангидаж, суран эдлэлийг шөрмөсөөр үдэж, оёж, сумын зэвийг мөсөнд суулгаад шөрмөсөөр ороож давхар бэхэлсэн зэрэг малын арьс, ширийг элдэж боловсруулан оёх, үдэх, зангидах наах олон аргыг хэрэглэн хэрэгцээний зүйлсээ хийдэг байсан баримт тэр үеийн булшнаас олдож мэдэгдсээр байна.

Хүрэл ба төмөр зэвсгийн үед Монгол нутагт амьдрагсадын сүргийн үндсэн хэсэг нь хонь болохыг эртний оршуулга ба ёслолын дурсгалыг малтан шинжлэхэд олддог хонины ясны олдвороос илэрхий. Хонины мах, сүүг идэж уухын зэрэгцээ түүний ноосоор эсгий, дээс арьсаар нь хувцас хунар, дэвсгэр зэргийг хийж, шөрмөсөөр бат бөх утас хийдэг байжээ.

Чандмань уулын булшнаас эсгийний тасархай өөдөс, хүрэл толины эсгий гэрний үлдэгдэл зэрэг хэдийгээр үл ялих жижиг боловч эрдэм шинжилгээний хувьд нэн сонирхолтой хэрэглэхдэхүүн олдсон юм.

Эсгий, арьс ширээр хийсэн эдлэл газрын гүнд урт удаан хугацаагаар хадгалагдахдаа муу байдаг тул эдгээр эдлэлээс ийнхүү өчүүхэн жижиг биет баримт болон үлдэж хоцорсон юм. Эдгээр нь хэдийгээр жижиг боловч эсгий, арьс ширэн бүтээгдэхүүн хэрэглэж байсныг гэрчилж чадна. Хонины ноосоор эсгий хийх хэд хэдэн арга, эсгийг олон төрлийн бүтээгдэхүүн хийдэг заншил өнөө хүртэл Монголчуудын дунд өргөн дэлгэр уламжлагдаж ирсэн юм. Ийнхүү төмөр зэвсгийн эхэн үед Монгол нутагт амьдрагсад адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ таван төрлийн малыг нүүдлийн хэлбэрээр өсгөн үржүүлж тэдний махыг идэж, сүүгээр нь янз бүрийн сүүн бүтээгдэхүүн хийж хоол хүнсээ бэлтгэн, арьс шир, ноос үсийг боловсруулан хувцас, хунар эсгий, сур бэлтгэн аж ахуйн хэрэгсэл, тоноглолоо хийж өөрсдийн ахуйн хэрэгцээг төвөггүй хангадаг байв.

Чандмань уулын зарим булшинд эзнийг нь дагуулан хойлоглон оршуулсан нохойн яс олдсон нь нүүдлийн мал аж ахуй, ан агнуурыг эрхлэн амьдарч байсан төмөр зэвсгийн түрүү үеийнхний амьдралд хоточ, анч нохой чухал үүрэгтэй байсныг энэхүү баримт гэрчилж байна.

Монгол оронд хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед амьдарч байсан овог аймгуудын аж ахуйд түүний үндсэн салбар болох мал аж ахуйгаас гадна ангийн аж ахуй чухал үүрэгтэй байжээ. Хүрэл ба төмөр зэвсгийн үеийн ан автай холбогдох баримт элбэг бөгөөд булшнаас янз бүрийн ангийн яс, ангийн ясаар хийсэн эдлэл, тэдгээр анг агнаж байсан зэр зэвсэг болон төрөл бүрийн ан амьтадын дүрсийг урласан эдлэлүүд элбэг олддог. Түүнчлэн хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн хадны зурагт ан амьтадын зураг үндсэн суурийг эзлэхийн хамт ан гөрөө хийж буй байдлыг харуулсан зураг ч элбэг дайралдана.

Мөн буган хөшөөнөө сүрэг бугыг дүрсэлдэг боловч түүний завсар зайд гахай, янгир, ирвэс, зэрэг амьтад тоодог мэтийн шувуудыг дүрсэлсэн байдаг. Монголын төв ба дорнод хэсэгт малтсан дөрвөлжин булшнаас тарвага, үнэг, өмхий хүрэн зэрэг амьтад болон шувууны яс, бугын эврээр хийсэн нумын ясан наалт, сумын зэв олддог.

Чандмань уулын булшнаас зээр, тарвага, шувуу, загасны яс болон буга маралын араа, тарваганы соёогоор хийсэн гоёл чимэглэл зүүлт, бугын эврээр хийсэн сумын зэв, бүсний нүүр, булцуу шахуурга, шөвөг, ялтас зэрэг эд өлгийн зүйлс олон тоогоор олдсон юм. Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянцогт овооны гурав дахь дөрвөлжин булшнаас усны шувууны толгойн сийлбэр, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын нэгэн дөрвөлжин булшнаас аргалын толгойн дүрстэй хос алтан сүлбээр гарсан юм. Чандмань уулын зарим булшнаас бөхөнгийн алтадсан хүрэл баримал, баавгайн

хэлбэртэй хүрэл товруу, баавгайн дүрстэй хүрэл шахуурга, аргаль ба бугын зурагтай хүрэл толиуд, шавар сав, бугын согооны сийлбэртэй бүсний ясан арал, хос шувууны цутгавар бүхий хүрэл чинжаал хутга, хотон шувууны толгойн дүрстэй хүрэл шөвөг, ирвэс (шилүүс)-ний дүрстэй саадагны хүрэл гох, дөрвөн шувууны толгойг өөд өөдөөс нь харуулж дүрсэлсэн хүрэл товруу, шар шувууны дүрстэй хүрэл товруу зэрэг ан амьтаны дүрс бүхий эдлэлүүд олон арваараа олдсон юм. Хүрэл, төмөр зэвсгийн эхэн үеийн хадны зурагт янгир, буга, аргаль, гахай, гөрөөс, үнэг, чоно, ирвэс, шилүүс зэрэг амьтадыг олноор нь дүрсэлсэн байхаас гадна эдгээр амьтадыг үргээж, бүслэн нум сумаар намнаж буй болон морьтой, явган хүмүүс нохой дагуулаад ан гөрөө хийж яваа сэдэв бүхий зураг олон байдаг.

Булшнаас ангийн ясны биет олдвор, тэдгээрийн дүрсийг урлаж дүрсэлсэн эд өлгийн зүйл, хадны зурагт дүрсэлсэн амьтад, ан гөрөө хийж буй байдлыг харуулсан зургаас үзэхэд хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед Монгол нутагт амьдарч байсан хүмүүс янгир, буга, зээр, гөрөөс, аргаль, тарвага, гахай, ирвэс, шилүүс, үнэг, чоно, өмхий хүрэн болон бусад ан, галуу, нугас, хотон, тоодог зэрэг шувууд мөн бас загас агнадаг байжээ. Эдгээр ангийн ихэнхийг нь махыг хүнсэндээ хэрэглэхийн гадна зарим ангийн үс, арьсыг элдэж боловсруулан дээл хувцасаа хийдэг байжээ.

Ганц нэгээрээ буюу хэсэг бүлгээрээ ан хийх аргын аль алинийг нь хэрэглэдэг байжээ. Ангийн холын тусгалтай үндсэн зэвсэг нь янз бүрийн зориулалт хэмжээ, хэлбэрийн яс, хүрэл, төмөр зэвтэй нум сум байсан бөгөөд сааль, чинжаал хутга, ердийн хутга, жад, сүх, зээтүү зэрэг зэвсгийг бас анд хэрэглэдэг байжээ. Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн аж ахуйн туслах нэг салбар нь газар тариалан юм. Монгол нутагт газар тариалан неолитын үед орон нутгийн шинжтэй бие даан үүссэн бөгөөд цаашид хүрэл төмөр зэвсгийн үед уламжлан хөгжиж иржээ. Монгол орны эх газрын эрс тэс уур амьсгалтай байгаль газар зүйн хатуу ширүүн нөхцөлд нүүдлийн л аж ахуйг эрхлэн аж төрөх нь газар тариаланг эрхлэж аж төрөхөөс илүү тохиромжтой байжээ.

Гэвч гол мөрний хөндий болон нөмөр дулаан үржил шимтэй хөрс бүхий зарим нутагт газар тариалан зохих хэмжээгээр эрхлэж байсан.

Гар урлал эрчимтэй хөгжих шатандаа орсон байв. Монгол орны нутаг дэвсгэрт малтсан хүрэл ба төмөр зэвсгийн үеийн олон арван булшнаас их бага хэмжээний ваар савны хагархай олддог байна.

Дээрх ваар сав суулганы зүйлсээс харахад хээгүй гөлгөр гадаргуутай, хээн чимэглэлтэй гэсэн хоёр төрөлд хуваан авч үзэж болмоор байдаг. Ваарны хүзүү болон мөрний дагуу голчлон хурц үзүүртэй багажаар тууш болон босоо зураас сараачмал хээ зэргийг гарган чимдэг байжээ. Хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үеийн ваар савыг бүдүүн ширхэгтэй элсэрхэг, хар, хар бараан, саарал, улаан шаргал өнгийн шавраар хийсэн хэмжээ зориулалтаасаа шалтгаалан нимгэн зузаан янз янз хийдэг байсан байна. Тухайн үед ваар сав суулгыг гар аргаар хийдэг байжээ.

МЭӨ II мянган жилд Монгол нутагт амьдарч байсан овог аймгийн нийгэмд хүй нэгдлийн нийгмийн овгийн байгууллын задрал хүчтэй явагдаж, нийгмийн бүтцийн шинэ хэлбэрүүд бүрэлдэж эхэлсэн юм.

Манай дэлхийн түүхнээ хүй нэгдлийн байгууллын задрах явц нутаг нутагт аж ахуй, түүхийн янз бүрийн хүчин зүйлээс болж харилцан адилгүй өнгөрчээ. Зарим нутагт хуучин нийгэм мөхөж, шинэ нийгэм гарч ирэхэд тааламжтай нөхцлүүд бүрдэж энэхүү үзэгдлийг түргэтгэж байсан бол зарим нутагт байгаль, газар зүй, эдийн засгийн хүчин зүйл харин хүй нэгдлийн байгууллын задрал, анги үүсэх явцыг саатуулж байв.

Монгол нутагт хүй нэгдлийн байгуулал задрах удаан хугацааны үйл явц анх бүр хүрэл зэвсгийн үед эхэлсэн билээ.

Монгол нутагт хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед амьдрагсадын нийгэм, эдийн засгийн хөгжилд нүүдлийн мал аж ахуйн ба металл боловсруулалтын хөгжил нэмүү бүтээгдэхүүний түргэн өсөлт, амьжиргааны хөгжил, өмчийн хуримтлал ба хүйн жирийн гишүүдээс чмнээлэг элементүүдийн төрөн гарахад хүргэжээ. Үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл ба хөдөлмөрийн бүтээгдэхүүний хувиарлалтанд ноёлж байсан хүй нэгдлийн тэгш зарчим өөрчлөгдөж эд хөрөнгийн ба нийгмийн дотор эзлэх байр суурийн ялгавар гарч буй нь археологийн судалгааны баримтаас ажиглагдаж байна.

Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед Монгол нутагт амьдрагсадын нийгэмд эцгийн эрхт овог ноёрхож, тэдний амьдралд цэрэг эрс, дайн байлдаан чухал үүрэгтэй болсон нь түүх, археологийн олон баримтаас харагддаг. Тухайлбал Монгол улсын нутгаас одоогоор 550 орчим олдож судлагдаад байгаа сүрлэг баримал буган хөшөө нь баатар дайчин эр хүнд зориулсан дурсгал бөгөөд түүнийг өвч зэвсэгтэй нь дүрсэлсэн байдаг. Нэг дор ганц хоёроос аваад хорь хүртлэх тоотой босгосон байдаг сүрлэг том буган хөшөө, түүний дэргэд байрлуулсан хиргисүүр, дөрвөлжин булш, ёслолын хэдэн арван цагираг, зам, цацраг мэт дагалдах байгууламжууд зэргийг тухайн овог аймгийн дундаас ялгаран гарсан ноёлох хэсэгт зориулан бүтээсэн байдаг бөгөөд тэдгээрийг хэд хэдэн овог буюу аймгийнхны хүчээр барьж байгуулсан нь тодорхой бөгөөд эцгийн эрхт овог аймгийн маш илэрхий дурсгал болно. Буган чулуу бүхий том хэмжээний цогцолбор дурсгалууд Архангай аймгийн Хүний голын Хөшөөн тал, Хануй гол, Шивэртийн ам, Цацын эрэг, Баянцагааны хөндий, Хөвсгөл аймгийн Уушгийн өвөр, Завхан аймгийн Дааган дэл, Увс аймгийн Байрамын ам, Баян-Өлгий аймгийн Цагаан Асгат, Булган аймгийн Халтарын дэнж зэрэг олон газарт байдаг. Мөн үүнтэй ижил хэдэн зуун хүний хүч хөдөлмөрөөр бүтсэн 5-6 метр өндөр, 60-100 метр хүртлэх голточ бүхий далантай том, том хиргисүүрүүд Монгол оронд хэдэн зуугаараа байдаг билээ. Тэр үеийн хүмүүсийн дунд өмч хөрөнгө болон нийгмийн дотор эзлэх

байр суурийн ялгаа гарсан нь дээр дурдсан хөшөө дурсгалаас гадна тэдний хэрэглэж байсан алт, үнэт чулуун эдлэл тусгайлан хийсэн гоё ганган хийцтэй зэр зэвсэг, сав суулгаас тодорхой байдаг. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын дөрвөлжин булшнаас гарсан аргалийн толгойг урлан хийж, оюу шигтгэсэн хос алтан сүлбээр, Өмнөговь аймгийн нутгаас олдсон аргаль, янгирын толгойн тольттой хүрэл илд, том том хүрэл чинжаалууд зэргийг жишээ болгон дурдаж болно.

Хүрэл ба төмөр зэвсгийн үеийн Монголын нүүдэлчин овог аймгуудын цэрэг эрс нь иж бүрэн зэр зэвсэгтэй байжээ. Тухайлбал, гардан тулалдаанд чинжаал, хутга, байлдааны алх (зээтүү), илд, урт богино жад бороохой, зэрэг охор зэвсгүүд холын тулалдаанд энгийн ба зүймэл хийцтэй нум сум, дүүгүүр зэрэг уртын зэвсгийг хэрэглэдэг байжээ. Үүнээс гадна бамбай, дуулга зэрэг хамгаалах зэвсэг өмсгөлтэй байсан юм.

Дээр дурдсан байлдааны зориулалттай зэвсэг болон хутга, шөвөг, ооль, сүх, билүү, ганзагны хүрэл тогоо зэрэг аж ахуйн зориулалттай багажуудыг ч байлдааны үед ч, ердийн ан агнуур, аж ахуйд ч хослуулан хэрэглэж байсан нь тодорхой.

Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед цэрэг эрс хоорондоо явган, морьтой тулалддаг байсан бөгөөд энэ нь хадны зурагт ч тодорхой тусгалаа олсон байдаг. Өвөрхангай аймгийн Тэвш уулын хадны зурагт дүрслэгдсэн цэрэг эрсийн дүр, тэдний зэр зэвсэг, хувцас зэргийг эрдэмтэд тусгайлан судлаад хүрэл зэвсгийн сүүл, төмөр зэвсгийн эхэн үед цэрэг эрс иж бүрэн зэвсэгтэй байсан ба цэргийн жагсаал буй болсон байна хэмээх чухал дүгнэлтэнд хүрсэн юм. Энэ үед морьт цэрэг нэгэнт буй болсон, өөрөөр хэлбэл тэр үеийн хүмүүс байлдаанд морь унаж тулалддаг байсныг олон газрын хадны зургаас мэдэж болох ба дээр дурдсан Дундговь аймгийн Хулд сумын нутгаас олдсон хүрэл толин дээрх хоёр морьтны тулаан бүр тодорхой өгүүлж байна. Тэр үед морины тоног хэрэглэл болох хазаарын хүрэл нуман зуузайтай, дугуй цагирган ба дөрөөн хэлбэрийн үргэлж амгай зуузай, шахуур, бөгж, оломны арал зэрэг зүйлс өргөн хэрэглэж байсан нь булшны малтлагаас болон түүврээр олддог. Дээрх түүх археологийн олон баримт нь Монгол нутагт амьдарч байсан овог аймгуудын нийгмийн амьдралд дайн байлдаан онцгой үүрэгтэй болсон ба эцгийн эрхт ёс нэгэнтээ хэлбэршин тогтож, улмаар нийгмийн хөгжлийн “Цэргийн ардчилал”, “Хөдөөгийн хүй”, “Аймгийн холбоо” гэж янз янзаар нэрлэдэг шатанд орсон билээ.

Үйлдвэрлэлийн харьцаа цусан төрлийн холбоотой давхцаж маш нягтаар уялдан байдаг нийгмийн нийтлэг нэгж болох овог, ураг төрлийн бус харин орон нутаг-үйлдвэрлэлийн зарчим дээр бүрэлдсэн хүйд аяндаа байраа тавьж өгдөг байна.

Түүхэн үйл явц эхлээд овгийн холбооноос нийгмийн бүтэц шууд хараат байдгийг сулруулж, эцэст нь овгийн байгууллын хамаадлыг хайхрахгүй эдийн засаг ба орон нутгийн эрх ашигт үндэслэн хүйг бүрдүүлэхэд хүргэдэг. Хүй нэгдлийн овгийн байгууллын задралын үеийг цэргийн ардчилал буюу хөдөөгийн хүйн шат гэж нэрлэдэг. Цэргийн ардчилал, хүй нэгдлийн хөдөөгийн хүй гэдэг хоёр ойлголт нь бие биеийг үгүйсгэдэггүй, харин хүй нэгдлийн байгууллын задралын үеийн нийгмийн бүтцийн өөр өөр онцлог талуудыг илэрхийлж байгаа юм.

Монголын нүүдэлчдийн соёл урлаг төмөр зэвсгийн эхэн үед хөгжлийн харьцангуй өндөр түвшинд хүрсэн байна. Төмөр зэвсэг үйлдвэрлэлд нэвтэрч, нүүдлийн мал аж ахуй цаашид боловсрон хөгжсөнөөр тэдний эдийн ба оюуны соёл ихээхэн өөрчлөлтөнд оржээ. Ази-Европын хээр талын бүс нутагт ижил төстэй аж ахуй эрхлэн амьдарч байсан олон овог аймгууд Монгол, Өвөрбайгаль, Өмнөт Сибирь, Хар тэнгисийнхэн олон талаараа ижил төстэй соёлын нийтлэгийг бүрдүүлжээ. Энэхүү нийтлэг нь тэдний хооронд эдийн засаг, соёлын өргөн харилцаатай байсныг харуулдаг. Аж ахуй, соёлын өргөн харьцаа тогтоход тэдгээр аймгийн нааш, цаашийн нүүдэл хөдөлгөөн юуны өмнө унаа хөсөг онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Гэвч тэдгээр нийтлэгээс гадна тухайн овог, аймаг бүрт өөрийн өвөрмөц онцлог, орон нутгийн шинж байдал байсан юм.

Төмөр зэвсгийн эхэн үед манай оронд амьдрагсадын ахуй амьдрал, орон сууц, хувцасны талаархи хэрэглэгдэхүүн тун хомс юм. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн зураг, Дундговь аймгийн Өлзийт сумын Дэлхийн зүүн билийн хадны зурагт гэрийг дүрсэлсэн байх ба, Говь-Алтай аймгийн Наран цээл сумын залгаа Цагаан голын хадны зурагт гэр байшин дүрсэлсэн байдгаас энэ үед амьдрагсад эсгий гэр, модон байшин барьж суудаг байсныг мэдэж болно.

Хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед амьдрагсад биеэ барьсан өмд цамц буюу урт хормойтой дээл өмсч, дээлэн дээрээ бүс бүсэлдэг байжээ. Мөн өргөн хүрээтэй ба дуулга мэт бөмбөр хэлбэртэй мөн салаа оройтой малгай өмсдөг байсан болохыг хадны зургаас мэдэж болно. Тэд өргөн нарийн янз бүрийн суран бүс бүсэлдэг бөгөөд бүсэн дээрээ янз бүрийн хээ гаргаж товруу хаддаг байжээ. Бүс, тэлээ нь жирийн хүрэл буюу ясан аралтай байснаас гадна зарим бүсний арал дээр амьтны дүрс сийлж урладаг байна.

Булшны хэрэглэгдэхүүнээс үзэхэд төмөр зэвсгийн эхэн үед амьдрагсад “өвөг дээдсийг”, “овог өрхийн онго ба ивээгчийг” шүтэн биширдэг байжээ. Эдгээр бишрэлийн уг сурвалж нас барсан төрөл төрөгсөд нь, хойт насандаа өөр ертөнцөд өөрийн овог хүйн зан заншил, дадал хэвшил, ёс журмаар үргэлжлэн амьдардаг гэж итгэдэг ёсонд үндэслэсэн байдаг байна. Иймээс ч тухайн хүнийг үхэхэд түүний нэр хүнд, хүйн дотор эзлэх байр суурьтай тохирсон эд агуурсыг дагуулан тавьж, өөрийн овог аймгийн оршуулгын газар тухайн овог аймгийн зан үйлийн дагуу оршуулгын нарийн ёсыг үйлдэж нутаглуулдаг байжээ.

Хэдэн арваас хэдэн зуу хүртлэх тооны булш бунхан бүхий овгийн оршуулгын газар нэг дор байхаас гадна ганц хоёр буюу цөөн хэдэн булш бүхий оршуулгын газар элбэг тохиолдоно. Энэ нь юуны өмнө нүүдэлчид нэгэн дор урт удаан хугацаагаар суурьшин амьдардаггүй, жилийн дөрвөн улиралд нүүж байдгаар тайлбарлагдана.

Монголын нүүдэлчдийн дунд нар, сар, тэнгэр эрхэс, гал, сайн морь зэргийг дээдлэн шүтэж биширдэг зан үйл эрт дээр үеэс уламжлалтай юм. Галыг муу муухайг ариутган цэвэрлэдэг гэдэг ойлголт, нарыг эрхэмлэн шүтэх ёсноос уламжлалтай гэж эрдэмтэд үздэг бөгөөд энэхүү заншил Ази-Европын олон нүүдэлч овог аймгуудын дунд нийтлэг тархсан юм.

Энэ үед анимизм, тотемизм, маги зэрэг хүй нэгдлийн сүсэг бишрэлийн нэн эртний ойлголтууд ч бас хувирч өөрчлөгдсөн хэлбэрээр оршиж байв. Эд юмсыг ид шидтэн гэж үздэг сүсэг бишрэлийн анимизмын хэлбэрийг эрдэмтэд тайлбарлахдаа булшинд зориуд эвдэж хугалж хийсэн гоёл чимэглэл, зэр зэвсэг зэргийг жишээ болгон авч үздэг байна. Янз бүрийн онго, зүүлтийг тотемизм ба магийн сүсэг бишрэлийн үлдэцтэй холбон тайлбарладаг юм. Овог ба аймгийнхны ямар нэгэн амьтнаас гаралтай гэж үздэг тотемизмын ойлголт янз бүрийн амьтны дүрд тусгалаа олсон байна. Тийм ч учраас тэдгээр амьтдын дүрсээр зэр зэвсэг, гоёл чимэглэлээ чимж, тийм зэвсэг нь дайн байлдаан, ан агнуурт ашиг тус өгдөг гэж үздэг байжээ.

Монголын хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үеийн дурсгалд буга, янгир, аргаль, барс зэрэг амьтдын дүр өргөн тархсан байдаг нь тэднийг хөнгөн шалмаг, түргэн хөдөлгөөнтэй, хүч чадалтай төдийгүй ид шидийн хүчтэй гэж хүртэл ойлгогдоос тэр билээ.

Монгол нутагт хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед оршин тогтнож байсан аймгуудын урлаг соёлын хөгжилд чимэглэх урлаг, сүрлэг баримал, хадны зураг үндсэн суурийг эзэлдэг. Эдгээрийн гол шинж нь “амьтны загварт урлагийн” өвөрмөц дүрслэх хэлбэр юм. Амьтны загварт урлаг НТӨ VII-III зууны үед Ази, Европын хээр талын бүсэд нутаглаж байсан овог аймгуудын дунд өргөн тархсан бөгөөд харин түүний гарал үүсэл нь хүрэл зэвсгийн үед холбогдоно. Амьтны загварт урлагийн арга барилаар бүтээсэн дурсгалууд эхлээд Скифүүдийн, дараа нь Сибирийн нутгаас олдож байсан тул “Скиф-Сибирийн амьтны загварт урлаг” гэдэг тоймолсон нэрийг авчээ. Энэхүү урлагийн гол сэдэв нь араатан амьтдын дүрслэл юм. Амьтны загварт урлаг агуулгын хувьд бодит хандлагатай бөгөөд бүхэлдээ хавсрага чимэглэл шинж чанартай юм. Амьтны загварт аргыг зэр зэвсэг, гоёл чимэглэл, ахуйн хэрэгцээний зүйлсийг хийхэд өргөн хэрэглэж байжээ. Эд юмсын дүрслэлийн зохиомжийг чадмаг хослуулж чадсан амьтныг загварчлан дүрслэх аргаар хийсэн эртний урчуудын олон бүтээл дэлхийн урлагийн шилдэг бүтээлд зүй ёсоор тооцогддог юм. Эдгээр эртний урчууд хүрээлэн буй орчин, тэдний амьтдын ертөнцтэй ихэд холбоотой ойр байсан учир өөрсдийн уран бүтээлийн гол дүрийг сонгон авдаг байжээ.

Урлагийн гол дүр нь тухайн нутагт амьдардаг, тэдний амьдрал ахуйд чухал үүрэгтэй байсан буга, аргаль, янгир, зээр, гөрөөс, гахай, барс, хандгай, шувуу зэрэг зэрлэг амьтад, адуу, үхэр, тэмээ зэрэг мал байлаа. Амьтдын дүрийг чулуу, хүрэл, алт, яс, мод болон шавраар бүтээдэг байв. Амьтны загварт урлагийг ерөнхийд нь хөгжлийн гурван үндсэн үед хамааруулан үзэж болно. Үүнд: анх үүссэн, цэцэглэлтийн, буурч суларсан.

Амьтныг загварчлан дүрслэх аргын гарал үүслийн талаар гурван үндсэн санал байдаг. Амьтны загварт урлаг чухам ямар агуулгатай болох нь одоо болтол бүрэн тогтоогдоогүй байна. Гэхдээ тахилгын шинж чанартай байсан байх гэж эрдэмтэд үздэг. Амьтны загварт урлагийн сэдэвт голчилж буй амьтдын дүр нь тодорхой овог аймаг, угсаатны бүлгийн тотемны өвийг дүрсэлсэн байж болох юм. Янз бүрийн эдлэлд эдгээр амьтдыг дүрсэлсэн нь нэг ёсны овгийг хамгаалагч, онгоны үүрэгтэй байсан байж болно. Амьтдын тэмцэл нь овог аймгийн хооронд ширүүн тэмцлийг илэрхийлдэг бололтой.

Хүй нэгдлийн нийгмийн задралын үед хээр талын нүүдэлч аймгуудын дунд баатарлаг туульс үүсчээ. Тэдгээр туульсын зарим дүр, зохиомж ихээхэн хувирч өөрчлөгдсөн хэлбэрээр өнөө үеийг хүрчээ.

Хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үеийн чимэглэх урлагийн чухал төрөл нь хээ угалз юм. Хээ угалз, амьтны загварт урлагтай зэрэгцэн, харилцан бие биедээ нөлөөлөн хөгжиж иржээ. Амьтан, ургамалын гаралтай эдээр хийсэн зүйл хадгалж ирсэн нь туйлын хомс бөгөөд бидний үеийг хүртэл чулуу, хүрэл, алт, ясан эдлэл дээр уралсан хээ, угалз үлджээ. Энэ үед хамаарах хээ угалзыг геометрийн, амьтны, билэгдлийн гэж үндсэнд нь гурав ангилж үзэж болно. Геометрийн хэлбэртэй хээ угалз нь бүр неолит, хүрэл зэвсгийн үеэс эхэлж дайралдах ба хүрэл зэвсгийн сүүл, төмөр зэвсгийн түрүү үед гурвалжин, дөрвөлжин, чон, дугуй, хушуу хэлбэртэй хээ угалзыг буган чулуун хөшөө, хүрэл, алтан эдлэлд гаргадаг байв. Билэгдлийн холбогдолтой хээ угалзын эх үүсвэрийг байгаль, тэнгэр эрхсийн хүчинд бишрэх явдлаас үүсвэрлэн гарсан гэдэг бөгөөд энэ төрөлд хамаарах дугуй, цагираг болон янз бүрийн хэлбэрийн тамга тэмдгийн зүйл хадны зураг хөшөө чулуунаа өргөн тархсан байдаг. Амьтны дүрстэй (гаралтай) хээ угалз нь гол төлөв амьтныг загварчлан дүрслэх урлагийн дүрслэлд тулгуурласан байдаг бөгөөд ганц ба хос амьтны толгой, шувуу болон амьтдын тоймолсон дүрслэлээр илэрхийлэгдсэн байдаг. Гэвч нэг эдлэл дээр хэд хэдэн төрлийн хээ угалзыг хослуулан хэрэглэсэн нь элбэг тохиолдоно.

Монгол улсын нутагт өргөн дэлгэр тархсан хадны зураг бол эртний дүрслэх урлагийн дурсгалын нэгэн гол төлөөлөгч юм. Хаданд дүрс зургийг хурц үзүүртэй төмөрлөг багажаар буюу хатуу чулуугаар хонхойлон цохиж дүрсэлдэг бөгөөд тэгэхдээ уг дүрсийг бүх талбайгаар нь хонхойлгон цохиж

гаргах, зөвхөн гадаад тэгийг хөвөөлж гаргах, нарийн зураасаар зурж гаргах зэрэг хэд хэдэн барилыг хэрэглэж байжээ. Заримдаа нэгэн дүрсийг бүтээхэд дурдсан барилуудыг аль алиныг хослон хэрэглэсэн ч байдаг. Хадны зураг бүхэлдээ түүхийн олон үед хамаарах боловч хамгийн өргөн дэлгэр тархсан үе нь хүрэл, төмөр зэвсгийн эхэн үе билээ. Энэ үеийн зургийг бусад зургаас ялган үзэж буй гол шинж нь чимэглэх урлагаас бидний сайн мэдэх амьтныг загварчлан дүрслэх арга юм. Архангай аймгийн Чулуут гол, Хөрөөгийн үзүүр, Өвөрхангай аймгийн Тэвш уул, Их дөрөлж, Паалуу, Булган аймгийн Баруун могой, Орхон гол, Өвгөнт, Үүдэнт, Увс аймгийн Хандгайтын гол, Баруун, Зүүн, Дунд Турга, Ховд аймгийн Үзүүр хөх хад, Баянхонгор аймгийн Бугат, Баян-Өлгий аймгийн Цагаан салаа, Бага ойгор, Ховд аймгийн Ямаан-Ус зэрэг олон газрын хаданд түүхийн олон үеийн турш зургийг сийлж ирсэний дотор амьтныг загварчлан дүрслэх аргаар урласан зураг элбэг байдаг. Эдгээрийн дотор амьтныг загварчлан дүрслэх сонгодог аргаар урласан, буга, янгир, гахай болон бусад амьтдын дүр элбэг тохиолдоно. Үүний зэрэгцээ хавсрага чимэглэх урлагт төдийлөн байдаггүй сэдэв, зохиомж бүхий зураг ч олон байдаг. Ан агнуурын, дайн байлдааны сэдэвтэй болон гэр орон сууц, хүний дүрстэй зургууд байдаг.

Бүхэл бүтэн үйл явдлыг өгүүлсэн сэдэв зохиомж бүхий бүтээлүүд нь хадны зургийн хавсрага чимэглэх урлаг болон буган чулуун хөшөөнөөс ялгагдах онцлогийг харуулаад зогсохгүй, түүний давамгай шинжийг илэрхийлнэ.

Хүрэл, төмөр зэвсгийн үеийн овог аймгуудын урлаг, уран сайхны бүтээлүүдийн олон талтай болохыг тэр үеийн археологийн дурсгалууд харуулж байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

- Баяр Д. Монгол Алтайд шинээр олдсон зарим буган хөшөөний тухайд // SA. t.XY. f.5. УБ., 1995.
- Волков В.В. Бронзовый и ранний железный век Северной Монголии. -УБ., 1967.
- Волков В.В. Оленные камни Монголии. -УБ.,
- Волков В.В. Древние колесницы Монгольского Алтая // АС. т.У. ф.6.УБ., 1972.
- Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг // ЭСУЗБ. УБ., 1963.
- Дорж Д. Писаницы бронзового века Монголии // SA. т.II. f.2. УБ., 1963.
- Дорж Д., Новгородова Э.А. Петроглифы Монголии. УБ., 1975.
- Доржсүрэн Ц. Говь-Алтайн Цагаан голын хадны зураг //АС. т.II. f. II. УБ., 1963. -тал 16-26.
- Наваан Д. Дорнод Монголын хүрлийн үе. -УБ., 1975.
- Наваан Д. БНМАУ-ын нутаг дахь дөрвөлжин булш // Монголын эртний түүх соёлын зарим асуудал. SA. т.9. УБ., 1982.
- Новгородова Э.А. Центральная Азия и карасукская проблема. -М., 1970.
- Новгородова Э.А. Древняя Монголия. -М., 1989.
- Окладников А.П. Петроглифы Центральной Азии Ховд сомон (гора Тэбш). -Л., 1980.
- Окладников А.П. Петроглифы Чулутын-гола (Монголия). -Наука, Новосибирск. 1981.
- Окладников А.П. Петроглифы Монголии. -Л., 1981.
- Пэрлээ Х. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд // SA. т.X. f.4. УБ., 1982
- Савинов Д.Г. Оленные камни-СПб, 1992
- Сэр-Оджав Н. Баянлигийн хадны зураг. -УБ. 1987.
- Сэр-Оджав Н. Шунхлайн булш // ШУТ. '3, 1958.
- Сэр-Оджав Н., Долгорсүрэн Д. Дундговь аймгийн нутаг хүрлийн үед.
- Цэвээндорж Д. Чандманийн соёл // SA. т. IX. f.3. УБ., 1980.
- Цэвээндорж Д. Хадны сийлмэл зургийн шинэ дурсгалууд // SE. т.V. f.5. УБ., 1976. тал 73-118.
- Цэвээндорж Д. Монгол нутгаас олдсон зарим буган хөшөө // SA. т.X. f.2. 1977. тал 6-21.
- Цэвээндорж Д. Хонгиогийн голын хадны зураг //ШУА. 1978. '3.
- Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал. -УБ., 1983. .
- Цэвээндорж Д. Ишгэн толгойн хадны зураг // SA. т.X. f.2. 1982. тал 6-21.
- Цэвээндорж Д. Хад үзүүрийн зураг. АС. т.XV. f.1. УБ. 1995. -тал 3-16.
- Эрдэнэбаатар Д. Асгатын дөрвөлжин булш // SA. т.13. f. 4. УБ., 1992.
- Эрдэнэбаатар Д. Эгийн голд явуулсан археологийн судалгаа // SA. т.XIV. f. 4. УБ., 1994.

ЭРТНИЙ УЛСУУДЫН ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

ХҮННҮГИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

МЭӨ Y-IV зууны үед Төв Азийн өндөрлөгт Хүннү, Дунху нэртэй 2 аймгийн холбоо байсан тухай эртний Хятадын сурвалж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг байна. МЭӨ III зууны үед хүннүчүүд бусад нүүдэлч аймгуудаасаа хүчирхэгжин аймгийн байгууллын хувьд шинэ шатанд орох эхлэлээ тавьжээ. Аймгийн зохион байгуулалтын улс төрийн хэлбэр нь цэргийн ардчилал болж хөгжсөн байна. Овгийн захиргаа хүчтэй болж, овгийн язгууртан сурвалжтаны эрх мэдлийг үе залгамжлуулан захируулж, цэргийн эрхтэн тушаалтануудын хооронд ялгаа гарч, өвөр хоорондоо буюу бусадтай дайн байлдаан байнга хийдэг нийгмийн байгууллыг цэргийн ардчилал хэмээн тодорхойлдог. Хүннүгийн аймгийн холбоог шанью нэртэй хаан захирдаг байсан бөгөөд МЭӨ III зууны үе хүртэл аймаг буюу зонхилогчийн зөвлөлөөр сонгодог байсан боловч дараагаар нь үе залгамжлуулах хэлбэрт шилжсэн байна. МЭӨ 209 онд өөрийн эцэг Түмэн шаньюг өгүүтгэж хаан ширээнд суусан Модун шанью сурвалж язгууртны үе улиран захирах эрх мэдлийг улам бэхжүүлжээ. Тэрээр өөрийн эзэмшил нутгаа гурван хэсэгт хуваан засаг захиргааны эрс өөрчлөлт хийсэн байна. Төвийн хэсгийг шанью өөрөө, нөгөө хоёрыг нь жүки, лули гэсэн вангууд захирдаг байв. Эдгээр вангууд нь хүннүд байсан 24 зонхилогч түмний ноёдыг захирдаг байсан төдийгүй нэг түмэн морин цэргийг өөрийн мэдэлд байлгадаг байжээ. Түмний ноёд нь мянгат, зуут, аравтын дарга нарыг томилж захирдаг байсан байна. Хүннүчүүд Модунг хаан болсны дараагаар хөрш зэргэлдээ аймаг улсуудыг цэрэглэн эзлэж газар нутгаа тэлэн өргөсгөх бодлого баримталсан байна. МЭӨ 209 онд Дунху нарын эсрэг довтолж газар нутаг, хүн малыг нь өөрийн эрхшээлд авч чадсан байна. Дараагаар нь баруун зүг юэчжи аймгийг, өмнө зүг Ордосоор нутаглаж байсан олон аймгийг эзэлсэн төдийгүй Цин улсын үед (247-207) Хятадад эзлэгдсэн өөрийн газар нутгаа эргүүлэн авч чадсан байна. Цинь улсыг залгамжлагч Хятадын Хан улс Хүннүчүүдийг өөрийн эрхшээлдээ оруулахыг ихэд эрхэмлэж байсан бөгөөд зуун мянган цэрэг бүхий өөрийн армиа хүннүчүүдийн эсрэг илгээж байжээ. Гэсэн хэдий ч МЭӨ 198 оноос хүннүтэй найрамдан эвлэрэх бодлого барьж, хүннүгийн шанью бэлгэ сэлт илгээн, гүнж нараа хатан болгон өгөх болжээ. МЭӨ 162 онд Хан улсын эзэн хаан Сяо Вэньди хүннүгийн шаньюд явуулсан нэгэн захидалдаа “Урт хотоос хойших нум сум барьсан иргэд шаньюйн цаазыг дагасугай. Урт хотоос дотогш дээл малгайн улсыг би захирсугай” гэж албан ёсоор мэдэгдэж байсан байна.

Хүннү нарын дотоодын зөрчил болон овог аймгуудын хоорондын тэмцлээс шалтгаалан Хүннү гүрэн нь МЭӨ 57-55 оны хооронд умард, өмнөд гэсэн хоёр хэсэг болон хуваагдаж Хуханье шаньюйгаар толгойлуулсан өмнөд хүннүчүүд Хан улсын харьяанд орж, Хуханьейн ах Чжичжи умард Хүннүг захирах болжээ. Умард Хүннүчүүдийн зарим хэсэг нь Дундад Азийн Кангюй аймагтай холбоо байгуулан баруун тийш нүүдэллэсэн төдийгүй цааш Каспийн тэнгис орчмын аймгуудтай бас холбоо тогтоон нүүдэллэн явсаар Y зууны үед Дунай мөрний орчимд Атиллаар удирдуулсан нэгдмэл улсын хүртэл байгуулсан байна.

Уугуул нутагтаа үлдсэн умард хүннүчүүд ухуань, сяньби аймагтай дайтсаар хүч нь ихэд доройтон байсан ч Хан улстай хүч хавсран сяньби нарын эсрэг 89-93 онуудад дөрвөн удаа цэрэглэн дайтсан байна. Гэсэн хэдий ч 93 он гэхэд Хүннү гүрэн оршин тогтнохоо нэгэнт больжээ. Хүн амын нэг хэсэг нь дайн тулалдаанд алагдаж, үлдсэн зуу мянга орчим хүннүчүүд сяньби аймгийн дотор нэгдэн нийлсэн байна. Харин өмнөд хүннүчүүд IV зууны сүүл үе хүртэл хойд Хятадад оршин тогтносоор байжээ.

МЭӨ III - МЭ II зуун хүртэлх хугацаанд Төв Азийн өргөн уудам нутагт Хүннү нар нүүдэллэн амьдарч, төр улсаа цогцлон байгуулж, мандан бадарч байсны бодит нотолгоо болох археологийн дурсгалууд Монгол орны нутаг дэвсгэрээс олон тоотойгоор олддог.

Хүннүгийн археологийн дурсгалыг дотор нь булш бунхан, хот суурин, хадны зураг гэж ерөнхийлөн ангилан авч үзэж болмоор байна.

§ 1. ХҮННҮГИЙН БУЛШ БУНХАН

Хүннүгийн үед холбогдох булш бунханыг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд зүйл зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваан авч үздэг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсийн хувьд ч ялгагдана.

Язгууртны булш нь хэмжээний хувьд харьцангуй том, дөрвөлжин чулуун өрлөг далантай, үүдэвчтэй байдаг. Үүдэвчийг дөрвөлжин далангийн чанх урд чулууг мөн давхарлан өрж үйлддэг байсан байна. Үүдэвчний голоос эхлэн булш хүртэл хавтгай чулууг босоогоор нь зоож босгосон байдаг. Зарим булшины дотор талд хэд хэдэн эгнээ чулуун хана босгодог байжээ. Нас барсан хүнээ 8 м-ээс доош гүнд хоёр давхар тусгай дүнзэн бунхан доторхи модон авсанд оршуулдаг байжээ. Хүннүгийн язгууртны ийм булш манай орны Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигт, Зурамт, Хужиртын ам, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Архангай аймгийн Хайрхан

сумын Хүнүй голын Гол мод, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Борбулаг, Дуурлиг нарс зэрэг газруудад олон тоогоор байна. Мөн Буриадын нутаг Ильмовын ам, Дерестуй зэрэг газруудад ч хүннүгийн язгууртны бүлэг булшууд байдаг. Монгол оронд Хүннүгийн язгууртны булшийг малтан судлах ажил П.К.Козловын удирдсан Монгол-Түвэдийн судалгааны экспедицийн үйл ажиллагаатай нягт холбоотой. Ноён уулын Хүннүгийн булшийг Монголд ажиллаж байсан алт олзворлох “Монголор” алтны нийгэмлэгийн техникч Баллод гэгч 1912 онд анх санамсаргүй олж илрүүлсэн гэдэг. Тэрээр алтны судал хайж яваад том жижиг олон хонхор байсныг олж нэг томоохоныг нь малтаж үзэхэд булш байжээ. Олсон олдворынхоо заримыг Эрхүү, Петербургын холбогдох эрдэм шинжилгээний газар явуулсан нь Оросын эрдэмтэн судлаачдын сонирхлыг татсаар ийнхүү П.К.Козловын хээрийн шинжилгээний ангийнхныг Ноён ууланд аяны дөрөө мултлахад хүргэсэн байна. П.К.Козловын шинжилгээний ангийнхан 1924-1925 онуудад Ноён уулын Журамт, Сүжигтэйн аманд нийтдээ язгууртны 10 том булш малтан шинжилсэн байна. Ноён уулын эдгээр булшийг малтан шинжлэхэд газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн 14х14-50х50 м хэмжээтэй том дөрвөлжин чулуун дараастай, дараасныхаа урд, дээд тал нь 22,5 м хүртэл урт үүдэвчтэй байжээ. Дараасны доор 14 м хүртэлх гүн нүх ухаж дотор нь гуалингаар хоёр давхар хашлага хийж тэднийхээ дотор шургааган авсанд хүнээ оршуулдаг байжээ. Хашлагын дотор талыг торгон хөшгөөр бүрхэж, хоёр хашлагын завсар эсгий ширдэг дэвссэн байна.

Ноён уулын булшуудыг малтах явцад тэдгээр язгууртан хүний өмсөж эдэлж хэрэглэж байсан торгон дээл, өмд, гутал, малгай, шавар болон хүрэл, мөнгөөр хийсэн сав суулга, эмээл, бичигтэй чий будаг бүхий модон аяга, үнэт чулуу, алт мөнгөн эдлэл, малын болон ангийн үс, үр тариа зэрэг олон тооны эд өлгийн дурсгал олджээ. Эдгээр олдворын дотор ноцолдож буй амьтдын хатгамал дүрстэй эсгий ширдэг, амьтдын дүрстэй мөнгө, хүрэл эдлэл зэрэг гоёл чимэглэлийн олон зүйлс хүннү нарын урлаг, соёлын гайхамшигтай дурсгал гэж зүй ёсоор тооцогддог. Энд жишээ болгон Сүжигтийн аманд малтсан 1-р булшны зохион байгуулалт, олдсон олдворын тухай товч танилцаж. Энэ булш нь дөрвөлжин хэлбэртэй 21,9х21,9 м хэмжээтэй, урд талдаа 21 м урт үүдэвчтэй, түүний өргөн нь багалзууртаа 2 м, дунд хэрдээ 6,5 м, үзүүр хэсэгтээ 4,5 м байжээ. Дараасны өндөр нь хойд талдаа 1,25 м, урд талдаа 1,56 м, дунд хирдээ 1,73 м байсан бөгөөд булшны дунд хэсэгт 8 м голдоч бүхий 1,75 м гүн хонхортой байсан байна. Булшинд шургаагаар хийсэн дотуур гадуур хоёр бунхан барьж дотор талын бунханы зүүн хананд тулган авсаа байрлуулсан байжээ. Гадна бунхны хэмжээ нь 2,9х4,6 м өндөр нь 1,75 см ажээ. Дотоод бунханы хэмжээ нь хааш хаашаа 1,55х3 м дөрвөлжин хэлбэртэй, 1,45 м өндөртэй байжээ. Хоёр бунхан хоёулаа дээд талдаа хавхаг тагтай байсан бололтой. Дотуур гадна бунханы завсар хооронд эргэн тойрон гудамтай бөгөөд хойт талын гудманд гурав гурваараа хоёр үе зургаан багана байсан аж. Эдгээр баганыг дагуулан тавьсан гурван нуруу мод байсан бөгөөд түүн дээр гадаад хашлагын хавхаг гуалингуудыг хөндлөн тавьсан байжээ. Түүнчлэн дотуур бунханы урд ба хойт хананд нэжгээд баганатай, түүнийг дамнуулан тавьсан гол мод дээр дотор бунханыг гуалин тавьж тагласан байна. Дотор бунханы энд тэнд торгоны тасархай зүүлттэй байснаас үзэхэд торгоор өвч бүрсэн байсан нь тодорхой байна. Дотор талын бунханы шалан дээр торгоор өнгөлсөн хээ угалз бүхий эсгий ширдэг дэвссэн байжээ.

Авс нь ихээхэн муудсан байсан бөгөөд түүний ёроол хавьд далавчаа дэлгэсэн галууны зураг дүрсэлсэн байжээ. Энэ булшнаас торгомсог эдээр хийсэн ууттай тайрмал гээгний хуйнууд олон гарчээ. Хоёр бунханы завсар хоорондох гудмын баруун хойт буланд шавар ваар тавьсан байжээ. Энэ булшнаас нимгэн хавтгай алт, хаш чулуун чимгийн зүйл, төмөрлөг эдлэл, цэцгэн хэлбэртэй дог, зэс цорго, хутганы алт шармал зэс иш, араатны толгойн хүрэл дүрс, төрөл бүрийн торгоны тасархай, чий будагтай модон эдлэлийн үлдэгдэл зэрэг эд өлгийн зүйлс олджээ.

Бидний дурдсан болон бусад 3 булшнаас нийтдээ 120 гаруй гээгний хуй гарсан нь ихээхэн сонирхолтой баримт юм. Хүннүгийн Шаньюйг нас барахад түүний ойр дотны болон зарц шивэгчин нарыг алж нөгөө ертөнцөд хамт явуулдаг байсан гэх мэдээ сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг нь үнэн хэрэгтэй ойр дотны хүмүүс болон боол шивэгчин нарыг алаад хамт оршуулдаг бус харин тэднийг төлөөлүүлэн гээгийг нь огтлон хамт дагалдуулан оршуулдаг байсан баримт бололтой. Гээгийг 2-оор болон 3-аар сүлжсэн байх бөгөөд угаар нь чанга боосон байна.

Ноён ууланд малтсан бусад булшууд нь зохион байгуулалт олдсон эд өлгийн зүйлсээр хоорондоо адил төстэй байсан байна. Эдгээр булшууд нь бүгд эрт цагт тоногдсон бөгөөд хамгийн баялаг олдвортой нь 6-р булш юм.

Эндээс гарсан олдворуудаас хамгийн алдартай нь эсгий ширмэл ширдэг юм. 2,6 х 1,95 м хэмжээтэй улаан торгоор бүрж, хар хүрэн торгоор эмжиж ханан хээ ширээд дээгүүр нь ногоон өнгийн ноосон утсаар төвийлгөн 9 ургаа мод тэдний завсар хооронд бугыг бөгсөн талаас нь хазан дайрч буй махчин шувуу, сарлагийн урд талаас нь довтлон зоон дээрээс нь хазаж буй бар зэргийг оёж дүрсэлсэн ба тэдгээрийн дотуур дөрвөлжин, нэмэх тэмдэг хэлбэртэй хээ, мөөгөн хэлбэрийн дүрсийг улаан, ногоон, шар, улбар шар өнгийн ноосон утсаар төвийлгөн дүрсэлж салаавчлуулан оёсон ба ширдэгний төв хэсгийг эзлүүлэн бие биенээсээ салбарласан 24 ороомог маягийн хээ (үүлэн хээ)-гээр чимэглэжээ. Түүнчилэн бунханы тааз, хананд хадсан элдэв ургамал, яст мэлхий, загасны дүрс, морьтой хүнийг дүрсэлсэн эсгий ширдэг, ноосон нэхмэл даавуу олдсон байна.

Ноён уулын хүннүгийн язгууртны булш нь XX зууны эхэн үеийн археологийн шинжлэх ухааны томоохон нээлтийн нэг гэж зүй ёсоор тооцогддог.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт, Үүдэнт, Хөвсгөл аймгийн Галт сумын Нүхтийн ам, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгой, Батцэнгэл сумын Худгийн ам, Солби уул, Хөвсгөл аймгийн их-Уул сумын нутаг Сул толгой, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул зэрэг олон газруудад малтан шинжилжээ.

Хүннүгийн жирийн иргэдийн булш нь 5-13 м голдоч бүхий дугуй чулуун далантай байх ба далангийн доор 1-7 м хүртэлх гүн нүх ухаж дотор нь банзан авс болон мод чулуугаар хийсэн хашлаганд хүнээ толгойгоор нь хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар хэвтүүлэн оршуулсан байдаг. Хүнээ дагалдуулсан гол төлөв нум сум, жад, илд, чинжал хутга, эмээл хазаарын хэрэгсэл, хувцас хунар, хүрэл сав суулга, үнэт чулуун ба шил сувсан зүүлт, алтан чимэг, хүрэл толь, зэрэг гоёл чимэглэлийн зүйлс, мал, ангийн мах, үр тариа зэргийг тавьдаг байжээ. Тэгэхдээ эд өлгийн зүйл бүрийг утга учиртай тодорхой байранд, хэвшсэн заншлын дагуу тавьдаг байна. Тухайлбал нумыг хүнийхээ дээгүүр тэгнүүлэн тавьдаг бол сумыг саадагт хийж бүсэлхий орчимд тавьсан байх ажээ. Авсны толгойн харалдаа нүх ухаж адуу, үхэр, хонь, ямааны хэд хэдэн толгой, шавар болон хүрэл саванд будаа, мах хийж тавьдаг байжээ. Ийнхүү шавар сав суулганд хоол хүнс хийж тавих заншил хүннүгийн булшинд өргөн дэлгэр бөгөөд тэхдээ шавар саваа хүнийхээ толгойн харалдаа дээр, эсвэл зэрэгцээ хажууд, заримдаа хөл талд нь ч тавьдаг байжээ.

Хүннү булшнаас олдсон шавар сав нарийхан хүзүүтэй, жижиг амтай, шингэн ба нунтаг зүйл хийдэг, намхан хүзүүтэй, том амтай хоол унд чанадаг зориулалт бүхий, том амтай тарианы үр хадгалдаг гурван үндсэн төрөл байх бөгөөд өнгөний хувьд хар бараан, саарал хоёр янз буй нь гол төлөв шаврын чанар, шатаалтаас хамаарсан бололтой. Ихэнх ваарыг мөрөөр нь тойруулан хурц үзүүртэй багажаар зурж хээлсэн байх ба огт хээлж чимэглээгүй ваар сав ч тохиолдоно. Ваарны мөрөөр тойруулан зурсан хээнд долгион хээ, цулгүй хоёр зэрэгцээ зураас, хоёр зэрэгцээ хэвтээ зураас татаад хооронд нь олон зэрэгцээ босоо зураас гаргасан хээ, хоёр зэрэгцээ зураас татаад хооронд нь хурц өнцөгтэй долгио гаргасан хээ, хоорондоо өргөн зайтай хоёр зэрэгцээ зураас татаад дотор нь ханалсан хээ гаргаж нүд тус бүрийн дотор дөрвөлжин дүрсээр давхар чимсэн хээ зэрэг даруй 5 төрлийн хээ гол төлөв тархсан байхаас гадна ваарны амсраас мөрний хээг хүртэл эргэн тойрон тодорхой багажаар жигд цацраг хэлбэртэй дарж гоёсон ч тааралдана.

Дагалдуулан тавьсан эд өлгийн зарим зүйлсээс хүннүчүүдийн аж ахуйн хөгжилт, цэрэг байлдааны чадвар, зан заншил, сүсэг бишрэл, соёлын түвшингийн талаар багагүй зүйлийг нөхөн сэргээж мэдэж болно. Тухайлбал хүннү булшнаас сумны гурван хянгат, шөрөгт төмөр зэв, навчин хэлбэрийн төмөр зэв, нуманд хүч оруулах бариулын, гичирийн, элэгний ясан наалт олноор олддог нь хүннүчүүд ясан наалт бүхий хүчит нумыг хэрэглэж байсны баталгаа болж байна.

Булган аймгийн Хутаг Өндөр сумын Бурхан толгойн 26,28-р булшнаас тод хар өнгийн бэхний толботой бийрний чулуун янтай олдсон нь хүннүчүүд бичиг үсэг хэрэглэж байсныг харуулах чухал олдвор юм.

Хүннүгийн амьдралд эн тэргүүний үүрэг гүйцэтгэж байсан морь малын тоног хэрэгсэл жирийн иргэдийн булшнаас олон тоогоор гардаг бөгөөд амгай л гэхэд бугын эврэн, нуман зуузайтай, цагираган зуузайтай гэсэн гурван янз байдаг.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг малтан шинжлэх явцад урьд өмнө олдож байгаагүй эрдэм шинжилгээний онцгой ач холбогдолтой олдворууд цөөнгүй олддог. Тухайлбал, 1989 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хүннүгийн дурсгал судлах анги Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойд малтсан нэг дэх булшнаас ясан хэл хуур олсон юм. Хэл хуурыг 12,5 см урт, 1,4 см өргөн, 2 мм нимгэн ясаар сийлж хийжээ. Хуурыг татахад түүний хэлний хэлбэлзэл чичрэх физик хөдөлгөөнөөс гарсан дуу шүд, амны хөндийн зайгаас цуурай авч чангаран эгшиглэх зарчимд тулгуурлан хүннү нар энэхүү хөгжмийн зэмсгийг бүтээжээ. Энэ хөгжмийн зэмсэг нь хүннүгийн зөвхөн урлаг соёлын дурсгал төдийгүй тэдний оюун санааны, тухайлбал техник сэтгэлгээний хөгжлийг харуулах ховор баримт болж чадаж байгаа юм. Морин толгойн булшнаас олдсон хэл хуур нь одоогоос даруй 2000 гаруй жилийн тэртээд холбогдох ба энэ төрлийн хөгжмийн зэмсгийн одоогоор мэдэгдэж байгаа хамгийн эртнийх ч байж магадгүй юм.

Хүннүгийн гоёл чимэглэлийн зүйлс дотор өнгө хорших аргыг хэрэглэн хийсэн нарийн чимхлүүр ур хийцтэй эдлэл цөөн тоотой тааралдаг байна. Өнгө хорших гэдэг нь урлагийн ба ур дархын арга барилаар өнгө хоршин гоёл чимэглэл хийдэг арга юм. Хүннүгийн үеийн өнгө хорших аргаар хийсэн гоёл чимэглэлийн зүйлсийн дотор Тэвш уулын нэгэн булшнаас олдсон алтан чимэг эрдэм шинжилгээний болон урлагийн бүтээлийн хувьд онцгой ач холбогдолтой тооцогддог. Энэ алтан чимэг нь 1,7 x 0,25 см хэмжээтэй. Алтан чимгийг хийхдээ дөрвөн хажуудаа дөрвөн жижиг дугуйтай нимгэн хавтгай алтны ирмэгээр хоёр зуун наяд орчим алтан үрлийг хоёр эгнээ зэрэгцүүлэн гагнаж эмжин нуух гаргажээ. Чимэгний ар тал тэгш бөгөөд түүнд зүүх зориулалт бүхий сэнж гагнаж хийсэн байна. Нууханд шигтэн суулгасан шигтгээг бэхлэх зориулалт бүхий жижиг сүвэгч нүхийг гаргасан байна. Дээрхи алтан чимгэнд олон жижиг алтан үрлээр хоёр эгнээ хөвөө гагнаж шигтгээ суулгах нуухыг

гаргасан нь үрлэн арга гэж нэрлэгддэг ба хүннү нарын гоёл чимэглэлийн зүйлсийг урлан дархлах ажилд хэрэглэгдэж байсан бас нэгэн өвөрмөц арга юм. Өнгө хорших энэхүү аргаар хийсэн эдлэлүүд Дундад Ази, Зүүн Европын олон улс орны археологийн дурсгалаас олддог нь хүннүгийн соёлын нөлөө хүнүүчүүдээр дамжин тэдгээр орны газар нутагт амьдарч байсан овог аймгуудад хүрсэн болохыг харуулж байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл Хүннү нар МЭ III-IV зуунаас өмнө зарим хэсэг нь баруун тийш Европд нүүдэллэн очоогүй төрлөх нутаг орондоо байх үедээ өнгө хорших аргаар алтан чимэг хийж хэрэглэж байсан төдийгүй, алтны урлалын маш нарийн төвөгтэй үрлэн аргыг төгс эзэмшсэн байжээ хэмээн дүгнэн үзэж болох юм.

Түүнчлэн янз бүрийн чулуун эдлэлүүдэд ч өнгө бүрийн чулуу шигтгэж урлаж байсан байна. үүний жишээ нь Дархан хотын ойролцоох төмөр замын Салхитын өртөөний орчмын хүннү булшнаас гарсан улаан, ягаан ногоон өнгийн чулуун шигтгээтэй хар өнгийн чулуун (богхед) гэрэгэ зүүлт юм.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг малтан судалсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд сонгосон газар зүйн байршилт (уулын энгэр наран тал), булшны гадаад байдал, бүтэц зохион байгуулалт, булшинд үхэгсдийг оршуулах зан үйл (банзан авсанд хүний хоёр хөлийг жийлгэн, хоёр гарыг их биеийг дагуулан тавьж толгойг чанх хойт зүг хандуулан гэдрэг харуулан хэвтүүлж оршуулдаг), дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл зэрэг бүхий л талаараа дундад зууны төдийгүй өнөөгийн монголчуудын үхэгсдээ оршуулдаг заншилтай ижил төстэй байгаа нь хүннү монголчууд хоёр нэгэн угсаатан болохыг археологийн талаас нь харуулж буй маш чухал үндсэн баримт гэж үзэж болно.

§ 2. ХҮННҮГИЙН ХОТ СУУРИН

Хүннүгийн археологийн судалгааны чухал хэрэглэгдэхүүний нэг бол тэр үеийн хот суурин юм. Хүннү нар нүүдлийн мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ тодорхой хэмжээгээр газар тариалан эрхлэн хот суурин байгуулан сууж байсан байна.

Төв аймгийн Борнуур сумын Бороогийн суурин, Мөнгөнморьт сумын Хүрээн дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Эрдэнэ сумын Өндөр дов, Баянжаргалан сумын нутаг Хэрлэн голын Цагаан арлын Гуа дов, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Баруун Дөрөөгийн хэрэм, Барс хот II, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутагт орших Цэнхэрийн голын хэрэм, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Шувуутайн голын хэрэм, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулагийн турь зэрэг Хүннүгийн үед холбогдох хот суурины үлдэцийг археологийн хайгуул шинжилгээний ажлын явцад олж илрүүлэн заримыг малтан судалжээ. Эдгээрийн зарим нэгтэй танилцай.

Гуа дов. Гуа дов нь эргэн тойрон шороон хэрэмтэй байсан бөгөөд түүний хойт урд тал нь 367 м, баруун, зүүн тал нь 360 м ба хэрмийн нурсан үлдэцний өндөр 50-70 см өргөн нь 3,5 м байгаа бөгөөд хойт урд талдаа хэрэм хаалгатай байжээ. Хэрмийн төв хэсэгт нэг барилга, хэримэнд тулгаж барьсан арваад барилга байжээ. Төв хэсгийн барилгыг дагтаршуулсан шороон дээр барьсан байжээ. Хэрмийн ханыг боржин чулуун суурьд босгосон баганын хооронд шавар шахаж хийсэн байжээ. Малтлагын явцад барилгын дөрвөлжин ба зууван тоосго, дээврийн нөмрөг, тосгуур, нүүр ваар, баганын суурь, хээтэй хавтгай дөрвөлжин тоосгоор өнгөлсөн тахилын ширээ зэрэг илэрч олдсон байна.

Бороогийн суурин. Төв аймгийн Борнуур сумын төвөөс баруун хойш 30 гауй км-т Цагаан чулуутын хөндий Бороо голын хойд дэнж дээр орших эртний хотын үлдэгдлийг Бороогийн суурин гэж нэрлэдэг. Эргэн тойрон 100 м хэмжээтэй. Хэрмийн үлдэгдлийн одоогийн өндөр нь 20 см өндөртэй байна. Энэ сууринг анх 1962 онд археологич Ц.Доржсүрэн олж илрүүлсэн байна. 1990 онд Монгол-Унгарын хамтарсан хүннүгийн дурсгал судлах ангийнхан нарийвчилсан малтлага шинжилгээ хийжээ.Тэд 5 хэсэг газар малтлага явуулж хэд хэдэн сууцны үлдэгдэл, шавар ваар савны хэлтэрхий, малын яс, тариа цайруулдаг чулуун самбарын тал зэргийг олж илрүүлжээ. Мөн түүнчилэн шавар ваар савны амсрыг үйлдэхэд хэрэглэж байсан бог малын далны ясаар хийсэн багаж олсон нь чухал ач холбогдолтой олдворт тооцогддог.

Энэ суурин нь хүннү нар байнга оршин сууж байсан аж ахуйн төв, гар урлалын газар байсан бололтой. Мөн малтлагын явцад шатаагдаагүй түүхий үедээ эвдэрч үйлдвэрийн гологдол болсон шавар савны амсар олджээ. Хүннүгийн бусад хот суурины үлдэгдлээс тахилын шинж чанартай олдвор олддог бол Бороогийн суурингаас аж ахуйн зориулалттай эдлэлүүд гарч байгаа тухайн үедээ аж ахуйн төв байсныг харуулж буй баримт юм.

Баянбулагийн турь. Хүннүгийн үед холбогдох энэ хотын үлдэгдэл Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг, сумын төвөөс урагш 30 гаруй км-т оршино. Дөрвөлжин хэрмийн ихэнх хэсэг нь эвдэрч, зөвхөн хойд талын хана бүтнээрээ, баруун талын хананы тал хэсэг нь хадгалагдан үлджээ. Хэрмийг шороо дагтаршуулан хийсэн бөгөөд хойд тал нь 180 м, баруун тал нь 110 орчим м-ийн урттай. Хананы өргөн нь 10-16 м ажээ. Хойд талд нь 2 м орчим өндөртэй 2 овгор байх агаад энд харуулын цонж байсан бололтой. Энэхүү турийг 1957 онд Х.Пэрлээ анх судлан дэвсгэр зургийг нь үйлдэн, тодорхойлолт хийсэн байна. Тэрээр хэрмийн ойролцоох дэнжийн дор буй хоорондоо холбоотой хоёр овгор шороог хог хаядаг байсан газар гэж үзсэн ба эндээс хүннүгийн үеийн шавар ваарны хагархай, төмөр шилбэтэй хүрэл зэв зэргийг олжээ. Мөн эндээс Хан улсын үеийн у-шу зоос, хүрэл эдлэл, ваар савны хагархайнуудыг олж илрүүлсэн ба 1990 онд Түүхийн хүрээлэнгийн Хүннүгийн дурсгал судлах

анги хоёр хэсэг газарт малталт хийж түүхий тоосгоор өрж барьсан барилгын үлдэцийг илрүүлэн, олон тооны шавар ваар, савны хагархай, хүрэл зэв, у-шу зоос, төмөр эдлэлийн үлдэгдэл, хүрэл толины хагархай, хүрэл тамга зэрэг эд өлгийн зүйлсийг олсон юм. Хүрэл тамга нь дээрээ янгирын дүрстэй бөгөөд түүхэнд холбогдох чухал баримт болно.

Тэрэлжийн дөрвөлжин. Энэ хэрэмт хотын үлдэгдэл Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн голын зүүн эрэгт оршино. Анх 1925 онд Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов, буриад эрдэмтэн Бараадын Базар нар сурвалжлан олж илрүүлэн бага хэмжээний малталт хийсэн байна. Хэрмийн хэмжээ нь хааш хаашаа 235х235 м. Хэрмийн одоогийн өргөн нь 10-15 м, өндөр нь 0,5-0,8 м, хэрмийн гадна талаар нь татсан сувгийн өргөн нь 3-6 м, гүн нь 0,5-0,7 м ажээ. Оросын судлаач В.С.Киселев 1949 онд нүдээр үзэж хүннүгийн үед холбогдохыг нь тодорхойлжээ. 1952 онд Х.Пэрлээ хоёр барилгын орыг малтан шинжилсэн бөгөөд малтлагаас гарсан барилгын тосгуур ваар, нөмрөг ваар, хээтэй тоосго зэрэг олдвор хэрэглэгдэхүүн нь Гуа довоос олдсон олдворуудтай адил байсан байна.

Малтлагын үр дүнд үндэслэж Х.Пэрлээ энд хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ

§ 3. ХАДНЫ ЗУРАГ

Хүннү нарын үлдээсэн археологийн дурсгалын өөр нэг төрөл бол хадны зураг юм. Манай орны нутаг дэвсгэрээс олдсон хэдэн мянган хадны зургаас судлаачид Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутаг Ямаан усны хавцлын Ханан хаданд дүрслэгдсэн гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг, тамган дүрс, Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Цагаан салаагийн хаднаа буй нохойд хөөгдсөн аргалийг угтан харваж буй анчныг дүрсэлсэн зургуудыг хүннүгийн үед холбогдуулан авч үздэг. Ямаан усны хаднаа найман хигээстэй дугуй бүхий гурван морь хөллөсөн сүйх тэргийг нэлээд нарийн сийлж, дотор нь хүн сууж яваа байдлыг харуулж урласан байна. Тэрэгний урд, нум саадаг агссан морьтой хүн, ар талд нь мөн нэг морьтой хүнийг дүрсэлжээ. Уг зурагт морины хатирч яваа байдлыг мэдэгдэхүйц сийлсэн байна. Дараагийн зурагт нэг моринд хөллөсөн хөсөг тэрэг дотор сууж яваа хүнийг тоймлон дүрсэлсэн байна. Энэ тэрэгний өмнө морьтой хүнийг мөн дүрсэлжээ.

Цагаан салаагийн хаднаа махиралдсан том эвэртэй аргалийн биеийн ерөнхий тэгийг нарийн зураасаар хөвөөлөн эх бие, хүзүү, эврийн доторхи зайг муруй тахир олон зураасаар дүүргэн сараачин дүрслэхдээ түүнийг өргөн хоншоорыг тод гаргаж, хурдтай харайж дүүлж яваагаар үзүүлжээ. Ингэхдээ аргалийн дөрвөн хөл, сүүл, чих, нүд, ам, хамрыг ихэд бодитойгоор дүрсэлжээ. Аргалийн хажуу доод талд түүнийг хөөж буй урт том сүүлтэй нохойг дүрслээд тэр хоёрын урдуур хоёр зэрэгцээ зураас татсан нь гол юмуу зам болтой. Аргалийг тэрхүү хоёр зэрэгцээ зураасны хоорондох завсарлуу нохойг шахаж хөөж буй мэт дүрсэлсэн байна. Харин аргалийн урд талаас шовх оройтой малгайтай, шовх хоншоортой гуталтай, ардаа бүснээсээ гурван сум зүүсэн анчинг нум сумаар тосон харвах гэж буйгаар дүрсэлжээ. Энэ зурагт дүрслэгдсэн аргалийн дүрс нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Тариатад малтсан хүннүгийн булшнаас гарсан ясан эдлэл дээр хурц үзүүртэй багажаар зурсан аргалийн зурагтай урласан аргаараа тун төстэй ажээ. Мөн Цагаан салаагийн зурагт дүрсэлсэн хүний малгай нь Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын булшнаас олдсон шовх оройтой даавуун малгайтай ижил төстэй бөгөөд нум нь хүннүгийн нум шиг зүймэл хүчит нум болох нь сайн танигдаж байна. Хүннүгийн үед холбогдох зурагнууд нэлээд байх боловч тэдгээрийг одоо хир нарийвчлан судлаагүй байгаа билээ.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

Баяр Д. Дуулга уулын нэгэн булш. СА. т.ҮII. f.6. УБ., 1976. -тал 60-65.

Бернштам А.Н. Гуннские могилники Ноин-ула и его историко- археологическое значение // АН СССР. отд. общест. наук. 1947, вып. 4.

Дамдинсүрэн А. Археологийн шинжилгээгээр олдсон хүннүгийн бичгийн дурсгал // СА (Монголын эртний түүх соёлын зарим асуудал). т.5. f.8. УБ., 1972.

Доржсүрэн Ц. Умарт Хүннү. УБ., 1969.

Доржсүрэн Ц. Хойд хүннүгийн булш // ШУХ-ийн эрдэм шинжилгээний бичиг. 11. УБ., 1956.

Доржсүрэн Ц. Раскопки могил хунну в горах Ноён-ула и на реке Хуни-гол (1954-1957) // МАС. М., 1962.

Козлов П.К. Северная Монголия. Нойн-улинские памятники // Краткие отчеты экспедиции П.К.Козлова. - Л., 1925.

Пэрлээ Х. Хүн нарын гурван хэрмийн үлдэц (МЭӨII-МЭI зууны үе).УБ.1957.

Пэрлээ Х. Хэрлэн барс гэдэг хотыг малтан шинжилсэн тухай // ШУХБ. НУА.12: УБ., 1957. -тал 119-164.

Руденко С.И. Культура хуннов и Ноинулинские курганы. Л.,1962.

Тревер С. Находки из раскопок Монголии в 1924-1925 гг. // Сообщении ГАИМК. 1931. вып. 9-10.

Умехара С. Моко Ноин-ула хакена ибүцү, (Монголын Ноён уулнаас олдсон олдвор). Токио., 1960 (Япон хэл дээр).

Хандсүрэн Ц. Ноён уул дахь Хүннүгийн булшнаас олдсон аяганы бичээсийг уншсан нь // SA. t. IV., f. 5. УБ., 1965. - тал 29-34.

Худяков Ю.С., Цэвээндорж Д. Новые находки хуннских луков в Говийском Алтае // АЭАИМ. Новосибирск 1990. -Стр 126-131.

Цэвээндорж Д. Новые данные по археологии хунну // ДКМ. Новосибирск, 1985. -Стр. 51-86.

Цэвээндорж Д. Хиргист хоолой, Онътольтын Хүннү булш // SH. t. XIII. f. 8. -тал 59-81

Цэвээндорж Д. Морин толгойн булшнаас олдсон Хүннү хэл хуур // ШУАМ. 1990. '3. -тал 72-80

Цэвээндорж Д., Эрдели И. Худгийн толгой, Солби уул, Наймаа толгойн хүннү булш // SH. t.24. f.11. - тал 105-129.

Цэвээндорж Д нар. Хүннүгийн шавар ваар // SA. t.XIV. f.5. УБ., 1994. -тал 76-108.

Эрдэнэбаатар Д., Төрбат Ц., Эрдэнэбат У. Хүннүгийн үеийн шинэ олдворууд // SA. t.XIX. f.7. УБ., 1999. -тал 64-73.

ТҮРЭГИЙН ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Түрэгүүд нь Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм. Монгол болон зөрчид угсаатны нэгэн адил алтай язгуурын хэлний бүлэгт хамаарах түрэгүүд YI-YIII зууны үед нийт Төв Ази түүний дотор одоогийн Монгол нутгийг харьяандаа багтаасан хүчирхэг хаант улсыг байгуулж энэ бүс нутаг дахь түрэг угсаатны 400 орчим жилийн ноёрхлын эх үндсийг тавьжээ.

Түрэгийн өвөг дээдэс эхэн үедээ, эдүгээгийн Дорнод Туркестанд нутаглаж байгаад 460 оны үеэс Жужан улсын харьяанд даган орж Алтайн өмнөд биед шилжин суугаад төмрийн хүдэр хайлан алба барьж байжээ. Түрэгүүд улс төрийн уран нарийн бодлого явуулж хүчээ зузаатгасаар 552 онд Түрэгийн зонхилгоч Буман, Жужаны эсрэг босон тэмцэж бут цохисон байна. Ингээд өмнө нь Жужаны харьяанд байсан олон овог аймгийг газар нутагтай нь эзлэн Түрэгийн хаант улсыг байгуулжээ. Түрэгүүд дорно зүг нутаг тэлэн суурьшсаар удалгүй Монголын төв нутаг Орхон голын саваар төвлөх болж улам улмаар хүчирхэгжин газар нутгаа тэлж байв. Үүний үр дүнд Солонгосоос Баруун тэнгис (Арал нуур), их элсэн цөлөөс умрын Байгал нуур хүртлэх нутгийг эзэлсэн хүчирхэг улсыг байгуулж, Хятад, Византи зэрэг тухайн үеийн том гүрнүүдтэй өрсөлдөх болжээ. Хятадаас байнга албан татвар авсаар хүчирхэгжин бэхэжсэн боловч түрэгийн язгууртан нар бие даахыг эрмэлзэн тэмцэх болж, улс гүрэн дотроосоо задрах аюул тулж иржээ. Энэ байдлыг Хятад улс зүйл бүрээр өөгшүүлэн, хүчийг задлах бодлого явуулсаар ирсний дүнд Түрэг улс 590-ээд оны үед Зүүн, Баруун хоёр хэсэг болон хуваагджээ. Монгол нутгаар төвлөрсөн Зүүн Түрэгийн хаант улс нь үндсэн хүчээ алдалгүй хадгалж, бүрэн эзлэн авах гэсэн хятадын Сүй (581-618) улсын эсрэг тэмцсээр ирснээр барахгүй, Сүй улс мөхөж Тан (618-907) улс мандах үйл явцад идэвхитэй үүрэг гүйцэтгэсэн байна.

Шинээр үүсэн мандсан Тан улс эхэн үедээ Түрэгийн эсрэг шийдвэртэй бодлого явуулж чадахгүй байсан боловч яваандаа, хүчийг олох тутам нүүдэлчдийг эзлэн захирах уламжлалт бодлогод шилжин оржээ. Тан улсыг үүсгэн байгуулагч Ли Ши Мин, Хятадын цэрэгт шинэчлэл хийж, байлдах чадвар, зохион байгуулалтыг нь сайжруулсан ба Хятадын цэргийн гол хүчийг, тэдний албанд орсон Табгач хэмээх, нүүдэлчин гаралтай морин цэрэг бүрдүүлж байв. 626 онд Ли Ши Мин Тайзүн цолтойгоор Тан улсын хаан ширээнд сууж Гадаадын байлдаанаар дотоодын амгалан тайван байдлыг хангах бодлого явуулжээ. Хятадын бодлогын уршгаар, Түрэгийн харьяанд байсан олон аймаг босч тэмцэн Хятадад дагаж орох болов. Ингээд Тайзүн хаан 630 онд их цэрэг хөдөлгөн Түрэг улсыг бутцохиж, говиос өмнөх нутгийг эрхэндээ оруулжээ. Түрэгүүд ийнхүү 50 гаруй жил Хятадын мэдэлд орсон боловч удаа дараа босч тусгаар байдлын төлөө тэмцсээр байсан юм.

690 оны үед Түрэгийн нөлөө бүхий язгууртан Күтүлүг, түүний зөвлөх Тоньюкук нарын толгойлсон бослого амжилтанд хүрч Күтүлүг, Элтэрэс буюу улсыг хураагч цолтойгоор хаан сууж төр улсаа сэргээн тунхаглажээ. Түүний дараа Можо (693-716), Могилян буюу Билгэ (683-734) зэрэг хаад төрийг барьж, алдагдсан нутгаа эргүүлэн авах, улс орныхоо эдийн засаг, улс төрийн байдлыг сайжруулан бэхжүүлэх арга хэмжээ авч, бусад улс гүрэнтэй найрамдалт харилцаа тогтоохыг зорьсоор иржээ. Гэвч эдгээр хаадын дараагаар Түрэгийн хүчин сулран мохож, 745 онд, харьяанд нь байсан Уйгурын босогчдод цохигдон, ноёлох байр сууриа алджээ.

Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйл гэвэл, юуны өмнө хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдийг оршуулсан булш хиргисүүр зэрэг зүйлс орж байна.

Түрэгийн тухайт эд өлгийн дурсгал, нэн ялангуяа тэдний хамгийн их нийтлэг бөгөөд өргөн тархсан дурсгал болох тахил тайлгын онгоны цогцолборууд нь түрэг угсаатан оршин суусан Евразийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртлэх нутагт элбэг олддог. Түүнчлэн, одоогийн манай улсын хил хязгаарын чанад дахь Тува, Уулын Алтай, Хакас, мөн Казахстан, Киргизстан улсын нутаг, БНХАУ-д харьяалагдах ӨМӨЗО-ны зарим хушууд, Дорнод Туркестан буюу Шинжааны нутгаар тархжээ. Олдож буй дурсгалын хамгийн баруун зах нь Украины нутаг хүрч байна. Бид өөрийн нутагт байгаа түрэгийн үеийн археологийн дурсгалын талаар лавтган судлахдаа, харьцангуй сайн судлагдаж, он цаг учир холбогдол нь илт тодорч нийтээр хүлээн зөвшөөрсөн, дээрх нутгуудын дурсгалын талаарх баримтад тулгуурладаг билээ. Тэгээд ч одоогийн хил хязгаар тэр цагт байгаагүй, дурдсан газар нутгаар оршин сууж байсан ард түмэн нь бүгд угсаа гарал, түүх соёлын нэгэн улбаатай, тухайн үедээ нэгэн улсын харьяанд багтаж байсан нь тодорхой билээ.

Монгол нутагт буй Түрэгийн тахилын онгонуудын газар зүйн байршлыг үзэхэд, тэдгээр нь их гол мөрний сав хөндийгээр голлон бөөгнөрсөн байдаг. Тухайлбал, Орхон, Туул, Хэрлэн, Тамир, Хануй, Хүнүй, Онги, Тэрх, Түйн гол зэрэг манай орны төв нутгийн томоохон гол мөрнийг дагаад түрэгийн үеийн хүн чулуут тахилын онгонууд нэн олноороо байрлажээ. Энэхүү дурдсан нутгуудад 19-р зууны сүүл үеэс одоог хүртэл хийсэн археологийн хайгуулын үр дүнд янз бүрийн овор хэмжээтэй тахил

тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан бүтээсэн хүн чулууны дурсгал нэн олноор илрэн олдсон билээ. Түүнчилэн эдгээр цогцолбор дурсгалын дотор нарийн зохион байгуулалт, сүрлэг том овор хэмжээгээрээ ялгардаг, хаад ноёдын хэмээн нэрлэгддэг томхон дурсгалууд 87-г илрүүлэн олж судлаад байна. Харин жирийн иргэдийн гэж нэрлэгддэг энгийн болхи хийцтэй тахилын онгонууд нь Хэнтийгээс Алтайн уулс хүртлэх уудам их нутгаар олон байдаг.

§ 1. ТҮРЭГИЙН ТАХИЛ ТАЙЛГЫН ОНГОН

Эртний түрэгүүд нас барагсдаа булшлан оршуулахын зэрэгцээ тэдний сүнсийг амаржуулах зорилгоор олноор цуглан тахил тайлгын зан үйл гүйцэтгэх онгоны газрыг тусад нь байгуулдаг байжээ. Эдгээр нь уг нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч эрс ялгаатай байв.

Жирийн иргэдийн онгон. Түрэгийн тайлгын онгон нь хавтан чулууг газарт хайрцаглан суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, түүний өмнө (зүүн талд) байрлуулсан хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ зэрэг үндсэн хэсгээс бүрдэнэ. Эдгээр байгууламжууд нь уг онгоныг зориулан цогцолж буй талийгаачийн зэрэг дэв, язгуур сурвалжаас шалтгаалан овор хэмжээ, бүтэц зохион байгуулалтаараа өөр өөр байна. Тухайлбал, эгэл жирийн хүмүүсийнх гэж үздэг хамгийн энгийн онгонууд нь бараг засч янзлаагүй шахам хавтан чулуудыг хэд хэдээр нь цувруулан газарт шигтгэж хашлага үйлдээд голын зайг шороо чулуу хольж дүүргэсэн байх ба үүний зүүнтээ маш болхи тойм дүрстэй хүн чулуу буюу хүн чулууг орлуулсан жирийн гозгор чулуу тавьж өмнөөс нь цөөн тооны зэл чулуу цувуулсан байдаг.

Язгууртны онгон. Угсаа сурвалжит язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байна. Түрэг улсын төрд онцгой гавьяа байгуулсан цэргийн жанжин, түшмэд, төрийн их хаадын онгоныг шавар хэрэм цогцлон усан шуудуугаар хүрээлж тахилын сүм босгон, шадар бараа бологсод хийгээд зарц үйлчлэгчдийн хөрөг дүрс, арслан, хонь зэрэг амьтны чулуун дүрсүүдийг хийж нүсэр хийц, нарийн зохион байгуулалттай бараа сүр ихтэй том цогцолбор байгууламж босгон хийсэн байдаг. Тахил тайлгын хашлагыг гоёмсог хээ угалзаар чимэглэсэн дөрвөн хавтангаар том хэмжээтэй үйлдэж булангуудыг нь засмал чулуун бэхэлгээгээр бэхлэх ба зарим тохиолдолд үүний дээрээс голдоо нүхтэй том чулуугаар тагладаг байжээ. Билгэ хаан болон Культегины онгонд энхүү хашлага чулууг голдоо нэвт нүхтэй цул том дөрвөлжин чулуугаар орлуулсан байжээ. Эдгээр тахилын чулууг ихэнх том дурсгалуудад тахилын сүмийн ар талд, уг цогцолборын баруун хэсэгт байрлуулдаг байв. Хэрэмд орох хаалганы хатавчинд чулуугаар үйлдсэн арслан буюу хонины дүрсийг хосоор нь үйлдэж өөд өөдөөс нь харуулан тавьсан байдаг. Эдгээрт байх балбал зэл чулууны тоо хэдэн зуу, зарим их томынх мянгад ч хүрч байсан бололтой бөгөөд үргэлжлэн цуврах уртын хэмжээ нь 2-3 км хүрдэг байжээ.

Эдгээр онгоны утга учрыг эрдэмтэд тайлбарлахдаа, түрэг угсаатны амьдралын хэв заншил, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэлтэй холбон үздэг байна. Тухайлбал, онгон бүхэнд заавал байдаг чулуун хашлагыг хүний орон гэрийг төлөөлүүлэн хийсэн зүйл бөгөөд уг нас барсан хүн хойт насандаа оршин суух орон сав нь болно гэж зарим судлаач үздэг. Өөр нэгэн санал бол, энэ нь эрт үед дорно дахинд ихэд дэлгэрсэн, утгаа Энэтхэг, Ираны соёлоос гаралтай ертөнцийн загвар, түүний оргил болсон сүмбэр уулыг дүрсэлсэн зүйл бөгөөд талийгаачийн сүнс тэнд түр хоргодон байснаа тэндээсээ тэнгэрт халин одохын санааг агуулжээ гэж тайлбарладаг байна.

Балбал хэмээх зэл чулууны учир утгыг эрдэмтэд хоёр янзаар тайлбарлаж байгаа нь юуны өмнө нанхиад сурвалжид тэмдэглэснийг баримтлан энэхүү онгоны эзэн баатар эрийн амьд насандаа дайн тулаанд алж устгасан дайсных нь тоогоор босгосон зүйл гэж үздэг.

Нөгөө нэг тайлбар нь түрэг угсаат ард түмний зан заншил ёс уламжлалд тулгуурласан бөгөөд эдгээр чулуу нь уг хүнийг оршуулах болон тахиж тайх ёслолд оролцсон бүх хүн өөрсдийгөө төлөөлүүлэн босгосон тэмдэг гэж үздэг байна. Тэрчлэн ёслолд оролцсон хүмүүсийн морины уяа гэж үзэх санал байгаа нь үүнтэй утга бараг нэг юм. Зэл чулууны зарим нь болхидуухан дүрсэлсэн хүний биеийн ерөнхий дүрстэй байхаас гадна заримд нь Түрэгийн гол ноёлох Ашина овгийн янгир тамгыг сийлсэн нь бий. Энэ бүхнээс үзэхэд зэл чулуу нь ямар ч атугай хүнийг төлөөлүүлэн бэлгэдсэн дурсгал болох нь тодорхой ажээ. Түрэгийн тайлгын онгоныг газар газарт малтан судалсан байдлаас үзэхэд алинд нь ч хүний булш оршуулга гарч байсангүй. Зарим нь үнс, нүүрсний толбо гарч байсан тохиолдол байхаас гадна ихэвчлэн малын яс, сав суулгын зүйл тохиолдож байжээ. Тухайлбал Уулын Алтайн Юстыд хэмээх газарт малтсан хоёр онгоноос тус бүр мөнгөн болон шавар суулгыг чулуун хөшөөний яг өмнө амсрыг нь дээш харуулан тавьсан нь олдсон байна. Тэрчлэн чулуун хашлагын дээр ямар нэгэн асар саравч бололтой барилга байсны шинж тэмдэг болох модон баганын үлдэгдлүүд хашлагын эргэн тойрноос олдож байсан тохиолдол бий. Мөн хашлагын гол дунд ч модон багана суулгаж байсан баримт нэг бус тааралджээ. Энэ бүх байдлаас үзэхэд эртний түрэгүүд нь нас барагсдаа нууцлан оршуулаад харин тэдний сүнсийг тайх онгоныг огт ондоо газарт барьж байгуулдаг байжээ.

Түрэгүүдийн эзлэн сууж асан бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд, алдар цуутай хаад ноёдод зориулж цогцолсон хамгийн сүрлэг том онгоны байгууламжууд гагцхүү Монголын төв нутгаар байрлажээ. Тухайлбал, Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам хэмээх газарт буй Билгэ хааны (735) онгон, Культегины (732) онгон, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт буй Онгийн голын дурсгал буюу Алп Элетмишийн (731-732) онгон, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Их хөшөөтийн дурсгал буюу Кули-Чурын онгон (742-745), Налайхын орчимд буй Тоньюкук сайдын онгон (720-иод он), Архангай аймгийн Хайрхан, Булганы Баян-Агт сумдын зааг нутагт буй Шивээт Улаан (682-683) зэрэг нарийн зохион байгуулалттай, олон хүн амьтны дүрс бүхий сүрлэг том дурсгалыг нэрлэж болох юм.

Хөшөө цайдамын дурсгал. Их Монгол улсын нийслэл Хар хорум хотын туурь үлдэгдлээс чанх хойш 45 км-т Хөгшин Орхон голын зүүн хөвөө, Цайдамын хөндийд Түрэгийн язгууртны дөрвөн онгон оршдогийн хоёрынх нь цаг хугацаа, зориулсан эзэн тодорхой юм. Эдгээр нь Зүүн Түрэгийн Билгэ хаан, түүний дүү цэргийн нэрт жанжин Культегин нарын онгон бөгөөд 1958 онд Монгол-Чехословакийн эрдэмтэд Культегины дурсгалыг нэлээд хэмжээгээр малтан судалжээ. 1996 оноос Монгол, Туркийн эрдэмтэд хамтран судлаж байна.

Уг байгууламжийг гонзгой дөрвөлжин хэлбэрийн шороон хэрэм, түүний гадуур татсан усан сувгаар хүрээлүүлж 67х29 м хэмжээтэй тэгш талбайд байгуулсан нь урт тэнхлэгээрээ өргөргийн дагуу чиглэлтэй юм. Хэрмийн зузаан 1 м, тойрсон шуудууны гүн 2 м байжээ. Хэрмийн зүүн хэсэгт орох хаалга байсан ба хаалгын хоёр хатавчинд хоёр чулуун хонины дүрсийг өөд өөдөөс нь харуулан тавьсан байжээ. Хаалганаас дотогш 8 м орчим зайд үзэмжтэй сайхан цоолборлож хийсэн яст мэлхийн нуруунд түрэгийн руни болон нангиад бичээст сүрлэг том гэрэлт хөшөөг суурилуулан босгосон байжээ. Хөшөөний өндөр нь 333 см, өргөн нь 132 см, зузаан нь 43 см. Гурван талдаа нийт 68 мөр, 10 000 гаруй үсэг зурлага бүхий түрэг бичээстэй. Дээрхи бичгийн 1-13 дах мөрийг их бичээс, 14-68 дах мөрийг бага бичээс хэмээн нэрлэдэг. Анх мэлхий чулуун дээр нүүрэн талыг нь наран ургах зүг харуулан босгож байжээ. Энэ хөшөөг Түрэгийн хаган Билгэ өөрийн төрсөн дүү Культегины гэгээн дурсгалд зориулан босгуулж, Иолуг Тегин хорь хоногт багтаан ухаж сийлсэн гэдэг. Тан улсын хаан Минь-Хуан элч зарж гашуудлын үг илгээснийг хөшөөний ар талд бас сийлжээ. Энэхүү бичигт хөшөөнөөс хэрэмт талбайн төв дундах тахилын сүмийг хүртлэх зайд шадар түшмэл, зардсан нарын чулуун хөрөг дүрсийг хоёр эгнээгээр зэрэглэн босгосон байжээ.

Тахилын сүмийг, шавар дагтаршуулж үйлдсэн, орчны гадаргаас 1 м орчим өндөр дөрвөлжин тавцан дээр барьсан бөгөөд үүний эргэн тойрон хэрмийн доторхи талбайг дөрвөлжин хөх тоосгоор нэлд нь шалласан байжээ. Сүмийн хэмжээ 10 х10 м бөгөөд арван зургаан модон багана суурилуулж байсан дөрвөлжин суурь чулуунууд хадгалагдан үлдсэн байдаг. Сүмийн дотор талд малтаж үзэхэд хөх өнгийн гантиг чулуугаар урласан Куль Тегин ноёд зориулан хийсэн хөшөөнийх нь хугархай толгой, мөн түүний хатны дүрсний нүүрний тал хэсэг олдсон байна.

Энэ хоёр хөргийг сүмийн дотор байрлуулсан байсныг хэмх цохин эвдэж толгойг нь булсан байжээ. Тахилын сүмийн ханыг улаан тоосгоор ташуу өрж хийсэн байжээ. Барилгын баруунтай, голдоо нэвт нүхтэй, цул боржинг засч хийсэн тахилын дөрвөлжин чулуу байсныг хожим хажуу талаас нь цуулан авч бичээст хөшөөний ивүүр болгон тавьсан байна. Хэрмийн хаалганы гадна талд хиймэл усан сан байжээ. Бичээст хөшөөнөөс наран ургах зүг чиглүүлэн 3 км орчим зайд цувуулж тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ байсан нь хадгалагджээ.

Наймдугаар зууны Түрэг улсын төрийн нэгэн гарамгай зүтгэлтэнд зориулан босгосон энэхүү нүсэр байгууламж нь түрэгийн тахилын онгоны зохион байгуулалтын сод жишээ болох бөгөөд Монголын төв нутгаас олдсон хаад язгууртны бусад том онгонууд ч мөн л энэ зарчмаар бүтээгдсэн байна. Малтлагаас мухар тэгш иртэй төмөр зэв, суран бүсний үзүүрийн хэл, нимгэн алтаар бүрсэн олом, хүрэл чимэг олсон байна.

Зүүн түрэгийн II хаант улсын нэрт хаадын нэг Могилян буюу Билгэ хаанд зориулан босгосон тахил шүтээний цогцолбор Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамд Культегины дурсгалаас урагш 1 км-ийн зайд оршдог. Билгэ хааныг 734 онд нас барахад энэхүү онгоныг барьсан бөгөөд хожим уйгарчууд маш ихээр эвдлэн сүйтгэжээ. Одоогийн байгаа байдлаараа 95х60 м хэмжээтэй далангийн ортой, түүний дотор талд сувгийн ором, дунд хэсэгт нь гонзгой уртавтар төвгөр довцог мэдэгддэг. Энэхүү мэдэгдэх төдий далан нь бунханы хэрмийн үлдэгдэл бололтой. Зүүн талд нь цагаан өнгийн чулуугаар хийсэн яст мэлхийн нуруу хэсэг газрын хөрснөөс цухуйж харагдах ба түүний дэргэд 3 хэсэг болон хугарсан бичигт хөшөө байдаг. Энэхүү хөшөөний өндөр нь 345 см, өргөн нь 174 см, зузаан нь 75 см юм. Түрэгийн их хаадын хөшөө дурсгалд нэгэнт тогтсон уламжлал ёсоор оройг нь эвхэрсэн лууны дүрсээр чимж нэг талд нь руни, нөгөө талд нь нанхиад бичээс сийлжээ.

Хөшөөний эргэн тойронд толгой гар зэрэг нь эвдэрч хугарсан хэд хэдэн хүн чулуу байдаг бөгөөд эдэн дотроос цагаан гантигаар завилан суугаа байдалтай урласан эрэгтэй эмэгтэй хоёр хүний дүрс ур хийцийн хувьд бусдаасаа ялгардаг. Эдгээрийг Билгэ хаан, түүний хатан хоёрыг дүрсэлсэн хөшөө гэж үздэг билээ.

Төв хэсэгт нь хөх гантигаар урласан, зүүн ташаандаа урт илд зүүсэн хүнийг зогсоо байдалтайгаар дүрсэлсэн толгойгүй хөшөө байдаг. Цогцолбороос зүүн зүг 3 км орчим зэл чулуу тавьсан байна.

Хөшөө Цайдам дахь Түрэгийн язгууртны тахил тайлгын дурсгал нь зөвхөн энэ хоёр том онгоноор хязгаарлагдахгүй бөгөөд хэмжээгээрээ эдгээрээс бага, нэр тодорхойгүй өөр хоёр дурсгал байдгийг ч судлаачид удаа дараа тэмдэглэсээр иржээ.

Дэлхийн түрэг судлаачдын дунд ихэд нэр алдаршсан Хөшөө Цайдамын эдгээр дурсгалыг XIX зууны сүүл үеэс анх илрүүлэн судлаж, тэр цагаас хойш олон орны эрдэмтэд шинжилсээр ирсэн ба тэнд буй руни бичигт гэрэлт хөшөөдийн бичээсийг тайлан уншихад голлон анхаарч байжээ. Эндхийн хөшөө чулууд нь он удаан жил байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр өгөршин муудаж, бас дээр нь хүний болчимгүй үйл ажиллагаанд өртөн улам бүр элэгдэж муудсаар байсан билээ. Дэлхийн олон оронд нэрд гарсан эдгээр дурсгалыг бүрэн судлаж, авран хамгаалах талаар 1997 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн Монгол, Туркийн хамтарсан төсөл их зүйлийг гүйцэтгэж байна. Энэхүү төслийн хүрээнд, нэр дурдсан дурсгалуудыг бүрэн хэмжээгээр малтан судлах, уг онгонуудын анхны хэлбэр дүрсийг сэргээн тогтоох, ил задгай оршиж, өгөршин муудсаар буй чулуун хөшөө дурсгалыг бэхжүүлэн сэргээж музейн байранд хадгалах ба уг газарт нь яг адилхан дууриамал дүрсийг хийж тавих ажлыг төлөвлөж байгаа билээ. Энэ ажлын анхны том амжилт бол гурван хэсэг хугаараад газарт хэвтэж байсан Билгэ хааны бичигт хөшөөг эвлүүлэн нааж, шинэ сууринд суулгаж залсан явдал болно. Төсөл бүрэн хэрэгжсэнээр Билгэ хаан, Культегин, Тоньюкукийн тахилын онгоныг бүхэлд нь сэргээн засч бэхжүүлэн, музей байгуулж, эх орны түүхийг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чухал түүхэн дурсгалт газар болгон ашиглах юм. Энэ нь манай оронд том хэмжээний түүхэн дурсгалыг судлахын зэрэгцээ авран хамгаалж, сэргээн бэхжүүлэх талаар хийж буй анхны том ажил болно.

§ 2. БИЧИГ ҮСГИЙН ДУРСГАЛ

Түрэгийн соёлын хамгийн гайхамшигт ололт бол Орхон-Енисейн бичиг хэмээн алдаршсан 38 үсэг бүхий авианы бичгийг зохион хэрэглэж, төр улсынхаа түүхийг тэмдэглэн бичиж үлдээсэн явдал билээ. Түрэгүүд хэдийгээр Нангиад мэт эртний өндөр хөгжилт улс оронтой хөрш зэргэлдээ нутаглаж соёлын ололт амжилтаас нь багагүй зүйл авч хэрэглэсэн боловч хятдын дүрс үсгийг авсангүй, харин нүүдэлчдийн ахуй орчин, хэл соёлын өвөрмөц онцлогт яв цав нийцэж оюуны хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангахуйц өөрийн бичиг үсгийг зохиож хэрэглэж байжээ.

Түрэгийн руни бичиг хаанаас гаралтай болох талаар эрдэмтдийн дунд нэгдмэл санал одоо хир үгүй юм. Ихэнх эрдэмтэд үүнийг эртний арамей бичгээс үүсэлтэй, түүний хамгийн зүүн захын нэгэн салбар гэдэг. Гэтэл үүний зэрэгцээ, руни бичиг нь Төв Азийн нүүдэлчдийн дунд эртнээс уламжилж ирсэн овог аймгийн тамга тэмдэг, мод хэрчиж хэрэг тэмдэглэх арга зэргээс уламжлан үүссэн гэж үзэх нь бас бий. Үүнээс үзэхэд “орхон-енисейн бичиг” нь зөвхөн гаднаас бэлнээр хуулбарлаж авсан бус, харин орон нутгийн хуучин уламжлалд тулгуурлан гарч ирсэн нь тодорхой ажээ. Энэхүү бичиг үүссэн цаг хугацаа болон орон нутгийн асуудал одоо хир эрдэмтдийн анхаарлыг татсаар байна.

Нэлээд хожуу үеийг хүртэл Долоон мөрөн, Енисей орчмын нутаг дахь руни бичгийн дурсгалыг хамгийн эртнийх гэж үзэж байсан бол сүүл үеэс манай улсын Дорноговь аймгийн нутаг Чойроос олдсон нэгэн хүн чулууны гэдсэн дээр бичсэн бичгийг хамгийн эртнийхэд тооцох болжээ. Судлаачдын уншиж тогтоосноор энэхүү дурсгал 688-691 оны үед холбогдох юм. Үүнээс үндэслэн Түрэгийн руни бичиг нь Төв Азид, тэр дундаа Монгол нутагт анх үүссэн хэмээх үзэл баримтлал бий болжээ. Олдож буй дурсгалуудын байршил ч үүнийг нотолдог. Энэхүү бичиг нь VII зууны хоёрдугаар хагаст үүсч улмаар XII зууныг хүртэл хэрэглэгдэж байсан бөгөөд аль нэгэн тодорхой нутаг орны чанартай үзэгдэл биш харин нийт түрэг овогтны тархан нутагласан бүх газар нутагт түгэн дэлгэрсэн байжээ.

Руни бичгийг анх 1893 онд Данийн эрдэмтэн Вильхельм Людвиг Петер Томсен тайлан уншсан байна. Мөн үүний зэрэгцээ Монголд ажилласан Орхоны шинжилгээний ангийн ахлагч, академич В.В.Радлов бас биечлэн оролдоод тайлан уншиж чадсан бөгөөд

Билгэ хаан, Культегин нарын хөшөөний бичээсийг 1894 онд хөрвүүлэн тусгай дэвтэр болгож хэвлүүлжээ. Түүнээс хойш олон орны түрэг судлаач эрдэмтэд Түрэгийн эртний бичиг үсгийн дурсгалуудыг тайлан уншсаар ирэв.

Одоо Монгол нутагт Орхон-Енисейн бичээсээр бичсэн их бага хэмжээний 50 гаруй бичээс илрэн олдож бүртгэгдээд байгаа бөгөөд жил ирэх тутам шинээр нэмэн олдсоор байна. Эдгээрийн дунд дээр нэр дурдсан алдарт хоёр хөшөөний бичээснээс гадна Тоньюкукын хөшөө, Онгийн голын хөшөө, Их хөшөөт буюу Кули Чурын хөшөө зэрэг нэр бүхий хаад ноёдын дурсгалд зориулан тусгайлж босгосон хөшөө чулууны бичээсүүд бий. Түрэгийн руни бичгийн дурсгал нь тусгайлж зассан пайлуур гэрэлт хөшөөнөөс гадна байгалийн ердийн хад чулуун дээр, барилгын хананы шааваас дээр, дээврийн ваар дээр, зоос мөнгөн дээр, судар номын баринтагийн тээг чулуун дээр бичсэн зэрэг олон хэлбэрээр олдож байна. Орхоны их бичээсүүдэд тухайн хүний намтрыг, Түрэг улсын төрийн түүх, гадаад харилцаа, цэрэг дайны үйл явдалтай холбон бичсэн байдаг тул эдгээр нь зөвхөн хэн нэгэн хүний намтар төдий бус, Түрэг улс мандан хөгжсөний түүх юм. Түүнчлэн Түрэгийн харьяанд байсан, эсвэл холбоо харилцаатай байсан овог аймаг, аймгийн нэгдэл холбоодын тухай, шашин шүтлэг, угсаатны гарвал, зан заншил, аж ахуй соёл, хэл, уран зохиолын зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарсан байдаг. Руни бичгийн дурсгал нь өөрсдийн оюун сэтгэлгээ, ур ухаанаар төр улсынхаа түүхийг тэмдэглэн бичиж үлдээсэн биет баримт болохын хувьд эрдэм шинжилгээний онцгой ач

холбогдолтой түүхэн сурвалж төдийгүй Алтайн хэлний хөгжлийг судлах, монгол түрэг хэлний харьцуулсан судалгаа хийхэд чухал хэрэглэгдэхүүн болохоос гадна эртний нүүдэлчдийн яруу найраг, уран зохиолын үнэт өвийн тоонд зүй ёсоор ордог юм.

Куль Тегиний хөшөөнд “Тэнгэрээс ивээлт, Тэнгэрлэг түрэг Билгэ хаан үг ману. Дээр хөх тэнгэр, доор бараан дэлхий үүдсэний завсарт хүний хөвүүд буй болсон ажгуу. Эстеми хаан хэмээн алдаршсан миний дээд өвөг Буман хаан хүний хөвүүдийг эзлэн сууж, Эл улсаа тэтгэн засаг төрийг бататгав. Дөрвөн зовхисын улс дайсагнан халдсанд цэргийг удирдан хөдөлгөж дөрвөн зовхисын олон аймгийг хүчнээр дагуулан номхотгохоор толгойтныг бөхийлгөн тойгтныг сөлтгөв” гэх мэтчилэн Түрэг улсын мандан бадарсан түүхийг яруу сайхнаар өгүүлжээ. Тэгээд цааш нь Хятадын эрхшээлд орж хэрхэн зовж зүдэрч явсан, эрхшээлээс гарахын тулд нойр хоолоо хасч баатарлан тэмцэж явсан болон хөрш зэргэлдээ олон улс Түрэгтэй харьцаж байсан зэргийн түүхэн үйл явдлуудыг дэс дараатай илэрхийлжээ. Эдгээр хөшөөний бичээст зүйр цэцэн үгийг арвин ашиглаж, хэлэх зүйлээ улам яруу тод болгон дүрсэлж байсан нь тухайн үеийн нүүдэлчдийн аман зохиолын өв уламжлалыг бүрэн дүүрэн харуулдаг байна.

§ 3. ХҮН ЧУЛУУ

Түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ төвшинг илтгэн харуулдаг байна.

Монгол нутагт эдүгээ нийт 500 гаруй хүн чулуу илрүүлэн олж бүртгээд байгаагийн 400 гаруй нь түрэгийн үед холбогдох ба цаашид ч шинээр нэмэн олдох боломжтой юм. Ийм төрлийн дурсгалыг манай оронтой хил залгаа орших Алтай, Тува болон Дундад Азийн нутгаас Орос, Зөвлөлтийн эрдэмтэд их хэмжээтэй илрүүлэн олж сайтар судлан тодорхойлж эрдэм шинжилгээний томхон бүтээлүүд олныг нийтлүүлсэн нь манай нутгийн хүн чулууны судлалд ч нарийн нягт холбогддог.

Хүн чулуу хэмээх нь боржин, гантиг, хүрмэн чулуу, элсэн чулуу занар зэрэг чулуугаар хүний дүрс оруулан хийж тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан босгодог хөшөө юм.

Түрэгийн хүн чулууг чухам хэнд зориулан босгож байсан талаар судлаачдын дунд эсрэг тэсрэг үзэл бодол оршоор иржээ. Нэг хэсэг судлаачид эдгээр хөшөө нь нас барсан баатар эрийн хамгийн хүчит дайсан этгээдийг дүрслэн үзүүлсэн дурсгал гэж үздэг бол нөгөө зарим нь нас барсан баатрыг өөрийг нь дүрслэн түүнд зориулж босгосон хөшөө гэж үздэг байна. Түрэгийн тахилын онгонууд нь хүн дүрстэй чулуун хөшөө, түүний өмнөөс зүүн урагш чиглүүлэн цувуулан зоосон балбал буюу зэл чулуу хэмээх хоёр үндсэн хэсгээс бүрэлддэгээс үүдэн эдгээрийг хооронд нь хольж хутгах явдал гарч ийн зөрүүтэй үзэл бодол үүсэхэд нөлөөлжээ. Гэвч одоо дийлэнх судлаач, хүн чулуун хөшөө нь нас барсан баатар дайчныг дүрслэх ба цувуулж тавьсан зэл чулуу (балбал) нь түүний алж устгасан дайсан этгээдийг буюу оршуулга тайлгын ёслолд оролцсон хүмүүсийг төлөөлүүлдэг гэсэн саналыг баримтлах болжээ.

Ихэнх тохиолдолд тахил тайлгын нэгэн онгоны бүрэлдэхүүнд буюу чулуун хашлагын дэргэд нэг л хүн чулуу тавьсан байдаг. Эдгээр нь босоо зогссон буюу завилан суусан дүрстэй, гартаа сав суулга барьж, зүүн гараар бүснээс зүүсэн сэлэм буюу хутганы бариулаас атгасан байх ба ихэнх хүн чулуунд хөл дүрслээгүй байна. Алдар цуутай хаад ноёдын онгоны нүсэр цогцолборын бүрэлдэхүүнд олон хүн чулуу тавьсан байдаг. Тухайлбал, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Өнгөтийн хөшөө хэмээх тахилын том онгоны бүрэлдэхүүнд 28, Куль Тегин ноёны онгонд 10, Шивээт Улааны онгонд 9, Их хөшөөтөд 6, Тоньюкукийн болон Билгэ хааны онгон, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг дахь Онгийн голын дурсгал зэрэгт 5 хүн чулуу мэдэгдэж байна. Анх эдгээр дурсгалыг цогцлон байгуулах үед чухам хэдэн хүн чулуу тавьсан нь тодорхойгүй, гагцхүү одоо байрандаа үлдэж хоцроод байгаа нь ийм тоотой ажээ. Ийнхүү олон хүн чулуу нэг дор байгаа тохиолдолд тэдгээрийн хийц дүрслэл өөр өөр байдаг нь уг хүмүүсийн угсаа гарал, зэрэг дэвийн ялгаанаас шалтгаалсан байна. Тухайлбал, онгоны эзэн язгууртан ноёны хөрөг дүрсийг завилан суусан байдлаар, онгоны байгууламжийн хоймор хэсэгт байрлуулах ба зарим онцлог тохиолдолд хатных нь хөргийг мөн зэрэгцүүлэн тавьсан байх нь бий. Үүнд, Билгэ хаан болоод Куль Тегиний онгоны аль алинд тэдгээрийг хатных нь хамт урлан хийж дүрсэлсэн байх ажээ. Түүнчлэн эдгээр ихэс дээдэст үйлчлэх шадар дагалт, зарц зэрэг хүмүүсийн дүрсийг уг байгууламжийн үүдэн талд босоо зогссон буюу сөхрөн суусан байдлаар урлан хийж тавьдаг байжээ.

Эртний Нангиадын түүх сударт түрэгүүдийг зөв энгэртэй дээл өмсдөг мэтээр тэмдэглэсэн байх боловч хүн чулууны хэрэглэгдэхүүнээс үзэхэд буруу, зөв энгэртэй аль аль нь тохиолддог. Тэгэхдээ түрэг хувцасны хэв маяг жигд, хоёр тийш эргүүлсэн өргөн захтай дээл байх ба тал дүгрэг буюу дөрвөлжин товруутай, олон унжлага бүхий агсарга бүс бүсэлсэн байна. Бүснээс шулуун урт илд, махир чинжаал хутга, дүгрэг хэлбэртэй хавтага сав зэргийг унжуулдаг байжээ. Хүн чулуунд дүрсэлсэн эд өлгийн эдгээр зүйлс нь мөн үеийн булшны малтлагаас биет байдлаараа олдож байсан нь цөөнгүй бөгөөд тэдгээр дурсгалын он цаг хийгээд хэрэгцээ зориулалтыг тодорхойлох найдвартай баримт нотолгоо болдог байна.

Хүн чулууд нь түүхийн урт удаан хугацааг туулж өнөө бидний үед уламжлан ирэхдээ толгой нь хугарч алга болох, энд тэндээсээ хагарч хэлтрэх, байгалийн хүчин зүйлээс элэгдэж мөлийх зэрэг янз бүрээр гэмтэж муудсан байдаг. Гэмтэл эвдрэлийн шалтгааныг судлаачид тайлбарлахдаа, Түрэгийн дараа Төв Азийн түүхэнд тодрон гарсан уйгарууд эвдэж гэмтээх зэрэг олон шалтгаан байсан гэж үздэг.

Толгой нь бүтэн үлдсэн хүн чулуудыг ажиглахад ихэвчлэн монголжуу өргөн шанаатай, жартгар нүдтэй, нэлээд тохиолдолд махирлаж эргүүлсэн живэр сахалтай байх ажээ. Толгойн үсээ урт ургуулж олон салаа гээг, эсвэл ганц бүдүүн гээг унжуулах зэрэг байдлаар засч янзалдэг байсан нь түүх сударт тэмдэглэн бичсэнтэй үндсэндээ тохирох ажээ. Түүнчлэн зарим үед огт гээг байхгүй, үсээ хуссан мэт тохиолдол ч байдаг. Гээг үсээ ийнхүү янз бүрээр засч янзлах, мөн буруу болон зөв энгэртэй дээл зэрэгцэн байх зэрэг нь Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд өөр өөр заншилтай олон овог аймаг багтаж байсныг харуулж байх бололтой. Энэ бүхнээс үзэхэд түрэгийн хүн чулуу нь тухайн үеийн угсаатны зан заншил, дээл хувцас, эдлэл хэрэглэлийн онцлог, Түрэгийн бүрэлдэхүүнд байсан олон овог аймгийн угсаатны бүрэлдэхүүнийг тодруулан гаргахад нэн ач холбогдолтой дурсгал болох ажээ.

§ 4. ХОТ СУУРИН, УРАН БАРИЛГА

Түрэгийн үеийн хот суурины дурсгал хэмээн тодорхой нэрлэх дурсгалт зүйлсийг илрүүлэн судалсан нь үгүй боловч тэр үеийн орон барилга, архитектурын хэв маягийг бүрэн харуулж чадах хэрэм далан, тахилын сүм, хөшөө дурсгалын үлдэц манай үед уламжлагдан ирснийг археологич эрдэмтэд нэлээд хэмжээгээр судлан шинжилсэн байна. Тухайлбал, Куль Тегин ноёны хөшөө чулуунд сийлсэн бичгийн үгэнд, “Миний эцэг хаан агсанд хорин долоон эрийн хамт мордлуга. Түүний захад явсныг хотон дахь хүмүүс сонсоод хотоос угтан гарч, уулан дахь хүмүүс уулнаас угтан бууж бүгд нийлэн далан эр болов” хэмээн өгүүлсэн байдаг.

Тэр үеийн нэртэй их хаад, цэргийн алдар цуут жанжингуудын дурсгалд зориулсан онгон тайлгын иж бүрэн цогцолбор байгууламжуудыг малтан судалсан байдлаас үзэхэд барилгын багана нурууг элдэв амьтны дүрс бүхий чимэглэлээр гоёж үүдний хоёр хатавчинд том чулуун хонь зэргийг тавьдаг байжээ. Байшин барилгын хана туургыг өнгийн будгаар будаж угалз хээ тавьдаг байв. Барилгыг нутгийн ба олзны хүмүүс барьдаг байсан бөгөөд тэр үед барилгачин, чулуучин, модчин гэх мэт нарийн мэргэжлийн хүмүүс байсныг Билгэ хаан, Куль Тегин нарын хөшөөний бичигт нэр зааж дурдсан байдаг. Туул голын хөндийд орших Өнгөтийн хөшөө хэмээх том хэмжээний тахилын онгоныг малтан судлах явцад барилгын хэрэглэгдэхүүн, тоосго, дээврийн тосгуур, нөмрөг, нүүр ваар, чулуугаар цоолборлон урлаж хийсэн хонь ба арслангийн дүрс, хүн чулуу зэргээс гадна тухайн үеийн үйлдвэрлэлийн төвшинг харуулах чухал олдвор болох, морин цэргийн довтолгоог зогсоох зорилгоор газарт тараан хаяж хамгаалдаг, дөрвөн үзүүрт төмөр өргөс бүхий сөргө хэмээх зэвсэг олноор олдсон юм. Энэ нь бэхэлсэн суурин газрын эргэн тойрон тараан хаяж, довтлон бүслэх дайснаас хамгаалах тусгай зориулалтын зэвсэг болохын хувьд ихээхэн сонирхолтой юм.

Түрэгийн уран барилгын жишээ болгож Куль Тегин нарын онгоны байгууламжийн барилгын хэрэглэгдэхүүн ямар байсныг авч үзье. Эндээс тухайн үеийн орон барилгыг чимэглэж байсан янз бүрийн чимэглэл, барилгыг бүтээн цогцлуулах бие ангийн хэсгүүд олноор олдсон байна.

1. Тоосго. Куль Тегин нарын тахилын сүмийн барилгаас хоёр үндсэн хэлбэрийн тоосго гарчээ. Үүнд, 33х33х6 см хэмжээтэй тэг дөрвөлжин тоосгоор тахилын сүмийн шал хийх буюу хэрмийн доторхи талбайд дэвсэж хэрэглэдэг байжээ. Гонзгой дөрвөлжин тоосго нь 33х15х6 см хэмжээтэй, үүгээр барилгын хана өрж байжээ. Тоосгууд нь хүний гарын алганы ором буюу хосоор нь дөрвөлжлүүлэн дарсан данз нэхмэлийн дардастай байжээ.

2. Дээврийн ваар. Дээврийн ваар нь эрт үеийн барилгын гол хэрэглэгдэхүүн болох бөгөөд үүрэг хэрэгцээнээсээ шалтгаалан хэдэн янз байдаг. Үүнд:

а. Тосгуур ваар. Энэ нь гонзгой өргөн, дэлбэн хэлбэртэй. Үүнийг дээврийн дээр задгай талаар нь дээш харуулан бүрхэж тавьдаг. Ийм ваарны урт 37 см, өргөн тал нь 29 см, нарийн тал нь 23 см, зузаан нь 2 см байна.

б. Нөмрөг ваар. Энэ нь гонзгой урт шулуун, тал дүгрэг цөмбөн хэлбэртэй байх ба үүнийг дээврийн тосгуур ваарны уулзвар дээр хөмрөн тавьж хооронд нь залган бэхэлдэг. Үүний хэмжээ 31х14 см, зузаан нь мөн 2 см орчим байна.

в. Нүүр ваар. Үүнийг барилгын дэврийн зах ирмэгт чимэг болгон тавьдаг, өөрөөр хэлбэл нөмрөг ваарны төгсгөл хэсэг юм. Ерөнхий хэлбэрээр нөмрөг ваартай ижил боловч нэг үзүүрт нь дүгрэг нүүр нааж түүнийгээ цэцэг болон зээбад хэмээх хүн амьтны нүүрийн дүрст хээгээр чимдэг. Энэ нь дээврийн зах ирмэгийн гол чимэг болдог.

3. Усны татуул хоолой. Куль Тегин нарын барилгаас гарсан онц сонирхолтой нэг олдвор бол хэрмийн дотор тогтсон бороо хурын усыг гадагш урсган, тойрон хүрээлсэн шуудуунд оруулахад зориулсан татуул хоолой юм. Энэ нь гонзгой бортого хэлбэртэй, уртаараа 31 см, голчоороо 8 см, зузаан нь 1-1,5 см байжээ. Эдгээрийг хооронд нь залган тусгай шаваасаар бэхэлж уртасгаад хэрмийн

хоёр хатавчинд шалан дор тавьж усыг гадагш урсгадаг байжээ. Үүнээс арай болхи хийцтэй усны хоолой Тоньюкукийн онгоноос олдож байжээ.

Эндхийн барилгын чимэглэл дотроос судлаачдын сонирхол татаж буй бас нэг зүйл бол үлгэр домгийн гаж амьтны дүрс бүхий шавар чимэглэл болно. Ийм чимэглэлийн хэсэг нийт 6 олдсон бөгөөд бөлтгөр том нүдтэй, сартгар хамартай, ангайсан аман дотроос нь дөрвөн соёо цухуйсан, завьжнаас унжсан урт сахал, гурвалжин оочтой, үс нь сэрвийн боссон, хэт догшин сүрлэг дүртэй амьтны дүрс байжээ. Үүнийг барилын үүд хаалга, баганын чимэг гэж судлаачид үзжээ.

Түрэгийн үеийн уран барилгын гол дурсгал болох тахилын онгоны барилгын хэрэглэгдэхүүн, гоёл чимэглэл, бүтэц зохион байгуулалт сэлтээс үзэхэд хятад мэт суурин соёлт орны болон нүүдэлчдийн өөрсдийн ахуй байдлаас үүдэлтэй соёлын дэвшилт зүйлс холилдон сүлэлдэж өөрийн гэсэн өвөрмөц шинж төрхийг олсон нь харагддаг.

§ 5. БУЛШ ОРШУУЛГА

Түрэгийн булшлан оршуулах зан үйл, тахил тайлгын ёсны талаар хятад сурвалжид тэмдэглэн бичсэн нь багагүй бий. Гэхдээ эдгээр тэмдэглэлд, нас барагсдыг булшилж оршуулах болон тэднийг тахиж тайх зан үйлийн зүйлсийг хооронд нь хольж хутган өгүүлсэн зүйл байдаг нь хожмын судлаачдын дунд ч энэ талаар үл ойлгон төөрөлдөх зүйл гарахад нөлөөлжээ. Гэхдээ судалгааны өнөөгийн төвшинд, түрэгийн булш болон тахилын онгоны учир утга, хэлбэр төрхийг хооронд нь ялган зааглаж тодруулсан байна.

Түрэгийн түрүү хаант улсын байлдан дагууллын үр дүнд Хар тэнгисээс Хятадын түмэн газрын цагаан хэрэм хүртлэх өргөн уудам нутагт нэгэн ижил зан үйлийн дагуу оршуулсан булш оршуулга өргөн хэмжээтэй тархжээ. Эдгээрийн хамгийн онцлог шинж нь, нас барсан хүнийг чулуун дараастай булшинд нүх ухаж булшлан оршуулаад талийгаачийг дагалдуулан хүлэг морь, зэр зэвсэг, эд хэрэглэлийн зүйлсийг хамт хойлоглодог ёсон бөлгөө. Түүхэн сурвалжид тэмдэглэснээр түрэгүүд эхэн үедээ нас барагсдынхаа бие цогцыг эд юмс, хүлэг мориных нь хамт шатааж чандарлан оршуулдаг байжээ. Ийнхүү чандарлаж оршуулсны хамгийн сүүлийнх нь 634 оны үед холбогдох ба үүнээс хойш булшлан оршуулах ёсонд шилжсэн гэдэг.

Манай оронд түрэгийн үеийн булшийг Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Туул голын сав дагуух Хайрхан, Их алаг уул, Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хутаг уул, Хайрхан сумын нутаг Наймаа толгой, Өвөрхангай аймгийн Шанх сумын нутаг Жаргалант, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Дэнсэлгийн ам, Сонгины Баруун Хайрхан уул, Хэнтий аймгийн Хэнтий сумын нутаг Төгсгийн өвдөг зэрэг газруудад малтан шинжилжээ. Эдгээрээс заримыг тодорхойлон бичвэл:

1. Хайрханы булш. Улаанбаатараас доош 140 орчим км-т Туул голын урд биед, Хайрхан уулын зүүн сугад байсан энэхүү булшийг 1925 онд Зөвлөлтийн судлаач Г.И.Боровка малтан шинжилжээ. Уг булш голчоороо 8 м, өндрөөрөө 40 см чулуун дараастай бөгөөд голд нь эрт цагт тонож малтсаны тэмдэг болох хонхортой байжээ. Энд 2,6х2 м нүхэнд хоёр морь, нэг хүний яс байжээ. Нэг морины толгойг тавцан засч тавиад нөгөө морины толгойн дор чулуу дэрлүүлсэн ба дэргэд нь төмөр амгай, төмөр дөрөө, чөдрийн ясан чагт, эмээлийн мод, оломны төмөр арал олдсон байна. Хүний ясны дэргэд дөрвөн ширхэг гурвалжин хүрэл чимэг, хүрэл толины хагархай, гурван ясан булцуу, төмөр хутганы үлдэгдэл, үйсэн хоромсогны хэсэг олдсоноос гадна цэцгэн ба луун хээтэй торгоны тасархай гарчээ.

2. Хутаг уулын булш. Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Орхоны Хөшөө Цайдамаас хойш 7 км зайтай Хутаг ууланд гурван булш малтсны нэгийг тодорхойлон бичье. Уг булш Хутаг уулын гол шовхын өмнө орших ба 6,5х5,5 м хэмжээтэй дөрвөлжиндүү хэлбэртэй, мөн л эрт цагт тоногдсон байжээ. Энэ булшинд хоёр адууг зүүн хойд зүг хандуулан хүний толгойн эсрэг чиглэлтэй тавьсан байжээ. Талийгаачийг дагалдуулан бүсний чимэг, хэдэн хүрэл товруу, төмөр хутга, арьсан эдлэлийн хэсэг, үйсэн хоромсого, сувдан зүүлттэй, нарийн унжлагатай өрөөсөн алтан ээмэг, түүнчилэн адуу малын хэрэглэлээс дэгрээ хэлбэрийн зуузайтай амгай, эмээлийн төмөр олом, мушгимал сэнжтэй төмөр дөрөө, чөдрийн ясан чагт зэрэг зүйл тавьсан байжээ. Эндхийн олдворууд нь Архангай, Өвөрхангай болон Тува, Енисей, Алтай, Казахстаны нутагт малтан шинжилсэн мөн үеийн булшнаас олдож байжээ.

3. Баруун Хайрхан уулын булш. 1993 онд Монгол, Солонгосын хамтарсан экспедици Сонгины Баруун Хайрхан ууланд хоёр булш малтсаны нэг нь тоногдоогүй байжээ. Уг булш 300 х 250 см хэмжээтэй чулуун дараастай байсан бөгөөд 40 см гүнд булшны нүх илэрч 70 см гүнд оршуулга гарчээ. Энд толгойг нь баруун тийш хандуулж тавьсан хүний бүтэн араг яс гарсан нь хөлийг жийлгэн, баруун гарыг аарцаг дээр нь тавьж, зүүн гарыг бие дагуулан тэнэгэр байдлаар оршуулсан байжээ. Толгойн баруун талд 10 см урт шилбэтэй хавтгай төмөр зэв, зүүн гарын сарвуу орчимд дуут ясан зэв, ясан чагт, төмөр цагираг зэрэг зүйлс, хавирганы дотор талд нимгэн төмөр хутга олджээ. Эндээс гарсан эд өлгийн зүйлс нь V-XII зууны үе буюу цаг хугацааны хувьд нэлээд өргөн хүрээнд хамрагдах боловч уг булшны органик гаралтай олдворт хийсэн радиокарбон шинжилгээгээр одоогоос 1360±70 жилийн өмнө буюу манай эриний 590 оны үед холбогдно гэсэн дүн гарчээ. Энэ нь цаг хугацааны хувьд Түрэгийн эхэн үед холбогдох ба харин оршуулгын ёс заншлын хувьд жинхэнэ түрэг булшнаас ялгаатай, чухам ямар овог аймгийн дурсгал болох нь тодорхойгүй байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

- Базилхан Б. Күл-тегины хөшөөний бичээсийн монгол орчуулга // Хэл зохиол. ХҮИ боть. УБ., 1987
- Баяр Д. Өвөрхангай аймгийн нутагт буй Түрэгийн үеийн хүн хөшөөний тухай // SA. t. XIII. F.4. УБ., 1992.
- Баяр Д. Монголын Төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. УБ., 1997.
- Баяр Д., Эрдэнэбаатар Д. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. УБ., 1999.
- Баттулга Ц. Дэл уулын Баруун билүүний II, III бичээс // SA. t. ХҮИ. f. УБ., 1998, тал 109-115.
- Болд Л. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс (Түрэг бичээсийн дурсгал). УБ., 1990.
- Болд Л. Орхон бичгийн дурсгал. УБ., 2000.
- Войтов В.Е. Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв. М., 1996
- Доржсүрэн Ц. Шивээт улаан гэж юу вэ? ШУТ. 1957. 11.
- Евтюхова Л.А. Каменные изваяния Южной Сибири и Монголии // МИА. 1 24. М., 1952, с. 72-120.
- Радлов В.В. Атлас древностей Монголии.- Вып. 1, 1892; Вып. 2, 1893; Вып. 3, 1896; Вып. 4, 1899.
- Сэр-Оджав Н. Культегиний булшнаас олдсон хүн чулууны толгой // SA. t.I. f. УБ. 1959.
- Сэр-Оджав Н. Эртний Түрэгүүд // SA. t. Y. f. 2. УБ. 1970.
- Харжубай С. Шивээт улааны цогцолбор дурсгал // SH. УБ. 1979, тал 15-22.
- Харжаубай С., Очир А. Тэсийн гэрэлт хөшөөний тухай // ШУА. 1977. 13. тал 75.
- Худяков Ю.С. Древнетюркские поминальные памятники на территории Монголии // ДКМ. Новосибирск, 1985, с. 181-189.
- Цэвээндорж Д. Новые Надписи орхон-енисейской письменности из Тумур цорго // SH. 1984, тал 124-126.
- Шинэхүү М. Тариатын орхон бичгийн шинэ дурсгал // SA. t. YII. f. I. УБ.1975.
- Шинэхүү М. Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал. УБ.1980.
- Sohn Pokke, Choe Pok-Kyu, Han Chang-gyun. Radiocarbon dating Results in Eastern Mongolia // Corea-Mongol Joint Studies-5. 1997. Seoul.

УЙГУРЫН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний ор суурийг Уйгур улс эзэлж VIII-IX зууны үед Монгол нутагт ноёрхлоо тогтоожээ. Уйгур нь мөн алтайн хэлний бүлэгт багтах түрэг угсаатан байв. Хятадын түүхэнд уйгурын өвөг дээдсийг МЭӨ III зууны үеэс Дин-Лин гэж нэрлэж байсан ба МЭ IY зууны үеэс дили, тэлэ гэж нэрлэх болсон байна. Тэд өндөр дугуйтай тэрэг хэрэглэх учир гаогюй (өндөр дугуйтан) ч гэдэг байв. Y зууны үеэс тэднийг Хуйхэ, Ойхор, Уйгур гэх нэрээр түүхэнд тэмдэглэх болжээ. Тэд эрт үеэс Хүннү, Сянби, Тоба, Жужан, Түрэг нартай айлсан оршиж тэдэнтэй байлдаж найрамдан, эрхшээлд нь орох зэргээр тусгаар улс болохын төлөө тэмцсээр ирсэн байна. YII зууны эцэс, YIII зууны эхээр аймгийн зонхилгч, тэргүүлэгчдийн эрх нь үе залгамжлан дамжих болжээ. YIII зууны дөчөөд оныг хүртэл уйгурууд Түрэгийн хаант улсын мэдэлд байсан ба зонхилгч нь Пэйло байв. 744 онд Пэйло биеэ Куль Билгэ хэмээх цолтой хаан болгон өргөмжилж бослогыг удирдан түрэгүүдтэй тэмцжээ. Ингээд 745 онд уйгурууд Түрэгийн хаант улсыг бүрмөсөн бут цохин мөхөөсөн байна. Ийнхүү Уйгур улс байгуулагдав. Уйгурын овог аймгийн сурвалжтан нар цол, эрх ямбаа хэвээр үлдээж овог аймгаа толгойлж байсан ч хараат орныг ноёрхох хагас феодал маягийн язгууртан болж байжээ. Пэйлог нас барахад түүний хүү Моюнчур буюу Баянчур (747-759) хаан ширээнд сууж “тэнгэрээс заяат төр засагч мэдэлтэй хаан” хэмээн алдаршсан ба тэр үед Уйгур улс хүчирхэгийн туйлд хүрэв. Моюнчур, эцгийн бодлогыг үргэлжлүүлэн умар зүгт Киргиз, дорно зүгт Киданы эсрэг аян дайн хийв. Үүний үр дүнд газар нутгаа тэлж YIII зууны үед Алтайн уулсаас Хянган, говиос Саяны уулын хоорондох нутгийг эзлэх болжээ. Бусад улс оронтой эдийн засаг, соёлын харилцаа өрнүүлж хот суурин барьж байв. 751 онд Орхоны хөндийд Балыклык (Хар балгас) гэдэг хот байгуулан улсын нийслэл болгожээ.

Моюнчурын үеийн үйл явдлыг “Сэлэнгийн чулуу” хэмээн алдаршсан гэрэлт хөшөөний бичээст тэмдэглэжээ. Хятадын Тан улстай найрамдах замаар өмнө зүгээс учрах аюулыг сэрэмжилж дорно, өрнө, умар тийш нутгаа тэлэх бодлого явуулж байв. Уйгур улс өөрийн хүчин чадалд тулгуурлан Хятадын дотоод хэрэг ч оролцох болжээ. 755 онд Хятадад гарсан Ань Лу Шанийн бослогыг дарахад Тан улс Уйгураас тусламж гуйжээ. Моюнчур хаан 4000 цэрэг явуулж уг бослогыг дарсан ба хариуд Хятадын хаан асар их бэлэг шагнан, бага гүнжээ хатан болгон ураг холбохоор илгээж байв. Үүний дараа Тан улстай худалдаалах эрх олж гэрээ байгуулан агт морь, торгоны наймаа хийж байхаар тогтжээ. Эдийн засаг, соёл хөгжихийн хамт эзлэгдсэн аймгууд бослого гарган тэмцэж эхэлсэн байна. Ноёд түшмэдийн эрх мэдэл нэмэгдэхийн хирээр төрийн эрхийн төлөөх тэмцэл ширүүсч байлаа. Моюнчурын дараа хаан суусан Идигань (759-779)-ийг алж Дуньмохэ хаан ширээнд суув. Тэр хаан суухын тулд өмнөх хаадын төрөл садан 2000 орчим хүнийг алсан байна.

IX зууны эхээр, эзлэгдсэн аймаг угсаатны эсэргүүцэл, язгууртны хоорондын тэмцэл зөрчлөөс болж Уйгур улс маш сулрав. 820 оны үеэс Енисейн Киргис аймаг довтлон байлдаж хүнд байдалд оруулжээ. Энэ дайн удтал үргэлжилсний эцэст 840 онд Уйгур улс мөхөж, киргисүүд нутгийг нь эзлэн авч нийслэл Балыклыкыг шатааж эвдэн сүйтгэжээ. Уйгурын зарим нь тэдний эрхшээлд орж нөгөө хэсэг нь Дорнод Туркестан Зүүн гарын нутагт шилжин шинэ улс байгуулан суусан байна.

Уйгурууд эрт дээр үеэс нүүдлийн мал аж ахуй эрхлэн аж төрсөөр ирсэн боловч сүүлдээ согд, хятад урчууд дархчуудын хүчийг ашиглан хот балгад олноор барьж байгуулах болжээ. Уйгур улс дотоодын хүчин чадалд бүрэн тулгуурлаж мал аж ахуйн бүтээгдэхүүнээ бүрэн ашиглан ихэд баяжиж хүчийг олж байсан уламжлалтай. Улмаар хөрш улс орнуудтай харилцах болж худалдаа наймаа хөгжүүлж байв. Уйгур улсын эр хүн нь цэрэг зэвсгийн эрдмийг сайтар эзэмшсэн, дайнд хүчтэй баатар цэрэгт тооцогдож байв. Соёлын талаар тэд их ололт дэвшилд хүрсэн ба тэдний үлдээсэн хот суурин болон бичиг үсгийн дурсгалт зүйл Монгол нутагт их хэмжээтэй хадгалагдан үлджээ. Монгол хэл, монголын соёлын хөгжилд уйгурын оруулсан нөлөө асар их юм. Өдгөөгийн монгол угсаатны дунд уйгураас гаралтай овог ястан, монгол хэлэнд уйгураас гаралтай овог ястны нэр, газар усны нэр багагүй байхаас гадна утга соёлын зүйлд ч тэндээс үндэс эхтэй зүйл багагүй бий. Ялангуяа манай уйгаржин монгол бичиг үсэг үүсч хөгжихөд уйгур, согдын нөлөө тун их байжээ.

§ 1. УЙГУРЫН ХОТ БАЛГАД

Уйгурчууд хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлогтой байлаа. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дугана барьдаг байжээ.

Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Ялангуяа хил хязгаараа умар зүгээс сэргийлэн хамгаалах нумарсан хэлбэрт их бэхлэлт хэрэм, түүний бүрэлдэхүүнд олон тооны шивээ цайзыг оруулан барьсан байжээ. Энэ их хэрмийн дагуух хилийн 17 бэхлэлт цайзыг Тува улсын нутагт илрүүлэн судалсан байна. Бэхлэлт хотуудын зарим нь засаг захиргааны төвийн үүрэг ч гүйцэтгэж байжээ. Эдгээр нь суурин амьдралын төв болж газар тариалан, гар урлал, худалдаа наймаа цэцэглэн хөгжиж байв. Манай улсын нутагт уйгур улсын сүр жавхлант нийслэл Ордубалык буюу Хар

балгас, мөн шашин номын томхон төв болж байсан Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Бийбулагийн балгас зэрэг хотууд байдгийг археологийн талаар бага сага шинжин судалж байжээ.

Хар балгас. Уйгур улсын нийслэл Хар балгас буюу эртний уйгур хэлээр Орду Балык хотын ор үлдэц эдүүгээгийн манай улсын Архангай аймгийн Хотонт сумын нутагт Орхон, Жирмэнтэй хоёр голын бэлчирт байдаг. Үүнийг XIX зууны сүүлч үед Оросын эрдэмтэн Д.А.Клеменц, В.В.Радлов нар удаа дараа шинжин эрдэм шинжилгээний талаар тодорхойлон бичиж нийтлүүлсэн юм. 1933-1934 онд Монгол улсын ШУХ-д ажиллаж байсан орос эрдэмтэн Д.Д.Букинич бага сага малтан судалж байжээ. 1949 онд С.В.Киселев, Х.Пэрлээ нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний анги хэсэгчлэн малтаж байсан байна. Судалгааны байдлаас үзэхэд Хар балгас нь 25 км² талбай эзэлсэн асар том хот байсан нь мэдэгддэг. Хотын талбай нь худалдаа, гар урлалын хэсэг, хааны орд харш, сүм дугана зэрэг хэсгүүдээс бүрдэж байв. Хааны орд нь тусгайлж барьсан бат цайзат хэрэмтэй, хойт урд хоёр талдаа тус бүр хоёр том хаалгатай байсан бөгөөд цэрэг дайны зорилгоор цайзны ханыг тойруулан олон цонж цамхаг барьсан байжээ. Хар балгасны цайзат хэрэм хэмжээгээр ихийн (600 x 600 м) дээр түүний хана туурга нь одоо нэлээд нурсан боловч арваад м өндөр, цайз нь 12 м, хэрмийн төвд байсан том цайз (хараат) одоо 14 м байна. Хэрмийн дээгүүр цамхагийн оромтой ба гурван талаасаа шуудуугаар хүрээлэгджээ.

Цайзат хэрмэнд Уйгурын хааны орд харш байсан нь малтлагын олдвороос мэдэгджээ. Хэрмийн дотор малтахад сайхан үзэмжит чимэглэлтэй ордны барилгын ор олдсон нь Хятадын Тан улсын (618-907) үед холбогдох зүйл байжээ. Түүнээс гадна хааны ордонд хамаарах бурхан шүтээнийг агуулж байсан бололтой хэрэм бүхий дугана сүм байсны ор олджээ. Үүний үүдэнд согд, хятад, орхон-енисейн бичигтэй гэрэлт хөшөөнүүд тавиаатай байжээ. Тэдгээр хөшөөг Уйгурын хаадад зориулан босгодог байжээ. Цайзат хэрмийг тойрон тусгай шороон цонж байсан ба цайзын гадаад буланд налуулан хийсэн тусгай цонжийг цэргийн зорилготой гэж үзсэн зүйл бий. Цайзат хэрмийн үүдэнд цэцэрлэг зугаалгын газар байсан бололтой. Хар балгасны баруун хойт, баруун хэсэгт худалдаа гар үйлдвэрийн хэрэм барилга олон байжээ. 1949 оны малтлагаар эндээс төмөрлөгөөр юм дархалж байсан баримт болох лав, хавтгай хүрэл, хүрэл хайлж байсны үлдэц олдсноос гадна 840 онд холбогдох хятад зоос олджээ.

Хар балгаснаас олддог уйгурын ваар сав нь янз бүрийн хэлбэр хэмжээ, зориулалт бүхий зүйл байжээ. Эдгээр бүх сав суулгыг хүрдэн оньсон дээр үйлдсэн, жигд сайн шатаалттай, сайтар хольж нягтруулсан саарал шавраар хийсэн ба хээтэй хээгүй янз бүрийн ваар сав байсан нь тус тусдаа өөр өөр зориулалттай юм. Эдгээр сав нь тусгай хэвээр дарж гаргасан хээтэй байдаг. Хөндлөн зураастай зэрэгцээ шугам, дарж гаргасан хонхортой хөндлөн зураас, ороолдож сүлжилдсэн болон дугуйрсан гэх мэтийн олон хэлбэрийн хээ байна. Эдгээр нь Дундад Азийн нутгаас олддог сав суулганы хээтэй ижил байдгийг Уйгурын соёлд согд нарын нөлөө оролцоо их байснаар тайлбарлаж болох юм.

Түүхэн сурвалжийн мэдээ ёсоор киргис нар Уйгар улсыг мөхөөн дараад Хар балгасыг ихэд эвдэн сүйтгэсэн гэдэг. Энэ их эвдрэлийн ор мөрийг одоо ч Хар балгасны байдлаас харж болно. Эдүгээ Хар балгасны зөвхөн хэрэмт хэсэг нь л бүтэн үлдэж, бусад хэсгүүд ихэд эвдрэн сүйдсэн ба ялангуяа баруун болон өмнөд хэсгийн хорооллууд Хар Хорины сангийн аж ахуйн тариан талбайд орж хагалагдан хотын соёлт давхарга ихээр эвдэрч сүйджээ.

Бийбулагийн балгас Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг, сумын төвөөс баруун тийш 13 км зайтай, Сэлэнгэ мөрний хойт хөвөөнд, эртний балгасны туурь байдаг нь Уйгур улсын соёл, шашны нэгэн томоохон төв Байбалык хотын ор үлдэц юм. Нутгийн ард олон эрт цагаас энэ хотын туурийг Бийбулагийн балгас хэмээн нэрлэсээр ирсэн нь даруй эртний нэрээ хадгалан үлдсэн гайхамшигт жишээ болно. Эл хотыг үүсгэн байгуулсан тухай “Сэлэнгийн чулуу” хэмээн алдаршсан Могойн шинэ усны хөшөө буюу Моюнчур хааны гэрэлт хөшөөнд өгүүлжээ.

Энд нийт гурван хэрэм буйн үндсэн хэсэг нь, баруун болон хойт талдаа шавар дагтаршуулан дэлдэж хийсэн өндөр ханатай дөрвөлжин том хэрэм юм. Үүний өмнөд ба хойт хана 238 м, зүүн хана 235 м, баруун хана 237 м бөгөөд хэрмийн далан нурж ихэд сунан тогтсон нь өргөнөөрөө арваад м, өндөр нь 2-3 м байна. хойт ба зүүн талын далан дээр шавар шороо үелүүлэн дагтаршуулж хийсэн өндөр хэрмэн хана буй нь 428-720 см өндөртэй. Нөгөө хоёр хананд ийм зүйл үгүй юм.

Энэ хэрмийн дотор хожим богдын шавь нарын байсан Бий-булагийн хийд оршиж байсан ба эндхийн ба-рилгын олдвор хэрэг-лэгдэхүүний дотор эрт-ний Уйгурын болон хож-мын сүм хийдийн юмс холилдон байдаг. Уг хийдийг 1930-аад онд эвдэн нураасан бөгөөд харин сүүлд 1990-ээд онд шашин сүм хийдийг сэргээх болсон үеэс болхи хийцтэй модон дугана барьж хурал номын ажил явуулах болсон байна. Энэхүү дуганын үүдэнд эртний гурван чулуун арслан болон тээрмийн ингийн чулуу зэрэг юмс байдаг нь эртний Байбалык хотод холбогдох зүйлс ажээ.

Энэхүү гол хэрмээс урагш 750 м зайд өөр нэг жижиг хэрэм орших нь хойт хана 149 м, өмнөд хана 158 м, баруун хана 149 м, зүүн хана 149 м хэмжээтэй дөрвөлжин шороон хэрэм бөгөөд дотор нь орон барилгын ор үлдэц мэдэгдэхгүй, дээгүүр нь өвс ногоо урган их л хулширч эдгэсэн байна. Хэрмийн дотор талд ил хэвтэх уур чулуу хэмээх засмал чулуунаас гадна шороон дороос ваар савны хэлтэрхий олддогийн зарим нь кидан маягийн хээтэй байжээ. Гуравдахь хэрэм дээрхээс баруун тийш 1 км орчим зайд орших ба 329x320x314x332 м хэмжээтэй. Хэрмийн далан бүр хулшран эдгэрч зарим газраараа огт мэдэгдэхгүй болсон, хэрмийн дундуур олон жалга, шуудуу нэвт гарсан байна.

Хэрмийн зүүн хойт өнцөгт маанийн үсэгтэй чулуун хөшөө босгосон байх ба энэ хавийг “Арслангийн үүд” гэж нэрлэдэг байна. Одоо эндхийн гол хэрэмд байгаа болон зарим нь Монголын Үндэсний түүхийн Музейд байгаа чулуун арслангуудыг чухам энэхүү “Арслангийн үүд” хэмээх газарт байсан гэдэг.

Бичгийн сурвалжид өгүүлснээр, энэхүү балгасыг согд, хятад урчууд барьсан ба энд худалдаачид сууж арилжаа наймаа эрхлэхээс гадна согд багш нар залран ирж бурханы болон маанийн шашны ном номлож, шашны ном судар уйгур хэлээр орчуулж байжээ.

§ 2. УЙГУРЫН ТАХИЛ ТАЙЛГЫН ОНГОН

Эртний улсуудын үеийн эд өлгийн дурсгал судлаач эрдэмтэд, тухайн үеийн тахил тайлгын онгоныг төрөл ялгаагаар нь зүйлчлэн ангилж, холбогдох цаг хугацаа, түүх соёлын хамаадлыг тогтоосны дүнд Уйгурын үеийн онгон тахилын дурсгалыг онцлог шинжээр нь ялган тодорхойлжээ. “Ноёдын” хэмээх нэрээр ихэд алдаршсан олон тооны онгон тахилгын дурсгал дотроос Уйгурын үеийн дурсгал нь зохион байгуулалт хийгээд бүрэлдэхүүн хэсгийнхээ онцлогоор тодорхой ялгардаг. Эдгээрийн бусдаас ялгарах өвөрмөц шинж нь гэвэл, урт тэнхлэгээрээ хойноос урагш чиглэсэн байхаас гадна түрэгийн тахилын онгонд заавал байдаг чулуун хашлага, хүн чулуу, балбал буюу зэл чулуу, шүтээний сүмийн барилга зэрэг гол бүрэлдэхүүн хэсгүүд байдаггүй. Эдгээрийн жишээ болгож хоёр томхон дурсгалыг нарийвчлан авч үзье.

Могойн шинэ усны дурсгал. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших энэ дурсгал нь Уйгурын хаан Моюун-чурт зориулан босгосон тахилын онгон юм. 25 х 47 м хэмжээтэй гонзгой дөрвөлжин хэрэм, түүний дотуур усан шуудуутай. Төвийн хэсэгт нь дүгрэг хэлбэрээр чулуу овоолж хийсэн голдоо хонхортой чулуун овоолго бий. Дурсгалын хойт хэсэгт, яст мэлхийн нуруунд суурилуулсан урт том хөшөө байсан нь Орхон-Енисейн руни бичээстэй. Уйгурын хаан Моюнчурын алдарт үйл явдал хийгээд уйгур улсын түүхэнд холбогдох гол гол үйл явдлын талаар өгүүлжээ. Энэхүү дурсгалыг 759-760 оны үед босгосон байна.

Мөн энэ үед хамаарах бас нэгэн чухал дурсгал нь Хөшөөн талын онгон бөгөөд үүнийг Могойн шинэ усны дурсгалаас өмнө үед холбогдох зүйл гэж судлаачид үздэг. Учир нь, 763 онд уйгурууд маанийн шашин авснаас хойш өвөг дээдсийн онгон барих уламжлалаа орхисон гэдэг.

Хаад язгууртанд зориулан босгосон эдгээр нүсэр том онгоны байгууламжаас гадна эгэл жирийн иргэдийн гэж үзэж болмоор, энгийн жижиг онгонуудыг малтан шинжилсэн нь бас бий. Чухам ийм төрлийн дурсгалыг Өвөрхангай аймгийн Хар хорин сумын нутаг, Орхон голын хөвөө, Бага Арцатын аманд малтан судалсан бөгөөд энэ нь, тайлгын идээ ундааны үлдэгдэл болох малын яс болон шавар ваар савны хагархай зэргийг дарж булсан багавтар чулуун дараастай дурсгал болно. Ийм хэлбэрийн дурсгал түрэгийн үеийн онгон тахилын байгууламжийн дотор тохиолдож байгаагүй бөгөөд Уйгурын нийслэл Хар балгасны тахил шүтлэгийн зан үйлтэй холбогдох юм.

§ 3. БИЧИГ ҮСГИЙН ДУРСГАЛ

Уйгурууд, Монгол нутагт оршин тогтнож байсан олон аймаг, улсын дотор нэлээд дээгүүр соёлтой байжээ. Тэдний соёлын хамгийн том ололт амжилт бол бичиг үсэгтэй болж, албан бичиг хөтлөн ном зохиол бичиж, гадаад хэлнээс судар шастирын зүйл өргөн хэмжээгээр орчуулан туурвих болсон явдал юм. Уйгурууд анхандаа түрэг бичиг буюу орхон-енисейн бичгийг хэрэглэж байжээ. Тэр үеийн дурсгалын тоонд, “Сэлэнгийн бичээс” хэмээн алдаршсан Могойн шинэ усны гэрэлт хөшөө, Архангай аймгийн Тариат сумын нутаг дахь Тэрхийн бичээс зэрэг бичиг үсгийн томхон дурсгалууд орно. Түүнчлэн Уйгурын нийслэл Хар балгас хотноо буй, одоо эвдэрч ихэнх хэсэг нь устсан түрэг, согд, нангиад гурван хэлний бичээст аварга том хөшөө тэр үеийн утга соёлын үнэт дурсгалын тоонд зүй ёсоор ордог байна.

Уйгурууд Түрэгийн харьяанаас гарч өөрийн төр улсыг байгуулснаас хойш бусад улс оронтой өргөн харилцаж өөрийн соёлын нөлөөг түгээхийн хамт тэдгээр орны соёлын дэвшлийг тусган авч байжээ. Тухайлбал, Дундад Азийн өндөр соёлт согд нараас бичиг авч өөрийн хэлний аялгуунд зохицуулан хэрэглэсэн нь түүхэнд уйгур бичиг хэмээн алдаршжээ. Энэхүү бичиг нь Уйгур улсын үндсэн бичиг болж дэлгэрээд хожмын үед түүгээр олон зохиол бичиж орчуулж байсны зарим нь бидний үед хадгалагдан хүрч иржээ. Уйгур бичгийг, тэдний бүрэлдэхүүнд орсон түрэг, монгол угсааны зарим аймаг хэрэглэж байсан бөгөөд улмаар Их Монгол улсын албан бичиг болсон юм. Уйгур бичгээр дамжин олон үг монгол хэлэнд нэвтэрсэн нь ном, дэвтэр хэмээх согд үг, судар, эрдэнэ, шүлэг, бадаг гэх зэрэг энэтхэг үг, сүм, суварга, билэг, хөрөг, эрдэм гэх зэрэг уйгур үгс болно.

Манай улсын нутагт уйгур нарын үлдээсэн бичиг үсгийн томоохон дурсгалуудаас танилцуулбал:

Моюнчурын хөшөөний түрэг бичээс. Одоогийн Булган аймгийн Сайхан сумын нутаг Могойн шинэ ус хэмээх газар буй Моюнчур хааны тахилын онгоны бичигт хөшөөг 1909 онд Финлянд улсын их эрдэмтэн Г.И.Рамстедт нутгийн ард олноос олж мэдэн илрүүлж судалснаас хойш энэхүү дурсгал Сэлэнгийн бичээс хэмээх нэрээр судлаачдын дунд алдаршжээ.

Уг тахилын онгоны овоолго чулууны хажууд, толгой нь хугарч алга болсон мэлхий дүрст чулуу, сууринаасаа салж ойчоод хоёр хэсэг болж хугарсан бичигт том хөшөө бий. Энэхүү хөшөөний урт хугархайн нэг үзүүрт, сууринд суулгах засмал углуургатайгаас гадна нөгөө богино хугархайн нэг үзүүрт бас нэг углуурга байгаа нь хөшөөний оройд өмсгөн тогтоох ямар нэгэн чимэглэлийн хэсэг байсныг харуулж байна. Урт хугархайн урт 2,65 см, өргөн тал нь 49 см, нарийн тал нь 40 см, Углуургын хэмжээ 20 см. Богино хэсгийн урт 1, 26 см, өргөн тал нь 37 см, нарийн тал нь 30 см, углуурга 7 см юм. Энэ байдлаас үзэхэд уг хөшөөний анхны өндөр 3,91 см орчим бөгөөд мэлхий сууринд суулгасан байдлаараа 4 м гаруй өндөртэй байжээ.

Эл хөшөөг олон орны нэр судлаач эрдэмтэд судлан шинжиж тайлан уншиж, учир утгыг тодруулан нийтэлж ирсэн бөгөөд анх бүтэн байхдаа 6750 орчим үсэг-зурлагатай байсан нь одоо гэмтэж муудсаар 5000 орчим нь хадгалагдан үлджээ. Уг хөшөөнд, уйгурууд, Түрэг улсыг бутцохиж өөрийн төр улсыг төвхнүүлэн байгуулсан тухай үйл явдлыг тэмдэглэн бичсэн ажээ. Бичээсийн дотор, “Өтүкэний орчин тойронд хоёр (уул)-ын дунд нутагладаг. Тэдний ус Сэлэнгэ бөлгөө”. “Тэнд улс нь нүүдэллэн агсан” бөгөөд “...арван уйгур есөн огузыг зуун жил захиран”, “Сэлэнгийн (эрэгт) Байбалык хотыг байгуулахыг согд, табагач нарт даалгалаа би” гэхчлэн гардаг нь эл улсын нутаглан суусан газар орон, тэдний бүрэлдэхүүнд байсан овог аймгийн нэр ус, түүнчлэн тухайн үеийн түүхэн үйл явдлуудыг яруу сайхнаар тэмдэглэн бичсэн түүхэн сурвалж төдийгүй, нүүдэлчдийн утга соёлын үнэт дурсгал болно. Энэхүү хөшөөг, түрэгийн “орхон-енисейн” хэмээх руни бичгээр бичсэн нь, уйгурууд түрэгийн захиргаанд явах үеэсээ эл бичгийг хэрэглэсээр ирсэн, утга зохиолын бүрэн төгс боловсорсон хэл бичигтэй байсныг гэрчлэн харуулдаг юм.

Тэрхийн бичээс. Эрдэм шинжилгээний зохиолд Тариатын буюу Тэрхийн бичээс хэмээн алдаршсан энэхүү руни бичгийн дурсгал нь шинжлэх ухааны эргэлтэд орохдоо монгол хүний нэрийг түрэг судлалын хүрээнд өргөн гаргаж ирснээрээ нэн онцлог юм. Уг бичээс Архангай аймгийн Тариат сумын төвөөс баруунш, хойт Тэрхийн голын хойыг буюу Долоон модны ам хэмээх газар орших ба 1956 онд Монгол улсын шинжлэх ухааны хүрээлэнгийн ажилтан, археологич Ц.Доржсүрэн нээн олж анх нийтэлсэн байна. Энэ хөшөө эхэндээ газрын хөрснөөс цухуйж байсныг малтан үзэж мэлхий суурийг олж гаргаснаа буцаан булсныг хожим 1970 онд Түүхийн хүрээлэнгийн шинжилгээний анги дахин шинжиж хөшөөний өөр хоёр хугархай илрүүлэн олж мэлхий суурийн хамт ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологийн лабораторид авчирсан юм. Эл хөшөөний бичгийг тайлан уншиж монгол хэлнээ хөрвүүлэх үйлсийг манай улсын түрэг судлаач М.Шинэхүү үйлдсэн байна.

Энэхүү агуулга тайллаас үзэхэд уг хөшөөнөө, Торян гэгч хаан тэнгэрт болгоогдсон эл иргэнийг хураасны учирт хаан, хатан нэрийг олж улмаар орд өргөөгөө сүндэрлүүлэн бүтээж, төр улсаа цогцлон байгуулсны бэлгэ тэмдэг болгон гэрэлт хөшөө босгож, дөрвөн зүгээс нөмрөх дайсны аюулыг номхотгон улс орноо төвхнүүлж засаг төрөө батжуулан орд өргөөний мэргэн зөвлөх шадар туслагч сайд, дархан хүмүүс, ноёд түшмэд, цэргийн нэрт жанжин, Төлис Тардушийн ябгу, шад болон цэрэг эрийн зохион байгуулалт зэргийг эмхлэн байгуулсан тухай гардаг. Цааш нь, эл дурсгалыг үйлдсэн ёс горим ба түрэг, уйгурын өвөг дээдсийн тухай дурсамж болон уйгур улсын нэр сүр мандсан Өтүкэн уулын дунд орших Сөнгүз түмний тахилгат нутаг “Ыдук Башканы” баруун дор өргөөгөө босгосон тухай өгүүлжээ.

Уйгуруудын ийнхүү түрэг руни бичгээр тэмдэглэн үлдээсэн өөр дурсгал гэвэл, Булган аймгийн Сайхан сумын Сүүжийн давааны бичээс, Хар балгасны гурван хэлээр бичсэн их хөшөөний руни бичээс зэрэг дурсгалууд орно.

Долоодойн хөшөө. Түүхийн шинжлэх ухаанд Долоодойн буюу “Хар усны гэрэл хөшөө” хэмээх нэрээр орсон энэ хөшөө нь Увс аймгийн төв Улаангом хотын баруун хойно байдаг Хар ус гэдэг газарт буй Долоодойн хиригсүүр гэж алдаршсан их бага хоёр булшийг малтан шинжлэхэд их булшны зүүн талаас олджээ. Үүнийг 1955 онд археологич Ц.Доржсүрэн илрүүлэн олж уг хөшөөнөө буй 8 мөр уйгур бичгийг гэрэл зургаар буулган авч шинжлэл судлалын хүрээнд оруулсан байна.

Уг хөшөөний үг нь:

Баатар нэр минь Богаз-тегин. Би 17 настай байхдаа цэргийн хамт Бур-улууд очиж,

Би мянган адууг олзолсон. 19 нас (арай) хүрээгүй байхдаа

Би Оги-Сунуту-Тытагуд аян дайн хийсэн ба Чонуд цэрэг илгээж билээ.

Ярмагзед үлдэнгүүт (?) би (тэдний) замыг тосож хааж билээ. Өндөржил

Түвдээс хойш оршдог газар нутаг дахь Тюрис-Болучу-Огузыг би эзлэв.

21-тэйдээ би Омузуд цэргээ аваачаад

Далай (?) -тай залгасан газар дахь Биди хүртэл доош (дугтарч) бууж

..... гэсэн утгатай ажээ.

Эртний бичиг үсгийн судлалтан эрдэмтэд үүнийг, согд-уйгурын буюу эртний уйгур бичиг гэж дүгнэжээ.

Эл хөшөөний бичиг нь хэлбэр дүрс ба бичилтийн байдлаараа согд-уйгурын буюу, согд бичиг, уйгур бичигт шилжиж байсан үеийн бичигтэй төстэй ажээ. Эл бичигт зарим үсэг дүрсийг ялган тэмдэглэсэн болон зарим үг, газар орны нэр Орхон-Енисейн ба бусад эртний түрэг бичгийн дурсгалд байдаг үгүүдтэй тохирч байгаа хийгээд бичгийн найрлага, он жилийг нэрлэсэн нэр, хэл зүйн онцлог зэргээс үндэслэн энэхүү дурсгал нь VIII буюу IX зууны үед хамаарах бололтой гэж үздэг. Эртний уйгур

бичгийн маш чухал дурсгалт зүйлсийн нэг болсон энэ гэрэлт хөшөө одоо Увс аймгийн ОНС Музейд хадгалагдаж байна.

Манай нутагт уйгур бичгээр бичиж үлдээсэн дурсгал үүнээс гадна Архангай аймгийн Их Тамир сумын нутагт буй Тайхар чулуу, Бичигт булан, Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Хайрханы бичээс гэх мэт дурсгалуудад байна.

§ 4. ХҮН ЧУЛУУ

Төв Азийн ихэнх нутагт илрэн олдож судлагдсан олон үеийн хүн чулуун дурсгалын дотор хийц дүрслэл, хэмжээ овор болон дэргэд нь буй тахил шүтээний байгууламжийн хэлбэр дүрсээр түрэгийн хүн чулуунаас мэдэгдэхүйц ялгарах хэсэг дурсгал бий. Эдгээрийн онцлог шинж нь, хоёр гараар хэвлийн өмнө сав барьсан, босоо дүрстэйгээс гадна хоёр чихэвчийг нь дээш сөхсөн дүгрэг малгайтай, олон унжлага зүүлт бүхий бүстэй байдаг. Эдгээрт түрэгийн хүн чулуунд байдаг шиг хутга, сэлэм зэрэг зэр зэвсгийн зүйл үгүй, мөн түүнчлэн харьцангуй том хэмжээтэй байна. Түүнээс гадна ойр орчинд нь, түрэгийн дурсгалд байдаг шиг тахилын хашлага чулуу, цуварсан зэл чулуу зэрэг зүйлс огт тохиолдоггүй байна.

Ийм хэлбэрийн хүн чулуу Тувагийн нутагт хэд хэд байдгаас гадна Хакаст ч бас олдож байжээ. Манай улсын Баян-Өлгий, Увс зэрэг баруун талын нутгаар тохиолддог ба төдийлэн нарийн сайн судлагдаж хараахан амжаагүй юм. Эдгээрийн заримаас жишээ болгон тодорхойлж бичвэл,

Битүүгийн хөшөө. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төвөөс баруун тийш 8.5 км-т Битүү хэмээх газарт оршино. 10 x10 м талбайтай 120 см өндөр дөрвөлжин шавар тавцангийн баруун хэсэгт нүүрээрээ зүүн зүг хандан газарт зоолттой байна. Саарал өнгийн боржингоор босоо хүний дүрстэй хийжээ. Хавтгайдуу оройтой дүгрэг малгайн хоёр чихэвчийг сөхөж өмссөн ба хөмсөг хамрыг нэгэн үргэлж товгороор дүрсэлжээ. Өргөн дүгрэг царай, хоорондоо хол зайтай зууван хэлбэрийн нүдтэй, шувтан эрүүтэй. Хоёр гараар хэвлийн өмнө цүлхэн бөөр, дэрэвгэр амсар ба тусгайлж гаргасан ёроол бүхий ваар барьжээ. Дөрвөн унжлага бүхий цулгүй өргөн бүстэй. Ар талыг нь засч янзлаагүй байна. Газраас цухуйсан өндөр 183 см, нүүрийн өргөн 70 см, мөрний өргөн 77 см, бүсэлхийгээрээ 87 см, зузаан нь 32-48 см.

Ногооннуур сумын төв дэх хөшөөнүүд. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын төвд хоёр хүн чулуу буйг сумын төвөөс урагш орших Ямаат улаан хэмээх уулнаас авчирсан гэдэг.

1 хүн чулууг цайвар саарал боржингоор босоо хүний дүрстэй хийжээ. Чихэвчийг сөхсөн дүгрэг малгайтай, өргөн нүүр, урт шувтан эрүүтэй, хоёр үзүүр нь дэрвийсэн хөмсөгтэй ба хөмсөг, хамрыг нэг үргэлж товгороор гаргаж давхар аньсагатай зууван том нүд, жижиг ам дүрсэлжээ. Хоёр гараар хэвлийн өмнө шулуун амсар, цүлхэн бөөр, босоо ёроолтой ваар барьжээ. Чихэндээ бөөрөнхий унжлагатай онгин хэлбэрийн эзмэг зүүсэн байна. Бүс зүүлт байхгүй. Газраас цухуйх өндөр 174 см, нүүрийн өргөн 54 см, мөрний өргөн 59 см, зузаан 38 см.

2-р хүн чулуу нь улбар шар өнгийн боржингоор хийсэн босоо хүний дүрс юм. Өргөн нүүр шувтан эрүүтэй, өмнөөс нь харахад бортого хэлбэрийн малгай өмссөн ба цээжинд нь доош унжсан хоёр хөх гаргаснаас үзэхэд эмэгтэй хүний дүрс ажээ. Хоёр гараа хэвлийн өмнө авч ямар нэгэн сав барьж байсан бололтой. Энэ хавь нь холтрон унасан тул савны хэлбэр тодорхойгүй. Газраас цухуйх өндөр 140 см, нүүрийн өргөн 55 см, мөрний өргөн 59 см, зузаан 37 см.

Эдгээр хүн чулууны хийц дүрслэл болон дэргэд нь байх байгууламжийн хэлбэр дүрс түрэгийн хүн чулууныхаас эрс ялгарч байна. Харин газар зүйн байршлын хувьд, түрэгийн хүн чулуу элбэг тархсан Баруун Монгол, Алтайн уулсаар байх ба Уйгур улсын төв байсан Монголын төв нутагт огт тааралддаггүй байна.

§ 5. БУЛШ ОРШУУЛГА

Монгол нутагт малтан шинжилсэн дундад зууны үед холбогдох булшнуудын дотор, 1949 онд Л.А.Евтюховагийн Орхоны Дэл ууланд малтан шинжилсэн бүлэг булшийг уйгурын үед хамааруулан үздэг юм. Тухайлбал, эндхийн 5,7, 11-р булшууд Уйгурын соёлд холбогдоно гэжээ.

5-р булш. Энэ нь 12 м орчим голчтой, дөрвөн өнцөгт хэлбэрийн чулуун дараастай бөгөөд булшны нүх нь тун гүехэн байжээ. Уг булшийг эрт цагт тонож ухсан, хүний зөвхөн гарын яс л бүтэн үлдсэн байв. Уг булшинд хонины яс хойлголон хийсэн байжээ. Харин эндээс адууны яс олдсон эсэх талаар хоорондоо зөрүүтэй дүгнэлтүүд байдаг. Олдсон эд өлгийн зүйлсийн дотор хоёр талыг нь хайрс мэт иржийлгэж зассан бүсний горхи хэлбэрийн зүйл олдсон байна. Түүнчлэн залгаас бүхий төмөр амгай, улбар шар өнгөтэй шавар савны хагархай зэрэг эд юмс гарчээ. Энэхүү савны хэлтэрхий нь гадаргаараа сүлжилдсэн нуман хээтэй байсан нь Уйгурын нийслэл Хар балгаснаас олдсон сав суулганы хээтэй ижил байснаас үндэслэн уг булшийг уйгурын үед холбогдуулан үзсэн юм.

7-р булш. Дөрвөлжин хэлбэрийн чулуун дараастай бөгөөд дараасны дор 1,4x1,4 м хэмжээтэй 1,25 м гүн нүх байжээ. Нүхэнд хүний ясны зарим хэсэг, тарж бутарсан адуу, үхрийн ясны хэсгүүд, хоёр ясан чагтын хамт олджээ.

11-р булш. Дүгрэг хэлбэрийн чулуун дараастай булш бөгөөд эндээс хоёр хүний яс, төмөр хэт, сумын зэв тав, хүрэл хамбуур зэрэг зүйл гарчээ.

Судлаачид, эдгээр булшийг уйгурын соёлд хамааруулан үзсэн бөгөөд эндээс уг нутгийн оршин суугчид нүүдлийн хуучин уламжлалаа хадгалахын сацуу хот суурины соёлтой ямар нэгэн хэмжээгээр холбоотой байдал харагдаж байгаа нь тэдний, Төв Азийн бусад нүүдэлчдээс ялгарах шинж гэж дүгнэжээ. Оршуулгын зан үйл тодорхойгүй боловч, байгаа цөөн олдворт түшиглэн талийгаачийг оршуулахдаа тоног хэрэгсэл бүхий адуу, хонь, үхрийн яс зэрэг зүйлсээр хойлголон ёсолж дагуулсан бололтой ажээ. Эндхийн ваар савны хээ Хар балгасны олдвортой дүйж байгаа нь эдгээрийг Уйгурын үед холбон үзэх гол баримт нотолгоо болжээ.

Цагаан Хайрханы булш. Энэхүү булшийг 1990-ээд онд Монгол, Оросын судлаачид малтан шинжилсэн юм. Уг булш нь 9 м голчтой, 0.2 м өндөр чулуун дараастай, голдоо хонхор бүхий нэлээд хөрсжиж бэхжсэн байжээ. Дараас чулууны дунд адуу хонины яс болон нүүрсний хэсгүүд тохиолдож байжээ. Дараасыг авсны дараа 2,6 x 2,1 м хэмжээтэй булшны нүх илэрсэн нь 2 м гүнтэй байв. Нүхийг дүүргэсэн хөрсний дотор чулууны хэлтэрхий, өмхөрсөн модны хэсгүүд, хонь адуу болон хүний ясны хэсгүүд тааралдаж байжээ.

Нүхний ёроолд зүүн өмнөд хэсэгт нь хөлийг нь нугалан хоньчилж хэвтүүлсэн адууны араг яс гарсан нь толгойгоор баруун өмнө зүг чиглэсэн байв. Яс бүрэн бус бөгөөд цагираган зуузайтай амгайтай байжээ. Булшны баруун хойд хэсгийн хананд хөндийлөн ухсан нүхэнд залуухан эмэгтэй хүний араг ясны үлдэгдэл олдсон нь ихээхэн хөндөгдөж байрлалаа алдсан, хагас дутуу, тоногдсон бүх шинж тэмдгийг агуулсан байв. Гэхдээ зарим эд зүйлс хадгалагдан үлдсэн нь төмөр хутга, билүү, ваарын хэлтэрхийгээр хийсэн ээрүүлийн дугуй, ясан чагт, төмөр жижиг эдлэлийн зүйлс байжээ. Энэ булшийг эд өлгийн зүйлсийнх нь зарим онцлогоор, тухайлбал, төмөр амгай, шавар савны хээ зэрэгт үндэслэн VIII-XII зуун буюу уйгарын соёлд холбогдоно гэж тодорхойлсон байна.

Уйгурын үеийн булшны зохион байгуулалтыг авч үзвэл дугуй хэлбэрийн чулуун дараастай, нас барсан хүнээ гол төлөв зүүн зүг толгойг нь хандуулан, хажууд нь морь дагалдуулан оршуулсан байдаг. Булшны гаднах төрх байдлаараа Түрэгийнхтэй төстэй боловч ялгагдах нэг гол онцлог нь хүн ба морины толгойг нэг зүг рүү хандуулан тавьсан байдаг оршдог. Үрлэн унжлагатай гархин ээмэг, шавар ваар сав суулга, ясан зэв, модон сам, ээрүүлийн дугуй, хүрэл толь, морь малын тоног хэрэгсэл амгай, дөрөө, чөдрийн ясан чагт зэрэг эд өлгийн зүйлийг дагалдуулан тавьдаг байна.

Түүнчлэн Өвөрхангай аймгийн хуучин Шанх сумын нутаг Жаргалантын аманд малтсан булшинд хоёр морь дагалдуулан тавьсан байжээ.

Уйгурын үед холбогдох нэгэн булшыг 1994 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Элст хөтөлд малтан шинжилснээс харахад дугуй чулуун дараастай, хүнээ зүүн зүг толгойг нь хандуулан гэдрэг харуулан тавьж, морь дагалдуулан оршуулсан нь илэрсэн.

Тувагийн нутагт малтан шинжилсэн уйгурын булшууд нь шороон овоолготой, шуудуугаар хүрээлэгдсэн бөгөөд булшны нүх ухаж тавьсан буюу нүхний хананд далд нүх ухаж оршуулсан байдаг. Талийгаачийг банз модон дээр, эсвэл үйсээр бүрсэн модон авсанд гэдрэг харуулан умар зүг чиглүүлэн тавьсан байх ба олон төрлийн сав суулга, хонь, үхэр, ямааны яс, төмөр хутга, ээрүүлийн таваг, элдэв төрлийн зүүлтүүд, эр хүний зарим булшинд нум сум, бүсний төмөр гархи зэрэг зүйлс дагалдуулан тавьсан нь олдож байжээ.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

Вандуй Э. Увсын Хар усны гэрэлт хөшөө // ШУТ. 1958. ¹³.

Грумм-Гржимайло Г.И. Западная Монголия и Урянхайский край. Т. 2. Л., 1926.

Доржсүрэн Ц. Долгоодойн булш ба түүний хөшөө // ШУТ. 1957. ¹ 5-6.

Евтюхова Л.А. О племенах Центральной Монголии в IX в // СА. 1957. ¹ 2.

Кляшторный С.Г. Терхинская надпись // СТ- 1980. ¹ 3, с. 82-95.

Монголын археологи // СА. т. XII. Ф. 1. II бүлэг, § 2. УБ., 1987, тал 82-101.

Пэрлээ Х. Монгол Ард Улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961.

Рамстедт Г.И. Уйгар улсын түүхийн товч // ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан (уйгаржин монголоор).

Төрбат Ц. Морьтой нэгэн оршуулга // СА. т. XYIII. ф. 12. УБ., 1998, тал 130-134.

Худяков Ю.С., Цэвээндорж Д. Керамика Орду-Балыка // Археология Северной Азии. Новосибирск, 1982, с. 85-94.

Худяков Ю.С. Памятники уйгурской культуры в Монголии // Центральная Азия и соседние территории в средние века. Новосибирск, 1990, с. 84-89.

Худяков Ю.С., Цэвээндорж Д. Древнетюркское погребение из могильника Цаган-Хайрхан уул в Убсу-Нурской котловине // СА. т. XYII. ф. 8. УБ., 1997, с. 88-97.

Шинэхүү М. Тариатын орхон бичгийн шинэ дурсгал // СА. т. YI. ф. 1. УБ., 1975.

КИРГИСИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

840 онд Енисейн киргисүүд Уйгурыг байлдан дарж, Саяны уулсыг даван ирээд Төв Азид ноёрхлоо тогтоожээ. Енисей мөрний дунд хэсгээр нутаглан сууж нүүдэлчин ард түмний өвөрмөц соёлыг бүтээлцсэн энэ ард түмэн ийнхүү өмнөд хөршүүдийнхээ улс төрийн үйл явдалд гол үүрэг гүйцэтгэх болов. Зайлан бутарсан Уйгурын нутаг орныг эзэлж, эдүгээгийн Монгол, Зүүнгар, Дорнод Туркестан зэрэг Төв Азийн гол нутгуудад ноёрхлоо тогтоожээ.

Киргисийн тухай мэдээ YI зууны үеэс түүх сударт их гарах болсон ба тэр цагт тэд Енисей мөрний орчим уугуул эх нутагтаа оршсоор байжээ. Киргисүүд YIII зууны үеэс өмнө зүгт харилцаагаа өргөтгөж Хятадад элч илгээн холбоо тогтоож, Тан улсын ноёрхлыг эсэргүүцсэн Зүүн Түрэгийн тэмцэлд идэвхитэй оролцон Түрэгийн ахрыяанд орж, дараа нь Түрэгийг мохоосон Уйгурын харьяанд ч орж наяд гаруй жил болсоор сүүлдээ Уйгурын эсрэг ширүүн тэмцэж 840 онд ийнхүү Уйгурыг мөхөөжээ. Тэд мөн түрэг хэлтэн, түрэг угсаатан байсан боловч түүхийн зарим зохиолд киргис, чик нарыг ондоо угсааиан, ондоо хэлтэн байсан хэмээн тэмдэглэсэн байдаг нь тэд үндсэн түрэг нараасаа ялгарах ямар нэгэн онцлогтой байсныг гэрчилдэг.

Киргис улсын төрийг хаан толгойлж, түүний дор дараалсан олон зэрэг дэв бүхий түшмэдүүд байжээ. Эл хэмээх язгууртан, хар будун хэмээх эгэл ард иргэд байв. Енисейн киргисийн төр улс нь угсаатны хувьд холимог, нарийн төвөгтэй нэгдэл байсан бөгөөд уугуул киргис буюу ноёлох хэсэг, захиран дагасан өөр овог угсааны хүмүүсээс бүрэлдэж байв.

Тэдний аж ахуй нь холимог шинж чанартай байсан ба тариа будаа тарьж боловсруулдаг байв. Тэдний уугуул нутаг Минусын хотгорт усалгаат тариалангийн барилга байгууламжийн үлдэгдэл их олддог нь, зөвхөн анжист төдийгүй, усалгаат тариалан хөгжсөнийг харуулдаг. Хагас суурьшмал нүүдлийн мал аж ахуй голлон эрхлэхийн сацуу агнуурын аж ахуй, гар үйлдвэр хөгжсөн, алт, мөнгө, зэс, тугалгаар олон төрлийн хэрэгцээт зүйл үйлддэг байжээ. Ваар савны үйлдвэр чухал ач холбогдолтой байв. Худалдаа арилжаа хөгжиж гадагш харилцдаг байлаа.

Гол шашин нь бөө мөргөл бөгөөд лус савдагийг тахиж бөөлөн тахилга үйлдэж найрладаг байжээ. Утга соёлын гол ололт нь бичиг үсэг бөгөөд Орхон-Енисейн руни бичгээр бичсэн дурсгалууд их олддог байна.

Тэд монгол нутагт удаан хугацаагаар ноёрхож чадаагүй боловч тэдний оршин байсныг илтгэх зарим мэдээ баримт хадгалагдан үлджээ. Тухайлбал, Монгол нутгийн хаана ч арвин тааралдах, их чулуу овоолж, дүгрэг, дөрвөлжин хэлбэрээр чулуу тойруулан шигтгэж хүрээлсэн том булшуудыг киргисийн үүр буюу киргисүүр гэж нэрлэж заншжээ. Энэ нь эдгээр булш оршуулга, тус нутагт түр хугацаагаар захиран сууж байсан киргис нартай ямар нэгэн холбоотойг харуулдаг. Монгол нутагт, киргисүүрийн бүрэлдэхүүнд буй зарим булш малтан шинжилснийг киргисийн үед хамааруулан үзэж байгаа зүйл бий. Жишээ нь, Г.И.Боровкагийн Туулын хөндийд Наянт сүм, Их Алаг зэрэг газарт малтсан булшуудыг энэ үед холбогдуулан үзжээ.

Киргисийн уугуул нутаг Енисей мөрний эхэн, дунд биеэр малтан шинжилсэн Чаатас буюу дайны чулуу хэмээн нэрлэдэг булшуудыг орос, зөвлөлтийн эрдэмтэд сайтар нягтлан судалсан юм. Энэ нь дөрвөлжин буюу зургаан өнцөгт хэлбэрээр хавтан чулуугаар өрж хийгээд, тойруулан чулуу зоож хашлага үйлдсэн булшууд бөгөөд булшны нүхэн дотор талыг шургааг модоор бүрж таглаад талийгаачийг чандарлаж оршуулсан байдаг. Энд, ваар сав, эд өлгийн зүйл, малын ясаар хойлголсон байна. Эндээс онгон сахиус, зэр зэвсэг, сав суулга, гоёл чимэглэлийн зүйлс олддог ажээ.

Монгол нутагт ийм хэлбэрийн булш хадгалагдан үлдсэн зүйл одоогоор мэдэгдэхгүй байна. Харин 1986 онд Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутаг Нахиугийн манхан хэмээх газарт элсэн дороос нэгэн булш илрэн гарсан нь XI-XII зууны киргисийн соёлд хамаарна гэж судлаачид үзжээ.

Эндээс цэрэг эрийн ялтсан хуягийн үлдэгдэл, модон эмээлийн хэсэг, ухмал модон авсны үлдэгдэл, үйсэн саадгийн тасархай, алт шармал араб бичигтэй илдний хугархай, морь малын тоног хэрэгсэл, бусад төмөр эдлэлийн хэсэг, гоёл чимэглэлийн жижиг мөнгөн товруу зэрэг зүйлс олдсон юм.

Түүнчилэн энэ үед холбогдох нэг дурсгал бол Дорноговь аймгийн Хатан-булаг сумын нутагт хадан дээр сийлж гаргасан морьтон баатрын зураг бөгөөд судлаачид үүнийг киргисийн үед холбож үздэг.

Киргисүүд Монгол нутагт зуу орчим жил ноёрхлоо тогтоож байсны ул мөр, биет олдвор баримт ийнхүү үлдэж хоцорсон нь цаашид нарийн судалгаагаар улам улам илрэн олдох боломжтой. Тэдний оршин байсны тухай ардын аман ярианд хадгалагдсан зүйл байдаг нь зарим нутагт, Киргис хаан гэж байгаад булш оршуулга, цогцлон үйлдэж, чулуун хөрөг дүрсээ бүтээгээд нүүгээд явчихсан юм гэнэлээ гэх домог ярианд уламжлагджээ. Энэ нь эрт үед болж өнгөрсөн түүхэн үйл явдлын ул мөрийг хадгалсан байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966, тал 141-145.

Боровка Г.И. Археологическое обследование среднего течения р. Толы. СМ. Вып. 2. Л., 1927, с. 43-87.

Дорж Д. Дорноговь аймгаас олдсон хадны нэгэн зургийн тухай // ШУАМ. 1963. ¹ 1. тал 44-49.
Евтюхова Л.А. О племенах Центральной Монголии в IX в // СА. 1957. ¹ 2.
Худяков Ю.С., Баяр Д. Кыргызский панцырь из Западной Монголии // Информационный бюллетень
МАИКЦА. Вып. 15. М., 1988, с. 110-114.

КИДАНЫ АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛ

Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг нь Кидан улс юм. Кидан болоод тэдэнтэй уг удмын холбоотой аймгууд одоогийн Хятадын Гирын муж, Ляохэ буюу Шар мөрний орчим нутаглаж байжээ. Манжуурын төв ба өмнөд хэсэг (Гирын, Ляонин муж, Өвөрмонголын нутаг) нь эртнээс монгол буюу манж зөрчид гаралтай ард түмний мандан бадарч улсаа байгуулж явсан нутаг юм.

Эртний хятадын сурвалж бичигт кидан нарыг хүннүгээс буюу дунхугаас гаралтай гэдгээс өөр нарийн тодорхой зүйл байхгүй. Түүнчилэн кидан, монголчуудын хэл, зан заншил нь онцын ялгаагүй гэж үздэг байна. Киданы үг, нэр томъёог үзэхэд монгол үг их тохиолддог. Тухайлбал, боол-боули, сүлд-сүндэ, хүч-хүсы гэх мэт. Эрдэмтдийн дунд тэднийг монгол гаралтай, монгол хэлтэн, эсвэл манж зөрчид гаралтай гэж үзэх хоёр янзын үзэл бий.

Кидан нарын тухай сурвалж бичгийн анхны мэдээ IV зууны үеийн “Вэй шу” хэмээх түүхэнд хадгалагдан үлджээ. Тэд найман аймаг болж Их Хянганы уул, Авын уул, Ляо голын эх, Шар мөрний саваар нутаглан мал маллаж нүүдэллэн аж төрдөг байжээ. Мөн ан гөрөө хийж загас барьдаг. Эхэн үедээ бусад аймаг, улсын харьяанд орж явжээ. VI зууны үед Солонгосын Гаоли (Корё) улстай нягт харилцаатай байв. VII зууны үеэс хүчирхэг болж, үе залгамжлан захирах “Дахэ” хэмээх ноёлох овогтой болов. Энэ үед дөрвөн түмэн цэрэгтэй, Түрэгийн харьяанд байжээ. VII зууны дундуур Тан улс Түрэгийг бутцохин эзлэхэд кидан нар Хятадын хаанд алба барьж харьяалагдах болов. Тэд Тан улсын харьяанаас гарахаар босч тэмцэн удаа дараа дарагдаж байжээ. Түрэг улс VII зууны сүүлээр дахин сэргэн мандахад кидан нар тэдний гол дайсны нэгэнд тооцогдож байв. Сүүлд уйгурууд ноёрхох үед мөн харьяанд нь орж явжээ.

901 онд Киданы хаанаар Елюй овгийн Амбагянь тодрон гарч эрх мэдлээ бэхжүүлэн хуучин найман аймгийг үндэс болгон Кидан улсыг байгуулжээ. Засаг захиргааны талаар Умарт ба Өмнөд Ордод хятад зэрэг суурьшмал хүн амыг захируулжээ. 921 онд хууль цааз тогтоон түшмэдийн зэрэг дэв бий болгож таван түмэн хүнтэй их цэрэг байгуулан, гадаад улс оронтой харилцаа тогтоов. Дотооддоо цэрэг, засаг захиргааны шинэтгэл хийж гүйцээд гадагш аян дайнд морджээ. Киргис улсыг довтолж, 924 онд Хэрлэнгээс урагш, Алтайгаас зүүн тийшэх нутгийг эзлэн тэндхийн овог аймгуудыг төрөл төрлөөр шилжүүлж 3 аймаг зохион Зү-бү гэж нэрлэжээ. Зү-бү нар адуу малаар алба барьж харьяалагдан явсаар XI зууныг хүрчээ. Хятадыг байн байн довтолж 924 онд Дорнод тэнгисийн захад орших, зөрчид угсааны Бохай улсыг эзлэн авчээ. Түүнээс хойш их гүрний шинжтэй болж улсаа Их Ляо хэмээн нэрийдэж гүрний нийслэлийг байгуулж эхлэв. 946 оноос Хятадын мужуудыг довтолж Шар мөрний өмнөх газруудыг эзлэн авчээ.

Кидан гүрэнд 55 аймаг улс багтсан ба тэдгээрийг өмнөд замын 16 аймаг, умарт замын 28 аймаг, гадаад 8 аймаг гэж хуваадаг. 5 нийслэлтэй, газар нутаг нь дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан суваг (Бо-гу) хүртэл өргөжсөн байна. Хятадын зүгээс цэрэглэн довтлох явдал байсан ба 1005 оны үед их Ляо улс, Хятадын Сүн улс хоёр найрамджээ. Ингээд зүүн хойш Солонгосыг довтолж, баруун ба баруун хойш Уйгур, Тангуд зэргийг эзлэн захиргаандаа оруулсан байна.

Их Ляо гүрэнд аймгийн 3 янзын захиргаа байсан нь 1) их аймаг, 2) бага аймгууд, 3) Захирагдсан (хараат) аймгуудын захиргаа болно. Их аймаг бүрийг илижин (эл эзэн) толгойлж, түүний дор зүүн, баруун зайсан, тайши, сыту зэрэг тушаалтан байжээ.

Эзлэгдсэн олон аймаг босч тэмцсээр, 1113 онд зөрчид аймаг бослого гаргаж газар нутгаа чөлөөлөн Киданы зарим нутгийг ч эзэлж 1115 онд Алтан улсыг байгуулав. 1118-1125 онд Алтан улс, Хятадын Сүн улстай хүч нийлж Киданыг хоёр талаас нь хавсран довтолж 200 гаруй жил тогтсон Кидан гүрнийг мөхөөн газар нутаг, хүн амын үлдсэн хэсгийг эзлэн захирав. Киданы нэг хэсэг нь Елюй Дашийн захиргаан дор баруун зүг зайлан явж хоёр замаар давшин Дорнод Туркестаныг дайлжээ. Ингээд Иран хүртэлх газар орныг байлдан эзлээд 1124 онд Елюй Даши биеэ Гүр хаанд өргөмжилж Чуй голын хавьд Хүсүн Орду гэдгийг барьж нийслэлжээ. Тэр улсыг Хятадын түүхэнд Баруун Ляо, араб, иран сударт Кара Китай гэдэг. Энэ улс Аму-Дарьяа Эрчис мөрний хооронд их газрыг эзлэн XIII зууныг хүртэл оршин тогтнож Дорнод Туркестан, Дундад Азийн түүхэнд их үл мөрөө үлдээжээ.

Кидан нар нь анхнаасаа нүүдэлчин ард түмэн байсан бөгөөд хожим Хятадыг эзлэн, суурин газрын соёлын олон зүйлийг авч хэрэглэжээ. Газар тариалан, гар урлал эрхэлж тариалангийн ухаан, ялам, хүр хорхой үржүүлэх мэдлэг дэлгэрч байв. Кидан нарын бүтээсэн хот балгад, сүм, чулуун гүүр зэрэг зүйлс манай үед хадгалагдан үлдсэн нь буй. Төмөр хайлах, цутгах, сав суулга урлах эрдэм их дэлгэрч байв. Бичиг үсгийн соёл ихэд хөгжиж, түүх шаштир зохиох, ном орчуулах ажил өрнөж байлаа. Уран зураг, жүжиглэх, бүжиглэх урлаг дэлгэрчээ. Шатар тоглох, бөмбөг намнах тоглоомууд байв. Тэд бөө мөргөлтөн учир тэнгэр, газрыг тахиж, хавар, намрын тахилга хийдэг байжээ. Түүнчлэн бурханы шашин, даос, күнзийн сургаал язгууртны дунд ихэд дэлгэрчээ. Кидан хэл бичиг сургахаар Солонгосоос сурагчид ирүүлдэг байв. Ийнхүү хоёр зуу гаруй жил тогтсон Кидан гүрэн, Төв Ази, Дундад Азийн монгол, зөрчид угсаатны нийгэм соёлын хөгжилд их нөлөө үзүүлжээ.

§ 1.КИДАНЫ ХОТ СУУРИН

Монгол нутгаас Киданы үед холбогдох археологийн дурсгалууд бусад үеийнхийг бодвол харьцангуй цөөн тоогоор олддог. Монгол нутагт буй Кидан нарын холбогдолт археологийн дурсгалаас хамгийн олон тоотой хийгээд харьцангуй сайн судлагдсан нь хот балгадын үлдэц юм. Киданчуудын монгол нутагт байгуулсан хотууд, урьд өмнө бусад аймаг угсаатны байгуулсан хотоос илүү олон тоотой байна. Ер нь Монголд олддог Киданы холбогдолт археологийн дурсгалын дотор хот суурины дурсгал зонхилж байдаг. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт киданы үеийн арваад хот мэдэгдэж байна. Өөр төрлийн дурсгал төдийлэн олддоггүй нь, Монгол нутаг Киданд эзлэн захирагдсан хязгаар нутаг байсан тул үндсэн кидан хүн ам төдийлэн суурьшин сууж байгаагүй, харин нутгийн эзлэгдсэн уугуул хүн амыг дарангуйлан захирах засаг захиргааны болон дарангуй цэрэг суух хотуудыг байгуулж түр хугацаагаар ашиглаж байснаас шалтгаалжээ. Кидан улсын хаан Елюй Амбагянь 923 онд Монгол нутагт довтлон орж Уйгурын Хар балгас хүрсэн байна. Тэр цагт Монгол нутагт хот байгуулж цэрэг суулгаагүй бөгөөд харин Х зууны хоёрдугаар хагасаас Орхон, Хэрлэнгийн сав газрын олон аймгуудыг “урвах, дагах нь хязгааргүй” гэж тэднийг дарангуйлан захирах бодлого явуулж эхэлжээ.

Тэр цагийн аймгууд Кидан улсад харьяалагдаж байсан боловч түүний дэвсгэр нутагт шууд тооцогддоггүй байжээ.

Ингээд, кидан нарын түүхэнд холбогдох зарим хотыг малтан судалсан байдлаас тодорхойлон бичье.

Хатан хот буюу Чэнь-Жоу. Энэ хотыг Киданы татвар хатан 994 онд бариулжээ. Баруун хойт хязгаарын Зү-Бү олон аймгийг баримтлан захирч тохинуулахаар гурван хот дараалан барьсны нэг нь Чэнь-Жоу хот юм. Археологийн мэдээ, хятад жуулчин нарын тэмдэглэлээс үзэхэд, одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт байгаа Чин толгой гэдэг их балгас Чэнь-Жоу хотын ор үлдэц болох нь илэрхий юм. Чин толгойн балгасанд гэрэлт хөшөөний суурь том чулуун мэлхий байхаас гадна эндхийн зарим барилгын ваар кидан бичигтэй байжээ. Чин толгойгоос зүүн тийш Талын улаан гэдэг балгас, баруун тийш Хадаасан Хар бухын балгас байдаг нь, түүх сударт, гурван хот дараалуулан барьсан гэдэгтэй дүйх ажээ. Чэнь-Жоуд баруун хойт (гадаад) аймгийн 20 000 дарангуй цэрэг сууж байснаас гадна хятад, зөрчид ялтан 700 гаруй өрх айлыг нүүлгэн ирүүлж цөлөн суулгасан байжээ. Энэ хотыг, нутгийн олон аймаг Киданы дарлалын төв гэж эсэргүүцэн тэмцдэг байжээ. Жишээ нь 1013 онд Да-дань (татар) цэрэг хотыг бүслэн байлдаж Киданы байлдан дагуулагчдыг асар их сандаргаж байсан гэдэг.

Зүүн хэрэм, Баруун хэрэм. Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт зэрэгцээ хоёр хэрэм байдгийг археологич Х.Пэрлээ 1952-1953 оны хооронд малтан шинжилжээ.

Зүүн хэрмийн хэмжээ, өмнө тал 420 м, баруун тал 502 м, хойт тал 510 м, зүүн тал 507 м. Баруун болон урд талдаа нэг, хойд болон зүүн талдаа тус бүр хоёр хаалга бүхий шороо дагтаршуулж хийсэн, гадуураа усан татаал шуудуу бүхий хэрэмтэй байжээ. Хэрмийн дөрвөн буланд болон нийтдээ 28 харуулын цонж байсан байна. Хэрмийн одоогийн өндөр нь 1,5-2 м. өргөн нь 4-6 м. Хэрмийн өмнөд ба зүүн далдавчтай хаалгуудаас эхэлж төв дунд хүртэл үргэлжилсэн, хоёр талаараа хэрэмтэй, хоёр өргөн чөлөө гудамж байжээ.

Хэрмийн дотуур хэсэг барилгын ор туурь мэдэгддэгийн заримыг тусгай өндөр довжоон дээр барьсан байжээ. Эндхийн барилгыг барьсан байдал, орсон хэрэглэгдэхүүнээр нь хэд хувааж болно. Үүнд:

Тусгай бяцхан хэрэмтэй хөх тоосгон дээвэртэй барилгууд

Тусгай хэрэмгүй, дээврийг нь ваарласан барилгууд

Хэрэмгүй, дээврийн вааргүй барилгууд

Эндхийн барилгуудыг ханз хэрэглэн халаадаг байжээ. Нутгийн байгалийн нөхцөлд тохируулан аргал голдуу түлдэг, ур дарх хийдэг газарт илч сайтай залуу мод, битүү шатаасан хусны нүүрс хэрэглэж байжээ.

Малтлагаас үзэхэд энд ваар сав, төмөр эдлэл, барилгын хэрэглэгдэхүүн хийдэг хэдэн төрлийн үйлдвэр байсны хамгийн их хэмжээтэй нь ваар савны үйлдвэр юм. Зүүн хэрмийн гол аж ахуй нь мал, тариалан хоёр байжээ. Малтлагаас малын яс их гарсан нь хонь үхрийнх олон, адуу тэмээнийх цөөвтөр байжээ. Гар тээрэм, үр тариа хадгалах том шавар ваарны үлдэц, тарианы чулуун уур, нүдүүр, анжисны төмөр хошууны хугархай, тариа цайруулах ингийн төмөр цөн, монгол аму будааны үлдвэр зэрэг зүйл гарсан байна. Хэрлэн голоос ус татаж байсан шуудууны ор өмнө талд нь мэдэгддэг. 1020-1031 оны хооронд цутгасан тайпин гэсэн хятад бичигтэй Кидан улсын хүрэл зоос олджээ. Зоос нь тус хэрмийн он цагийг тогтооход чухал ач холбогдолтой олдвор болжээ.

Зүүн хэрмээс баруун тийш 2 км зайд Баруун хэрэм оршдог. Хэрмийн урд тал нь 826 м, баруун тал 803 м, хойт тал 825 м, зүүн тал 862 м урттай, хэрмийн ханын зузаан одоогоор 7-12 м, 1,5-3 м-ийн өндөртэй байна. Өмнөө хоёр, зүүн талдаа гурав, баруун ба хойт талдаа тус бүр нэжгээд хаалгатай байжээ. Хэрмийн дээгүүр болон өнцөгт цонж байсны үлдэгдэл овгорууд бий. Гадуураа мөн усан сувагтай. Үүнийг дундуур нь хэрмээр тасалж, заримд нь барилга байшин барьсан, зарим нь огт хоосон байжээ. Энэ хэрмийг Зүүн хэрмийн аж ахуйн газар, өөрөөр хэлбэл одоо хоосон байгаа газруудад

хүнсний ногоо тарьж, барилгатай хэсгүүдэд аму будаа агуулан байсан гэж судлаачид үзэж байна. Энэхүү хэрмийг, судлаачид, 1012, 1015 оны үед Хэрлэнгийн дээд биеэр нутаглах аймгууд Кидан улсын эсрэг босч тэмцсэнийг кидан нар цэрэглэн дарж, амьд үлдэгсдийг Хэрлэн голын эхэнд хоёр дахин хот барьж суулгасан гэх мэдээтэй харьцуулан нягталж үүнийг мөн гэж үзсэн байна.

Барс хот-1. Дорнод аймгийн Цагаан Овоо сумын нутаг Хэрлэн голын хойт биед, Баруун Дөрөө нуурын зүүн урд байрлах өндөр суврагат их хэрмийг археологийн ном зохиолд Барс хот-1 хэмээн нэрлэдэг. 1953 онд энэ бүс нутагт хийсэн археологийн хайгуулын явцад 3 хэрмийн үлдэгдэл олдсон ба эдгээрийг хооронд нь ялгахын тулд Барс хот гэж нэрлэгддэг суварга бүхий их хэрэмт хотыг Барс-1 гэж бичиж тэмдэглэх болжээ. Энэхүү хэрмийн их хэрмийн хэмжээ нь 1600-1800 м, зузаан нь 4 м, өндөр нь 1,5-2 м байна. Хэрмийн баруун өмнөд хэсэгт дотроо дөрвөн барилгын ор бүхий өндөр шороон довжоон дээр чулуугаар барьсан бага хэрмийн ор байна. Х.Пэрлээ 1953-1955 онуудад энэ хэрмийн доторхи дөрвөн барилга, бага хэрмийн орчин тойрны жижиг барилгын суурь, мөн шохой шатааж байсан зуухны ор зэргийг малтан шинжилж олон тооны бурхны сэнтий, дээврийн хөх тоосгон ваар, том жижиг хэмжээний угалзтай, угалзгүй тоосго, шавар баримал, ур хийц сайтай бурхны үлдэгдэл, бурхны баримал, сийлбэртэй мод, цац зэргийг илрүүлэн олж энэ газар нь бурхан шүтээний газар байжээ гэж дүгнэсэн байна. Хэрмийн дотор болон зүүн талд 5, 7 давхар хоёр суварга байсан ба таван давхар суварга нь 1940-өөд оны үед нурж, одоо долоон давхар суварга нь л үлджээ.

Барс-1-ийн бага хэрмэнд хийсэн малтлагаас харахад Кидан улсад буддын шашин их дэлгэрч, олон хүрээ хийд байгуулсан ба олон мянган ламтай байсан гэсэн Киданы түүхийн сурвалж бичгийн мэдээтэй таарч байгаа юм. Ийнхүү энд явуулсан багахан хэмжээний малтлагаас бурхан шашны зан үйлтэй холбоотой олдворууд гарсан боловч бүхэлдээ их хот цэргийн хуаран байжээ. Кидан улс эзэлсэн баруун хойд талынхаа аймаг угсаатны эсэргүүцлийг дарж байхын тулд Хэрлэн голын хөндийд гол төлөв нүүдэлчдээс бүрдүүлсэн олон анги цэрэг суулгаж байсны нэг хэсэг нь Барс хотын их хэрмэнд түр суурьшин сууж байсан байж болох юм.

Хар бухын балгас. Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Хар бухын голын зүүн эрэгт байрладаг. Энэ балгас нь түүхийн хоёр өөр үед холбогдох нь судалгаагаар нотлогджээ. Өөрөөр хэлбэл эхлээд Киданчууд энд хэрэм бүхий хотыг байгуулсан агаад хожим

ХҮИ зууны үед хэрмийн дотор талд нь чулуугаар өрж хийсэн барилга байгууламжуудыг байгуулжээ. Хотын хэрмийг шавар шороо дагтаршуулан дөрвөлжин хэлбэрээр босгосон бөгөөд дөрвөн талдаа хаалгатай, гадна талаар усан татаал суваг шудуутай, 500х500 м хэмжээтэй юм. Хэрмийн дотор талыг баруунаас зүүн тийш чиглэсэн гол гудам зааглаж байсан ажээ.

Дээр дурдсанаас гадна Булган аймгийн зэрэг нутагт Талын улаан балгас, Дэрсэн хэрэм, Эмгэнтийн хэрэм, Цагаан хэрэм зэрэг Киданы үед холбогдох хот балгадын үлдэгдэл байдгийг археологийн хайгуулаар олж тогтоожээ.

§ 2. БУЛШ ОРШУУЛГА

Киданы булш оршуулгын дурсгалыг малтан шинжилсэн байдлаас үзэхэд эл төрлийн дурсгал, тэдний уугуул нутаг Шар мөрөн, Урчи мөрөн зэрэг нутгаас их олддог байна. Одоогийн байдлаар, Кидан улсын үед холбогдох булш зуу гаруйг малтан шинжлээд байгаа бөгөөд энэ нь 1930-40-өөд оны үед япончуудын, Өвөр Монгол болон Хойт Хятадын нутагт зохиосон судалгаа, мөн сүүлийн үед Хятадын археологчдын хийж буй малтлага шинжилгээний ажлын хэрэглэгдэхүүн болно. Эдгээр нь, киданчуудын соёл, зан заншил, түүх, уламжлалыг судлах үнэт хэрэглэгдэхүүн болж байна. Дурдсан бүх булшийг зохион байгуулалтынх нь хувьд үндсэн хоёр хэсэгт хувааж үздэг.

1. Нүх ухах оршуулсан булш. Энэ нь ихэвчлэн Ляо улс үүсэхээс өмнөх үеийн буюу ядуу хүмүүсийн булш байдаг. Эдгээрийн дотор шатааж чандарласан явдал их тохиолддог. үүний жишээ болгож Өвөр Монголын Баарин хошуунд малтсан нэг булшны талаар авч үзье. Уг булшийг чулуу өрж хийсэн дөрвөлжин хашлагаар хүрээлсэн ба дөрвөлжингийн нэг хана 15,6 м, өндөр нь 0,5 м, хажуу талаараа зүүн урагш хандсан чиглэлтэй, зүүн өмнөө үүдэвчтэй байжээ. Чулуун хүрээний төвд 1,65 х 1,56 м хэмжээтэй хавтгай чулуун овоолго байсан ба түүний дор мөн ойролцоо хэмжээтэй, 0,4 х 0,5 м гүн нүхэнд, хүнийг чандарласан яс хийсэн зургаан ваар сав байжээ. Эдгээр савыг хавтгай чулуун дээр тавьсан ба нэг савыг чулуугаар тагласан, өөр нэг саванд хонины зургаан шагай байжээ. Паалантай болон паалангүй шавар савны хэлтэрхий мөн олдсон байна. Өөр бусад булш ч мөн иймэрхүү байдалтай байжээ. Судлаачид сав суулганы хэлбэр, хээ угалзыг үндэслэн киданых гэж үзсэн байна. үүнээс гадна, хүнийг модон авсанд хийж оршуулсан, түүнчилэн чулуун австай, гаднаа шороон овоолготой гэх мэт хэлбэрийн булшууд тохиолддог. Зэр зэвсэг, морь малын тоног хэрэгсэл дагалдуулсан нь бас бий. Хүний аманд зоос хийх тохиолдол ч байдаг.

2. Газар дор хонгил хийж оршуулсан хаад ноёдын булш. Киданы эзэн хаадыг, төрийн тахилга үйлдэх зан үйлийн дагуу нүсэр их ёслол гүйцэтгэж баян тансаг байдлаар оршуулдаг байжээ. Эдгээр нь одоо, газрын дээр ил мэдэгдэх зүйлгүй боловч анхандаа барилга байшинтай байжээ. Газрын доорхи оршуулгын байгууламж нь нарийн зохион байгуулалттай, өрөө тасалгаа нь дүгрэг буюу дөрвөлжин хэлбэртэй хоорондоо залгалдсан хонгилуудтай, орох үүд нь доош шаталсан хонгилтой байдаг. Эдгээрт хүүрийг занданшуулж нүүрэнд нь металл баг өмсгөн, зэс утсаар сүлжиж хийсэн торон хувцас

өмсгөж оршуулсан байдаг. Оршуулгын өрөөний дотор талыг модоор нүүрлэх ба хананд нь аж амьдралын сэдэвт зураг зурж чимдэг байжээ. Орох хаалга нь ямагт зүүн урагш чиглэсэн байна. Ахуйн хэрэглээний зүйл, гоёл чимэглэл, үнэт зүйлсээр хойлголдог байжээ. Оршуулгын зан үйл нь Төв Азийн бусад нүүдэлчдийн дунд нийтлэг байдаг зарим зүйлстэй тохирно. Тухайлбал, дүнз модоор зааж хийсэн оршуулгын өрөө, металл баг гэх мэт зүйлс байна. Оршуулгын баг бол Сибирийн Таштыкийн соёлд байснаас гадна киданы эртний өвөг дунху нарын дунд нүүрийг нь товруу хадсан давуугаар бүтээх заншил байжээ. Нүүдэлчдийн ахуй амьдрал, зан заншлын өвөрмөц зүйлс ч харагддаг нь, морь малын тоног хэрэгсэл дагалдуулах, морь, үхэр, хонь зэрэг малаар хойлголох зэргээс харагддаг. Булшны тасалгааны зүүн талд сав суулга, баруун талд морины тоног хэрэгсэл, төмөр эдлэл байрлуулдаг нь монголчуудын гэр орондоо эд юмсаа тавьж байрлуулах заншилтай тун адил байгааг судлаачид тэмдэглэж байжээ.

Манай оронд киданы эгэл иргэдийн булшийг цөөн тоогоор малтан судалснаас хоёрыг тодорхойлон өгүүлье.

Академич Х.Пэрлээ 1951 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Зүүн Бүрэн ууланд буй тоногдсон хоёр булшны үлдцийг малтан судалж сонирхолтой олдвор олсон байна. үүнийг урьд нь, жараад жилийн өмнө нутгийн ардууд ухаж чулуун байшингийн орой цухуйлгаад орхисон гэдэг бөгөөд энд чулуугаар дөрвөлжлөн тойруулж хийсэн хүрээтэй, хүрээний голд тоосгон бунхан барьсан байжээ. Эндээс 34 x 15 x 5 см хэмжээтэй тоосго, дээврийн нүүр ваар, тосгуур, нөмрөг ваарны үлдэгдлүүд, ширмэн хонх, улаан шавар савны хагархай, 8 ш зоос зэрэг зүйлс гарсан байна. Зоосуудын эртнийх 713-740 оны үед цутгасан Тан улсын, хожмынх нь 1068-1077 оны үед цутгасан Сүн улсын үеийн зоос байжээ. Эндхийн тоосго болон зоос зэргээс үндэслэж уг булшийг Кидан улсын сүүлчийн (XI зуун) үед хийсэн булш гэж үзсэн байна.

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Хэрлэнгийн Улаан эрэг гэдэг газарт археологич Д.Наваан 1969 онд нэгэн сонирхолтой булш малтжээ. Газрын өнгөн хөрснөөс доош 4 м гүнд, 6-7 м орчим урт, 4 м өргөн ухаж тусгай бэлдсэн хавтан чулуудаар бунхан бариад эрэгтэй, эмэгтэй хоёр хүнийг дотор нь оршуулсан байжээ. Бунханы өмнө талд том хавтгай чулуун дээр ямааны толгой, өвөрмөц хийцтэй ширмэн хонх тавьсан байжээ. Эрэг нурултаас болж ясны байдал нэлээд алдагдсан боловч уул хоёр хүнийг хойш хандуулж тавьсан бололтой байжээ. Эндээс гар тээрмийн бул буюу загасны торны живүүр чулуу, шил, үнэт зүүлтүүд, элдэв төмөр эдлэл, хүрэл товруу, даруулга, яс, шаазан, бог, төл малын яс, ширмэн хонх, гуулин цагираг, ёроолдоо нүхтэй том ваарны хагархай, хээтэй, хээгүй бөөрцөг, амсар зэрэг зүйлс олджээ. Эндээс олдсон ширмэн хонх, цэнхэр шилэн сувс, ваар савны зарим шинж болон уг оршуулга Киданы үеийн Хэрлэн Барс хотын ойр байгаа зэргээс үндэслэн X-XI зууны Кидан улсын үед хамааруулан үзсэн байна.

§ 3. БИЧИГ ҮСГИЙН ДУРСГАЛ

Кидан нарыг VIII зууны үеэс зураг бичигтэй болж хэрэг явдал тэмдэглэх болсон гэж сурвалжид өгүүлжээ. Тэд, их, бага хэмээх хоёр янзын бичиг зохион хэрэглэсэн гэдэг. Их бичиг хэмээх улсын бичгийг 920 онд Амбаганы ач хүү Лубугу, эрдэмтэн Тулюйбу хоёр, хятад бичгээс үлгэрлэн зохиожээ. Кидан нар нэлээд хожуу үед уйгур бичгийг үлгэрлэн шинэ бичиг зохиож хэрэглэсэн мэдээ бий. Түүнийг бага бичиг гэдэг. Киданы харьяат нүүдэлчин аймгууд, тухайлбал зөрчид, монголчууд кидан бичиг хэрэглэж байсан мэдээ байдаг.

Киданы ноёлогч анги язгууртан сурвалжтанууд хятад бичиг их хэрэглэдэг байв. X зуунаас олон төрлийн утга зохиол хөгжиж шүлэг, магтаал, дуу их зохиох болжээ. Замын тэмдэглэл бичих заншил нэлээд дэлгэрч “Морилон саатсаны тэмдэглэл” зэрэг зохиол гарч байв. Эрдмийн хоёр хүрээлэн байгуулсан ба эрдмийн хэрэг эрхэлсэн Лин-я хэмээх эрдэмтэн түшмэдийн албан тушаал байжээ. Хятад заншлыг дагаж улсын албан түүх, шаштир зохиодог байв. Хятад хэлнээс түүх судар, бурхан шашны гүн ухааны ном, хууль цаазын бичиг орчуулдаг байв. XI зуунаас ном барлах ажил дэлгэрсэн байна. Том ноёд өргөөндөө номын сантай байсан ба эдгээрт кидан номоос гадна хятад, энэтхэг, солонгос бичиг зохиолууд байдаг байжээ. Кидан хэл сургахаар 995 онд Солонгосоос арван сурагч ирүүлж байсан мэдээ бий. Киданы бичиг үсгийн дурсгалыг 1927 оноос илрүүлэн олж судалсаар ирсэн боловч хараахан бүрэн тайлж уншиж чадаагүй байна. Кидан бичиг үсгийн дурсгалууд нь, хүүр оршуулгын оршил бичиг, гэрэлт хөшөөний дурсамж бичиг, Киданы хаад хатадын хөшөөний хавхаг дээрх бичээс, толь болон тоосгон дээр бичсэн бичээс, газрын доорхи хонгил бунхан оршуулгын ханын зургийн бичээс, мөнгө зоосон дээр, сав суулга, тамган дээр бичсэн гэх мэт олон янз хэлбэрээр олддог байна. Манай оронд кидан нарын холбогдолт бичиг үсгийн дурсгал нь хад чулуунаа сийлэн бичиж үлдээсэн байдлаар олддог. Тухайлбал, кидан бичээс Архангай аймгийн Их Тамир сумын нутагт буй Тайхар чулуу, Хэнтий аймгийн Мөрөн сумын Салбар уулын Бичигт ханан болон Сүхбаатар аймгийн нутгаас илрэн олджээ.

§ 4. ХҮН ЧУЛУУ

Булган аймгийн Ингэт толгойн сангийн аж ахуйн төвд нэгэн өвөрмөц сонин хийцтэй хүн чулуу байдаг. Сумын төвөөс зүүн тийш 1 км орчим зайтай, Сэлэнгэ мөрний урд хөвөөнд орших Ингэт толгойн өмнө энгэрт уг хүн чулуу нүүрээрээ өмнө зүг чиглэн зоолттой байна.

Улбар бор өнгийн элсэн чулуугаар нэлээд чадварлаг цоолборлон урласан босоо хүний дүрс бөгөөд чулуу нь нэлээд мөлийж элэгдэн сэвтсэнээс бус ерөнхийдөө бүтнээрээ байх ажээ. Толгойг нягт барьсан дүгрэг малгайтай, малгайн оройд овгор байгаа нь, үсээ толгой дээрээ овоолон засч, хэлбэрт нь яг тохирсон малгай өмсдөг өмнө газрын нанхиадын ёс заншлыг санагдуулна. Өргөн дүгрэг царайтай, нэлээд том зууван нүдтэй бөгөөд нүдэнд давхар хүрээ гаргаж дотор нь цөцгий дүрсэлсэн байжээ. Хамрын үзүүр хэлтэрч унасан, ерөнхийдөө нэлээд нямбай сайн урлаж хийсэн байдалтайгаас гадна цемент маягийн зуурмагаар зарим хэсгийг хийж өнгөлөн гөлийлгөсөн байгаа нь шинэ үеийн ажил бус анхнаасаа ийм арга барилаар үйлдсэн бололтой. Тухайлбал хоёр чихийг чулуугаар биш харин ийм зуурмагаар бурханы чихтэй төстэй хэлбэр оруулан хийсэн байна. Баруун гараа тохойгоор нугалан цээжний өмнө авч том ваар сав барьж байсан гэмээр, гэвч гарын үзүүр хэсэг хугаран унасан тул тодорхой мэдэгдэхгүй. Зүүн гараа хагас нугалж хэвлийн орчим барьсан нь мөн үзүүрээрээ хугаран унасан буюу эсвэл ерөөс гарын үзүүрийг зуурмагаар хийсэн байсан нь салж унасан байж болзошгүй. Газар шүргэсэн урт хормойтой дээл өмссөн ба хоолойн орчимд дугуйрсан зах гаргасанаас өөр энгэр заам гэж мэдэгдэх зүйлгүй. Дээлийн энгэр талд хэвлээс доош улбар шар өнгийн зосоор ханан хээ мэт хээ гарган чимэглэжээ. Маш өргөн нэлэмгэр ханцуйтай бөгөөд гарын үзүүрээс доош тунаран унжсан нь дээлийн хормойтой чацуу байна. Хөшөөний доод хэсгийг газарт буюу тусгай чулуун сууринд зоож суулгахад зориулан углуурга мэт зүйл гарган засчээ.

Энэ хүн чулууг өмнө нь эрдэм шинжилгээний ном зохиолд ХИҮ-ХҮ зууны Мин улсын үеийн дурсгал гэж үзсэн зүйл бий. Гэвч, Мин улсын цэрэг Монголд удаа дараа цөмрөн орж байлдаж дайтаж байснаас бус удаан хугацаагаар эзэрхэн сууж байгаагүй, ийм дурсгал үлдээх боломж нөхцөл дутмаг юм. Харин Монгол нутагт байсан овог аймгуудын дотроос нанхиадын нөлөөг илүүтэй тусган авсан нь кидан нар бөгөөд Киданы хаад язгууртны тахилын онгонд чулуугаар хүн амьтны дүрс урлан хийж тавьдаг заншилтай байсан зэргээс үзэхэд энэ нь X-XII зуун буюу Кидан улсын үед холбогдох дурсгал бололтой. Ингэж үзэх бас нэг шалтгаан бол, Ингэт толгойн оройд нэг сонирхолтой байгууламж байдаг нь, тэг дөрвөлжин хэлбэрээр чулуу шигтгэн суулгаж хийсэн 6,5 х 6,5 м хэмжээтэй, ертөнцийн зүг чигийн дагуу байрлалтай чулуун хашлага юм. Үүний голд дөрвөлжин булштай төстэй хэлбэрээр хэдэн чулуу өрж суулгасан байгаа нь бүрэн бус ч ерөнхий хэлбэрээ хадгалан үлджээ. Энэхүү байгууламж нь манай хилээс чанад нутгуудад малтан шинжилсэн Киданы зарим төрлийн булшны гадаад байдалтай төстэй юм.

Түүнчлэн Ингэт толгой хэмээх газрын нэр, үүнтэй холбоотой домог зэрэг нь эртний монголчуудын оршуулга, тахилгын зан үйлийг эрхгүй санагдуулах бөгөөд монголтой гарал нэгт кидан нар нь мөн нас барагсдаа оршуулах, тахиж тайхдаа, ижил төстэй зан үйлийг баримталдаг байсныг анхаарч үзүүштэй. Энэ бүхнээс үндэслэн, Монгол нутагт элбэг олддог түрэг, уйгур, монголын хүн чулуунаас нэн өөр энэхүү хүн чулуу нь Кидан улсын дурсгал гэж үзэх нь илүү үндэслэлтэй байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

- Баяр Д. Ингэт толгойн хүн чулуу // МНДТСД (сэдэвчилсэн лавлах). УБ., 1999, тал 106-107.
- Ивлиев А.Л. Городища киданей // Материалы по древней юи средневековой археологии юга Дальнего Востока СССР и смежных территорий. Владивосток, 1983, с. 120-133.
- Наваан Д. Эртний нэгэн оршуулга // ШУАМ. ¹ 3. 1974, тал 13-21.
- Пэрлээ Х. Зүүн хэрэм гэдэг эвдэрхий хотыг 1953 онд малтсан нь. УБ., 1956.
- Пэрлээ Х. Киданчуудын модон онгодын тухай // SM. t. 3. f. 8. УБ., 1956, тал 154-155.
- Пэрлээ Х. XI зууны үеийн булшны үлдэц // ШУ. 1956. ¹ 2. тал 40-43.
- Пэрлээ Х. Хятан улсын хоёр бэхлэлт (хот)-ийн үлдэгдэл. УБ., 1957.
- Пэрлээ Х. Хэрлэн барс гэдэг эвдэрхий хотыг малтан шинжилсэн тухай. УБ., 1957.
- Пэрлээ Х. Чин толгойн балгасны бичигт ваар. УБ., 1957.
- Пэрлээ Х. Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь // SH. t. I. f. 1. УБ., 1959.
- Пэрлээ Х. Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь УБ., 1959.
- Пэрлээ Х. Киданские города и поселения на территории Монгольской Народной Республики (X-начало XII в.) // Монгольский Археологический сборник. М., 1962. с. 55-62.
- Пэрлээ Х. Кидан булш // SM. т.IX. f.5. УБ., 1982, тал 85-105.
- Sechin Jagchid. The kitans and their cities // Central Asiatic Journal. 1981. Vol. XXV. ¹ 1-2. p. 70-88.

МОНГОЛ ГҮРНИЙ ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Төв Азид ноёрхон байсан Кидан гүрэн XII зууны үед мөхсөний дараа монгол угсааны овог аймгууд Хятадын цагаан хэрмээс Сэлэнгийн эх хүртлэх нутгийг эзлэн оршиж байв. Тэд нийгмийн хөгжлөөр харилцан адилгүй бөгөөд оршин суух нутаг газар болон эрхлэх аж ахуйнхаа хувьд “ойн иргэн”, “хээрийн нүүдэлчин” хэмээх хоёр үндсэн хэсэгт зааглагдаж байжээ. Ийнхүү хожим нь монгол хэмээх нэрийн дор нийлэн нэгдэж монгол угсаатныг бүрэлдүүлсэн тэр овог аймгууд нь тухайн үед Хамаг Монгол, Хэрэйд, Найман, Мэргид, Татар, Онгуд аймаг, ханлиг болон оршиж байв.

Ингээд XIII зууны эхээр эдгээрийн дотроос Хамаг Монголын ханлиг нэн хүчирхэгжин нийт монгол угсаатныг нэгтгэн 1206 онд Онон мөрний эхэнд их хуралдай хийж Тэмүжинг Чингис хаан цолоор өргөмжлөн Их Монгол улсыг байгуулжээ. Ингээд Чингис хаан засаг захиргаа шинэчлэн тогтоож цэргээ зохион байгуулж, хил хязгаараа өргөтгөн тохинуулжээ. Түүний дараа олон жилийн турш дайсагнасаар ирсэн Алтан улс, зүй бус харьцсан Сартуул буюу Хорезм улсыг эзлэн их хэмжээний газар нутаг хүн амыг эрхэндээ оруулсан байна. Чингис хааны зарлигаар Хар Хорумд улсын нийслэлийг байгуулж, дараах хаадын үед өргөтгөн барих ажлыг гүйцэтгэсээр иржээ. Хар Хорум төвтэй Их Монгол улс нь Чингисийн дараах хаадын үед уугуул нутагтаа цэцэглэн мандаж өрнө дорнын олон газрыг улс төр, эдийн засаг, соёлын талаар холбон ойртуулах чухал зангилаа болж байжээ.

Харин 1260 онд Хубилай хаан улсын нийслэлийг өмнө зүг шилжүүлж Хятад газар төвлөрөн сууж улсын нэрийг Их Юан болгон өөрчилжээ. Ийнхүү монгол хаад 100 гаруй жилийн турш улс төрийн төвөө харь газарт төвлөрүүлж уугуул нутгаа зах хязгаар нутаг болгосон нь Хятад улс мандан хөгжиж харин монгол нутаг орхигдон хоцрогдоход хүргэжээ. 1368 онд Монголчуудын байгуулсан Их Юан улс Хятадын босогчдод цохигдон мөхсөнөөр монголчууд уугуул нутагтаа төвлөрөх болсон ч өмнөх сүр хүч нь доройтон суларч өөр хоорондоо тэмцэн хямарсан бутралын үе эхэлжээ. Энэ байдал удтал үргэлжилсээр 17-18-р зууны үед монголчууд бүхэлдээ Манж Чин гүрний мэдэлд орж улс төрийн тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн юм.

XIII зууны үед Чингис хаан, тархай бутархай байсан монгол аймгуудыг нэгтгэж нэгдсэн их улсыг байгуулсан нь монголчууд улс төр, эдийн засгийн талаар нэгдэн нягтарч, аж ахуй соёлын хувьд дэвшин хөгжих үндсийг бүрдүүлжээ. Улмаар бусад улс орныг эзлэн захирсан нь нэг талаар сөрөг үр дагавартай байсан ч монголчууд бусад улс орны аж ахуй соёлын дэвшлийг тусган авч, өөрийн уламжлалт соёлтойгоо хослуулан хөгжүүлж улам их дэвшлийг олох таатай нөхцөл буй болгосон байна. Энэ үед гарсан асар их хөгжил дэвшлийн нэг нь уйгур үсгийг өөрийн хэлний онцлогт тохируулан авч төрийн хэргийг хөтлөх үндэсний бичиг үсэг болгон хөгжүүлж улмаар ардын аман домгийн хэлбэрээр уламжлан ирсэн түүх, ураг удмын бичгээ бичмэл түүх болгон тэмдэглэж үлдээх болсон явдал юм. Энэ ч учраас монгол түмний утга соёлын агуу дурсгал “Монголын нууц товчоо” мэт том хэмжээний түүх, уран зохиолын дурсгал бүтээж байжээ. Ази Европын суурин соёлт олон улс орныг харъяандаа оруулан захирснаар тэдгээр орноос урчууд, дархчуудыг олноор авчирч хот суурины соёлыг шинэ төвшинд хөгжүүлэх болов. Тухайн үеийн монголын хот суурины хөгжил нь дан ганц гадны нөлөөгөөр хөгжсөн бус, өмнөх хуучин уламжлал дээр бусад орны соёлын хөгжлийг тусган авч өөр өөр соёлын хосолмол шинжийг агуулсан шинэ маягийн хот суурин цогцолж, бусад улс оронд ч өөрийн уламжлалт соёлын онцлогийг хүртээж байсныг судлаачид тэмдэглэн бичдэг билээ. Эрт үеэс нүүдэлчин төр улсуудын улс төр, соёлын төв болж байсан Орхоны хөндийд байгуулсан Хар Хорум хот нь тэр үедээ Ази Европыг холбосон улс төр, эдийн засаг, соёлын томоохон төв болж, олон орны элч төлөөлөгч, урчууд дархчууд хуран цугларч байжээ.

Хубилай хааны үед Хятад орныг бүхлээр нь эзлэн захирч, улсын нийслэлийг өмнө зүг нүүлгэн, эхэн үедээ монгол нутгийн өмнөд хэсэг болох Шанд хэмээх газарт дээд нийслэл байгуулан сууж байснаа улмаар Хятад нутаг Бээжин хотноо шилжин суурьшсан байна. Монголын хаад ийнхүү Хятад газар төвлөрөн суух болсноор асар их нутаг дэвсгэрийг эзэлсэн эзэнт гүрний улс төр, соёлын амьдрал харь газарт төвлөрч, уугуул монгол нутаг зах хязгаарын муж болж баахан орхигдох шинжтэй болов. Энэ үед монгол хаадын захиргаанд байсан Хятад орон эдийн засаг, соёлын хувьд асар их хөгжин дэвшсэн явдал нь монгол хаадын удирдан захирах бодлоготой холбоотой билээ. Монгол хаад нь, асар олон хүн амтай, өргөн уудам нутаг дэвсгэртэй, төр ёсны баялаг уламжлалтай орнуудыг удирдан захирахдаа тэдгээрийн төрийн болон засаг захиргааны хуучин уламжлалыг хэвээр хадгалж, итгэл бишрэлийг нь хүндэтгэн, орон нутгийн төрийн түшмэд, бичгийн мэргэдийн санал зөвлөгөөг харгалзан төрийн бодлогоо явуулж байжээ. Үүний зэрэгцээ өөрийн уламжлалт соёлоо ч хэвээр хадгалахыг эрмэлзэж зүйл бүрийн арга хэмжээ авч байсны нэг тод жишээ нь, монгол хэл бичгийн уламжлалд нэн тохирсон дөрвөлжин үсгийг зохион хэрэглэж, нийт эзэнт улсын хэмжээнд дагаж мөрдөх албан ёсны бичиг болгохыг зорьж байсан явдал юм. Монгол ил хаадын захирсан Перс оронд ч монгол соёлын нөлөө тусгал багагүй байсан нь Рашид-ад-Дины эрхлэн зохиолгосон тэр үеийн бүх дэлхийн түүх болох “Судрын чуулган”-ыг бичихэд Болд чинсан тэргүүтэй монгол түүхч нарын үүрэг оролцоо нэн ач холбогдолтой байжээ. Түүгээр ч барахгүй энэ түүхэн зохиолын чимэглэл зургийг бүтээлгэх зорилгоор хэсэг монгол, түрэг зураач, урчуудыг Монголоос аваачиж байсан мэдээ бий. Тэгээд ч XIV зууны Персийн миниатюр хэмээх номын чимэглэл зурагт “Монгол-түрэг арга маяг” хэмээх монгол ахуй

байдлыг илтгэсэн өвөрмөц хэлбэр бүхий шинэ чиглэл орж ирсэн бөгөөд энэ нь Персийн энэ төрлийн урлагт удтал шинж чанараа алдахгүй оршсоор байсан юм.

Өргөн уудам нутгийг эзлэн захирч байсан Монголын их гүрэн задран унаснаар Монгол орон бутрал хямралын байдалд орсон ч өмнөх үеэс уламжлан ирж бусад орны дэвшилтэт зүйлсээр баяжсан соёлын ололт нь хожим хойч үедээ аль нэгэн хэлбэрээр хадгалагдан үлдсэн билээ.

§ 1.ХОТ СУУРИН

Түүхийн шинжлэх ухаанд нэн эртнээс ихээхэн газар авсан нэг үзэл бодол нь монголчууд хэдийнээс цэвэр нүүдэлчин бөгөөд суурин амьдралыг огт мэддэггүй байсан мэтээр дүрсэлдэг уламжлал юм. Энэ нь юуны өмнө хятад сурвалж бичигт монголчууд, тэдний өвөг дээдсийн нүүдэл амьдралыг хэт их дөвийлгөн үзүүлсэн, тэрчлэн монгол нутагт суурин амьдрал эрхэлж байсныг гэрчлэх овойж товойсон том дурсгал, олон зуун жилийн наст том хот балгад цөөн, мөн нүүдэлчдийн хот сууринг төдий л их анхааран судалж байгаагүйтэй холбоотой ажээ.

Энэ зууны гучаад оноос монгол нутагт эрт цагаас оршин амьдарч ирсэн овог аймаг, улс гүрнүүдийн хот суурин, газар тариалангийн хөгжлийг эрдэмтэн мэргэд зүй ёсоор анхааран судлах болсон нь Төв Азийн нүүдэлчдийн аж ахуйн энэхүү өвөрмөц талыг сэргээн гаргахад чухал ач холбогдолтой зүйл болжээ. Эртний монголчууд ямарваа нэгэн хэмжээгээр суурьшин амьдарч, газар тариалан эрхэлж байсан тухай монгол судлаач их эрдэмтэн Б.Я.Владимирцов “Монголын нийгмийн байгуулал” хэмээх бүтээлдээ анх дэвшүүлэн тавьжээ. Түүнчлэн монгол орныг түүх, археологийн талаар судалсан бусад эрдэмтэд ч мөн ийм санаа, дүгнэлтийг удаа дараа гаргаж байв.

Үнэхээр ч монгол орныг археологийн талаар судлан шинжлэх болсноор эрт цагаас нүүдэлчин ард түмний цогцлон байгуулж байсан олон зуун хот суурины үлдэгдэл илрэн олдсон нь Төв Азид ээлж дараалан мандан тогтнож байсан олон улс гүрэн, түүний дотор язгуурын монгол угсаатны өвөг дээдэс ч нүүдлийн мал аж ахуй голлон эрхлэхийн зэрэгцээ бага сага хэмжээгээр суурьшин амьдарч байсныг гэрчлэх баримт болжээ.

Хар Хоум. Монголчуудын байгуулсан хот суурингаас хамгийн их хэмжээтэй судлагдсан нь XIII зууны Монголын нэгдсэн улсын нийслэл Хар Хорум хот юм. Энэ хотын оршин тогтнож байсан нутаг газрыг оросын эрдэмтэн Н.М.Ядринцевийн удирдсан шинжилгээний анги 1889 онд олж тогтоосон байна. 1948-1949 онд С.В.Киселевийн удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан том шинжилгээний анги уг хотын дэвсгэр нутагт анхны томхон малтлага судалгаа хийсэн юм.

1976-1980-аад онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс томилон илгээсэн судалгааны анги энд ажиллахдаа тус хотод амьдран сууж байсан лалын шашинт иргэдийн томхон оршуулгын газар, мөн монголчуудын булш оршуулга зэрэг дурсгалыг малтан шинжилж байв. Эртний сурвалж бичигт өгүүлснээр Хар Хорумд олон янзын шашин мөргөл, угсааны хүмүүс амьдран сууж байсан хэмээх мэдээг биет хэрэглэгдэхүүнээр баталжээ. Хотын дэвсгэрт хийсэн малтлагаас янз бүрийн хэлбэр дүрстэй тамга тэмдэг бүхий тоосго олноор олдсон нь үйлдвэрлэлийн холбогдолтой сонин олдвор юм. 1995-1996 онд ЮНЕСКО-гоос зохион байгуулсан Монгол, Японы хамтарсан шинжилгээний анги тус хотын бүрэн хэмжээний топографийн зураг үйлдэж, эртний хотын хамгаалалтын бүс тогтоосон нь цаашдын судалгаанд ихээхэн ач тустай ажил болсон юм.

1999 оноос Монгол, Германы хамтарсан Хар Хорум төсөл хоёр улсын ерөнхийлөгчдийн ивээл дор зохиогдох болсноор Мон-голын эртний нийслэлийн судалгаа урьд өмнөхөөс илүү дэвшилтэт шинэ шатанд гарлаа. Тус шинжилгээний анги нь малтлагын хамгийн орчин үеийн дэвшилтэт арга барилыг баримтлан ажиллаж, олдсон дурсгалуудыг тэр хэвээр нь бэхжүүлэн хадгалж үлдээх талаар их зүйлийг санаачилж байна. Түүнээс гадна энэ шинжилгээний ангийн нэг онцлог нь судалгааны ажлын зэрэгцээ монголын оюутан залууст археологийн мэргэжил дадлага эзэмшүүлэх сургалтын ажлыг зохион байгуулж, орчин үеийн европын археологийн малтлага судалгаа, онолын шилдэг арга барилыг заан сургаж, үүнийгээ малтлагын явцад эзэмшүүлэн дадлагуулах ажлыг гүйцэтгэж байгаа билээ. Хот нь эргэн тойрон хүрээлсэн шавар хэрэмтэй, дөрвөн талдаа хаалгатай, төв хэсэгтээ огтлолцсон хоёр их гудамжаар гар урлал, худалдаа арилжаа, орд харш, сүм хийдийн гэх хэдэн үндсэн хэсэгт хуваагдаж байв. Хотын хэрмийн баруун өмнөд хэсэгт буй Өгөөдэй хааны ордыг нэлээд хэмжээгээр малтан судалж өндөрлөж хийсэн шороон довжоотой, 64 багана бүхий төв барилгын суурийг илрүүлжээ. Энэхүү ордны малтлагаас луу болон бусад амьтдын дүрс гаргасан улаан, ногоон паалантай, барилгын гоёл чимгийн зүйлс их олджээ. Ордоны орчмын малтлагаас илэрсэн хамгийн сүүлийн сонирхолтой олдвор гэвэл, барилгын материал шавар вааран чимэглэл, тоосго зэргийг шатаан боловсруулж байсан гэрийн хана мэт дүгрэг хэлбэртэй тоосгон зуух дөрвийг илрүүлж олсон явдал юм. Энэ нь дундад зууны монголын нийслэл хотод хөгжиж байсан үйлдвэрлэлийн арга ажиллагааг бодитойгоор харуулах нэн үнэт дурсгал болно.

Хотын нийт талбайд мөн хэд хэдэн газар малтаж Хар Хорум нь тухайн үеийнхээ гар үйлдвэрийн том төв байсныг гэрчлэх олон тооны олдвор илрүүлжээ. Ялангуяа төмөрлөг боловсруулах, цутгах үйлдвэр их хөгжсөн нь эндээс харагддаг. Хар Хорумын ширмэн эдлэлийг тусгай лабораторид задлан шинжилж үзээд 1350-т хайлдаг цагаан ширэм ба ган байсныг олж тогтоожээ. Тэрчлэн янз бүрийн хэмжээ, хэлбэртэй шавар ваар сав үйлдэх ажил их өрнөж байсны баримт

олджээ. Малтлагын явцад илрүүлэн олсон олон зуун зоос мөнгө, тэр үеийн худалдаа арилжааны цар далайцыг харуулж байна. Хамгийн сүүлийн малтлага судалгаагаар Хар Хорумын гар урчуудын хорооллоос монголын дөрвөлжин бичигтэй зоос, Аюушидар хааны нэр бүхий хүрэл тамга зэрэг сонирхолтой олдворууд олджээ. Хар Хорум хотын барилга байгууламжийн зохион байгуулалт, гоёл чимэглэлийн хэрэглэгдэхүүнээс IX-XII зууны үеэс уламжлан ирсэн орон нутгийн уран барилгын арга барил харагддаг.

Тэр үед монгол оронд Хар Хорумаас гадна хэд хэдэн хот байсныг сурвалж бичгийн мэдээ гэрчлэх бөгөөд, тухайлбал, Саорин, Тосху болон хааны дөрвөн их орд гэж байжээ. Одоо мэдэгдэж байгаагаар монголчуудын барьж байгуулсан хот суурины хамгийн эртнийх нь XII зууны үед холбогдох Аврагын балгас юм. Энэ нь Хэрлэн голын баруун гарын цутгал Аваргын голын хойд эрэгт Рашаан дэрсний ухаа хэмээх уулын өмнө бэлд орших ба 4,5 ам дөрвөлжин км талбайтай.

Энэ хотыг хүрээлсэн ерөнхий их хэрэм байхгүй боловч дотоод барилгуудыг хүрээлсэн тус тусын хэрэм байх ба худалдаа, гар урлал, шашны сүм хийд, орд харш гэх мэт хэсгүүдтэй, гол орд болон мөргөлийн сүмийг тусгайлан зассан өндөр довжоон дээр байгуулжээ. Аваргын балгасыг анх манай ууган археологич Х.Пэрлээ илрүүлэн судалж байсан ба 1990-1993 онд Монгол, Японы Гурван гол экспедиц уг хотын судалгааг үргэлжлүүлэн хийсэн бөгөөд эдүгээ мөн Монгол, Японы хамтарсан шинжилгээний анги энд нарийвчилсан судалгаа хийж байна. Хот суурин цогцлон байгуулах зохион байгуулалт, арга барилын энэхүү уламжлал нь VII зууны үеэс уйгур, киданаар дамжин эртний монголчуудад уламжлан хөгжжээ.

Археологийн судалгааны явцад Монголын их гүрний үед холбогдох өөр бусад хотуудыг ч илрүүлэн олж ямар нэгэн хэмжээгээр малтан судалж байсны тоонд Хэрлэн Барс, Хар хул хааны балгас, Шаазан хот, Халтарын балгас зэргийг дурдаж болно. Тэрчлэн хилийн чанадад эртний монголын хот сууриныг судалсны жишээнд зөвлөлтийн археологчдын малтсан Хавт Хасар түүний удмынхны сууж байсан Хархираагийн хот, Кондуйн орд, Дён Терек зэрэг хотууд, одоогийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шулуун Хөх хошуунд байх Хубилай хааны үүсгэн байгуулсан дундад зууны Их Монгол гүрний хоёрдах нийслэл Шанд балгас буюу Дээд нийслэл зэргийг дурдаж болох бөгөөд эдгээрээс мөн л монголчуудын хот байгуулалтын өвөрмөц онцлогийг харуулах олдвор их хэмжээтэй гарсан байна. Түүгээр ч барахгүй, нүүдэлчдийн хот суурины уламжлал нь Ижил мөрний орчим нутагт оршин тогтнож байсан Алтан Ордны улсын хотуудыг малтан судлахад мөн л харагддаг байна. Энэ бүхэн нь монголчууд нэгдсэн улс байгуулахаас өмнө хот орон цогцлон барих өвөрмөц уламжлалтай байсан нь хожим хойч үедээ уламжлан хөгжсөөр ирснийг гэрчлэн харуулдаг билээ.

§ 2. МОНГОЛЧУУДЫН БУЛШ ОРШУУЛГА

Дундад зууны монголчуудын нийгмийн харилцаа, үйлдвэрлэх хүчний хөгжил, зан суртахуун, шашин шүтлэг, ахуй байдлыг бодитойгоор судлан шинжихэд чухал ач холбогдолтой дурсгалын нэг нь тэр үеийн булш оршуулга юм.

Одоогоор манай улсын нутагт дундад зууны монголчуудын булшийг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Сэглэгийн улаан зааг (1951), аймгийн төвийн ойр Хар аараг, Алтанширээ сумын ойролцоо (1986), Их Хэт сумын хөшөөнө Ухаа (1988), Дундговь аймгийн Төвийн ойр Хан уул (1959), Өмнөговь аймгийн Манлай сумын Хар аргалант (1960), Ноён сумын Цагаан ханангийн агуй (2000), Өвөрхангай аймгийн Богд сум (1972), Хар хорин сумын Бага Арцат (1979), Маамуу толгой, Эрдэнэзуугийн ойр (1980), Гүмбийн дэнж (1994), Дорнод аймгийн нутаг Чойбалсан хотоос зүүн тийш 40 км, Хэрлэнгийн эрэгт (1973), Хэнтий аймгийн Дадал сумын төвд (1967), Галуут хан уул (1959), Мөрөн сумын Чандган тал (1971), Хүйтэн хошуу (1986), Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын бага Өлзийт (1971), Увс аймгийн Зүүнговь сумын Саран толгой (1973-74), Сэлэнгэ аймгийн Хонгорын САА-н нутаг Буурал уул (1982), Булган аймгийн Орхон-Бүрэгхангай сумын Зараа толгой (1979), Хутаг-Өндөр сумын Элст хөтөл, Айдын хүрэм, Холтост нуга, Баруун Бэлсэгийн ам, Эмгэнт хошуу, Бурхан толгой, Дөрөлж, Мухдагийн ам (1994-95), Туул голын хөндий Зүүн Богины ам (1982), Дадарт (1981) зэрэг газруудад малтан судалж үр дүнг хэвлэн нийтэлж байжээ. Түүнчилэн ОХУ-ын Байгал орчмын нутгаар эртний монголчуудын булш нэлээд хэмжээгээр малтаж үр дүнг нь хэвлэн нийтэлсэн нь тухайн үеийн эдийн соёлыг судлах чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Түүхийн сурвалжид тэмдэглэн үлдээснийг үзвээс эртний монголчууд нас барсан хүнээ газрын хөрсөн нүх малтаж булшлан оршуулах ба тэр хүний амьд ахуйдаа хэрэглэж асан эд юмсын зүйлсээс дагдлуудан хийдэг байсныг тодорхой өгүүлжээ. Эртний энэ заншил шарын шашин монголд дэлгэснээр орхигдож нас барсан хүнээ ил задгай нутаглуулах болжээ.

Хэрлэнгийн сав газрын булшууд. МЗТСХЭ-ийнхэн Хэрлэн голын сав нутагт, Чойбалсан хотоос зүүн зүгт 40 км зайд хэдэн булш малтсан байна. Эдгээрээс 2,3,4-р булшууд болон Хоолтын гол хэмээх газарт малтсан нэгэн булш нь X-XII зууны жирийн монгол иргэдийн булш болох ажээ. Эдгээр булшинд талийгаачийг толгойгоор нь умар зүг чиглүүлэн тавьсан, булшны гүн нэгэн жигд, төдий л гүн биш, чулуун дараасны хэлбэр хэмжээ, дагуулж тавьсан эд өлгийн зүйлс адил байгаа зэрэг нь цаг хугацаа болон түүх соёлын нэгэн хүрээнд хамруулж үзэх боломж олгож байгаа юм. Эдгээр булшинд навчин хэлбэрт төмөр зэв, үйсэн хормсого зэрэгнийтлэг эд өлгийн зүйлс гарсан байна. Тэгэхдээ дагуулж

тавьсан хойлгын эд зүйл төдий л баялаг бус байгаа нь монголын нэгдсэн улс бүрэлдэхээс өмнөх үед холбогдох жирийн иргэдийн булш юм гэж судлаачид үзжээ.

Дундговь аймгийн Хан уулын булш. Энэхүү булшийг 1959 онд малтан судалсан бөгөөд том том чулуу зэрэгцүүлэн тавьж хийсэн хүрээтэй, зууван хэлбэртэй ба дундаа чулуугүй хэсэг талбайтай байжээ. Булшны нүхний дотор тал бүхий модон хашлага хийж, дунд нь модон авсанд оршуулгыг үйлдсэн байжээ. Талийгаачийг толгойгоор нь умар зүг хандуулан хандуулан тавьж, толгой дор нь дэр тавьж байсны үлдэгдэл ялзарсан бүс давуу олдсон байна. Толгойн ясан дээр шар хоргойгоор хийсэн, бүч бүхий малгайн үлдэгдэл олджээ. Энэ булшнаас үйсэн сав, төмөр хайч, дотроо төмөр эдлэлийн үлдэгдэлтэй илэг, торгоор хийсэн уут, модон сам, модон иштэй төмөр шөвөг, жижиг толь, торгон хувцасны тасарханууд, гутлын үлдэгдэл, мөлгөр үзүүртэй, хавтгай төмөр зэв зэрэг зүйлс гарчээ. Эндээс гарсан эд өлгийн зүйлсээс харьцуулан судалж, XII-XIV зууны үед холбогдуулж үзсэн байна. Маамуу толгойн булш. Эртний Хар Хорум хотын зүүн өмнө Мэлхийт хэмээх толгойн ар биед нэгэн булш илрүүлж судалсан нь Маамуу толгойн булш хэмээн нэршжээ.

Үүнийг анх газар шорооны ажлын үед илрүүлсэн бөгөөд газрын гадарга дээр ямар нэгэн тодорхой шинж тэмдэггүй байжээ. Зузаан элсэн үеийн дотор 230 см гүнд модон авсанд уг оршуулгыг үйлдээд гадуур нь дөрвөлжин банзан хашлага хийсэн байв. Энэ нь толгойгоор нь өмнө зүг хандуулж тавьсан эмэгтэй хүний оршуулга бөгөөд авсны ёроолд сийрс дэвсч нүүрийг нь торгомсог эд болон нарийн утсан тороор бүтээсэн байжээ. Толгойн орчимд үсний чимэг болох алт шармал нимгэн төмөрлөг эдээр хийсэн 3 хавчаар, чих хумс цэвэрлэх халбага хэлбэрт эдлэл, ээмэгний хугархай, торгон уутанд хийсэн зөөлөн цагаан чулуун сийлбэр эд, хүний арван шүд үйсний тасархай зэрэг зүйлс гарсан юм. Шарилын бүсэлхий хавьд хятад үсэгтэй найман хүрэл зоос, аманд нь араб үсэгтэй хоёр мөнгөн зоос олдсон байна. Авсны гадга талд, хүрээлсэн банзан жаазны дотор ваар саванд хүний шарилын чандрын хамт шатаагүй шүднүүд хийж тавьсан байжээ. Хятад зоосууд 713-1190 он буюу Тан улсаас Зөрчидийн Алтан үе хүртэлх үед, арааб үсэгтэй зоос нь 1342-1357 он буюу Алтан ордны улсын Жанибек хааны үед холбогдож байгаагаас үзэхэд уг булшийг XIY зуунаас хойш үед үйлдсэн болох нь мэдэгддэг. Ийнхүү энэ булшны цаг хугацаа Хар Хорум хот оршин байх үед хамаарах нь тодрохой боловч оршуулгын зан үйл нь ихээхэн өвөрмөц, эртний кидан нарын уугуул нутагт тохиолддог, шарилын биед торон сүлжмэл хувцас өмсүүлэх, нүүрэнд нь баг хийх буюу торгоор бүтээх, аманд нь зоос хийх зэрэг зан үйлтэй төстэй байна.

Эдүгээ манай улс болоод ОХУ-ын нутагт монгол булш малтан шинжилсэн байдлыг үзэхэд эгэл жирийн иргэдийн булш оршуулга голлож байна. Эдгээрийг газар зүйн байрлалыг ажиглахад ямар нэгэнүүл, өндөрлөг газрыг сонгон авч уулын өмнөд энгэр, хормой бэл, тэгш дэвсэг газар оршуулдаг нь хаа ч нийтлэг үзэгддэг юм. Дундад зууны монгол булш ихэвчлэн газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн, чулуун дараасны өрлөг нь урт талаараа умар зүг чиглэсэн, цөөвтөр чулуутай, нуугдмал байдалтай байна. Дараасыг хуулж авахад голдуу дан шороогоор булж төдий л гүн биш (1-3 м), австай, авсгүй хоёр янзаар оршуулсан байдаг. Монголчуудын оршуулгын зан үйлд өнө эртнээс уламжилсан зүйл байгаа нь хүнээ булшлан авсан хийж газарт булаад дээрээс нь чулуун дараас хийдэг, толгойг нь умар зүг хандуулан тэнгэр байдлаар гэдрэг харуулж оршуулдаг, тэрчлэн бог малын голдуу яс, зэр зэвсэг, эдлэл хэрэглэлийн зүйлсийг дагалдуулан хийдэг, толгой дор нь чулуугаар тусгай дэр хийдэг зэрэг онцлог болно. Ийнхүү, нас барсан хүмүүст хойт насандаа хэрэглэхэд нь зориулан эд өлөг дагалдуулдаг байсан тухай Саган сэцэний “Эрдэнийн товч” зэрэг сурвалжид тэмдэглэн бичсэн байх ба энэхүү заншлыг “хойлоглох” гэж нэрлэдэг байжээ. Дагалдуулан хийсэн зүйлс нь эрэгтэй хүний булшинд байлдааны зэр зэвсгийн зүйлс, тухайлбал, навчин хэлбэртэй нарийн шилбэ бүхий төмөр зэв, нумны ясан наалт, үйсэн саадаг, хоромсого, эмээл, дөрөө, хазаарын хэрэглэл, нэлээд чинээлэг булшинд үнэт төмрөөр хийсэн чимэгтэй бүс, арьс ба торгомсог эдээр хийсэн хавтага савын зүйл олдох ба эмэгтэй хүний булшинд үйлийн хайч, ээрүүлийн таваг, сам, толь гэх мэт зүйл нийтлэг тохиолдоно. Хүнээ модон авсанд хийж оршуулахын зэрэгцээ авсны оронд үйсээр ороосон байх нь ихэвчлэн умар зүг, Байгал орчмын монгол булшинд нэлээд таардаг.

Сурвалжит язгууртны булш

Сурвалж бичгийн мэдээнд анхаарууштай нэгэн зүйл байгаа нь хүн оршуулахдаа ихэд нууцлан чандалж, оршуулсан газрыг мэдэгдэхгүй болгохыг эрмэлздэг байсан тухай өгүүлсэн байдаг. Ялангуяа монголын их хаадыг оршуулахад энэ заншлыг тун нарийн чанд баримталдаг байсан бөгөөд хаадыг оршуулдаг “Ихэс газар” буюу “Их хори” хэмээх нууц оршуулгын газар Бурхан Халдун ууланд байжээ. Манай орныг археологийн талаар судлан шинжлэх болсноос хойш илрүүлэн олж судалсан монгол булшны тоо харьцангуй цөөн байгаа нь мөнхүү заншилтай ч холбоотой байж болох юм.

Монголын их хаадын булшийг илрүүлэн олж малтан шинжилсэн зүйл одоо хир үгүй боловч сурвалжит язгууртны гэмээр зарим булш олдож байжээ.

Энэ үеийн монгол язгууртны зан заншил, ахуй амьдралыг тодорхой харуулах баялаг нэгэн олдвор бол Чита мужид дундад зууны монголын Хархираа хотын дэргэд эрдэмтэн С.В.Киселевын удирдсан шинжилгээний анги малтан судалсан оршуулга юм. Энд огт тогногдож хөндөгдөөгүй нэгэн булш олдсон нь төмөр бүслүүртэй, торгоор бүрсэн модон авсан хийж оршуулсан 6 насны бүстэй хүүхдийн

шарил байсан бөгөөд ясан дөрөөтэй эмээл, төмөр амгайтай хазаар, сумтай үйсэн саадаг, нум, мөнгөн чимэгтэй бүс, цахиур, уул бүхий хэтэвч, самгарид үсэгтэй мөнгөн гавал аяга зэргийг дагалдуулан хийж шарилын биед торгон өмд, цамц, дээл, буддагийн санваартны торгон банзал өмсгөсөн байжээ. Уг олдвор, тухайн үеийн монголын нийгмийн дээд давхаргын дунд буддагийн шашин ямар нэг хэмжээгээр дэлгэрч байсныг гэрчилж байна. Түүнчилэн Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг, Цагаан ханангийн агуйд санамсаргүй байдлаар олдож, ухвар мөчид этгээдийн гарт эвдрэн сүйдсэн хадны оршуулга нь XIV зууны монгол язгууртны оршуулга болохын хувьд тухайн үеийн эд өлгийн соёлыг лавлан судлахад чухал олдвор болсон билээ.

Хүйтэн хушууны хадны оршуулга. XIII-XIV зууны жирийн монгол иргэдийн ахуй байдал, зан заншил, эдийн соёлыг сэргээн судлахад ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн шинжилгээний анги 1986 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүйтэн хушуу хэмээх газарт малтан шинжилсэн хадан агуй дахь булш үнэтэй баримт хэрэглэгдэхүүн болох юм. Энэхүү Хүйтэн хушуу хэмээх хадтай толгойн өмнөд үзүүрт буй хадан ангалын дотор 50 эргэм насны эрэгтэй хүнийг толгойг нь дорно зүг хандуулан оршуулсан байжээ. Авсны оронд их биеийг гэрийн ханаар ороож тэнэгэр байдлаар тавьсан ба доор нь ясан хяртай модон эмээл хөндлөн тавьжээ. Энэхүү эмээл уужим суудалтай, урд бүүрэг нь босоо өндөр, хойт бүүрэг нь өргөн налуу байгаа нь урьд өмнө малтан шинжилсэн зарим монгол булшны олдвор, Ордосын Эзэн хороонд олон зуун жил хадгалан тахиж ирсэн Чингэс хааны хэмээх эмээл зэрэгтэй хэлбэр ижил юм.

Эндээс мөн 1 ширхэг төмөр гархи, ээмэг, зэс товч, шарилын хөлд ширэн гутлын үлдэгдэл байжээ. Хамгийн сонирхолтой нэг зүйл бол нас барсан ар дагазанд гэзэгний хэсэг хадгалагдан үлдсэн нь хэд салаалан гөрж бөөгнүүлэн мушгиж боогоод хоёр чихний араар унжуулж байсан бололтой бөгөөд энэ нь XIII-XIV зууны үед монгол оронд айлчлан ирсэн харь орны элч жуулчдын замын тэмдэглэлд бичиж үлдээсэн хийгээд мөн үеийн уран зургийн дурсгалд дүрслэн гаргасантай яг адил байна. Дундад зууны монголчуудын булшнаас тэр үеийн хүмүүсийн эдлэж хэрэглэж байсан эд юмс, хувцас хунарын зүйлс багагүй олдож байгаа нь эртний монголчуудын эдийн соёлыг судлахад чухал ач холбогдолтой юм. Тухайлбал дурдсан шинжилгээний анги 1988 онд Хэнтий аймгийн нутагт хэд хэдэн монгол булш малтсанаас XIII-XIV зууны монгол эмэгтэйчүүд өмсч байсан богтаг хэмээх өвөрмөц сонин хийцтэй малгай хэдийг илрүүлэн олсон нь их биеийг үйсээр хийж гадуур нь улаан өнгийн торгоор бүрсэн байжээ.

Цагаан ханангийн агуй дахь хадны оршуулга. Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Цагаан ханан хэмээх үргэлжилсэн их дэл хадтай, олон агуй хонгил бүхий уулын нэгэн агуйд эртний нэгэн оршуулга байсныг 1999 онд нутгийн нэгэн хүн эвдлэн сүйдэлсэн тухай мэдээ ирснээр археологчид 2000 онд газар дээр нь очиж судалсан юм. Энд модоор угсарч хийсэн хашлагатай, гурван давхар торгоор ороож тавьсан бүрэн хувцастай язгууртан бололтой хүний оршуулга байжээ. Эндхийн эд зүйлсээс бүтэн үлдсэн нь цагаан өнгийн торгоор хийсэн бөмгөр оройтой, ардаа шилэвчтэй, тойрсон дугуй саравч хүрээтэй малгай, сайтар боловсруулсан шар өнгийн ширэн гутал, торгон хэтэвч зэрэг зүйлс байжээ. Эд өлгийн эдгээр баримт нь энд оршуулсан хүн XIII зууны сүүлч XIV зууны үеийн монгол язгууртан хүн болохыг гэрчилж байгаа ба эндээс олдсон ясны үлдэгдэлд Герман улсын археологийн лабораторид хийсэн радиокарбон судалгаагаар энэхүү он цаг батлагдсан юм.

Ийнхүү археологийн олдвор нь дундад зууны монголчуудын талаархи бичмэл сурвалжийн мэдээ баримтыг биет олдвороор нотлон бодит байдлаар харуулаад зогсохгүй огт мэдэгдээгүй зарим зүйлсийг ч тодруулан сэргээж судлахад үнэлж баршгүй ач тусаа өгч байна.

§ 3. ХҮН ЧУЛУУ

Монгол нутгийн уул талаар нэн элбэг тохиолддог дундад зууны үеийн археологийн нэгэн төрөл дурсгал бол чулуугаар хүний дүрс гарган урлаж хийсэн хүн чулуу хэмээх сүрлэг хөшөө юм. Эдгээр нь эртний бөө мөргөлтний ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэл, зан үйлийн холбогдолтой дурсгал бөгөөд тухайн үеийн эдийн ба утга соёлыг судлахад ихээхэн ач холбогдолтой сурвалж болдог билээ. Хүн хөшөөг түүхэн тодорхой үед амьдарч байсан биет хүмүүст зориулан босгосон дурсгал тул тэр үеийн хувцас, өмсгөл, зэр зэвсэг, эд хэрэглэл, гоёл чимгийн зүйлсийг үнэн бодитой дүрсэлсэн байх бөгөөд энэ нь уг дурсгалын он цаг, түүх-соёлын хамаадлыг олж тогтоох чухал хэрэглүүр болдог байна. Монгол нутагт байгаа хүн чулуун хөшөөг XIX зууны сүүл үеэс судлан шинжилж эхэлсэн бөгөөд одоо манай нутагт 500 орчим хүн чулуу бүртгэгдээд байгаа юм. Ийм төрлийн дурсгал зөвхөн манай орон төдийгүй хөрш зэргэлдээ нутаг Тува, Уулын Алтай, Дундад Ази, Өмнөд Оросын тал, Өвөр Монгол, Шинжаан зэрэг газар элбэг олддогийг судлаач эрдэмтэд сайтар шинжлэн дундад зууны түүхийн олон үед холбогдох хэд хэдэн төрөл болгон ангилсны дотор VI-VIII зуунд Төв Азид төр улсаа мандуулсан Түрэгийн хаант улсын үеийн хүн чулуу зонхилж байна. Монгол оронд байгаа хүн чулуу нь VI-IX зууны Түрэг овог аймгуудын, XIII-XIV зууны Монгол гүрний үеийн хүн чулуу хэмээх үндсэн хоёр төрөлд хамаарна.

Монгол гүрний үеийн хүн чулуу Монгол улсын зүүн өмнөд хэсгээр байрлажээ. Сүүлийн үеийн судалгаагаар ийм төрлийн хүн чулуу одоогийн манай хилээс урагш БНХАУ-ын нутагт харьяалагдах ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн нутгаар байдаг нь тогтоогдсон байна.

Монгол гүрний үеийн хөрөг чулуу нь хийсэн дүрслэл, дүрслэн гаргасан эд юмс, зохион байгуулалт зэрэг зүйлээрээ өөрийн гэсэн онцлог шинжийг агуулжээ. Үүнд:

1. Юуны өмнө хүн чулууг дагалдуулан байгуулсан тахилын цогцолбор байгууламжийн хэлбэр төрх, зохион байгуулалтын хувьд түүхэн өөр цаг үед холбогдох хүн чулуудаас нэлээд ялгаатай. Хүн чулууг тусгайлан судалсан олон судлаачийн шинжилгээний хэрэглэгдэхүүн ажиглалтаас үзэхэд түрэгийн үеийн хүн чулууг, газарт хавиргалан зоосон дөрвөн чулуун хавтангаас бүтсэн тахилгын хашлагын зүүн өмнө талд байрлуулдаг байжээ. Үүний зэрэгцээ уг цогцолбор байгууламжийн бүрэлдэхүүнд тойрсон шороон далан, ус урсгах суваг, зарим томоохон цогцолборт шүтээний сүм барилга, руни бичээст хөшөө, элдэв амьтан хийгээд шадар бараа бологч хүмүүсийн чулуун дүрсийг сийлэн тавьсан байхаас гадна түрэгийн дурсгал хэмээн ялгах хамгийн онцгой шинж тэмдэг бол хүн чулууны өмнө талаас наран ургах зүгт чиглүүлэн газарт зоож цувуулан тавьсан олон зэл чулуу байдаг ажээ.

Тэгвэл Дорнод Монголын хүн чулууг, дүгрэг хэлбэр гарган овоолж хийсэн булш гэмээр байгууламжийн зүүн өмнөд хэсэгт мөн зүүн өмнө зүг хандуулан байрлуулсан байх ба түрэгийн цогцолбор дурсгалд заавал байдаг онцлог зүйлс-шороон хэрэм, усны суваг, бичигт хөшөө, ан амьтан, хүмүүсийн дүрс, цуварсан зэл чулууны аль аль нь байхгүй юм. Энэхүү хүн чулуут цогцолборыг ихэвчлэн өндөрлөг уул толгодын нар эзвэр энгэр бэлээр байрлуулсан байх бөгөөд түрэгийнхтэй ижил төстэй зүйл гэвэл гагцхүү тэдгээрийн зүг чиг тохирч байгаа нь ерөөс нүүдэлчид наран мандах зүгийг эрхэмлэдэг эртний уламжлалыг баримталсан гэлтэй. Даргангын хүн чулууг анх судалсан эрдэмтэн В.А.Казакевич эдгээр байгууламжыг булш гэж нэрлэсэн байх боловч бид судалгааны явцадаа малтан судалсан байдлаас үзэхэд энэ нь булш оршуулга биш харин тухайн үеийн нэр хүнд бүхий язгууртан хүмүүсийн дурсгалыг мөнхжүүлэн үлдээж тахилга тайлга үйлдэх шүтээний чанартай байгууламж болох нь мэдэгдсэн бөгөөд эндээс гэрийн мал, зэрлэг амьтны ясны үлдэгдэл их гарч байсанаас бус хүн оршуулсан тохиолдол нэгээс өөр таарсангүй. Үүнээс үзэхэд эдгээр байгууламж утга зориулалтаараа түргийн хаад язгууртны цогцолбор дурсгалуудтай нэгэн адил Төв Азийн нүүдэлчдийн эцэг өвгөдийн онгодыг эрхэмлэн тахиx эртний бөө мөргөлийн ёс заншилтай холбоотой болов уу.

2. Хүн чулууг урлан хийсэн арга маяг нь мөн өөрийн гэсэн өвөрмөц талтай. Тухайлбал, Монгол орон хийгээд зах залгаа бусад нутгаас олдож буй түргийн үеийн хүн чулуудыг ихэвчлэн босоо байдлаар тэгэхдээ хөлийг бараг дүрсэлдэггүй, нүүр толгой, цээжин биеийн хэсгийг онцлон тодотгож урладаг уламжлалтайгаас гадна суугаа байдлаар урласан хүн чулуу тун цөөн тохиолдох нь ихэнхдээ завиран суусан, зарим нь өвдөг нугалан сөхөрч суусан байдлаар дүрслэн хийдэг байжээ. Харин Дорнод Монголд босоо, суугаа байдлаар урласан хүн чулуу аль аль нь тохиолдох боловч дийлэнх олонхыг түшлэгтэй сандалд суусан байдлаар дүрсэлсэн нь эдгээрийн өвөрмөц шинж юм. Түүнчлэн эдгээр хөшөөнд хүний биеийн бүхэл хэсгийг аль болох бүрэн дүүрэн дүрслэхийг хичээсэн байна. Ялангуяа хөлийг нарийн нямбай сийлж гаргасан нь түргийн хүн чулуунаас эрс ялгардаг. Дорнод Монголын хүн чулууны юуны түрүүнд нүдэнд тусах онцгой шинж нь: баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэгт, эсвэл өвдөг дээрээ тавин түшлэгтэй сандалд суугаа байдлаар урладагт оршино. Харин ийнхүү баруун гартаа сав барьсан нь түргийн болоод нийт нүүдэлчдийн хүн чулуу бүтээх урлагийн нийтлэг заншил юм. Түүнээс гадна түргийн хүн чулууны урлалд хэвшил болсон хүний нүд хөмсөгийг “Т” үсгийн хэлбэртэй нэг үргэлж товгор шугамаар гаргах, зарим тохиолдолд гар хурууг их л янз маяг оруулан дүрслэх зэрэг хийц дүрслэлийн арга барил энд огт тохиолдохгүй байгааг цохон тэмдэглүүштэй. Мөн эрэгтэй, эмэгтэй хүний ялгааг бие бялдын онцлог шинж тэмдгээр цохон гаргасан байдаг нь бас л нийт хүн чулууны урлалын нийтлэг шинж болно.

3. Хүн чулуунд дүрслэн гаргасан эд юмс (хувцас, зэр зэвсэг, гоёл чимэглэл, эд хэрэглэл г.м.) зүй ёсоор түүхийн биет сурвалж баримт болох бөгөөд эдгээрийг задлан шинжилснээр уг дурсгалын холбогдох он цаг, түүх-соёлын хамаадлыг олж тогтоох боломж бүрдүүлдэг билээ. Бидний судлан бүхий хүн чулуун хөшөөнд сийлж урласан эд юмс нь хэлбэр байдлаараа дундад зууны монголчуудын эд өлгийн соёлыг лавшруулан судлахад туйлын үнэмшилтэй шинэ сэргэг сурвалж болж байна. Тодотговол, малгай, дээл, бүс, гутал, бүснээс зүүсэн хавтага сав, хутга, гоёл чимэглэлийн зүйлс, сандал суудал, гэзэг үс зэрэг бүх л зүйлс нь түрэгийн хүн чулууныхаас огт ондоо байгааг дурдах хэрэгтэй.

Дорнод Монголын бүх хүн чулууг зөв тийш дарсан ташуу энгэртэй, урт хормой, нарийн ханцуйтай дээлтэй, мухар буюу шөвгөрдүү, заримдаа яльгүй ээтийж эргэсэн хоншоортой гутал өмссөнөөр дүрсэлсэн нь түрэг болоод бусад төрлийн хүн чулуунаас их ялгаатай байна. Түрэгийн хүн чулууг ихэвчлэн буруу энгэртэй, гадагш эргэсэн өргөн захтай дээлтэй дүрсэлдэг нь сурвалж бичигт тэмдэглэн үлдээсэн түрэг угсаатны хувцасны онцлог шинж юм. Харин Дорнод Монголын хүн чулуунд байгаа шулуун ташуу захтай, зөв энгэртэй дээл нь XIII- XIV зууны үеийн монгол хувцасны тухай сурвалж бичигт тэмдэглэсэн хийгээд уран зурагт дүрсэлсэнтэй яг дүйж байна. Зарим хөшөөнд дээлийн дээгүүр давхарлан өмссөн, тохойноос дээхнүүр богино ханцуйтай, дээл мэт урт хормойтой хувцас байгаа нь мөн дурдсан үеийн монголчуудыг дүрсэлсэн уран зургийн дурсгалд элбэг тохиолддог юм. Бүсийг ихэвчлэн ургамлын дүрс, саран хээтэй товруугаар чимэглэсэн нь түрэгийн хүн чулууны олон унжлага, дөрвөлжин товруут бүснээс эрс ялгарах ажээ. Эртний монголчууд бүсийг нэн их эрхэмлэдэг ба хаад язгууртан алтан бүс хэмээх бүстэй байсан тухай сурвалж бичигт олонтоо дурджээ.

Үүнийг монгол булш малтахад олдож байсан алт, мөнгөн чимэгтэй бүсний олдвор ч гэрчилж байна. Гутлын хэлбэрийг ажиглахад, урт түрийтэй, эсгий оймс бүхий монгол гутлын эртний хэлбэр болох нь илт бөгөөд одоо ч буриад, өвөрлөгчдийн хэрэглэсээр буй гуталтай туйлын адил юм.

Дорнод Монголын хүн чулууны онцлох тэмдгийн дотроос хамгийн их анхаарал татаж буй зүйл гээг үсний хэлбэр болно. Тэдгээрийг нэгбүрчилэн судалсны эцэст нэгтгэн тодорхойлоход, зулай дээр дух руу унжсан хэсэг гэхөл үс үлдээж тойруулан хусаад, ар дагзанд тэр хэвээр нь үлдээсэн ихэнх үсийг олон нарийхан гөрж хоёр хэсэг болгон нийлүүлж багцлан боогоод чихний араар унжуулсан байх нь XIII зууны үед Монголд айлчлан ирж тэр үеийн монгол хүмүүсийн гээг үсийг тодорхойлон бичиж үлдээсэн гадаад орны элч, жуулчдын замын тэмдэглэлд хадгалагдан үлдсэн байдаг билээ.

Монголчуудын хүн чулууны дурсгал дотор уран сайхан хийц, бодит дүрслэлээрээ хэний ч анхаарал татмаар, тухайн үеийн чулууч урчуудын мэргэжлийн ур чадвар, уран сайхны сэтгэлгээ ямар өндөр түвшинд байсныг тодорхой харуулж чадахуйц хөрөг чулуу цөөнгүй бий. Эдгээрийн тоонд Дорнод аймгийн Халх гол сумын Шонх таван толгойн хөргийг (одоо Монголын Үндэсний Түүхийн музейн үзмэрт буй) дурдаж болох бөгөөд энэ хөргийн толгой хугараагүй бүтнээрээ хадгалагдан үлдсэн бөгөөд нүүр царайны хэлбэр төрх, дотоод сэтгэлийн хүчин чадлыг тод томруун илэрхийлж чадсаны зэрэгцээ, дундад зууны монгол эр хүний гээг үсний янз байдал, дээл хувцас, чимэглэлийн онцлог, хаад язгууртны залран суух исэр суудал тэргүүтний талаар бүрэн тодорхой ойлголт өгч байна. Түүнчилэн Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газарт буй хоёр хөрөг нь, хэдийгээр толгой нь хугаран унасан боловч гайхалтай уран нарийн хийц, хүний биеийг бодит байдлаар дүрсэлснээрээ нэн онцгой юм. Энэ хоёр хөргийн дээлийн цээжин хэсэгт үүлэн хээтэй, тэнгэрт нисч яваа луу ороолгон дүрсэлсний зэрэгцээ исэр суудлын түшлэг дээгүүр нь барын арьс нөмөргөн урласан нь дэлхийг донсолгосон монгол хаадын сүр хүчийг бүрэн илтгэх ажээ.

Монголчуудын хүн чулуун хөрөг нь тухайн үеийн хүмүүсийн бодит дүр төрх, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, эдлэл хэрэгслэлийн онцлогийг тусган харуулах түүхэн чухал сурвалж болохын зэрэгцээ тэр үеийн монголчуудын гоо сайхны мэдрэмж, урлаг уран сайхны түвшин, урчууд дархчуудын ур чадварыг илтгэн харуулах дүрслэх урлагийн үнэт дурсгал болох юм.

§ 4. БИЧИГ ҮСГИЙН ДУРСГАЛ

Дундад эртний монголчууд нэгдсэн төр улсаа байгуулаад соёлын талаар олсон том дэвшил бол уйгаржин монгол бичгийг төрийн бичиг болгон хэрэглэсэн явдал болно. Улмаар Монголын Их Эзэнт гүрний үед гүрэн даяар нийтээр хэрэглэхэд зориулан дөрвөлжин бичгийг зохион хэрэглэж байсан уламжлалтай Монголчууд өөрийн түүхэндээ хэд хэдэн төрлийн бичиг зохион хэрэглэж ирсэн бөгөөд бичиг номыг ихэд эрхэмлэн үздэг байв. Түүгээр ч барахгүй дэлхийд анх ном барлан хэвлэх ажилд ч өөрийн хувь нэмрийг үзүүлж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал хэвлэлийн төмөр барыг Германы И.Гутенбергээс даруй 150 гаруй жилийн өмнө зохион бүтээсэн ба энэ ажлыг Монголын цэргийн жанжин Бэбуха ивээн тэтгэж хийлгэсэн болох нь баримтаар нотлогджээ.

Монголчуудын зохион бүтээж хэрэглэж байсан эдгээр бичиг үсгийн биет дурсгал хадгалагдан үлдэж өнөө бидэнд уламжлагдсан нь багагүй билээ. Монгол бичгийн нэн эртний дурсгал нь одоогийн ОХУ-ын Чита мужийн нутагт харьяалагдах Ононы сав Хархираа голын хөндийгөөс илрэн олдож “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдаршсан пайлуур хөшөөний бичээс болно.

Одоогийн манай нутагт хадгалагдаж үлдсэн эртний судлалын дурсгалууд дотор монгол бичигт пайлуур хөшөө, хад чулуунаа бичсэн дурсгал багагүй байдгийн тоонд Хар Хорумын 1,2-р монгол бичээс, Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээс, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бичигтийн голын Хадан хушууны бичээс зэрэг XIII-XIV зууны үед холбогдох дурсгал, дундад зууны хожуу үед холбогдох Хэсэг байшингийн бичээс, Цогт тайжийн Дуутын хар чулууны бичээс зэргийг дурдаж болох юм. Түүнчлэн Монголын дөрвөлжин үсгээр бичсэн зарлиг, зоос, тамга, цаасан мөнгөн тэмдэгт, хад чулуунаа бичсэн зүйлс, пайз болон модон барын ном сударын тасархай зэрэг олон дурсгал хадгалагдан үлдсэн байдаг.

Хар Хорумын монгол бичээс. Их Монгол улсын нийслэл Хархорум хотноо 1346 онд Тогоонтөмөр хааны зарлигаар босгосон энэхүү гэрэлт хөшөө нь 1380 онд Мин улсын цэрэг Хархорум хотыг довтлох үед эвдэгдсэн гэж үздэг бөгөөд уг хөшөөг гадаад дотоодын олон эрдэмтэн удаа дараа судлан учир утгыг тодруулж хэвлэн нийтэлж байлаа. Энэ хөшөөний бичээс нь Хар Хорум хотын уран барилга, бүтэц зохион байгуулалт, түүнийг сэргээн засварлаж шинээр барилга байгууламж нэмэн барьж байсан талаар өгүүлсэн байдаг. Тухайлбал Хар Хорум хотноо 5 давхар сүм суварга байгуулж, түүнийг хожмын жилүүдэд сэргээн засварлаж сэлбэн барьж байсныг тэмдэглэн бичжээ.

Мөнх хааны гэрэлт хөшөө. XIII зууны Их Монгол улсын үед хамаарах бичиг үсгийн нэгэн үнэт дурсгал болох Мөнх хааны гэрэлт хөшөө Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Дэлгэрхаан уулын өвөрт, Дэлгэрмөрний зүүн хөвөөнд буй эртний балгасын тууриас олджээ. Үүнийг 1953 онд О.Намнандорж илрүүлэн олж, 1956 онд хөшөөний бичээсийг нийтэлсэн ба мөн Б.Ринчен герман хэлээр нийтлүүлж байв.

Хөшөө нь 144 см өндөр, 78 см өргөн, 20 см зузаан бөгөөд тусгай чулуун суурин дээр углуургадан суулгасан байжээ. Хөшөөний дээд талыг дугуйруулан мөлийлгөж засаад нүүр талын

хүрээгээр нь хоорондоо 3,5 см зайтай хоёр нарийн гурив гаргаж, дундуур нь эвэр угалз сийлэн чимсэн ба энэхүү нүүр талд 3 мөр монгол бичээс, мөн нангиад бичээстэй. Уг хөшөө нь тахилын сүм мэт зүйлийн дотор байсан нь малтлагын явцаас мэдэгджээ. Хөшөөний монгол бичээсийг орчин цагийн монгол хэлэнд тоймлон буулгавал: “Ургийн ургаар хэдэн хэдэн үест Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж Барс Түгэ босгуул...хүртэл ана (энэ)-д давирганд (учралт) буян хүртүгэй” гэжээ. Уг хөшөөг 1257 онд Мөнх хааныг амьд сэрүүн ахуй цагт тавнан Бамту (Барс Түгэ), гүнж Исижи (Исүгий) нар босгуулжээ. Үүнийг, Мөнх хаан Хятадын Сүн улсыг 3 замаар байлдаж явсан үед их хааны өлмий бат оршихыг ерөөж босгосон бололтой гэж үздэг. Энэ хөшөө одоо Улаанбаатар хотноо Монголын Үндэсний Түүхийн Музейд байна.

Бичигт хушууны бичээс. Монголчууд бичиг үсгийн дурсгалаа олон янзаар бүтээн үйлдэж байсан бөгөөд тусгайлж зассан пайлуур гэрэлт хөшөө босгон сийлж бичихээс гадна байгалийн бэлэн тогтоц болох хад чулууны толигор тэгш гадаргууд хар өнгийн бэхээр бичиж бүтээсэн дурсгал ч бас тохиолддог. Ийм төрлийн дурсгал манай орны энд тэнд шинээр илрэн олдож судалгааны хүрээнд орсоор байгаагийн нэгэн жишээ нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бичигтийн голын хадан хушуун дээрх хар бэхээр бичсэн бичээс болно. Үүнийг залуу судлаач Д.Боролзой судлан уншиж, утгыг тайлан олны хүртээл болгон нийтлүүлжээ.

Он цагийн уртад элэгдэн бүдгэрч энд тэндээсээ холтрон унасаар өнөө хүртэл хадгалагдан үлдсэн энэ бичээс нь орчин тойрондоо буй эртний булш хиргисүүр, газар усны нэртэй нягт уялдан холбогдож олон үе дамжин хүн нутаглаж байсныг гэрчлэх түүх соёлын үнэт дурсгал болж байна. Уг бичээс нь дундад эртний үед холбогдох монгол бичгийн анхны хэлбэрт хамаарах бөгөөд энэ үеийн бичгийн дурсгалд нийтлэг тогтсон уламжлал болох “ ” хэмээх үгээр эхэлж байна. Түүнчлэн энэ бичгийн дотор “ ” хэмээн Их Монгол улсын анхны нийслэл Хар Хорумын тухай өгүүлсэн зүйл байгаа нь нэн сонирхолтой юм. Уг бичээсийг “тахиа жил бичүүлвэй” хэмээсэн байдгаас үндэслэн үүнийг 1381 онд буюу Мин улсын цэрэг Хар Хорум хотыг довтолж эвдэн сүйтгэсний дараа жил бичсэн гэж үзэж байна. Хүйтний голын бичээс. Дархан хотоос зүүн хойд зүгт 70 гаруй км-т Хүйтний голын Бичигт хошуу хэмээх газарт буй монгол, дөрвөлжин бичгийн дурсгалыг анх 1981 онд Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж, А.Очир нар илрүүлж Хүйтэний голын бичээс хэмээн нэрлэжээ. Монгол бичээс нь өндрөөшөө 36 см, өргөнөөрөө 21 см талбай эзэлсэн багаад хар бэхээр бичигджээ. Он цагийн уртад ихэд баларсан тул бүрэн тайлан уншихад нэлээд бэрхшээлтэй болжээ. Зарим үг үсгийг нь тайлан уншсанд тулгуурлан уг бичээсний ерөнхий утгыг тоймловол: Мөнх тэнгэрийн хүчинд хааны суу дор нэгэн үйл явдлыг дурсан хаданд бичиж, хүр дурсгал болгон бэлэгдэж, тахиа жилийн есөн сарын шинийн наймнаа уг бичээсийг үйлдсэн мэт байна. Бичээсний хэлбэр байдлаас үндэслэн судлаачид XII-XIV зууны үед холбогдуулан үзжээ. Мөн уг бичээсний дэргэд долоон мөр босоо дөрвөлжин бичиг байгаа нь басхүү Мөнх тэнгэрийн хүчинд хааны сууд хэмээн эхлэж байна. Яг монгол бичээс шиг хар бэхээр бичигдсэн эл дөрвөлжин бичгийн дурсгал үлэмж элэгдэж баларсан тул утга нь тайлагдаагүй байна.

§ 5. ХАДНЫ ЗУРАГ

Дундад эртний монголын түүхэнд холбогдох эд өлгийн дурсгал дотор хадны зураг сүгийн зүйл нэгэн төрөл болон ордог билээ. Тухайн үед хад чулуунаа хар бэхээр ямарваа зураг дүрсийг зурж дүрслэн дэргэд нь бичээс үйлдсэн дурсгал, мөн чулууны толигор гадаргууд нарийн хурц үзүүртэй зүйлээр сараачин зурж хүн амьтан болон байгалийн байдал, орон барилга, эд юмс зэргийг дүрсэлсэн зураг тохиолддог.

Их тэнгэрийн амны хадны зураг. Улаанбаатар хотын чанх өмнө, Туул голын өмнө биед Их тэнгэрийн амны зүүн үзүүрийн хойш хандсан хадан хясаанд цаг хугацааны үед өөр өөр үед холбогдох хадны зургийн гайхамшигт дурсгал оршдог.

Энд хүрлийн үеийн улаан зосон зургаас гадна хар бэхээр зурсан XIII зууны Их Монгол улсын үед холбогдох зураг, бичээс байдаг нь нэн онцлог юм. Энэ зургийн хамгийн гол дүрслэл нь нүүрэн талаараа эгц хандсан эмэгтэй хүний бүтэн биеийн дүрс бөгөөд энэ нь урт хормойтой нарийн ханцуйтай дээл, өргөн түрий нарийн хоншоортой гуталтай, энгэртээ давхарлаж хадсан олон гоёл чимэгтэй ажээ. Уг зургийн хамгийн сонирхолтой бөгөөд холбогдох он цагийг тодрохойлох гэрч баримт болсон зүйл нь оройг нь өд мэт зүйлээр чимэглэсэн өндөр малгай болно.

Судлаачид үүнийг, уг дурсгалын он цагийг тодорхойлох хамгийн гол баримт болгон үзсэн бөгөөд энэ нь XIII зууны үеийн монгол оронд айлчлан ирсэн гадаадын элч жуулчид олонтаа тэмдэглэн бичиж байсан, тэр үеийн эхнэр хүний өмсөх богтаг малгай гэж үзсэн байна. Энэхүү малгай нь Юант улсын хатан хүний хөрөг зурагт нийтлэг дүрслэгдэхээс гадна манай оронд малтан шинжилсэн монголчуудын булшны хэрэглэгдэхүүн дотор биет байдлаараа олдож байсан юм. Энэ ч учраас уг зураг нь дундад зууны монгол эмэгтэйн дүрийг хад чулуунд мөнхөлсөн монгол зураачийн бүтээл болохын хувьд Монголын түүх, соёл, урлагийн нэн үнэт дурсгалд тооцогдож байна. Тэгээд ч дэргэд нь дүрсэлсэн цоохор толбот согоог монголчуудын өндөр дээдэс Гоо маралын дүртэй холбон үзэж, тоймчлон дүрсэлсэн хүмүүсийн дүрсийг бөө мөргөлийн онгон сахиус хэмээн тайлбарласан нь энэхүү дурсгалын он цагийн бас нэг нотолгоо болж байна. Түүгээр ч барахгүй зургийн дэргэд дундад зууны монголын бичигт үсгийн дурсгалд уламжлал болж тогтсон: “Мөнх тэнгэрийн хүчин-тур” хэмээн эхэлсэн

монгол бичээс байдаг нь он цаг утга соёлын талаархи энэ дүгнэлтийг улам ч үнэмшилтэй болгож байна.

Их сарын хадны зураг. Увс аймгийн Сагил сумын нутагт Цагаан голын Үүрэг нуурт цутгах цутгалын урд орших Их сар хэмээн нэрлэгддэг жижиг толгойн баруун тийш харсан нэгэн толигор хаданд матмал махир мөртэй, нумманд навчин хэлбэрийн сум онилсон, нэг хөлөө гишгиж, нөгөө хөлөө өргөн гүйж яваа хүнийг дүрсэлжээ. Энэ хүн одоогийн жанжин малгай маягийн шовх оройтой, дөрвөн талтай, хоёр тийш унжсан чих бүчтэй, духаа дагасан хүрээтэй харагдах малгай, ээтгэр шовх хошуутай гутал өмсч, өргөн бүс бүсэлсэн байх нь эрт үеэс уламжлагдаж ирсэн монгол малгай гуталтай төстэй бөгөөд нумын хэлбэр хийц ч гэсэн XIII зууны үед хэрэглэгдэж байсан монгол нумынхтай ижил байна.

ХОЛБОГДОХ НОМ ЗОХИОЛ

Баяр Д. Каменные изваяния из Сухэ-Баторского аймака // ДКМ. Новосибирск, 1985. с. 148-158.

Баяр Д. Дорнод монголын хүн чулуу монголын дундад үеийн түүхэнд холбогдох нь // SA. t.XII. f.I. УБ., 1987, тал 110-147.

Баяр Д. Перс номын чимэглэлд хадгалагдаж үлдсэн монголын уран зургийн зарим мэдээ // SH. t. 24. УБ., 1990, тал 87-99.

Баяр Д. Монголчуудын чулуун хөрөг. УБ., 1995.

Баяр Д. Эзэн Богдын эх хөрөг. УБ., 1997.

Баяр Д. Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь. УБ., 2000.

Боролзой Д. Бичигтийн нууц -УБ., 1998.

Войтов В.Е. Могильники Каракорума // АЭАИМ. Новосибирск, 1990.

Волков В.В. 1959 онд Дундговь аймгийн нутагт эртний судлалын хайгуул хийсэн тухай // SA. t. II. f. 2. УБ., 1963, тал 47-51.

Волков В.В. Эртний монгол булш // ШУАМ. ¹ 4. УБ., 1962, тал 66-67.

Древнемонгольские города. Под ред. С.В.Киселева. М., 1965.

Лхагвасүрэн Х. Буурал уулын монгол булшууд // SH. t. XXIII. f. 15 УБ., 1989, тал 137-144.

Майдар Д. Монголын архетиктур ба хот байгуулалтын тухайд. УБ., 1972.

Мэнэс Г., Баяр Д. Два погребения монгольского времени из Каракорума // SH. t. XXIII. f. 14. УБ., 1989, тал 127-131.

Наваан Д. Дундад зууны монголчуудын оршуулгын зан үйлийг судлах асуудалд // SA. t. VI. f. 1. УБ., 1986, тал 3-5.

Намнандорж О. Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай. УБ., 1956.

Очир А. Mongolian and square memorialscripts of the river "Huiten" // Nomadic. ¹ 18. April. 2001.

Пэрлээ Х. Нэгэн шарилын тухай. УБ., 1959.

Пэрлээ Х. Эртний монголчуудын үхэгсэдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд

Пэрлээ Х. Монголын олон наст нийслэлийн нэг // ШУ. ¹ 2. УБ., 1970, тал 26-27.

Төрбат Ц. Хар Хорумын монгол бичээсийн талаар дахин өгүүлэх нь // SH. t. XXX. f. 11. УБ., 1997. тал 90-99.

Түмэн Д. Палеоантропологический материал монгольского времени из Хар Хорина // SA. t. XI. f. 8. УБ., 1986, тал 85-97.

Цэвээндорж Д. Эртний оршуулга // SA. t. XI. f. 6. УБ., 1985.

Эрдэнэбат У. Сайр хээрийн Халиутайн орд хаана байсан бэ? // SA. t. XVI. f. 11. УБ., 1996, тал 136-143.

Эрдэнэбат У. Эгийн голын савд малтсан монгол булшны тухайд // SA. t. XVIII. f. 13. УБ., 1998, тал 135-152.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЭАИМ-Археологические, этнографические и антропологические исследования Монголии.

ДКМ-Древние культуры Монголии

МАИКЦА-Материалы археологии, истории и культуры Центральной Азии

МЗТСХЭ-Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици

МИА-Материалы исследования археологии

МНДТСД-Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах)

ТХГБС- Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан

СА-Советская археология

СТ-Советская тюркология

СПб-Санкт-Петербург

ШУАМ-Шинжлэх Ухааны Академийн мэдээ

ШУ-Шинжлэх ухаан

ШУТ-Шинжлэх ухаан техник

ШУА-Шинжлэх ухаан амьдрал

ЭСУЗБ-Эртний судлал, угсаатны зүйн бүтээл

SA- Studia Archaeologica (Археологийн судлал)

SH-Studia Historica (Түүхийн судлал)

SM-Studia Mongolica (Монгол судлал)

SE-Studia Ethnografica (Этнографын судлал)